

As this is a Dhamma text,  
we request that it be treated with respect.  
If you are finished with it,  
please pass it on to others or  
offer it to a monastery, school or public library.  
Thanks for your co-operation.  
**Namo Amitabha!**



《蒙古文：THE EXPLANATIONS OF BUDDHIST RITUALS》

財團法人佛陀教育基金會 印贈  
台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

**The Corporate Body of the Buddha Educational Foundation**

11F., 55 Hang Chow South Road Sec I, Taipei, Taiwan, R.O.C.

Tel:886-2-23951198,Fax:886-2-23913415

Email:overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

**This book is for free distribution, it is not for sale.**

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

Printed in Taiwan

MO012

MO012 Сангийн тайлбар ✽ Балингийн тайлбар ✽ Мандалын тайлбар ✽ Тарничдын эдлэлийн тайлбар



## Сангийн тайлбар

*Өлзий хутгийн зуун чүдийг нээгч*

## Балингийн тайлбар

*Балингийн зан үйлийн үгийн утгыг  
машид тодруулагч*

## Мандалын тайлбар

*Хязгааргүй буйны чуулганыг хураагч  
гайхамшигт эртгэлчилэнгийн гэгэ*

## Тарничдын эдлэлийн тайлбар

*Тарничдын тангаргын эдийн тийн  
агуулга машид тодорхой зуул*

# ХУВРАГИЙН ЧУУЛГАНЫ УЛАМЖЛАЛЫГ ДЭЛГЭРҮҮЛЭХ ТӨВ

## Сангийн тайлбар

*Өлзий жутгийн зуун үндийг нээгч*

## Балингийн тайлбар

*Балингийн зан үйлийн үгийн утгыг  
машинд тодруулагч*

## Мандалын тайлбар

*Хязгааргүй буюны чуулганыг хураагч  
гайхамшигт сэтгэлчилэнгийн гож*

## Тарничдын эдлэлийн тайлбар

*Тарничдын тангаргын эдийн тийн  
агуулга машинд тодорхой зул*

Printed for free distribution by

**The Corporate Body of the Buddha Educational Foundation**

11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: [overseas@budaedu.org](mailto:overseas@budaedu.org)

Website: <http://www.budaedu.org>

**This book is strictly for free distribution, it is not for sale.**

**ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО**

## **Монголын бурханы шашны сэргэн**

### **мандалтын төлөө**

Бурханы шашин Энэтхэгт үүсч дэлгэрсэн үеэс эхлээд шууд болон дамжиж Монгол оронд түгэн дэлгэрч байсан түүхтэй.

Бидний өвөг эцэг маань бурханы шашны мөн чанарыг таниж амьдралдаа хэрэгжүүлж нүүдэлчний соёл иргэншилд шилжүүлж чадсан нь бурханы шашны нэг дэвшил юм.

Өнөөдөр бурханы шашин гурван үеэ өнгөрөөж хэсэг хугацаанд дарагдмал байж цаг үеийн хувьсалын үеэр нээгдсэн нь бурханы шашины дөрөв дэхь дэлгэрэлт болж буй явдал юм.

Гэвч өнөөдөр цаг үеийн үймээн болон орчин хүрээ нь сэтгэлийг царцаагдмал, явцуу болгосон энэ үед бид бурханы шашнаа эрхэмлэн жинхэнэ мөн чанараар нь таньж хэрэгжүүлэх нь гол зүйтэй юм.

Эдүгээгийн бурханы шашны оршиж байгаа чанар нь бол заслага хариулга тэргүүтэн ахуй хэрэгцээ талаасаа давуутай хөгжиж байна.

Энэ нь нэг талаасаа буруутай бөгөөд бурханы шашны мөн чанар алдагдахад хүрэх уршигтай.

Тиймээс бид тэр дундаас хуврага лам нар маань боловсролын түвшин онолоо сайтар эзэмшин шашины зүрхэн бүтээл бясалгалд шамдах нь зүйтэй юм.

Иймд хуврага бүр шарын шашнаа дэлгэрүүлэх их үйлсэд чадах чинээгээрээ өөрийгөө зориулж ард түмэндээ тус хүргэж чадах Бодьсадын агуу их явдалаар замнах нь хуврага бидний эрхэм үүрэг юм.

Эдүгээ бурханы шашны урсгалууд шарын шашны нэр дор нэгдэн тус тусынхаа номлол сургалт бүтээл бясалгалаа үйлдсээр ажгуу.

Одоо бурханы шашны хөгжилд дутагдаж буй зүйл бол өдөр тутамын зан үйл хэсэг бусагийн тайлбар, ард түмэнд таниулан сурталчилах танилцуулга ба Монгол лам нарын төвд хэлээр зохиосон гүн ухааны, нууц тарнийн сурах бичгүүд лам нартаа төдийлөн хүрэлцээгүй байгаа юм.

Тиймээс хуврага миний үүрэг хариуцлага бол шашиндаа хувь нэмэр болж ахуй хэрэгцээ, сан, тахил, балин тэргүүтний бага тайлбар хийгээд нийт бус нууц тарнийн үүсгэл төгсгөлийн зэрэг тэргүүтэй бясалгалын их тайлбаруудыг орчуулан нэгтгэн гаргах ажилд зорилт тавин ажиллаж байна.

Иймд хуврага лам нарыг эвсэн нэгдэн номлол бүтээлийн шашинаа дэлгэрүүлэх их үйлсэд уриалж байна.

Дашчойнпэл дацангийн лам. Д.Бямбасүрэн

## **Хуврагын чуулганы уламжлалыг дэлгэрүүлэх төвөөс**

### **эрхлэн гаргах номууд**

#### **Бага тайлбарууд**

1. Сангийн тайлбар
2. Балингийн тайлбар
3. Мандалын тайлбар
4. Тарничидын эдлэлийн тайлбар
5. Тахилын тайлбар
6. Чуулганы тахилын тайлбар
7. Жинсрэг буюу гал мандалын тайлбар
8. Равнай буюу Бат оршиолгын тайлбар
9. Чуулганы ороны тайлбар
10. Итгэлийн тайлбар
11. Ламын өгүүзэрийн тайлбар
12. Очирсадвагийн бясалгал урилгын тайлбар
13. Ангид тонилгогч, Бодьсадын, Нууц тарнийн гурван сахилын тайлбар
14. Нялхасын үйлд чухал хэрэгтэй сахиус тарнийн тайлбар
15. Үхэгсэдийн зан үйлд чухал хэрэгтэй сахиус тарнийн тайлбар
16. Үндэсний аймгийн ерөнхий тийн агуулга (тайлбар)
17. Үндэсний дөрвөн аймгийн бурхадын нямба үйлдэх ёсны тайлбар
18. Үндэсний дөрвөн аймгийн таван мөр арван газрын мөрөөр зорчих ёсны тайлбар
19. Элдэв хэрэгт сахиус тарнийн тайлбар
20. Малчдад зориулсан чухал хэрэгтэй таван хошуу малын сахиус тарнийн тайлбар

#### **Их тайлбарууд**

1. Наро Хажодын үүсгэл төгсгөлийн зэрэг
2. Хутагт Дарь эхийн үүсгэл төгсгөлийн зэрэг
3. Хутагт Жанрайсэгийн үүсгэл төгсгөлийн зэрэг
4. Цогт Очир аюулгагчийн үүсгэл төгсгөлийн зэрэг
5. Янсан Ядамын үүсгэл төгсгөлийн зэрэг
6. Мажиг Лавдонмагийн үүсгэл төгсгөлийн зэрэг
7. Лхүндэв бандидагийн Тарнийн мөрийн зэргийн тайлбар
8. Цогт Наровагын зургаан ном
9. Цогт нууцын хураангуйн үүсгэл төгсгөлийн зэрэг
10. Увдисын тайлбар Цогт нууцын хураангуйн таван зэрэг нэгэн дэвсгэртийн улаан хөтөлбөр
11. Цогт Наровагын зургаан ном сэтгэл итгэмжлэхүй гурав болой.

Эдгээр нь бурханы шашны гол сурах бичиг бөгөөд бүгд Монгол лам нарын Төвд хэл дээр зохиосон зохиолууд болно.

**Хуврагын чуулганы уламжлалыг дэлгэрүүлэх их үйлсэд  
эвсэн нэгдэгсэд**

**Удирдсан багш нар**

Урлахуй ухааны дээд сургуулын захирал

Бурханч лам Г.Пүрэвбат

Номун хан гэгээний чихний үндэслэлийг баригч лам

Г.Пүрэвдаваа

Ламын гэгээний чихний үндэслэлийг баригч лам

Ц.Төмөрбаатар

Хүүхэн хутагтын хувилгаан лам О.Тагарва

Гандантэгчинлин хийдийн дэд хамба Ё.Амгалан

**Номын орчуулгын ажилд голлон оролцогчид**

Номын орчуулгыг Д.Бямбасүрэн

Б.Рэнцэнсамбуу

Эх судруудыг Паньд чойнхорлин хийдийн тэргүүн

Г.Данбийбалжир

Зураг чимэглэлийг Ч.Гомбо

Номын эх бэлтгэлийг Д.Солонго

## Сангийн тайлбар Өлзий хутгийн зуун

### үүдийг нээгчийн гарчиг

#### Сангийн тийн агуулга

|   |    |
|---|----|
| Сангийн уг гарал нь                               | 18 |
| Сан нь Төвд Монгол оронд ямар мэт дэлгэрсэн ёс нь | 18 |
| Сангийн гарын авлага бодитойг номлох нь           | 20 |
| Сангийн зан үйлийн гишүүн нь                      | 20 |
| Цаг болон орны ялгавар нь                         | 20 |
| Сангийн эд зайны тийн ялгал нь                    | 20 |
| Тахил балины тийн агуулга нь                      | 21 |
| Эдлэл бусдын тийн агуулга нь                      | 23 |
| Сангийн зан үйл бодитой нь                        | 24 |

#### Сангийн урьд одуулга

|   |    |
|---|----|
| Сан тахил тэргүүтэнд адистэдлэгэ үйлдэх ёс нь                             | 25 |
| Зургаан тарни, зургаан мутарлага, зургаан дияан нь                        | 28 |
| Номын чанарын асар ариун тарниар дэлгэр цэвэрлэх нь                       | 28 |
| Огторгуйн сангийн дэлгэр арвидахад  | 29 |
| Рашааны уйлгалтын тарниар дэлгэр урвуулах нь                              | 30 |
| Хүссэн хэрэг гарах тарни дэлгэрээд тус тусын хүсэлийг<br>бүтээн үйлдэх нь | 31 |
| Агуу их хүч төгс тарни дэлгэрээр тус тусад олж үйлдэх нь                  | 32 |
| Эрхшээн урвуулагч хүрдэний дэлгэр тарни эрхэнд үйлдэх нь                  | 33 |
| Үнэний хүчийг өгүүлэх нь  | 33 |

#### Сангийн бодит суурьт

|   |    |
|---|----|
| Зочидыг залах нь                                | 34 |
| Алинаас залах орон нь                           | 34 |
| Алин залагдах зочид нь                          | 36 |
| Хүндлэлийн зочидын эрхэм нь                     | 36 |
| Шид гарах орон идамууд үндэсний дөрвөн аймаг нь | 38 |
| Сансарт шуналыг буцаасан ширваан брадига буд нь | 39 |



|   |    |
|---|----|
| Бэлгэ билигт сахиус нь  | 40 |
| Ертөнцийн сахиус нь   | 40 |
| Ариун язгуурт Цогт далан таван итгэл нь                                 | 41 |
| Арван зүгийг тэтгэгч нь   | 42 |
| Найман их тэнгэр нь   | 44 |
| Найман их лус нь  | 45 |
| Найман их гариг нь  | 45 |
| Ертөнцийг тэтгэгч дөрвөн махранз нь                                     | 45 |
| Хорин найман од нь  | 47 |
| Есөн аюулгагч нь  | 48 |
| Найман аймагтыг ангилах ёс нь   | 50 |
| Төвдийн Нинмавагын урсгалд алдаршсан тэнгэр<br>мангасын найман аймаг нь | 51 |
| Найман аймагтын ялгал нь  | 51 |
| Гадаад найман аймаг нь  | 51 |
| Дотоод найман аймаг нь  | 52 |
| Нууц найман аймаг нь  | 52 |
| Дээд найман аймаг нь  | 52 |
| Хувилгаан найман аймаг нь   | 53 |
| Жил сар цагийн тэнгэрүүд нь   | 53 |
| Жилийн тэнгэр нь  | 53 |
| Сарын тэнгэр нь   | 54 |
| Цагийн тэнгэр нь  | 54 |
| Хөлөлийн тэнгэр нь  | 55 |
| Мэнгэний тэнгэр нь  | 55 |
| Махбодын тэнгэр нь  | 56 |
| Газрын эзэний богд түшмэл албатууд нь                                   | 57 |
| Оршигч далан хоёр газрын эзэн нь  | 57 |
| Ашид үл солигдох хорин нэгэн газрын эзэд нь                             | 58 |
| Газрын доорх есөн зэрэгийн газрын эзэд нь                               | 59 |
| Төлөг зурхайн тэнгэр нь   | 59 |
| Хамт төрсөн тэнгэрийн язгуураас заяаны таван тэнгэр нь                  | 60 |

|  |    |
|--|----|
| Ад тотгор өр төлөөсний зочид нь                  | 68 |
| Адын язгуур гурван зуун жар нь                   | 69 |
| Тотгорын язгуур нь                               | 70 |
| Тотгорын язгуур наян ад хэмээн алдаршсан нь      | 70 |
| Өр төлөөсний өштөн дөрөв нь                      | 72 |
| Зочидыг ямар мэт залах ёс нь                     | 73 |
| Тахилд өргөх ёс бодитой нь                       | 76 |
| Тахилын ялгавар элдэвийг өргөх нь                | 76 |
| Сангийн тахил өргөх нь                           | 76 |
| Өргөх шалтгааны сангийн тахил нь                 | 76 |
| Тэрнийг алинд өргөх нь                           | 76 |
| Гэмийг ариусгах нь                               | 76 |
| Ялгамжгайд ариусгах нь                           | 77 |
| Сангийн зан үйлд мэргэшээгүйн гэм нь             | 78 |
| Үйлсээ даатгах нь                                | 79 |
| Үйлсээ ерөнхийлөн даатгах нь                     | 79 |
| Ялгамжит тодорхой зоригдолтойгоор даатгах нь     | 79 |
| <b>Сангийн сүүлийн зан үйл</b>                   |    |
| Алтан ундаа буюу сэргим өргөх нь                 | 82 |
| Хишиг даллага авах ёс нь                         | 83 |
| Хишиг даллага авах үеийн зоригдол нь             | 83 |
| Эндүүрсэний хүлцэл өчих нь                       | 84 |
| Зочидуудыг үдэх нь                               | 84 |
| Өлзий өгүүлэх нь                                 | 84 |
| Дээд сан өлзий хутгийн хурыг буулгагч            | 86 |
| Дээд сан өлзий хутагийн хурыг буулгагчын тайлбар | 96 |

**Балингийн тайлбар балингийн зан үйлийн үг утгыг машид  
тодоруулагчын гарчиг**

|  |     |
|--|-----|
| Балингийн анхааран авлагад итгэмжилж бишрэл үүсгэхийн<br>тухайд уг гаралыг номлох нь | 108 |
| Үндэсний дөрвөн аймгаас балингийн гарын авлагыг номлосон ёс нь                       | 108 |
| Балингийн гарын авлага үүний үндэслэлийн зэрэг нь                                    | 109 |
| Балингийн гарын авлага бодитойд орох ёс нь   | 110 |
| Балингийн мөн чанар нь   | 110 |
| Балингийн ялгаа нь   | 111 |
| Балингийн магадлах үг нь   | 111 |
| Балин ч бодьгал нь   | 111 |
| Балингийн зочидын ялгавар нь   | 111 |
| Балингийн зочидыг өчүүхэн дэлгэрэнгүй ялгавал  | 112 |
| Балин талбих цаг нь  | 115 |
| Балингийн эд хийгээд балин түүнийг адистэдлэх ёс нь                                  | 117 |
| Балин хийх сав нь  | 117 |
| Балингийн уг нь  | 118 |
| Балингийн хэмжээ нь  | 118 |
| Балинг адистэдлэх ёс нь  | 119 |
| Адистэдлэг үйлдэх ёс нь  | 120 |
| Аврал одуулах нь   | 120 |
| Сэтгэл үүсгэхүй нь   | 120 |
| Бурханыг бясалгахуй нь   | 120 |
| Зочидыг залах нь   | 120 |
| Тогтоол тарни урих нь  | 122 |
| Дөрвөн бурханыг өгүүлсэн ач тус нь   | 124 |
| Балинг ямар мэт хүртээх ёс нь  | 126 |
| Балинг өргөсөний буяны үндэсийг зориулах ёс нь                                       | 128 |
| Балин үүнд мөрийн оньс бүхэнийг бүрдүүлэн үзүүлэх нь                                 | 129 |
| Зургаан барамэд бүрдсэн нь   | 129 |
| Хураахуй бодит дөрөв бүрдсэн нь  | 129 |
| Гурван санваар бүрдсэн нь  | 129 |

|   |     |
|---|-----|
| Балингийн тангараг нь   | 130 |
| Балинг талбисаны ач тусыг үзүүлэх нь  | 132 |
| Үйл бүгдийн урьд одуулга бөгөөд эс гүйцээсэний нэмэрлэг болох нь                    | 133 |
| Үйл эс бүрдсэний нэмэрлэгт болох нь   | 133 |
| Насыг уртасган саадыг арилгах нь  | 133 |
| Балинаар зэтгэрийг арилгах ёс нь  | 133 |
| Балинаар царай туяа лугаа төгс болох нь   | 134 |
| Төгс эдлэл арвидах нь   | 134 |
| Сүр хүч ихдэх нь  | 134 |
| Ихэд хүчирхэгжих нь   | 135 |
| Хүн бусыг эрхэнд хураах нь  | 135 |
| Юу санасан бүхэн бүтэх нь   | 135 |
| Ахуй үес сайн заяаг олох нь   | 135 |
| Бурханы хутгийг олох ач тус нь  | 135 |
| Номыг тэтгэгч сахиуснуудын балингийн зан үйлд чухал хэрэгтэй увдис зоригдолын зэрэг | 137 |

**Мандалын тайлбар хязгааргүй буяны чуулганыг хураагч  
гайхамшигт сэтгэлчилэнгийн гохын гарчиг**

|   |     |
|---|-----|
| Алинаас номлосон уг гаралыг номлох нь   | 147 |
| Уламжлалаар төгс мандалыг хийх ёс нь  | 151 |
| Мандалын мөн чанарын номлох нь  | 151 |
| Мандалын уг нь  | 153 |
| Мандалын хэлбэр ба өнгийг номлох нь   | 154 |
| Мандалын хэмжээ нь  | 154 |
| Ёс зохилдсон мандалыг өргөх зан үйл бодитой нь  | 155 |
| Барилдлага түрхэх эд болон цомцогуудыг хурааж үйлдэх нь   | 155 |
| Мандал өргөхийн зан үйлийг гишүүн лүгээ сэлттэй өргөх нь  | 156 |
| Дуршилыг үүсгэхийн тухайд ач тусыг номлох нь  | 156 |
| Ловон Гамбала бээр тэр мэт өргөсөний эрдэм нь   | 157 |
| Мандал эс өргөсөний гэм эргүү нь  | 158 |
| Мандалыг алинд өргөх орон нь  | 159 |
| Түүнээ өргөх мандалын тийн ялгалыг номлох нь  | 161 |
| Гадаад хумхын эрх лүгээ барилдсан мандал нь   | 161 |
| Доганчойжилпаггон ёсны гучин долоон цомцогтыг номлох нь   | 161 |
| Их бандид Нароба тэргүүтэн Энэтхэгийн их бүтээлчин ба<br>Богд лам Зонхаба ба нарын заншил мэт мандалын<br>цомцог хорин гуравтыг өргөх ёс нь | 171 |
| Цагийн хүрдний ёсны есөн цомцогт мандалыг өргөх ёс нь   | 175 |
| Долоон цомцогт мандал өргөх ёс нь   | 178 |
| Дотоод нууц эрх лүгээ барилдсан мандал өргөх ёс нь  | 179 |
| Нууц билигийн эрх лүгээ барилдсан мандал өргөх ёс нь  | 181 |
| Хоосон чанар үгийн эрх лүгээ барилдсан мандалыг өргөх ёс нь   | 182 |
| Тэдгээрүүдийг увдис гарын авлагыг үзүүлэх нь  | 183 |
| Дотоод мандал өргөх ёс нь   | 184 |
| Нууц мандал өргөх ёс нь   | 185 |
| Хоосон чанарын мандал өргөх ёс  | 185 |
| Мандалд шүтсэнээр үйл бүтээх ёс нь  | 186 |
| Гэвч хэсэг бусаг үйл нэжгээдийг бүтээх ёс нь  | 186 |

## Тарничидын тангарагийн эдлэлийн тайлбарын гарчиг

### Очир хонхны тийн агуулга

|  |     |
|--|-----|
| Ёгоос гарсан тийн агуулга нь   | 192 |
| Дээр үгүйгээс гарсан тийн агуулга нь                                   | 194 |
| Очир хонхны ялгал нь   | 194 |
| Очир бэлгэдэхүүн утгын очир нь   | 194 |
| Бэлгэдэгч тэмдэгийн очир нь  | 194 |
| Хэмжээ хэлбэр тэргүүтэний бэлгэ чанарын номлол нь                      | 195 |
| Очир дагина, Самвуда тэргүүтэнээс гарсан тийн агуулга нь               | 195 |
| Очирын тийн агуулга нь   | 195 |
| Барьж үйлдэх очирын тийн агуулга нь                                    | 195 |
| Алинаар үйлдэхийн уг нь  | 195 |
| Ямар адил нэгэнд үйлдэхийн хэлбэр нь                                   | 196 |
| Хэр төдийд үйлдэхийн хэмжээ нь   | 197 |
| Чимэг очир нь  | 201 |
| Хонхны тийн агуулга нь   | 202 |
| Уг алинаар үйлдэх нь   | 202 |
| Хэлбэр ямар мэт үйлдэх нь  | 202 |
| Хэмжээний тийн агуулгыг номлох нь                                      | 203 |
| Очир сэтгэлтийн хонх буюу бэлгэ билигийн хонх нь                       | 205 |
| Тэдгээрийн хөрөнгийг зүг алинд байгуулах нь                            | 206 |
| Билгийн эхийн нүүр зүг алинд харах нь                                  | 207 |
| Баатарын хонх нь   | 208 |
| Түүнчлэн ажирсаны хонх нь  | 209 |
| Цагийн хүрднээс номолсон хонхны тийн агуулгыг товч төдий<br>өгүүлэх нь | 211 |
| Даширамд хонх очирыг адистэдлэх ёс нь                                  | 214 |
| Хонх, очирыг адистэдлэн үйлдэх ёс нь                                   | 214 |
| Бэлгэдэхүүн утгын очир, хонх нь  | 216 |
| Очир хонхыг адистэдлэх ёс бодитой нь                                   | 218 |

|                              |     |
|------------------------------|-----|
| Очир барих тарнийн утга нь   | 218 |
| Хонхыг барих тарнийн утга нь | 219 |

### **Дамар ба биеийн чимэгийн тийн агуулга**

|  |     |
|--|-----|
| Биеийн чимэгийн тийн агуулга нь              | 228 |
| Титэм нь                                     | 228 |
| Цэцгэн эрхин нь                              | 228 |
| Манжлага нь                                  | 228 |
| Удвалын цогнойлт нь                          | 229 |
| Эрдэний найман чимэг нь                      | 229 |
| Сондорт бүс нь                               | 229 |
| Титэм нь                                     | 229 |
| Чимэг бусдууд нь                             | 229 |
| Чимэг тэдгээрийн байдалыг ямар мэт үйлдэх нь | 231 |
| Оройн үснэрийн чимэг нь                      | 231 |
| Таван хатсан хохимой титэм нь                | 231 |
| Шанхлан цомцоглосон нь                       | 231 |
| Ясан сугавчлуур нь                           | 231 |
| Шагайвч, бугалгавч, бугуйвч нь               | 232 |
| Таван эрхиныг зөрүүлдүүлэн хавсрах ёс нь     | 232 |
| Хоолойвч нь                                  | 232 |
| Сондорт бүс нь                               | 233 |
| Ээмэг нь                                     | 233 |
| Их үнс нь                                    | 233 |

### **Хадамга болон гавлын тийн агуулга**

|                                      |     |
|--------------------------------------|-----|
| Хадамгааны тийн агуулга нь           | 235 |
| Гавалын тийн агуулга нь              | 236 |
| Хяргахын урд харсан зүгээр шинжих нь | 236 |
| Бүхэлийн тоог шинжих нь              | 237 |
| Өнгөөр шинжих нь                     | 238 |
| Хэлбэрээр шинжих нь                  | 239 |

|   |     |
|---|-----|
| Барьж үйлдэх гавалын хэлбэр нь                            | 239 |
| Шүдээр шинжих нь  | 240 |
| Нүхээр шинжих нь  | 240 |
| <b>Бурханы хумх болон хутгуур, цутгуурын тийн агуулга</b> |     |
| Бурханы хумх буюу бумба нь                                | 242 |
| Цутгуур хутгуурын тийн агуулга нь                         | 244 |



Лувсанчойжийням

# Сангийн тайлбар

Өлзий хутагийн зуун үүдийг нээгч

## **Дээд сангийн тайлбар**

### **Өлзий хутагийн зуун үүдийг нээгч түлхүүр**

Зөөлөн эгшигт бодит Лувсанжалва өөрөө  
Арвис тарнийн ёсыг барьсан Бадмажунай  
Тэр ямагт хилэнтийн тийн цэнгэлт Цогт Дээд морин  
хоолойт  
Элдэв хувилгаан бүжиглэлийг зохиогч түүнд мөргөмүй

Хоёрдугаар бурхан тэр ямагт бээр шашин амьтаны тус амгаланг арвитгах хийгээд егүзэрээр бодийг бүтээхийн мөрийн гишүүнд арга ёс увдис хязгааргүйг номолсноос хувь дордод тодорхой хүссэн бүхнийг амар хялбар бүтээн үйлдэгч сэтгэлчилингийн дээд санг алагчлалгүйгээр хувь төгстөний оройн эрдэнэд таалалын нууц далайн төвөөс гаргамуй.

Ёс үүнийг өнөөдрийн цагт гэргийтнээс дээшдих дээд доод бүхэн бээр гарын авлага үйлддэг боловч мэдэгдэхүүн утгыг мэдэхгүй үг төдийг хадны цуурай адил үйлдсээр байна.

Тийм учраас дээд сангийн далайгаас сайтар гарсан үнэн үгийн рашааны хумхыг сайн хувьтанд би бээр сайтар бичиж өгсүгэй.

Үүнээ сангийн зан үйлийн гарын авлага болон мэдэгдэхүүн утга, зоригдол (бодол)-уудыг сэтгэлд үйлдэх ёс тэргүүтэнг өчүүхэн өгүүлж үйлдэе.

### **Сангийн тийн агуулга үүнд хоёр буй**

1. Сангийн уг гаралыг номлох
2. Сангийн гарын авлага бодьтойг номлох.

**Анхан Сангийн уг гаралыг номлох нь:** Судар, Дандар болон Энэтхэгийн гол номлолуудад сангийн зан үйлийн томьёог бодитой номолсон нь үзэгддэггүй ч утгаар болбол сангийн утгад одох "Нууцын хураангуй язгуур үндэс"-ээс үнэртэнг гурав зүйлд мэдэж үйлдсэнээр хэмээх мэт нь олонтой байдаг.

Ялгажтайд Магада Санмо-гын түүхэнд Санмо бээр бурханыг тахихын тухайд хязгаар орон Вүрамшинпэлд өөрийн давхарлагт байшингийн индэр дээр ариусгалын утаан үүлсийг уугиулж ялж төгс нөгчсөн Нянедод орших үед өмнө тахилын үүлэн цогцос тулалцуулсаны түүхийг судраас номолсон түүнийг ч сангийн уг гаралд таалдаг.

### **Сан нь Төвд болон Монгол оронд ямар мэт дэлгэрсэн ёс нь:**

Ялгуусны эрхэт их тавдугаар бээр .

Цаст уулын цог төгс сала-ийн их дөхөмийн тэнгэр, лус, дэлхийн эздийг баясган үйлдэх ариусгал санг Шаншүн Шэнрав мэйво-гийн дагасан Юүндэн бон бээр сангийн журам талбихийг анхан дэлгэрүүлсэн.

Гүн уужим номын хүрдийг босгохын урьд одуулгын аймаг бурхан бүхэн хурсан Бадма тодпрэн бээр тэнгэр, мангас, найман аймагт тангараг зүүж дээд сан болон өөр өөрийн баясал үүсгэх зохилдонгуй эдээр тахь хэмээсэн .

Хамгийг айлдагч Банчин богд бээр Ловон Бадмажунайн таалалын далай ихэд давалгаалж дээд сан санасаныг арвитгагч индранилийг гарган ялгуусаны тэмдэгийг үзүүрт тахисанаар

хотол чуулсан есөн хүсэлийн хур бууж хувь дордуудыг ариутгамуй хэмээн номлосон мэт анханд Юүндэн бон бээр санг дэлгэрүүлсэн.

Мөн их Ловон Бадмажуннай бээр Самая-д номын хүрд босгохын урьд одуулга ба төвдийн албатуудын хөнөөл доройтолыг амируулах болон тус амгалангийн сайн чуулганг арвитгах арганд сангийн зан үйлийг зохиосон.

Бас Ялгуусаны эрхт бээр түүний тухайд ялгуусаны эрхт Бадмасамба бээр цастанд шашны зулыг бадраах цагт дээд сан үйлсийг тоолошгүй дэлгэрүүлж аюулгүй хайрцагт нууцлан санд нуусан хэмээн номолсон мэт хожмын шавь нарын тусад сан олныг нуусанд өмнө хойдод санг үзүүлэгчид бээр залж үүнд шүтсэнээр бусдын зүгийн багш олоноуд сан болон ариусгал утлагын зан үйл олонтойг зохиосон.

Өөрийн зүгт Богд эцэг хөвгүүний цагт дээд ариусгал сангийн заншлыг зохиогоогүй бөгөөд далай лам Содномжамцын үед хувилгаан Содномишэйванбу бээр дээд ариусгал сан Асар ариун номын бие-д алдаршсан санг зохиосонд өчүүхэн дэлгэрсэн.

Хожим хамгийг айлдагч Банчэн богд бээр дэлгэр, дунд санг зохиосон ба далай лам бээр Өлзийн уйлгалт тэргүүтэн санг зохиосноос уламжлагдан дэлгэрсэн.

Монгол орноо сангийн зан үйл урьд дэлгэрч байсан ч хожим Банчэн богдын зохиосон өлзий хутагийн хурыг буулгагч сан нь ихэд алдаршсан бөгөөд өндөр гэгээн өөрөө дэглэн ая дан зохиосон нь эдүгээ ч уламжлал тасралтгүй дамжсаар ирсэн.

**Хоёрдугаарт. Сангийн гарын авлага бодитойг  
номлоход хоёр буй**

1. Сангийн зан үйлийн гишүүн
2. Сангийн зан үйл бодит

**Анхан. Сангийн зан үйлийн гишүүнд**

Цаг болон орны ялгавар

Сангийн эд (зай) хийгээд тахил, балингийн тийн  
агуулга хоёроос

**Анханд. Цаг болон орны ялгавар нь:** Цаг нь од гариг, өдрийн  
сайн буюу үргэлжийн сан мэтэд цаг магадлаагүй тул үргэлжид  
санг талбисан ч болно.

Орон нь тэнгэр, лус ялгамжтай оршсон газар буюу сүм  
тэргүүтний хажууд, тэр бус ч дээвэргүй ариун газарт сэтгэлд  
зохистой өт хорхой тэргүүтэн шатаагдах гэм үгүй орон ба өөрийн  
байшингийн давхарлаг индэрт санг тавибал сайн болой.

**Хоёрдугаарт. Сангийн эд зай хийгээд тахил балин гурав**

1. Сангийн эд зайн тийн агуулга
2. Тахил, балингийн тийн агуулга
3. Хэрэглэл бусдын тийн агуулга болой

**Анхан. Сангийн эд зайн тийн ялгал нь:**

Сангийн эд нь агь, арц, даль гурвыг номолсон

Үхэлгүй эрдэмт рашаан мод

Үнэр анхилам хүж болон утаан үүлс огторгуйд тулалдснаар

Тэнгэр чөтгөр хүн гурвын будангуй харанхуйг арилгах

Тодорхой гэрэлд очсын гэрэл цацрагийн эрхин долгисон

Ухамсаргүй мунхагийн балар харанхуйг арилгагч

Халуун оч, шатаах эрдэм төгс

Бузар ариун бус, азар бузрыг шатаан үйлдэгч тэр мэтийн эрдэм ялгамж үлэмж гурван мод энэ хэмээн энэ гурвыг шатаасны гал утаагаар олон гэм арилдаг хэмээн номолсон.

Тийм учраас их ариун орон ялгамжтайд ургасан буюу тэр бус ч цэвэр газар ургасан агь, арц, даль гурав нь сангийн эдийн эрхэм учир хэр төдийгөөр хураа.

Тэрийг ч навч цэцэг дэлгэрсэн цагт түүнээ. Хүн, нохойн гишгэлгэ хүрээгүй ба ариун бус язгуураар эс буртагдсан, өт хорхой тэргүүтэн үгүй ариун газраас авах нь чухал.

Бас цагаан, улаан зандан, агар, жамуг, хус мод, хар агар, сухай, хулс тэргүүтэн үнэр анхилам элдэв модны бүрдэл ба Лазра, хорны язгуур, Шингүн тэргүүтэнг үнэр анхилам бусын язгуурыг тэвч.

Сайн зургаа, бойгор, ману, сила, усны матрын хумс, банбой тэргүүтэн элдэв эмийн язгуур, таван зүйл эрдэнэ, элдэв хувцас, элдэв торго, элдэв үрүүд ба мах архи, сонгино, сармис, тэргүүтэн эс холилдсон элдэв идээ.

Гурван цагаан, гурван амттан, гурил тэргүүтэн сангийн зай хэр мэт олдсон нугуудыг тус тус буюу бүгдийг нийлүүлж амарчилбал хамт холиод талхлан үйлдэж болохыг зарлигласан.

Сангийн тавцаны өндөр нь хүн нохой тэргүүтэн бээр үл алхахаар бэлтгэж үргэлжийн мэтэд их бойпор байсан ч болно. Асаах гал нь ч чулуу нүүрсний гал болохгүй аргал, модны цог тэргүүтэн ариун галаар бэлтгэж үйлд.

Өнөөдөр сангийн зан үйл үйлдэх нь ихэд дэлгэрсэнч олонхи нь сангийн зайнуудыг хүчлэн бүтээлгүй ороны ёс лугаа тааруулж мод ургамал алин байгаагаар нь талхлахыг өчүүхэн нэжгээдээр болин үйлдэх нь үзэгддэг ба энэ нь дээд доодын

зочидод баясал үүсгэх болон түүний хүчээр өөрийн алин хүссэн хэрэг бүтэх тэргүүтэний ач тус ямарчлан гарах нь бэрх юм.

### **Хоёрдугаарт. Тахил, балингийн тийн агуулгад**

Ширээ мэтийн индэрийн дээр бүтээлгээ ариуныг дэвсэн түүний дээр Лам, идам, дагинасын ерөнхий балин нь голд их бөөрөнхий цагаан балин, гадуур нь идээ, найман бөөрөнхий ба тэвжү-гээр хүрээл.

Түүний баруунд нэг саванд ариун язгуурт баясагч тэнгэр, лус, дэлхийн эзэдүүдийн их цагаан балинд гадуур жүгү найм, үрэл найм, атгамал наймаар хүрээлсэнд гурван цагаанаар хавсар.

Зүүн зүгт нэг саванд мах цусанд баясагч найман аймагт дэлхийн эздийн балин голд их гурвалжин балины гадуур бага найман гурвалжин, тэвжү лугаа сэлт цусаар түрхэн улаан махаар чимгэл.

Гурван балинг цагаан чимэглэлээр үзэсгэлэнтэй чимж үйлд.тэдгээрийн өмнө хуураагүй гурил түүний баруун зүүнд дээш аяга тосон дусалтын дотор тараг сүү тэргүүтэн цагаан ундаа, мөсөн чихэр, бурам, зөгийн бал тэргүүтний амтат ундаа, үрийн архи, үзэмийн архи тэргүүтэн согтоогч ундаа, алт, окуугаар хавсарсан алтан ундааг (сэржим) хэр олдсноор бас жимс тэргүүтэн идээ ундааны элдэв ялгавар болон хоёр уст чухал эдлэхүй лүгээ сэлтийг бэлтгэ.

### **Гуравдугаарт. Эдлэл бусад нь**

Дэлгэрэнгүйд баясвал элдэв дарцаг дэлдэх хөгжим, олон хиур, туг босгох, хуяг дуулга, мутрын барьц, мэлмийн болгоолт, элдэв горын эд, торгот сум нугуудыг байгуулснаар үлээх дун хөгжим тэргүүтэн чухал хэрэгтэй эдлэл бүгдийг бүрдүүлэх.

Харин үүнийг хураангуйлбал сан, нэг цагаан балин, тахил лугаа сэлт байхад болно. Үргэлжид сан талбих бол тахил балин үгүй ямагт ч болох болно.



## **Хоёрдугаарт. Сангийн зан үйл бодитойд**

Өнөөдөр сан болон санг тавиачид олоууд адистэдлэг хийгээд зориулгын зан үйл тэргүүтэнг үйлдэлгүй санг дангаар уугиулах хийгээд бодлоггүй уншигчин олон байна.

Тиймээс уламжил заншил тийн ариунаар сангийн зан үйлийг анхааран авах ёсонд

Сангийн урьд одуулга

Сангийн бодит суурь

Сангийн сүүлийн зан үйл гурав буй

**Анхан. Сангийн урьд одуулга нь:** Анхан сэтгэлээн засах нь чухал бөгөөд хамаг амьтны тусад туулсан бурханы хутгийг олж үйлдье.

Түүний тухайд сансар нирвааны зочидуудад сангийн тахилыг өргөөд агуу их чуулганыг хурааж үйлдье хэмээх ба хүссэн хэргийн тодорхой бодлого буй бол түүний тухайд хүссэн хэрэг алин энэ мэтийг бүтээж үйлдье.

Үйлдвэр энэ мэтийг эцэст хүргэх болон хүч лүгээ төгсийн тухайд сангийн тахилыг туурвиж үйлдье хэмээхийг гурван удаа тэргүүтэн уншиж үйлд.

**Тэднээс өөрийг бурханд үүсгэхийг хэр мэт бясалгах нь:** Сандуй, Дэмчиг, Жигжид гурван идам тэргүүтэн үлэмжийн тэнгэр аль нэгний егүзэрээр үйлдэхийг номолсон.

Аврал одуулах, бодь сэтгэл үүсгэх, цаглашгүй дөрвөн сэтгэлийг үүсгэхийг урьд одуулснаар үндэсний дөрвөн аймгийн бурхан аль нэгний егүзэр дэлгэр буюу агшинаар босох мэтээр өөрийг бурханд үүсгэ.

## **Сан тахил тэргүүтэнд адистэдлэгэ**

### **үйлдэх ёсонд**

Хуучин уламжлалд цэвэрлэх, арвитгах, урвуулах олж үйлдэх, цэнгүүлэн үйлдэх, эрхэнд үйлдэх, зургаан бурханы зүрхнээс гэрэл цацрагаар цэвэрлэх тэргүүтний зоригдол (бодол) үйлдэх ёсыг номолсончилэн хүсвэл дэлгэрэнгүйг бусдаас мэдэж үйлд.

## **Үүнээ ерөнхий одуулах ёсны адистэдлэгэ**

### **үйлдэх ёсонд**

Тахил балин сангуудыг тус тусад адистэдлэх нь сайн боловч орохуй хялбарын тухайд зүг нэгэнд адистэдлэгэ үйлдэх ёс нь

**Амрида**-гаар ариусган

**Сувава**-гаар хоосонд цэвэрлэж хоосоны агаараас тахил балинууд

**Ум**-аас эрдэнийн саванд

**Аа**-гаас гавалан саванд гурван ертөнцийн эн мэт уужим агуу их нугуудын дотор өөр өөрийн нэрийн үсэг анхан дусалаар чимсэн хайлсанаас гарсан тахил балинууд мөн чанар амгаланы хоосоны бэлгэ билиг бөгөөд байдал нь рашааны чанарт балин идээ, хүнс, ундаа, будаа нугуудын ялгавар элдэв өнгө үнэр амт чанар хотол чуулсан лугаа төгс хоёр уст чухал эдлэгч хөгжим, хүсэгдэхүүн таван тахил, долоон эрдэнэ, өлзийт найман эд тэргүүтэн дээд доодын зочид амирлангуй хилэнт алинд алин зохистой тахилын ялгавар уужим бөгөөд алагчаалалгүй, хязгааргүй ертөнцийн орон бүхэнд дэлгэрэн дүүрч орон цаг ахуй үес бүгдэд барагдашгүй гарах ба сангийн эдийн утаа лугаа сэлт ч хүсэгдэхүүн таван тахилын төгс эдэлж алин хүссэн ургасан,

бузар ариун бус тэргүүтний гэм арилан цувиралтгүй амгаланг үүсгэхийн чадал төгс болсонд бод.

Нэрийн үсэг анхан дусалаар чимсэнээс үүсэх нь нэрийн үсэг анханаар ном (хамаг юмс) бүгд нэрээр нэрийдсэн төдийгөөс бусад өөрийн талаас эс бүтсэн хоосон чанартай ба дусалаар их амгаланг бэлгэдсэнээр тэр хоёр чуулсанаас тахилын эд тэргүүтэнг үүсэх нь тэдгээр бүгд амгалан хоосоны тийн цэнгэл ямагтад мэдүүлэхийн тухайд тул аньс ихтэй.

Сангийн уламжлалд Утаан охин тэнгэр хөхөлбөр баруунаар рашааны хумх барьсан зүүн гараар эмийн тэвш барьсан. Хумхнаас рашааны үргэлжлэл буусанаар заяаны таван тэнгэр тэргүүтэнд угаал үйлдснээр ариун бус бүгдийг угаах ба эмийн тэвшнээс эм мэлмэрэн гарч лусын нян, газрын эзэний дэмийрэл бүгдийг ариусгаснаар бурханыг даган дурдаад өөрийн мянган нөхөр болсонд бод хэмээн зарлигласан.

**Адистэдлэгэ бодитой нь:** Гурван үр болон огторгуйн сангийн тарни, мутарлаг лугаа сэлтээр гурван удаа адистэдлэх ба дэлгэрэнгүйгээр адистэдлэх болбол зургаан тарни, зургаан мутарлага, зургаан самади дияанаар адистэдлэж үйлдэх болой.

Гурван үр /ум, аа, хум/-ын зоригдол нь тахил балин сангийн эдүүдийн дээр цагаан ум, улаан аа, хөх хум гурав давхарлагдан оршсоноос өөрсдийн гэрэл цацраг цацарч ертөнцийн орны рашааны шим бүгд хурч ялгуусны хөвгүүн сэлтийн адистэд бүгд ч цагаан, улаан, хөх, рашааны байдалтай залснаар гурван үр үсэгт шингээн тэр гурав зэргэмжээр тахил балин сангийн эдүүдэд шингэснээр

**Ум**-аар өнгө үнэр, амт чадалын гэмийг цэвэрлэн

**Аа**-гаар рашаан болгоод

**Хум**-аар барагдашгүй өвөрчилинд арвидсанд

**Ум** болон **хум** хоёрын үйлдлийг урвуудан номолсон буй тул алинаар үйлдсэн ч болно.

### **Огторгуй сангийн тарнийн утга нь**

**Ум** нь мөргөл ба елзий тэргүүтэн олон утгад ордог

**Сарва вид** нь бүхнийг ухагч

**Бүра бүра** нь дүүргэх буюу төгсгөн үйлдэхтүн буюу болтугай мөн цэнгэх болтугай

**Сүра сүра** нь түгээх буюу үзэсгэлэнтэй болтугай

**Авардая** хоёр нь бүхнээр арвитгах буюу бүхэнд арвитгах, бүхэнд орох буюу бүхэнд орох болтугай хоёр

**Хо** нь Ай хэмээх дуудлага

**Вазра парана хам** нь очир огторгуй цацрах хэмээх болой.

Тарнийн хэсэг энэ гурав өгөгдөхүүн орон, өглөгийн орон түүний үйл гурвын эрхэнд үйлдэх ба хэрэгтэй дүрс огторгуйн сангийн даяаны барилдлага бодит гурав буюу бас түүний үйлдлийн эрхэнд үйлдснээр номлож үйлдэх олонтой буй ч энэ төдийгээс эс цацраав.

**Зургаан тарни, зургаан мутарлага,  
зургаан дияан нь**

Зургаан тарни ба зургаан мутарлагт адилгүй зүйл үзэгддэгээс “Гурван хувьтын зан үйл”-ээс гарсан нь өнөөдөр алдаршил ихтэй бөгөөд ялгуусаны эрхэтийн дээд санд ч байгуулан зохиосон буй тул түүний эрхэнд үйлдвээс зургуул нэжгээд нэжгээдэд ч тарни болон мутарлаг дияан гурав гурав бүрдэх хэрэгтэй болой.

**Анхан. Номын чанарын асар ариун  
тарниар дэлгэр цэвэрлэхэд**

**Тарни нь Ум сувава** тэргүүтэн болой

**Тарнийн утга нь**

**Сувава** нь өвөрчилин

**Ви шүддэ ви** нь тийн ариун

**Шүддэ** нь ариун

**Дарма дэ** нь номын чанар

**Вазра сидди** нь Очирын шид бөгөөд өвөрчилингээр тийн ариун номын чанарын очирын шид хэмээгдэх болой.

Эхний **Ум** нь тарнийн толгойг удирдах ба сүүлийн **хум** нь таалалын хөрөнгө бөгөөд адистэдлэн үйлдэнэ.

**Мутарлага** нь барууны эрхийгээр чигчийг даран үлдсэн гурван хурууг тус тусад босгох

**Дияан** нь эдлэл ариун бусыг цэвэрлээд гэм лүгээ хагацсанд бод.

**Хоёрдугаарт: Огторгуйн сангийн дэлгэр арвидахад**

**Тарни нь Нама сарва тэргүүтэн болой**

**Тарнийн утга нь**

**Намасарва дата гадэ жо нь мөргөмүй түүнчилэн  
ажирсан бүгдэд**

**Вишу нь элдэв**

**Мүшэ хэ вая нь үүднээс**

**Сарва дад нь байдал бүгдэд**

**Хам нь огторгуй**

**Удгадэ нь үлэмж**

**Парана нь одох буюу түгэх**

**Хи мам нь энэ**

**Гага нь огторгуй**

**Хам нь төвд**

**Суха нь суурь зохилдох буюу сайтар өгөх хэмээгдэх  
болой.**

**Мутарлаг нь алгаа дэлгэхийн ёсонд үйлдэж магнайд агуулах.**

**Дияан нь Зочид тус тусын бишрэл лүгээ зохиолдсон эдлэлээр  
огторгуй түгсэнд бодох.**

## **Гуравдугаарт. Рашааны уйлгалтын тарниар дэлгэр**

### **урвуулахад**

**Тарни нь Ум амридэ хум пад хэмээгдэх**

**Тарнийн утга нь Амридэ-гийн мрида нь үхэл**

**А нь 'хаах үг мөнөөр харалдаа урвуулж үйлдэх нь үхэлгүй болох мөн ч утгачилбал рашаанд урвуулах.**

**Хум пад нь үүнийг дурдигтах бөгөөд тодорүүлэн үйлдэх болой.**

**Мутарлага нь гарын хуруунуудыг зөөлрүүлээд хоёр долооворын үзүүрийг нийлүүлж босгоод магнайд хүл.**

**Дияан нь Зочид тус тусын цэнгэгч рашаан болсонд бод**

**Дөрөвдүгээрт. Хүссэн хэрэг гарах тарни дэлгэрээр  
тус тусын хүсэлийг бүтээн үйлдэхэд**

**Тарни нь Ум агаро тэргүүтэн болой**

**Тарнийн утга нь**

**Агаро нь а хэмээгдэх болой**

**Мүхэм нь үүд болой**

**Сарва дарма нам нь ном бүгдийн**

**Адя нүдба нан дада нь эс төрсний тухайд хэмээгдэх  
бөгөөд**

**А хэмээгдэх нь эс төрсөн тул ном бүгдийн үүд болой  
хэмээх болой.**

**Мутарлага нь Зүүнээ очир нудрагыг зүрхэндээ агуулж баруунаа  
дээдийг өгөгчийн мутарлага үйлдэх**

**Дияан нь Зочид тус тусын хэрэг бүтсэнд бодох.**



**Тавдугаарт. Агуу их хүч төгс тарни дэлгэрээр**

**зочин тус тусууд олж үйлдэхүйд**

**Тарни нь Нама сарва тэргүүтэн болой**

**Тарнийн утга нь**

**Нама сарва дата гада нь мөргөмүй түүнчилин ажирсан**

**Авалогидэ нь бүхэнээр болгоогч**

**Самвхора самвхора нь үнэхээр дэлгэр буюу бүхнээр үнэхээр дэлгэрэх хоёр болой.**

**Мутарлага нь баруунаа хилэнтийн нудрага хүлж босгосноор эдэд талбин инчдэх талби.**

**Дияан нь Үлэмж тоосны тоо лугаа сацуу баясан амьтад ялах ялагдах тэмцэлгүй тус тусын бодлоор олсонд бодох.**

**Зургаадугаарт. Эрхшээн урвуулагч хүрдний дэлгэр тарни  
эрхэнд үйлдэхэд**

**Тарни нь Ум рүү тэргүүтэн болой**

**Тарнийн утга нь рүү нь байгуулах тарни**

**Пүү нь тодруулан үйлдэх**

**Зула нь сүр хүчийг бадруулах**

**Дишта нь орших**

**Сидди лозани нь төрвөлгүй бүтэх мэлмий  
хэмээн номолсон ч төлвөлгүйн утга бодитойд  
тодорхойгүй**

**Сарва арта нь хэрэг бүхэн**

**Сада нь хэмээн бүтэх**

**Суха нь суурь хатгах хэмээх болой**

**Мутарлага нь Баруун гараар аюулгүйн мутарлага үйлдэх**

**Дияан нь бүх зочид тангарагийн эрхээр бидэнд тус амгалангийн  
үйлсийг бүтээхэд зөвшөөрсөнд бодох.**

**Тэднээс үнэний хүчийг өгүүлэх нь**

**Миний үлэмж санааны хүч**

**Түүнчилин ажирсан бурханы адистэдийн хүч**

**Номын чанар шүтэн барилдлагын хүч лүгээ тэр нэжгээд  
нэжгээдээр ч элдэвийг хувилган чадах атал гурвуулангийн**

**Хүч чуулбал эс бүтэх зүйл алин ч үгүй.**

## Хоёрдугаарт. Сангийн бодит суурьт

1. Зочидыг залах
2. Тахил өргөх
3. Гэмийг наминчилах
4. Үйлсээ даатгах дөрөв буй

### Анхдугаарт. Зочидыг залахад

1. Алинаас залах орон
2. Алин залагдах зочин
3. Ямар мэт залах ёс гурав буй

**Анхан. Алинаас залах орон нь:** Бурхад өөр өөрийн сэтгэл үүсгэж ерөөлийн хүчээр бүтсэн ялгамжит орон Цаглашгүй гэрэлт (Авид) бурханы орон Диваажин, Үл хямралдагч (Минтүг) бурханы орон Илт баясгалант.

**Баатар дагинасын орон нь:** үхээрийн найман орон, хорин дөрвөн орон, гучин хоёр орон мэт хийгээд сахиус орших орон Гонбо Махагал бурханы сэрүүн цэцэрлэгийн үхээрийн орон, Лхам бурханы зүүн хойд зүгийн Мүлү дингийн далай мэт ба түүнчилэн орон, тэнгэр, дэлхийн эзэд тэргүүтэнд ч уул, хад, нуур, далай ийм нэрт хэмээгдэх мэт бодол тодорхойгоор олонтой гаравч үүнээ ерөнхийлсэний эрхэнд үйлдээд дээд доодын зочид бүгдийг амгалан хоосоны төвөөс зална.

Тэр ч Өвөрчилэн хоосны агаараас тахилын орон, тахилийн эд хэр зохистой байдлыг тодорхой талбихыг үндэсний аймаг доодуудад байдаг ч үүнд нь дээр үгүй егүзэрийн дээд мөрийн амь орон хоосон чанар ба оронтон их амгалангийн бэлгэ билиг хоёр усанд ус хийсэн мэт мөн чанар ялгалгүй одсон тэр ямагтаар сансар нирваан бат хэлбэрт сав шим бүгдийг тамгалаад зочидыг залах хийгээд тахил өргөх бүгдийг амгалан

хоосны бэлгэ билигийн тийн цэнгэл ямагтад харж үйлдэх хэрэгтэй бөгөөд сахиусын балингийн зан үйлүүдэд

Ая зөндөөн бүтсэн их амгалангийн ордоноос хэмээх тэргүүтэн ба

Алин ургасан амгалан хоосны дээд цэнгэлээс хэмээх тэргүүтэн номолсон нь машид олон байдаг.

Тийм учраас үес үүнд ч амгалан хоосон ялгалгүйн бэлгэ билигийн мэдлэг дээшидхээр үндсэнд үүсгэн үйлдээд түүнд зочидыг алинаас залах орон болон бэлгэ билиг түүний тийн цэнгэл дээд доодын зочидуудын байдалд санаад алин залагдах зочидын томьёо найруулах ба түүнчлэн сүүлд тахил өргөх үесд ч тахилыг гурван нөхөр түүний тийн цэнгэлд харж үйлдэх хэрэгтэй.

Тэр мэт мэдсэнээр сан тавих аваас даруйдын харш нөхцөл арилах төдийгээр үл барам мөрийг бясалгахын дэгжлэгт ч одох тул хэрэг машид их болоод үнэнд баримтлахын тийн атгагийн мунхаг сэтгэл ёзоороос ариусаад бурханы хутгийг олох болно.

### **Хоёрдугаарт. Алин залагдах зочид нь**

Дээд доод зочидыг нэг ч хоцроолгүй бүгдийг тус бүрээр нь тоолбол барагдашгүй учир ерөнхийлэх төдийн үүднээс ялгавал

Чухаг дээд хүндлэлийн зочид

Итгэл эрдмийн зочид

Зургаан язгуур нигүүлсэхүйн зочид

Ад тотгор ер төлөөсний зочид лүгээ дөрвөн хэсэгт зочид бүгд хурах бөгөөд

Тэдгээрээс алин гололсныг ялгах нь

**Хүндлэлийн зочидын эрхэм нь:** Багш мөн тул өөрт авшиг өгсөн, үндэсийг номолсон, увдис соёрхосон гурван зарлигийн ачлал төгс лам багш бээр голлосон адаглаад нэг шүлэгнээс дээшихэд ном сонссон номын барилдлага бодитой буй үндэсний лам багш нар.

Ангид тонилгогч, бодь сэтгэл, нууц тарнийн сахилын үндэслэл хийгээд

Судар тарнийн гол номлолыг номолсон Авшиг, даган соёрхол, увидсын үндэслэл лүгээ сэлтийн үндэслэлийн багш нар.

Шашинд ачлал ихтэй хутагтын оронд замба тивийн зургаан чимэг, хоёр манлай тэргүүтэн бандида нар.

Индра бүда, Сараха,Лү, Наг, Дил гурав, Лалида, Бал чэн тэргүүтэн шидтэн нар.

Төвдөд Шашинд ачлал ихтэй Ловон Бадмажунай, Ханчэн шивоца, Гамала шила тэргүүтэн Га, Жог, Шон гурав Их хэлмэрч Ринчэн санбо, Рало Дорж дагва, Нянло тэргүүтэн урьд хожид заларсан хэлмэрчид,

Чойжалмэйбон, Түмсамвода, Лхалам ишэйод тэргүүтэн хаан түшмэл Бодьсадва нар.

Бүтээлийн эрхэт Марво лозова Богд Милайрайба, Ханьцашгүй Гамбоба, Пагмодүв тэргүүтэн ба Хайдүв чүнба могож тэргүүтэн Гаржүдба урсгалын лам багш нар.

Падамба Санжа, Мажигловдон, Таннон Самдүв тэргүүтэн Шижидба болон Зодын урсгалын үндэслэлийн лам багш нар.

Сачэн Гунгаа нинбо, Ловон Содномзэмо, Жавзүн жанцан, Сажа бандид Даган Пагва тэргүүтэн ламврай урсгалын үндэслэл буюу сажын үндэслэлийн лам багш нар.

Ханьцашгүй Их Жово, Вромдонба, Гүчэдсүм, Налжор шалши тэргүүтэн Гаадамба урсгалын лам багш нар.

Хоёрдугаар ялгуусан их Зонхава хөвгүүдийн хоёр ууган тэргүүтэн Гэдан урсгалын үндэслэлийн ерөнхий лам багш нар. Ялгамжгайд нууцын тарнийн үндэслэлийг баригч Богд Шийравсэнгэ, эцэг хөвгүүн бүтээлийн үндэслэлийн үндэсийг баригч Догдон Жамбал Жамц эцэг хөвгүүн.

Гол номлолын үндэсийг баригч Жамьян Цорж Гэндүн дүва эцэг хөвгүүн тэргүүтэн ба үйлс нь огторгуй лугаа сацуу Банчин богд далай ламын үе төрөлүүд.

Монгол оронд ачлал ихтэй шашины гурван зул

Өндөр гэгээн Занабазар

Зая бандид Лувсан Прэнлэй

Ламын гэгээн Лувсанданзанжанцан тэргүүтэн хутагт хувилгаад нар эдгээр нь адистэд үндэсний багш нараас тойм хураангуй төдий юм.

## **Шид гарах орон Идамууд үндэсний дөрвөн аймаг хурсанаас**

Сандуй, Дэмчиг, Жигжид гурав

Дүйнхор, Жэдор, Хорчэн тэргүүтэн дээр үгүй  
егүзэрийн идамууд

Гүнрэг, Балчог, Зэмо, Дорен тэргүүтэн егүзэрийн үндэс

Намнон онжан, Чагдорвангүр тэргүүтэн явдлын үндэс

Түва дамцагсүмгод, Минтүг, Цагаан шүхэрт, Цэвэгмэд  
тэргүүтэн үйлийн үндэсний бурхадын чуулганууд  
болой

Нарийвчлан үзэхийг сонирховол гол номнуудаас мэдэж  
үйлд.

Хоёр тусын эцэст хүрч туулсан бурхадууд нь төгс жаргалантын  
болон хувилгаан лагшинт хоёрт хураад ялгуусан таван язгуур  
тэргүүтэн төгс жаргалантын лагшинт бурхад

Шашины эзэн бурхан багш тэргүүтэн сайн цагийн мянган бурхан  
Цөвийн цагийн итгэл түүнчлэн ажирсан долоон ах дүү

Алдрыг өгүүлсэн төдийгээр муу галбын хилэнц түйтгэрийг  
ариусгах гучин таван бурхан Ялгуусан Минтүг, Авид тэргүүтэн  
хувилгаан лагшинт бурхадууд

Бусдад туслан зохиогч ялгуусны хөвгүүн Бодьсадва нь  
бурхадын зохиолын үүргийг үүрсэн Майдар, Манзүшри тэргүүтэн  
шадар найман хөвгүүн

Бас бус Ишэй лам, Оджийдог, Монламлодой, ванбошива,  
Жавдо тэргүүтэнг судрын аймгаас сайшаан өгүүлэхийг агуу их  
номолсон.

### **Сансарт шуналыг буцаасан ширваан барадигабуд нь:**

Арван хоёр их барадигабуд найман ширваан.

Бурханы шашиныг сахьсан арван зургаан архад тэргүүтэн болой.

Үүнээс дээших нь чухаг дээд хүндлэлийн зочдын аймаг болой.

Баатар дагина буюу огторгуйгаар одогч охин тэнгэр хэмээгдэх нь судрын ёсонд үгүй бөгөөд нууц тарнийн үед ч үндэсний аймаг доодуудад томьёо бодитой найруулаагүй учир энэ нь дээр үгүй егүзэрийн ёс хийгээд түүнээс Дэмчог (Дээд амгалант) тэргүүтэн эх дандарын аймгуудад агуу их гарсан түүнийг ч бэлгэ билиг хийгээд ертөнц болон бэлгэ билигтэд ч онол өндөр номын үүднээс Шинжэ, Агжэ, Лханжэ-ийн элдэв язгуур буйгаар үл барам Хэрүга цогт их баатар хэмээсэн Цогт төгс Очир дагина хэмээх тэргүүтэн хот мандалын эрхэмд ч баатар ба дагинын томьёо номолсон тул тийн ялгалыг нарийвчилэн мэдэхийг хүсвэл Дэмчог, Жэ доржийн үндэсний тайлбар увидсыг сонсож үйлд.

Үүнд бэлгэдэлийн суурь төдий ангилбал

Үхээрийн найман орон, гучин хоёр орон, хорин дөрвөн орон тэргүүтэнд оршсон баатар дагина, үүсгэл төгсгөлийн онол илт болсонууд бөгөөд баатар тодба дүмбү ба Дагина машид дарах тэргүүтэн мэт болой.

Саад бүхнийг арилгагч номын сахиусанд бэлгэ билиг хийгээд ертөнцтөнд хоёр ба тэр тус тусад ч эцэг үндэс, эх үндэсийн ялгал хоёрт ялгадаг. Ертөнцтөнд ч мөн чанар бэлгэ билигт мөн ч байдал нь ертөнцийн догшин ёсыг барьсан ертөнцтөн өөрийн үндэст хэр зохистой нэг байгаагаас.



**Бэлгэ билигт сахиус нь:** Жанрайсигийн хилэнт түргэн зохиогч зургаан мутарт Гомбо. Хүрдэн Дэмчог дөрвөн эх лугаа сэлтийн мөн чанар цогт итгэл шалши эцэг эх тав, дөрвөн мутарт махагал буюу Жараг бэлгэт эр эм, баатар эр эм Дүртод дагбо. Жидорын мөн чанар Гүр гүнбо тэргүүтэн эр үндэс.

Янжинлхам хилэнтийн байдлыг үзүүлсэн Балдан магсорма, Дүдсолма, Намхай гойжанма, Одчэн варма тэргүүтэн эм үндэсний сахиусууд ба бас Үйлийн эрлэг, Намсрай, Бэгз тэргүүтэн нь бэлгэ билигт сахиус болой.

**Ертөнцийн сахиус нь** Мөн чанар нь таван язгуурын бурхан ертөнцийн байдлыг үзүүлсэн Чойжил Гүн а. Намнон бурхан ертөнцийн ёсыг барьсан Дамжин дорлиг мэт ба Ойжалбо, Чүжүджалбо, Пүхонжалбо, Бринрин жалбо, Зангод варлавүн долоо мэт дээд төрөлхтөн тангараг агуулж шашины сахиус болоход ам авсан хилэнт өөрийн үндэст ч хязгааргүй буй.

Олгаа Зэдүнбадмашадбидоржийн зохиосон “Тангарагтны далайн түүх”-д төвд орны хүн бус их хүчит бурхан бодьсадын хувилгаан ба тэдгээр ихэнхдээ дотроо нааш цааш мөн чанар нэгт ёсыг агуу номолсон байдаг. Сансар нирваан мөн чанар нэгд одсон их арвис шинжлээчидүүдийн оюунд багтахуй бэрх үзэгддэг.

Гэвч тэдгээрийг лам багш Идам бурханы мөн чанарт бясалагсанаар тахил балин өргөх тэргүүтэн болохгүй нь бус тарнийн егүзэрва бээр алин үзэгдлийг бурханы тийн цэнгэлд үзэх хэрэгтэйд номолсон.

### **Ариун язгуурт Цогт далан таван итгэл**

Ариун язгуурт цогт далан таван итгэл энэ нь үндэсний аймагт ихэд дэлгэрсэн байдаг бөгөөд түүнд ч ертөнцөөс нөгчсөн ба ертөнцөөс эс нөгчсөний хоёр хувь ба цагаан зүгийн тэнгэр ба хар зүгийн сахиусан тэнгэр хоёр буй. Үлгэрлэвээс сахиусан тэнгэртэд урьд одуулгын балинг талбих орон ертөнцтөн мөн ч цагаан зүгийн сахиусан тэнгэр бөгөөд гадас талбих ёсны сахиусан тэнгэр нь хар зүгийн ертөнцтөн ба хот мандалын үхээрийн оронд буй эрхэм нь бэлгэ билигийн үзэгдэхүй хувь мөн юм.

Дөрвөн махранзд ч Судар заримд үргэлжид оршсон хэмээх ба заримд бодьсадад номолдог ба үндэсний аймаг заримуудад хот мандалын бурханд байгуулалт хэр зохистой мэт байдаг.

Далан таван Цогт итгэл хэмээн бүхэнд салхи мэт алдаршсан ч тус тусыг танин барих хийгээд илт олон тэргүүтэн мэдэхүй ховор үзэгддэг учир үүнээ өчүүхэн номолвол тэдгээрийг Ансон жон жүдийн арван хоёр хот мандалын ертөнцтөний зургаан хот мандалын нөхрийн эрхэмүүд мөн учир үндэс энэ болон түүний тайлбаруудад шүтсэнээр мэдэх хэрэгтэй. Тэр ч Гүнрэгийн бүтээлийн арга Мридагын орчуулснаар гадаад хүрээнээ орших аюулгагч тэнгэр, лус,гариг, од, зүгийг сахигч, махранз – дор мөргөмүй ертөнцтөн бүхнийг магтаж үйлдье хэмээн номолсон мэт

### **Ариун язгуурт далан таван цогт итгэл нь**

1. Зүгийг тэтгэгч арав
2. Их тэнгэр найм
3. Их лус найм
4. Их гариг найм
5. Махранз дөрөв
6. Хорин дөрвөн од
7. Есөн аюулгагч

### **Анхдугаарх. Арван зүгийг тэтгэгч нь:**

1. Хурмаст гүргэмийн өнгөтэй баруунаа очир зүүнээ ташаанд агуулсан зургаан соёотой зааны дээр цэнгэсэний байдлаар оршсон, эхнэр Шази хийгээд Үваси хоёр лугаа сэлт олон нөхөрөөр хүрээлсэн.
2. Хөх Эрлэг махэ-ийн дээр баруунаа бэрээ зүүнээ ташаанд агуулсан эхнэр Нагмо болон Чивдагмо хоёр лугаа сэлттэй.
3. Усны тэнгэр цайвар улаан өнгөтэй могойн цогнойлтот, улаан матран суудалд оршсон цалам эрдэнэ барьсан, эхнэр болон олон нөхрөөр хүрээлсэн.
4. Ягчисын хаан шар өнгөтэй, цагаан морь хөлөглөсөн эрдэнийн түрүү, хулгана барьсан эхнэр хийгээд олон нөхрөөр хүрээлсэн.
5. Галын тэнгэр улаан өнгөтэй, улаан сэрх хөлөглөсөн, зуу насалсаны хэмжээт бумба, бэрээ барьсан эхнэр болон олон нөхдөөр хүрээлүүлсэн.
6. Мангас улаан хар өнгөтэй бэрд унасан баруунаа илд болон зүүнээ ташаандаа агуулсан эхнэр болон олон нөхдөөр хүрээлүүлсэн.

7. Хийн тэнгэр огторгуйн өнгөтэй буга унасан баруунаа хиур босгож, зүүнээ дуаз барьсан эхнэр нөхөр лүгээ олноор хүрээлүүлсэн.
8. Бүднэрийн эзэн үнсэн өнгөт гарьд хөлөглөсөн баруун хоёртоо сэрээ ба амра, зүүн хоёртоо бумба болон рагча эрхи барьсан эхнэр болон нөхрөөр хүрээлүүлсэн.
9. Газрын охин тэнгэр шар өнгөт лянхуад оршсон, лянхуа барьсанаар сөгдөх ёсыг үйлдсэн олон нөхрөөр хүрээлүүлсэн.
10. Тэдгээрийн дээр Асур улбар хар хуяг өмссөн илд барьсан.цагаан лус могойн цогнойлтод эрдэнийн сав барьсан тэр гурвыг зүгийг тэтгэгч аравт үйлдэх үед доод зүгийг тэтгэгчийн аймагт нэгд тооцдог.

Дурва-н дээр дээд зүгийг тэтгэгч Эсарва алтан өнгөт баруун хоёроор боть, эрхи барьсан зүүн хоёроор дээдийг өгөгч болон жилүг барьсан. Долоон морь хөлөглөсөн тэрэгэнд Наран улаан өнгөт баруунаа очир зүүнээ лянхуан дээр нарны мандалыг барьсан.

Галуун дээр Сар цагаан өнгөт хоёр гартаа лянханд оршсон саран мандал барьсан энэ гурвыг нэгд тооцдог.

## **Хоёр. Найман их тэнгэр нь**

Хар Махешвари сэрээ барьсан

Хурмаст цагаан шаргал өнгөт очир барьсан

Эсэрва шар өнгөт эрдэнэ барьсан

Виншү хар өнгөт хүрд барьсан

Амрагийн эрхэт улаан өнгөт нум сум барьсан

Чуулганы эзэн цагаан өнгөт зааны нүүрт сүх барьсан

Врингирэди ясан өнгөт эрдэнийн хайрцаг барьсан

Залуу зургаан хоншоорт улаан нялхасын өнгөт зургаан

нүүртэй Гашади буюу тонгорог барьсан.

Наймуул бүгд зүүнээр өөр адилаан эхнэртэй эвцэлдсэн эдгээрт суудал номлоогүй.

### **Гурав. Найман их лус нь**

1. Хязгааргүй улаан өнгөт
2. Эд дэлгэрч шар өнгөт
3. Агуулагч улаан өнгөт
4. Лянхуат цагаан өнгөт
5. Хүчээр гүйгч цагаан өнгөт
6. Их лянхуа хар өнгөт
7. Лавай тэтгэгч шар өнгөт
8. Ухаан төгс улаан өнгөт

Наймуул бүгд долоон могойн цогнойлт төгс нөхөр лугаа сэлт хоёр гарын алгаа хавсарсан буй.

### **Дөрөв. Найман их гариг нь**

Долоон морь хөлөглөсөн тэрэг унасан улаан Нар лянхуад  
оршсон нарны мандалыг хоёр гараар барьсан  
Галуу унасан Сар цагаан өнгөт лянхуанд оршсон саран  
мандалыг барьсан  
Ямаа унасан улаан Нүдэн улаан өнгөт баруунаа усны хутга  
барьсан зүүнээ хүний идсэн толгой  
Лянхан суудалд суусан Лхагва шар өнгөт нум сум барьсан  
Лянхуан суудалд Пүрэв цагаан өнгөт бумба барьсан  
Хумхан суудалд Баасан цагаан өнгөт эрхи болон бумба  
барьсан  
Яст мэлхийн суудалд Бямба хар өнгөт бэрээ барьсан  
Рах хар өнгөт нар сар барьсан үүнд суудал номлоогүй.

### **Тав. Ерөнцийг тэтгэгч дөрвөн махранз нь**

1. Орны нөхрийг тэтгэгч нь ногоон өнгөтэй бивам босгосон  
нөхөр гандрис олон лугаа сэлттэй

2. Үлэмж төрөлт нь хөх өнгөтэй илд барьсан
3. Сайн бус нүдэт нь улаан шаргал очир цалам барьсан долоон могойн цогнойлтод улаан нүдтэй товгор
4. Тийн сонсогчийн хөвгүүн алтан өнгөтэй бэрээ хулгана барьсан бүдүүн бөгөөд арслан суудалд оршсон өөр өөрийн олон нөхөдөөр хүрээлүүлсэн.

Жоджудаас гарсан илт онол энэ адил мөн учир тэдгээрийг бясалгах утганд сэтгэл итгэмжлэх орон мөн ч одоо сүм хийдүүдийн үүдэн хананд зурж үйлдэхэд өчүүхэн адилгүй байгаа нь тэдгээр өөр өөрийн дүрийг бэлгэдэн үйлдэхийн тухайд зурсан үзэгддэг.

Тэр нь ч Орны нөхрийг сахигчид хурц хор буй тул үүгээр бусдыг хорлохоос сэжигдэн чихний харалдаа цэцгийн баглаагаар хааж өөрөө бивам босгосон байдаг. Эхнэр нь линбэний дуугаар ч бусдын дууг сэрэхүйд оруулдаггүй.

Үлэмж төрөлтөд хурц хор буй тул бусдын хүрэлцэхүйг сахихын тухайд илд босгож барьсан байдаг.

Сайн бус нүдэт нь нүдээр үзэхэд хор буй учир гарт дахь суврагаа харсан.

Тийн сонсогчийн хөвгүүнд амны хорт уур буй тул нүүрээ буулган жимийсэн байдаг. Та нар оюун хэрцгийгээр шашин болон хуврагат хорлол үйлдвэл надад ч хор буй хэмээхийг бэлгэдсэн байдал мэтээр зурах хэрэгтэй хэмээн зарим дээдсүүд зарлигласан.

Үүнийг заримууд нүд сайн бус хэмээдэг нь алдаат бөгөөд сайн бус нүд гэдэг нь хэрцгийн утга мөн хэмээдэг боловч нүдний хор буй тул нүд сайн бус хэмээн өгүүлэвч гэм үгүйгээр үл барам энэтхэгт вирү вагша хэмээхийг муу нүдэт хэмээх шалтгаан байдаг тул сайн бус мэлмий нь сайтар илт болой.

### Хорин найман од нь

1. Тагар цагаан өнгөтэй эмэгтэй дүрстэй цээживч нь хөдлөхүй мэлмэлзсэн хоёр гарын алгаа хавсарсан тэр мэт бүгд хувцас цээживч мэлмэлзсэн эмэгтэй дүртэй гарын алгаа хавсарсан адил бөгөөд харин өнгө өөр байдаг.
2. Вранэ ногоон
3. Миндүг ногоон шар
4. Нарма улаан цайвар
5. Го хар
6. Навсо цагаан
7. Жал ногоон
8. Гаг цагаан
9. Чү улаан
10. Прэнва шар
11. Дэ ногоон шаргал
12. Бо ногоон
13. Мэши цагаан
14. Нагва ногоон
15. Сари цагаан
16. Сага хар
17. Лхацам ногоон
18. Нрон цагаан
19. Нрүв цагаан
20. Чүдод хар
21. Чүмад улаан цайвар
22. Дошин улаан цайвар
23. Жишин ногоон



24. Монду хар
25. Моду хар
26. Түмдод ногоон
27. Түммад шар
28. Намду шар цайвар

Бүгд өнгөнөөс бусад нь тагар од лугаа адил.

### **Долоо. Есөн аюулгагч нь**

1. Аюулгагч Их эзэн нь биеийн өнгө хар гурван нүдтэй, соёо ярзайсан, аймшигт хэрэглэл элдэв лүгээ төгс гартаа хадагаа барьсан, Үма лугаа сэлттэй.
2. Аюулгагч Бра мида цагаан өнгөт бадрангуй эрдэнэ барьсан, эхнэр Эсэрва эх лүгээ сэлттэй эвцэлдсэн.
3. Аюулгагч Вэрава хар хөх өнгөтэй гурван үзүүрт очир барьсан эхнэр Дэсогма лугаа эвцэлдсэн.
4. Аюулгагч Гүвэра цагаан хар өнгөт гавалт бэрээ барьсан эх Рэүдрима сэлттэй эвцэлдсэн.
5. Аюулгагч Ишэйвэра хар ногоон хүрд барьсан эх Гэүрэма лугаа сэлттэй эвцэлдсэн.
6. Аюулгагч вэ шанда улаан хар нум сум барьсан эхнэр Варахи лугаа сэлттэй эвцэлдсэн.
7. Аюулгагч Вида хар хөх сүх барьсан эхнэр Варахи лугаа сэлттэй эвцэлдсэн.
8. Аюулгагч Галавэра утаан өнгөт илд барьсан эхнэр Ману хара лугаа сэлтэй эвцэлдсэн үүний өнгийг сажава ёсонд шард номлодог мөн улаан цайварт таалдагч Богд эцэг хөвгүүн бээр утаан өнгөтэйд таалдаг.
9. Аюулгагч Банабади хар хөх бадрангуй очир барьсан, эхнэр Мамүнди лугаа эвцэлдсэн бүгд маш их хилэнтийн

нүүр лүгээ төгс өөртөө адил эмэгтэйг зүүн гараар тэвэрсэн.

Үүнээ арван зүгийг тэтгэгчийг нь Мриди бээр зохиосон Гүнрэгийн бүтээлийн арга мэтээр, их тэнгэрийн анхны дөрвийг Хансүм намжил болон Намхай дэмид-ээс номлосончилин хийгээд сүүлийн дөрвөн их тэнгэр болон найман их лус, найман их гариг, хорин найман одуудыг Номын төвийн зарлигийн эрхийн хот мандалын зан үйлээс гарсан мэтээр.

Ертөнцийг тэтгэгч дөрвөн махранзыг явдлын үүднээс, Аюулгагч есийг найруулгын үндэсний үр тайлбараас болон тайлбар тодорхой зулаас гарсанчилин номлов.

Зүгийг тэтгэгч ба их тэнгэр заримуудад зөрөөтэй мэт үзэгдэх нь Очир дарь бээр авшиг өгөх үесд хот мандал тус тусын нийт бусын нэр соёрхосны эрхээр учир харшлахгүй болой.

Тэдгээрийн биеийн өнгө мутарын барьц тэргүүтэнд үндэсний аймаг бусдаас адилгүй номолсон байдаг бөгөөд урьд номолсон эдгээр нь ертөнцөөс нөгчсөн тэнгэрүүд юм. Ертөнцийн далан таван Цогт итгэл тусдаа байдагч үүнээ ихдээс сэжигдэн эс бичив.

Үүнээс дээших нь итгэл эрдмийн зочдын аймаг болой. Үүнийг заримууд эрдмийн зочинд агуулах тэдгээр ч ихэнхдээ бурхан бодь сэтгэлтэн ямагт мөн тул чухаг дээдийн хүндлэлийн зочидоос тусгаар ялгаж болохгүй хэмээдэг ч мөн чанар тэр мэт мөн ч байдлын үүднээс тусгаар ялгасанаар гэмгүй. Тэр мэт эс үйлдвээс хот мандалын бурхадын чуулганд эрхэм болон нөхрийн томьёог агуулж болохгүй тул бэлгэдэл тийн агуулга нэгийг эрэлцэх хэрэггүй тул сэжигдэх хэрэггүй.

**Найман аймагтийг ангилах ёсыг гурван  
хувьтын балингийн зан үйлд**

1. Дэва тэнгэр
2. Нага лус
3. Ягча ягчас
4. Гандрва үнэр идэштэн
5. Асүр асар
6. Гарүда Гарьд
7. Гиннара Миамжи
8. Михорага их хэвлийгээр одогч аймгуудын хэсэг болой.

Үүний тарнийн эцэст Манүка хэмээх нь хүн амүнүша хэмээх нь хүн хийгээд хүн бусын дуун тусгал гарах хүн бус найман аймаг нийтэд одох боловч хүний үе үүнд ирэх утга байхгүй тул шинжилж үйлдээрэй.

Дэмчог тэргүүтний зүгийн балингийн үесд сарва ягча, рагча са хэмээх тэргүүтэн ягчас, мангас, бүднэр, бэрд, мах идэгч, согтогч умартагч, мамо, хандома нугууд гарсан тул хойт хоёрын нэгд тоолох бүднэр хэмээх ерөнхий дуунд үйлдээд бусдуудыг тоолох найман аймаг болой.

**Төвдийн Нинмавогийн урсгалд алдаршсан тэнгэр мангасын  
найман аймаг нь:**

Эрлэг  
Мамо  
Шулам  
Албин  
Хаан  
Лус  
Ягчис  
Гаригууд болой.

**Бас найман аймагт /Дэвжэд/-д**

1. Гадаад найман аймаг
2. Дотоод найман аймаг
3. Нууц найман аймаг
4. Дээд найман аймаг
5. Хувилгаан найман аймгийн тийн агуулгыг ч ялгадаг.

**Анхдугаар. Гадаад найман аймаг нь**

1. Тэнгэрийн эрхэт Хурмаст
2. Асурын эрхэт Тагсанри
3. Миамжи Жонба гонсан
4. Ноджин ганва санбо
5. Хаадин сэрмиг чилва
6. Чойжин маха гала
7. Сринбо линга динжү
8. Диса сүрлүд аба нугууд нь гадаад найман аймагт болой.

### **Хоёрдугаарт. Дотоод найман аймаг нь**

1. Явжиг дүдзэ нагбо
2. Занжил ямшүд марво
3. Юлха Чусан лүсрай
4. Срогдог Жалбо нинжин
5. Чойжин ноджин марбо
6. Лхамо Жигби логжин
7. Гэнэн дорж лэгба
8. Гармо нида тод прэн нугууд нь дотоод найман аймаг болой.

### **Гуравдугаарт. Нууц найман аймаг нь**

Дүдбо хатүн рагча

Шинжэ шидбо марбо

Лүдүд нага раза

Ноджин шанба дитог

Мамо сридба тамдэв

Зан ям шүд сроглэн

Дүдрэ дэгон яг

Срогдаг дүнги торцүгжан нугууд нь нууц найман аймаг болой.

### **Дөрөвдүгээрт. Дээд найман аймаг нь**

Саачог рахүла

Гарчог тамшин хатор

Дүдчог ману ягча

Занчог дизан түмбо

Магчог жэжан дүнзин

Лүчог лүжал дүнжон

Гончог нагбо дэгар

Жалчог лижан хара нугууд нь дээд найман аймаг болой.

**Тавдугаарт. Хувилгаан найман аймаг нь**

1. Чавжүгийн толгой Мангасд хувилсан
2. Хошуу шүд Шулам
3. Баруун зүүн мөр нь Далха болон Мамо
4. Баруун зүүн гар нь Эрлэг ба Лүзан
5. Сүүл нь му
6. Нүд соёо гурав нь гариг шуламд хувилсныг хувилгаан найман аймаг хэмээдэг болой

Мөн номлох ёс олон байдаг ч үүнийг эс бичив.

**Жил сар цагийн тэнгэрүүд нь**

Жил сар цагийн тэнгэрийг цагийн хүрд тэргүүтний үндэсний найман аймгаас номолсон ёс буй ч үүнээ хар зурхайгаас гарсанаар ба үүнээ илт онол тэргүүтэн адилгүй олноос найман гэгээний ёсоор номловол.

**Жилийн тэнгэр нь:** Бар, Туулай хоёр нь хөх өнгөтэй модны навч барьсан

Луу нь шар өнгөтэй гартаа хүрд барьсан

Морь, Могой хоёр нь улаан хиур барьсан

Хонь шар өнгөтэй гартаа уул барьсан

Тахиа, Бич хоёр нь хар хөх өнгөтэй төмөр бэрээ барьсан

Нохой шар өнгөтэй гартаа илд барьсан

Хулгана, Гахай хоёр хар хөх өнгөтэй бумба барьсан

Үхэр шар өнгөтэй гартаа сүмбэр уул барьсан

Бар, Туулай тэргүүтэн арван хоёрыг мод, гал, шороо, төмөр, устав тавд ялган хөгшин жил жар гэдэг бөгөөд бар туулай тэргүүтэн толгой хэлбэрт хэмээсэн мэт болой.

Жилийн эзэн арван хоёул үүнийг арван хоёр ордонд хэрэх түүнийг танин барих нь нум, матар, бумба, загас, хонь, үхэр, хамтгах, мэлхий, арслан, охин, жинлүүр, хилэнцийн арван хоёр ордоны эзэдүүд бар тэргүүтэн толгойт бөгөөд нум тэргүүтэн тэмдэгийн бэлгэ барьсан хэмээдэг. Арван хоёр жилийн эзэн тэдгээр нь гадаад дотоодын шүтэн барилдлагын эрхээр амгалан зовлонг өгөхөд хүч ихтэй бөгөөд дотоодын ертөнцийн амгалан зовлон бүхэн арван хоёр шүтэн барилдлагаас харгалздаг.

Гадаад жил сар хоног цаг өдөр бүгдийг арван хоёр жил эзлэн эрхшээдэг. Тийм учраас тэднийг эрхшээх цагт ордон арван хоёр нугуудыг хэрэх шүтэн барилдлага арван хоёр нь хүч ихтэй.

Ямар мэт гадаад түүнчлэн дотоод хэмээн номолсон мэт тэдгээрт гадаад дотоод бусад гурвыг бэлгэдэх ёсны ариун барилдлага агуу их бөгөөд гадаад мэт үзэгдэл газрын эзэн арван хоёр ордноор дотоодод ургахыг арван хоёр шүтэн барилдлагаар оновол үнэний утгыг онодог. Тийм учраас тэдгээрийг мэдэх нь чухал ч үүнд олондоос сэжигдэн эс бичив судалж мэдэхийг хүсвэл Цагийн хүрдний үндэс болон тайлбарыг үзээрэй.

Жил нь хаан мэт, сар нь түшмэл мэт, хоног нь цэрэг, цаг нь мэс мэтэд номлодог бөгөөд жил, сар, хоног, цаг тус тусад бурхан алин болон алиныг эрхшээсэн зургийн мөрөөс танин барьсанаас хязгаар нэгд магадлаагүй боловч тоо төдий нь

Жилийн тэнгэр нь хоёр зуун гучин нэг

Сарын тэнгэр нь зуун хорин дөрөв

Хоногийн тэнгэр нь зуун нэг

Цагийн тэнгэр нь Гурван зуун долоо байдагт номолсон бөгөөд нарийвчилсаныг “Эрдэнэ бүхэн хурсан” тэргүүтнээс мэдэж үйлдээрэй.

### **Хөлөлийн тэнгэр нь**

Зүүн зүг модонд урд зүгийн гал  
Баруун зүгийн төмөрт хойд зүгийн ус  
Зүүн урд хийнд баруун урдын шороо  
Баруун хойд огторгуйд зүүн хойд уул  
Зүгийн хөлөлийн зүгийн өнгөтэй  
Завсарын хөлөл шар бөгөөд гартаа бэрээ хумх барьсан  
байна.

### **Мэнгэний тэнгэр нь**

1. Нэг цагаан Газрын охин тэнгэр нь цагаан өнгөтэй сүмбэр уул барьсан
2. Хоёр хар Шуламын хаан нь хар өнгөтэй эрээн мод барьсан
3. Гурван хөх Дүгжид огторгуй өнгөтэй гартаа гавал эрхи, цуст гавал барьсан
4. Дөрвөн ногоон Варүни ногоон өнгөтэй гартаа эрдэнийн бумба барьсан
5. Таван шар Ертөнцийн эзэн нь шар өнгөтэй бумба цагаан лавай барьсан
6. Зургаан цагаан Төрөлхт амьтны цог нь цагаан өнгөтэй гартаа бэрээ, дуаз барьсан
7. Долоон улаан Зангод чинбо нь улаан өнгөтэй жадба шоо барьсан
8. Найман цагаан Ертөнцийн эрх баялагт нь цагаан өнгөтэй сэрээ ба гавалт цус барьсан
9. Есөн улаан Мамо Замүди нь улаан өнгөтэй өвчны тулам, түүдэг барьсан.



### **Махбодын тэнгэр нь**

1. Зүүн зүгийн модон махбодын хаан хөх гартаа эрдэнэ найлзуур барьсан
2. Урд зүгийн гал махбодын хаан улаан гартаа гал бадарсан уул барьсан
3. Баруун зүгийн төмөр махбодын хаан хар гартаа алтан илд барьсан
4. Хойд зүгийн усан махбодын хаан хөх гартаа усан хумх барьсан

Тэр дөрвийн эм нь туулай, могой, тахиа, гахай толгойтой хөх цайвар туг барьсан завсрын шороон махбодын дөрвөн хаан луу, хонь, нохой үхэр толгойтой шар өнгөтэй сүмбэр уул барьсан. Мөн таван махбодын таван охин тэнгэр тэргүүтэн болой.

### **Газрын эзний богд түшмэл албатууд нь**

Урьдын тэдгээр ч газрын эзэд мөн боловч хэрэгтэй эрхээр тусгаар ялгана. Ер нь газрын эзэн эрхэм нөхрийг махбодь “Эрдэнийн хураангуй”-аас дэлгэрэнгүйд мянга, дунд нь зуун тав хураангуй нь ерэн нэг. Түүнд ч дээд, доод, гадаад, дотоод, нууц, маш нууцаар ялгавал түмэн бум тэргүүтэн байдаг номлодог бөгөөд түүнээс

Оршигч газрын эзэн нь долоон зуун далан хоёр

Ашид үл солигдох хорин нэг

Газрын доорх есөн үеийн есөн газрын эзэд

жил сар хоног цаг харгалзалгүй хадаас хадсан адил оршдог учир эрхэмд номолсон.

#### **1. Тэдгээрээс Оршигч далан хоёр газрын эзэн нь**

Хойд таван мянга суурьт өгүүлбэл

ялгаа таваар завсарвал ус хоёр хувь

түүнчилин зүүнд бар туулайн төв

завсарвал модны хувь хоёр зүйл

Урдад морь могой таван зүйл

завсардвал галын хувь хоёр

Баруунд тахиа бич тав нэжгээд нэжгээдэд

гөвд төмрийн хувь хоёр зүйл

Дөрвөн завсарт дөрвөн эрлэгийн аймаг

тав нэжгээд төвдөө шорооны хувь нэжгээд нэжгээд сэлт оршигч

далан хоёрт таалдаг.

**2. Ашид үл солигдох хорин нэгэн газрын эзэд нь**

1. Газрын тэнгэр Гэүтэнба
2. Газар баригч Лагба чинбо
3. Зүүн зүгийн газрын эзэн Тэсэ
4. Баруун зүгийн Ханпан
5. Хойд зүгийн Вэүжин
6. Зүүн урд зүгийн Вилин Парма
7. Баруун урд зүгийн Дүвнян лагбажан
8. Баруун хойд зүгийн Данви миво чэ
9. Зүүн урд зүгийн Сэрнэво нугууд
10. Зүүн хорнаг жан
11. Урд вадан Сэрвө жан
12. Баруун Сигжүг жан
13. Хойд Сэва жан нугууд
14. Шинги савдаг Чэсаба
15. Харжи зэлха
16. Зигмангэ вэү
17. Лхадавжи шонну
18. Дүрчоджа тинян
19. Шинмү гонон жан
20. Найба орны савдаг хэмэх орон үүнд
21. Оршисон лус нян, зан сэнмо тэргүүтэнг бүгдийг нийлбэл  
хорин нэг болно

### **Газрын доорх есөн зэргийн газрын эзэд нь**

1. Лхамданма
2. Лалагон
3. Донсүмжалва
4. Сасринман
5. Варзэтаво
6. Гогчэндүг
7. Нансалчэддүг
8. Вэнажал
9. Тилативүн нугууд болой

тэдгээрийн хэрэглэл тэргүүтэнг бичих аваас олон болох ч мэдэхийг хүсвэл Найман гэгээн гол номлол болон Биндэръяа гарва тэргүүтнээс мэдэж үйлд.

### **Төлөг зурхайн тэнгэр нь**

1. Дүнлха гурван зуун жар
2. Бортон наян тэнгэр
3. Гавзү есөн тэнгэр тэргүүтэн болой

## **Хамт төрсөн тэнгэрийн язгуураас заяаны**

### **таван тэнгэр нь**

Молха идэр эмэгтэй байдалтай цагаан өнгөтэй торгот сум толь барьсан, хөх торгон нөмрөгтэй эрдэнийн торго элдэв чимэгээр чимсэн согоо хөлөглөсөн.

Сроглха идэр эрэгтэй байдалтай цагаан өнгөтэй, жад цалам барьсан хуяг дуулгатай хор сумыг бэлхүүсэндээ хүлээд хар морь хөлөглөсөн.

Полхо цагаа идэр эрэгтэй байдалтай эрдэнээр дүүргэсэн тэвш барьсан хөх нөмрөг нөмөрсөн торгот гавал болон эрдэнийн чимэгтэй цагаан морь хөлөглөсөн.

Юллха цагаан өнгөтэй нум сум барьсан хуяг дуулга өмссөн хор, сум хүлж цагаан морь хөлөглөсөн.

Далха идэр эрэгтэй дүртэй цагаан өнгөтэй жад цалам барьсан цагаан торгон хувцас болон торгон гавал эрдэнийн чимэгтэй хор, сумийг бэлхүүсэнд хүлсэн цагаан морь хөлөглөсөн.

Бас Далха нянбо Шонлха паван, Сроглха зинбо Молха жүнмо, юллха гонву тавыг ч танин барих нь ч үзэгддэг бөгөөд ялгуусан Гэндүн дүвийн зарлиг балингийн номлолд өөрийн буянаас бүтсэн тэнгэр хэмээгдэх нь тав байдаг. Амьдруулагч тэнгэр, сахигч тэнгэр, аврагч тэнгэр, нөхөрлөгч тэнгэр, заяаны тэнгэр лүгээ тав буй.

**Анхан.** Амьдруулагч тэнгэр нь орны тэнгэр болой.

**Хоёрдугаарх нь:** Сахигч тэнгэр нь амины тэнгэр бөгөөд ертөнцтөнд шулам, албин тэргүүтэн номтонд лхам, гонбо тэргүүтэн.

**Гуравдугаарх нь:** Аврагч тэнгэр нь ертөнцтөнд дайны тэнгэр тэргүүтэн номтонд номын сахиус тэнгэр тэргүүтэн болой.

**Дөрөвдүгээрх нь:** Нөхөрлөгч тэнгэр нь төлөгч эм тэнгэр бөгөөд биед сүүдэр мэт хагацалгүй зүрхэн очир аврагч эмийн тэнгэр юм.

**Тавдугаарх нь:** Заяаны тэнгэр нь эрийн тэнгэр бөгөөд ертөнцөд өвөг эцгийн тэнгэр номтонд багшаас үндэслэн заяаны тэнгэр болой.

### **Заяаны таван тэнгэр бээр нөхөр болох ёс нь**

Орны тэнгэр бээр оройн хэсгийг сахидаг  
Дайны тэнгэр бээр баруун мөрийг сахидаг  
Эрийн тэнгэр бээр баруун суганаас сахидаг  
Эмийн тэнгэр бээр баруун мөрнөөс сахидаг  
Амины тэнгэр бээр зүрхний төвөөс сахидаг хэмээдэг.

### **Зочид тус тусын танин барих сэлтээс гарсан нөхөрлөгч тэнгэрүүдийн зүг нэгэнд номловол**

Санасан хэргийг бүтээгч тэнгэр  
Язгуур үндэсийг арвитгагч тэнгэр  
Эд өгөгч тэнгэр  
Итгэл аврал түшиг бологч тэнгэр  
Баатар сүр хүч чадлыг үүсгэгч тэнгэр  
Таван эрхтний үйлдлийн үйлүүдийг бүтээхэд эрхшээгч тэнгэр  
Уралдагч моринд оршигч тэнгэр  
Бат хуягт оршигч тэнгэр  
Хурц мэсэнд оршигч тэнгэр  
Өндөр өглөг өргөн үйлдэхэд эрхшээгч тэнгэр  
Дордод даатгал эрхшээгч тэнгэр  
Хамт гэрт амьдрахад эрхшээгч тэнгэр  
Зүгийн тусыг чухалчилагчин эрхшээгч тэнгэр  
Цэрэг жуулчныг эрхшээгч тэнгэр

Гэрийн тэнгэр  
Зуухны тэнгэр  
Хотын тэнгэр  
Орны тэнгэр  
Малын тэнгэр  
Үүдний тэнгэр  
Замын тэнгэр  
Чимэг хувцасанд оршигч тэнгэр  
Төгс эдлэлд оршигч тэнгэр  
Нөхөрт оршигч тэнгэр  
Хүний угсаа үндэсний тэнгэр  
Мүрав үндэсний тэнгэр  
Сүмийн үндэслэлийн тэнгэр  
Багш нарын үндэслэлийн тэнгэр  
Заримуудыг дайны тэнгэр ба  
Заримыг хишигийн тэнгэр гэдэг.

**Тус тусаар танин барих арга нь:** Алтан гэрлийн хишиг аврал  
тэргүүтнээс гарсан.

Мизэ мангар

Срайзэ видог

Лхапүлхавран

Полха гарво

Молха гармо нугууд нь санасан тусыг бүтээн үндэсийг

арвитган эдийг өгч итгэл аврал бологч тэнгэр юм.

Чимхла гэтүн

Чиго лхасэржи мивочэ

Нанго лха Чүгмо

Тавжи лхарогбо

Шинги лха паван

Чүгжи лха нэрвү

Дай лха врэйво

Ври лха шамбо

Яггий лха дүнпо

Зой лха гэгөд

Лүггий лха мэнвү

Рай лха Цэрма нугууд нь хишигийн тэнгэрүүд бөгөөд нэр нэрийдсэн бас бус байгааг нарийвчлан онолдохоос сэжигдэн эс бичив.

Тэдгээр нь ихэнхдээ хамт төрсөн тэнгэрт багтдаг. Ер нь хүнд хамт төрсөн тэнгэр чөтгөр хоёр буй бөгөд буянтай бодьгалд хамт төрсөн тэнгэр нь олон байдаг. Харин буян өчүүхэнд хамт төрсөн нь чөтгөр олон байдаг.

“Гаадамбагын эцэг ном”-ноос сонсвол энэ адил бөгөөд төрсөн цагаас хамт төрөөд хамт төрсөн тэнгэр чөтгөр өөр өөр дурдтгадаг. Тэнгэр нь зохилдох нөхцөл бүгдийг бүтээн харшилдах нөхцөл бүгдийг нь тэвчүүлэн үйлддэг. Буян бүхэнд сануулга талбидаг. Буян алин үйлдсэнийг бичигт биччихдэг. Хилэнц буюу зововоос гаслан үйлддэг буян үйлдэх юмуу жаргалтай байвал ихэд баясдаг ч чөтгөр нь бол түүнээс буцдаг. Буян алинийг үйлдэх цагт тэнгэр бээр нөхөр болоод тэнгэр бээр туслан үйлддэг. Тэр цагт тэнгэр нь ийн хэмээн үр шалтгааныг даган бараадуулж хүн тэр бээр буяны үйлийг эдэлдэг. үр амгалан жаргалын язгуурыг эдлэхээс зовлонг эдүүлдэггүй учир биднийг аврагч нь тэнгэр юм.

Тэндээс чөтгөр чуулвал зовлон болдог. Хилэнцийн үйлд орших цагт хамт төрсөн ийн хэмээн үр шалтгааныг даган



бараадуулдаг. Хилэнц зовлонг уртасгаж тэнгэрийг гадагш хөөн тэндээс тэнгэрүүдийн хүч багасаж хүний сүлдийг чөтгөр эзэлдэг.

Буянд шамдвал хамт төрсөн чөтгөрийн хүч багасаж тэнгэрийн хүч их болсоноор хүн түүнд өвчин зовлон үгүй хотол чуулмал болдог. Хилэнц үйлдвэл тэнгэрийн хүч багаддаг. чөтгөрийн хүч дэлгэрвэл үл хүсэх элдэв зовлон гардаг.

Тэнгэр чөтгөр хоёр нь энэ насанд тэр мэт тус хорыг үйлддэгээр үл барам буян хилэнц алин үйлдсэнийг бичигт буулган хүн тэр үхээд зуурдад төөрөх цагт эрлэг номын хаанд өргөөд номын хаан түүнчилин асууж шинжилээд буян их байвал сайн заяанд хилэнц олон байвал муу заяанд талбидаг.

Орны тэнгэр дэлхийн эзэд нь орон улс агуу ихийн эзнийг орны тэнгэр (Юүллха) өчүүхэн газрыг эрхшээгчийг дэлхийн эзэн (Шивдаг) хэмээдэг.

Анхан нь: Дэлхийг ерөнхийлөн эрхшээгч нь газрын охин тэнгэр бат эх, газрын эзэн Дочэ юм. Төвд орны эрхэнд үйлдвэл Сридба чагва есөн тэнгэр, богдын гүр тэнгэр арван гурав, бат эх арван хоёр нугууд нь орны тэнгэр юм.

#### **Анхны Сридба чагва есөн тэнгэр нь**

1. Одэ гүнжал
2. Ярлха шамбо
3. Нячэн танлха
4. Мачэн бомра
5. Жогчэн донра
6. Гомбо лхазэ
7. Шонлха жүгбо
8. Жаво юлжал
9. Шэүхари нугууд болой.

Сүүлийн наймыг Одэ гүнжалын хөвгүүн хэмээдэг. Тэдгээр нь эхэн Айри гурван аймаг, завсар Үй зангын дөрвөн аймаг, адаг До, мад, ган гурав лугаа төвд орны эхэн дунд адаг гурвыг эрхшээн оршдог.

Тэр есийн дээр Жово чимлха о гурав ба Яабан, хүглха дөрвийг нэмээд богдын гүр арван гурван тэнгэр хэмээн алдаршсан ба сансар анхлан тогтох цагт гарсан учир сансар тогтсон тэнгэр буюу есөн Сридба тэнгэр гэдэг.

Төвдийн богд номын хаадууд бээр тэнгэрт таалж тахидаг учир богдын гүр тэнгэр хэмээн дууддаг. Мөн Явлха далдүг, Чалхавамчэн, Жалха вод одэ гүнжал лүгээ сансарын тэнгэрийн дөрвөн эгч гэдэг ба тэр тус тусаас олонтой арвидсан элдэв түүх үзэгддэг ч хэрэг өчүүхэн учир эс бичив.

### **Арван хоёр бат эх нь**

Хар гуа бусын дөрвөн охин шуламс нь

Доржэ гүндагма

Доржэ яаможон

Доржэ гүндүсан

Доржэ гэгжи зо нугууд болой

Улаан хилэнтийн дөрвөн ягчас охид нь

Доржэ жанжигма

Доржэ балжи юм

Доржэ лүможал

Доржэ дагможал нугууд

Гармошинсангийн эмч дөрвөн охин нь

Доржэ водхамжо

Доржэ манжигма

Доржэ ярмосил

Доржэ сүглэгма нугууд нь арван хоёр бат эх болой.

Тэдгээрийн биеийн өнгө, мутарын барьц хөлөг тэргүүтэн нь адилгүй байдаг.

Дэлхийн эзэдийг найман аймагтын язгуур элдэв буй бөгөөд бэрдэд багтах нь ч олон бөгөөд уул хад, ой шугуй, нуур цөөрөм, тал, сүм дуган тэргүүтэнд оршдог ба дээдсийн гэгээнийг үзэж тангараг агуулснаар цагаан зүгт баясагч ба тэр мэт бус хар зүгт баясагч ч элдэв байдаг.

Замба тивийн сав шимийн эрдэм нь лусын хаан Мадойба-гын цог хүчнийх хэмээгээд орны эзэн дэлхийн эздийн сүр доройтвол орон түүний хүн эдэд доройтол гардаг хэмээн зарим дээдэс нар номолсон байдаг. Орны тэнгэр лусын тэргүүтэнг доройтуулах үйлийн язгуурыг үйлдэлгүй тэдгээрийн хүч чадал сүр хүчийг арвитгаж сэргээхийн аргыг үйлдэх нь орон нутагт өлзий амгалан жаргал гарахын сайн үүдэнд үзэгддэг.

Өөрөө алинд суувч орон түүний дэлхийн эзэдэд хорлол үйлдэлгүй балин тэргүүтнийг өгснөөр нөхөр болгох хэрэгтэйг дээдэс багш нар чухалчилан захидаг.

Урьд номолсон найман аймгаас доошиход ертөнцийн эрхэнд үйлдсэн. Ер нь махбодын тэнгэр, орон нутаг, гэрийн тэнгэр тэргүүтэнд ертөнцийн магадлагаа үгүй.

### **Явдалын үндэс тэргүүтэнээс**

Галын тэнгэр Салжид хорло

Усны тэнгэр Дүджэд брүлшаг

Хийн тэнгэр Ёожод вадан

Савдаг лагчэн Хорло зинба нь дөрвөн махбодын тэнгэр болой.

Гэрийн тэнгэр Гүннан ринчэн домвү зинба  
Уулын тэнгэр Равдан лодой ринчэн варва  
Модны тэнгэр Гүннай одсэр шиндог  
Бүхэн баясгалантын тэнгэр Гүндү нанви лодой жонжин  
Орны тэнгэр Нацаг го хорол  
Үхээрийн тэнгэр Жүнбо гэва хорло  
Балгадын тэнгэр Содном Гэви лодой рэнчэн  
варвазинба нугууд нь

Хот мандалын эргэн тойрны тэнгэрт номолсон мэт болой.

Үүнээс дээших нь Нигүүлсэхүй зочдын аймаг бөгөөд зургаан  
язгуурын амьтан бусадууд ч үүнд хурах хэрэгтэй.

### **Ад тотгор өр төлөөсний зочид нь**

Ад (дон) болон тотгорын (гэг) ялгаа нь адад бодьгал бээр түгэвч тотгорт бодьгал мөн бусын язгуур буй. үлгэрлэвэл ган зуд мэт нь ургац хотол чуулсан гарахын тотгор мөнтэй адил хэмээдэг. Бас ад тотгор хоёуланг бодьгалд үйлдснээр үл хүсэхийг үүсгэх хийгээд хүссэн хэргийг бүтээлгүй үйлдэх мэт нь энэ хоёулангын үйлдэл мөн учир түүнийг зэтгэр гээд тотгорын томьёо нэрийддэггүй. Тэр тотгор бол тотгор зэтгэр хэмээн тус тус тоолж болохгүй хэмээдэг.

Бас адыг хүндэлвэл хорлол үл үйлддэг бөгөөд тусалдаг нь ч буй. Тотгор нь хүндэлсэн ч хорлол үйлддэг. Адын тоо зүйл адилгүй олон байдаг.

Цагаан шүхэртэд тэнгэрийн адаас өргөс гаргагч ад хүртэл хорин найман ад байдаг.

Мисагүса-ийн адыг цагаан шүхэрт Лхаюулма болон Шанжи мүтүв хоёуланд хорин зургаа, хорин долоо түүнээс ч илүү байдаг.

“Манзүшрийн язгуур үндэс”-ээс Эсэрвагийн эхнэр тэргүүтэн арван есөн эм адыг номолсон.

“Ригба чоги- үндэс”-ээс адыг найман түм дөрвөн мянга болон газарт гүйгч арван найман адыг номолсон.

Урьд нь найман түм дөрвөн мянган нисваанис тус тусаас үүссэн ад юм. Хойд нь эмийн шинжлэлийн үндэсээс гарсан арван найман адыг номолсон лугаа утга нэгэн адил.

**Адын язгуур гурван зуун жар  
хэмээн алдаршсан нь**

Гурван зуун жаран хоногийг эрхшээгч ад

Гурван зуун жар байдаг.

Цагийн хүрдэнд гурван зуун жард номлосончлон анагаах ухааны гол номлолоос биеийн судал гурван зуун жар ба түүний эрхээр хамт төрсөн чөтгөр гурван зуун жар байдагт номолсон.

Тэдгээр бээр айх цочих, зарсхийх тэргүүтэн сэтгэл амгалангүйг өгдөг учир гэнэтийн зэтгэрлэгч гурван зуун жаран ад гэдэг.

### **Тотгорын язгуур нь**

“Сайн цогцын үндэс”-ээс тотгорын язгуур нь дөрвөн зүйл ба газарт байгуулагдсан тотгорууд нь тийн аймшигт, үнэг, хулгана, гучин нэгт хэмээгдэх дөрвөн хэсгээр хураагаад

Анхны аймгийн ноён нь Гаслангүй, албат тотгор нь долоон живаа буй.

Хоёрдугаарх аймгийн ноён нь Заан ад, албат нь арван найман живаа байдаг

Гуравдугаарх аймгийн ноён нь Зүгнагчүн, албат нь машид их агуу түмэн живаа тэрбум мянгаар тоологддог.

Дөрөвдүгээрх гучин нэгт хэмээгдэх тотгорын аймгийн ноён Зүгчан, албат нь жаран живаа байдагт номолсон. Тэр бүгд ч ертөнцийг тэтгэгч дөрвөн махранзын нөхөрт багтдаг учир бүтээл хийхэд дөрвөн махранзын хорионы тэмдэг босгодог нь ч тотгор тэдгээрээс хамгаалах учиртай байдаг.

### **Тотгорын язгуур наян ад хэмээн**

#### **алдаршсан нь**

Эр ад, эм ад, манин ад тус бүрт хамт төрсөн, бүхэн нэрийдсэн ад хоёр нижгээд нижгээд тэр бүгд хүч их есөн зуун нижгээд ба хүч өчүүхэн ер нижгээд ялгаснаар гурван зуун жар болоод гурван хэсэг гарсныг нийлүүлбэл наян мянган ад болдог.

Бас Атаагийн үндэс тачаалаас цус, хий омогийн үр уринаас хорхой, шар мунхагаас бадганы өвчин босдог бөгөөд зүрхэнд хий шар бадган гурав хураад тэрний нөхцөлөөр орогч тотгор нь тачаалаас эм ад орж хий шар усыг дэлгэрүүлж үйлддэг.

Уринт сэтгэл үүсвэл эр ад орж шар болон хорхойг дэлгэрүүлж үйлддэг. мунхаг сэтгэлийг үүсгэвэл манин ад орж бадганыг дэлгэрүүлж үйлддэг.



**Өр төлөөсний /ланчаг, өштөн,  
шахан/ дөрөв нь**

Урьд төрөлд бусдын амь тасалсан, зодож үйлдсэн, эд эдлэлийг хулгайлах буюу булаасан эхнэртэй нь хурьцах мэт товчилбоос орон түүнээ хорлол үйлдсэний өр төлөөс болж хувирдаг.

Өш боссон тэр энэ насанд хариу хорлол хийж эс чадвал хойд төрөлд зөн билэгт хүн бус болж төрөөд өр төлөөсөө авдаг нь ч буй. Зөн билэг үгүй ч үйлийн эрхээр өр төлөөсөө нэхдэг нь ч буй. Тийм учир урьд хорлол үйлдсэн тэрийг одоо хүн бус зөн билэгт мэтэд төрснийг өр төлөөсөө цайруулж болдог боловч өр төлөөс нэхэгчин тэр тамын амьтан болж төрсөн байвал балин тэргүүтэнг өгвөл тэр нь эдэлж чадахгүй учир өр төлөөс цайрах арганд одох бэрхтэй хэмээвэл өөр өр төлөөс нэхэгч тэрэнд зоригдох санааг завсаргүйгээр цаад өр төлөөс нэхэгч тэр бодитой олсон олоогүйд харгалзах хэрэгтэй болбол бурхадууд өглөгийг барамэдийг төгсгөж чадахгүй болоод амьтад хязгааргүй ядуурах болно.

Өр төлөөс ланчаг нь ихэнхдээ адил ч урьд нь сэтгэлээр эс хураагдсан эд хойт нь сэтгэлээр хураагдсан биеийн дээрээс агуулдаг.

Өштөн нь амь солих, Үнэр эдлэгч хүн бус бүднэр нь үнэр идэштэн ихэнх ба зуурдын амьтан, ялгамжтайд алагдсан, боймлогдсон, халилд унаж үхсэн тэргүүтэн нь үхсэнээр урьдын биеийг орхиод төрөлөө ололгүй төөрсөн нугууд бөгөөд тэдгээрт сан, хиншүү сүр тавивал их тустай юм. Сансар нирвааны зочид бүгдийг хурааснаар зургаан язгуурын амьтан бусадууд ч сан зориулгын оронд бодох хэрэгтэй.

## Гуравдугаарт. Зочдийг ямар мэт

### залах ёс нь

Тус тусын заллагын үгийг өгүүлэх лүгээ цаг сацууд адил сансар нирвааны зочид бүгд дээрээс үүл манан буух мэт, завсараас цасан шуурга шуурах мэт, доороос их газрын чийг босох мэт ихэд шуугин залрахын бодол үйлдэнэ. Ертөнцийн тэнгэрүүд ч догшин ширүүн сэтгэл амирласнаар өөрт баясах бишрэх байдлаар ирсэнд бодох хэрэгтэй.

Тэдгээрийг гэгээн гэрэлд оруулснаас Идам бурханы байдалтай болсонд бодсон ч сайн бөгөөд өөр өөрийн байдалтай түүнд агуулсан ч болох тул алин бодсоноор үйлд алин мэт байсан ч дээд хувьд нь лам багш нар түүний доодод Идамууд үндэсний аймгийн дараалалчлан ба түүний доор төгс жаргалангийн лагшинт болон хувилгаант лагшинт бурхадууд түүний доор бодьсадууд, Ширваан, брадигабуд, баатар, дагинас, номын сахиусууд тэдгээрийн доор цогт далан таван итгэл, найман аймагтан, заяаны таван тэнгэр тэргүүтэн жил, сар, хоног, цаг, хөлөл, мэнгэ, газрын эзэд, орны тэнгэр, дэлхийн эздүүд, доод суурьт зургаан язгууртны амьтан, ад, тотгор, өр төлөөсний эзэд, өшт бүгд харанхуйлан мэлмэрч суусанд бод.

Зарим сангийн зан үйлд Жанрайсиг Аролига хасарвани мэт маш том гэгээн гэрэлт их далай адилын үснэрээс хоолой хүртэл чухаг дээд хүндлэлийн зочид, зүрхнээс хүйс хүртэл, итгэл эрдмийн зочид, лагшины доод хувьд зургаан язгуурын нигүүлсэхүйн зочид, лянхуан суудлын хувьд тотгорын язгуур өр төлөөсний зочдуудыг тодорхой талбиад зочдуудын залснаар тэдгээр лүгээ хоёргүй болж оршсонд боддог.

## Хоёрдугаарт. Тахилыг өргөх нь

Тэр өргөх шалтгаан тахил нь

Мөн чанарын ялгаа

Байдлын ялгаа

Үйлдлийн ялгаа гурав төгс байна.

**Мөн чанар нь:** Гэнтийн зассан мэт бус эхэн буюу анхнаас үнэнд бүтсэнээр тийн ариун хоосон чанарын чанарт болой.

**Байдал нь:** Тарни, дияан, мутарлагын хүчинд шүтсэнээр зочид тус тусын явдлын орон алин хүссэн тахилын эдэд ургах.

**Үйлдэл нь:** Тэдгээрийн үндсэнд цувиралтгүй амгаланг үүсгэх үйлдэл болой.

Мөн чанар нь өвөрчилингээр эс бүтсэн хоосон чанарт болбоос байдал тахилын эд тэргүүтэнд урвахгүй юу гэвэл өвөрчилингээр эс бүтсэний эрхээр байдал юунд ч ургаж чадах атал өвөрчилингээр бүтсэнийг урвуулан байгуулж чадах хэн ч бус. Тийм учраас “Үндсэн билиг”-ээс алин хоосон чанартай болсон түүнд бүхэн болох болно хэмээгээд алин хоосон чанар үл болох түүнд бүгд болохгүй хэмээн номолсон тэргүүтэн эш ухаан хязгааргүй.

Тэр мэт мөн ч бодитой бэлтгэсэн цөөн нь олонтойд арвидах нь ямар мэт чадах хэмээвэл бодитой буй нугуудыг сэтгэлээр төгсгөн үйлдэх хэрэгтэй бөгөөд урьд номолсон мэт өглөгийн барамэд ч талбих сэтгэлийг төгсгөхөд харгалзах хэрэгтэй. Барамэдийн хөлөгний үесд ч өглөгийн эд бодитой үгүй ч сэтгэлээр санасанаар бүтээвэл тэр нь номын төв юунд ургахын хүч тарни, мутарлага, дияан өөрийн тийн ариун үлэмж санаа бурханы зарлиг хуурамгүй үнэний хүч бүгд чуулсанд шүтсэнээр бодитой бэлтгэсэн нь цөөн ч тэр ямагт олон болоод цувиралтгүй алин хүссэн элдэв зүйлд урган гардаг. Тарни, мутарлага, дияаны

хүчээр тэр мэт гарсан нь бурхан бээр номолсон тул хуурмаггүй мөн ч бид дияаныг эрхшээвэл чадал эс гарах нь үгүй учир ном бүгд атгагаар нэрийдсэн төдий оньсоор юм.

Балин нь идээний ялгавар төдий юм. Сан нь хөвхөлзөн баагих утаа төдийгээс бодогдохуун агуу их ёсыг мэдэхгүй байх боловч тэр төдий бус үзэсгэлэнт дүрс, яруу дуу анхилам үнэр, амтат амт, зөөлөн хүрэлцэхүй лүгээ хүслийн таван эрдэм төгс ба орон, ордон, хувцас, чимэг, эд эдлэл, идээ ундааны ялгавар, үхэлгүй рашаан, өвчин арилгагч эм, доройтлыг арилгагч эрдэнэ хүсэлийг хангагч үнээ, галвирваасан мод өлзийт эд хорлолоос аврагч хуяг алин хүссэн зорчих хөлөг тэргүүтэн доод доодын зочидуудад алин юу хүссэн зүйлийг байдалтай санах хэрэгтэй.

Тэрнийг ч нарийвчлан ялгавал лам багш Идам бурхадад гадаад, дотоод, нууц тахил ба сав шимийн мандал тэргүүтэн тахилын эдийн элдэв ялгавар.

Номын сахиус нарт өөр өөрийн гадаад, дотоод, нууц шүтээний эд тахил балин тэргүүтэн. Ад тотгор тэргүүтэнд дой ба золиг, горын хувь элдэв байдлаар.

Бэрдийн язгуурт рашааны үргэлжлэлийн байдалтай санах ба амирлангуй хилэнтийн байдалтан тус тусад идээ сэлт хувцас хөлөг тэргүүтэнг түүн лүгээ зохилдсон байдалтай санах тэргүүтэн зоригдолын ялгаварыг тус тусад ялгавал машин сайн.

Үйлдэл нь дээд зочидуудын таалал үндсэнд амгалан хоосны ялгамжит бэлгэ билиг мэндлэх ба доод зочидууд ч төгс эдлэлд шүтсэнээр зовлон бүгд амирласнаар амгалан хотол чуулмал лугаа төгс болоод ялгамжтайд хорлогчдын муу санаа барилдлага лугаа хагацсанаар баясах бишрэх болсонд бодох хэрэгтэй.

Тахилын орон, тахил, өргөөчин лүгээ гурав нөхөр тэдгээр ч өвөрчилингээр эс бүтсэн илбэ зүүдний цэнгэл мэтэд бодоод дээр үгүйн егүзэртэн бээр энэ төдийгээр үл барам амгалан хоосон ялгалгүйн тийн цэнгэл ямагтайд бодох хэрэгтэй байдаг.

### **Тахил өргөх ёс бодитойд**

1. Тахилын ялгавар элдэвийг өргөх.
2. Сангийн тахилыг өргөх хоёр буй

**Анхдугаарт. Тахилын ялгавар элдэвийг өргөх нь** Хоёр уст, чухал хэрэглэгдэх, хөгжим, хүсэгдэхүүн таван тахил тэргүүтэнг өргөнө.

**Хоёрдугаарт. Сангийн тахил өргөхөд**

1. Өргөх шалтгааны сангийн тахил
2. Тэрийг алинд өргөх

**Анхан. Өргөх шалтгааны сангийн тахил нь:** Элдэв сайн эм тэргүүтэн болой.

**Хоёрдугаарт. Тэрнийг алинд өргөх нь:** Сансар нирвааны зочидуудад ерөнхийлэн зориулах, ялгамжтайд заяаны таван тэнгэрүүдэд зориулах, орон, дэлхийн эздүүдэд ялгамжтайд зориулж тахил өргөх гурав буй.

**Гуравдугаарт. Гэмийг ариусгах нь:** Үүнд ерөнхийлөн ариусгах ялгамжтайд ариусгах нь хоёр буй. Тэргүүлшгүйгээс хураасан арван хар нүгэл завсаргүй таван нүгэл тэргүүтэн хилэнц ба гурван санваар лугаа харшилсан унал тэргүүтэн гурван үүдийн гэм бүхэн ба ялгамжтайд лам багш, Идам, номын сахиусны лагшин зарлиг таалалын тангарагаас харшилсан нь ариуссанаар ариун болсонд бодох.

**Хоёрдугаарт. Ялгамжтайд ариусгах нь:** бузар ариун бус тэргүүтний гэм ба үйл үйлдвэрт мэргэжээгүйн гэмүүд ариуссанд бодох. Бузар тоо зүйл олонтой номолсон байдаг бөгөөд доройтлын бузар, идээний бузар, эд болон хувцасны бузар, хүүрийн бузар, хараалын бузар, бэлэвсний бузар, ярын бузар, адын бузар, өшийн бузар, бохир бузар тэргүүтэн болой. үүнээс доройтсон бузар нь тангараг санваар доройтсоны бузар юм. Тангараг санваар доройтсон хүн бусдад бузар халдан тангараг санваарыг доройтуулдаг гэмтэй. Түүгээр ч лам багш,Идам, бурхан номын сахиус тэргүүтэнд туссаныг доройтсоны бузар гэдэг. Энэ нь бузар бүхний дотроос нэн уршиг ихтэй тул ихэд хянамгаалаарай.

Тиймээс тэр мэтийн тангараг доройтсоны бузар туссан ба тэдгээр лүгээ үг өгүүлэлдсэн түүний эдийг авч идээг идсэн тэргүүтэний гэмүүд ариуссанд бодох хэрэгтэй.

### **Сангийн үйл үйлдвэрт мэргэшээгүйн гэм нь**

Чухаг дээдийн лагшин, зарлиг, таалалын шүтээн дээд төрөлхтөний хувцас тэргүүтэн тангарагын эд, суврага, багшийн сүүдрээс дээшдихэд алхаж гишгэх баас, шээс, нус тэргүүтэн ариун бусаар буртигдсан, сонгино, сармис лууван идсэний үнэр тамхи татсаны муу үнэрт утаагаар тусгавал энэ хойд хоёуланд үл хүсэх зовлон үүсэх учир хянамгайлан үйлдэх хэрэгтэй. Урьд үл мэдэхээр үйлдсэн байвал тэдгээр ариуссан ариун болсонд бодох хэрэгтэй.

## **Дөрвдүгээрт. Үйлсээ даатгахад**

1. Үйлсээ ерөнхийлэн даатгах
2. Ялгамжтайд тодорхой зоригдолтойгоор үйлсээ даатгах хоёр буй

**Анхан. Үйлсээ ерөнхийлөн даатгах нь:** Үлэмж асар ариун санаагаар бодитой бэлтгэсэн сэтгэлээр хувилгасан тахил, балин, санг өргөснөөр өөрийн болон бусдын хоёр түйтгэр ариусч гэгээрсэнд санах.

**Хоёр. Ялгамжтайд тодорхой зоригдолтойгоор үйлсээ даатгах нь:** Ялгамжтайд тодорхой зоригдолтойгоор үйлсээ даатгахад энэ үеийн бодол нь тэр мэт зочдуудыг тахилаар баясгаж үйлдснээр сангаар гэм бүхэн ариуссанд шүтсэнээр дээд доодын зочид бүгд бие сүр жавхлан хотол чуулж таалал нь өөрт баясан энэрэхүйн байдалт болсонд үйлсээ даатгасанд хүү бээр өөрийн эхэд хүссэн хэргээ өгүүлэхийг сонсохчлон Лам багш, Идам бурхан бодь сэтгэлтэнүүд бээр адистэд шидийг соёрхон авралд багтаад сахиуснуудын бээр бээр саадыг арилган алин хүссэн дөрвөн үйл торолтгүй бүтэх ба заяаны тэнгэр, орны тэнгэр, дэлхийн эздүүд бээр харш нөхцөлийг арилгаж хүссэн хэргийг бүтээх сайн нөхөр болоод, хорлогчид бээр өш хонзонгийн санаагаа орхиод хойшид хэзээд хорлол үл үйлдэхүйд ам авсанд санах хэрэгтэй.

Мөн лам багш Идам чухаг дээд гурван сахиуснуудын биенээс рашаан ба таван зүйлийн гэрэл цацрагийн үргэлжлэл хэмжээшгүй гарч өөрийн бие сэтгэлд оршносоор хилэнц түйтгэр өвчин ад саад бүхэн цэвэрлэгдэн ариусч нас буян барилдлага учрал эрдэм тэргүүтэн сайн чуулган бүгд дэлгэрэн үйлдсэнээр рашааны гэрэл цацраг лугаа сэлт өөрийн орон гэр байшинаар



бэлгэдсэн сав ертөнц бүхэнд тусч ариун орон диваажин мэт тэнгэрийн үлшгүй ордоны мөн чанартай болж зоригдолын оронд үйлдэгдсэн доод зочидуудаар бэлгэдсэн шимийн амьтан бүгдийн бие сэтгэлд оршсоноор хорлогчдын муу санаа барилдлага бүгдийг амирлуулан үйлдэж хамаг амьтаны хилэнц түйтгэр зовлон лугаа сэлт ариусч агшин тэр ямагт сэтгэлийн үндэс түйтгэр лүгээ хагацсанаар тэнгэр ба охин тэнгэрийн чанартай болсоноор сав шим бүгд ариун ямагт болсонд бод.

Мөн тэр бүгдийн гурван оронд (орой, хоолой, зүрх) **Ум, аа, хум**-аар бэлгэдсэний **хум** үсгээс гэрэл цацарч бэлгэ билигийн бурхадын чуулганыг залаад тэдгээрт шингээн тангараг бэлгэ билигт ялгалгүйд болсоны гурван үсгээс рашаан болон цагаан, улаан, хөх, гэрэл гарч өөрийн гурван оронд шингэснээр гурван үүдний эгэлд баримтлах тийн атгагын хир ариусч гурван очирын чанартай болсонд санаад **Ум, аа, хум**-ыг олонтой тоолох буюу тарнийг эс тоолсон ч болно.

Тэр мэт үйлдвэл муу нөхцөлүүд мөрд урваад хорлогч нөхөр болоод муу ёрын халил хаагдах болно.

Бас Ад чөтгөр, лус, савдаг мэтийн хорлолыг зоригдол тодорхойгоор арилгах хэрэгтэй бол тахил, сан өргөх гэмийг наминчилахын үесд түүнд тухайлан зорьж үйлдэн завсар үүнд хорлогч тэр доод зочидын дотор буйн байдалтайгаар тодорзуулан үйлдээд дээд лам багш чухаг дээдүүдийн лагшины хувиас рашааны гэрэл цацрагийн үргэлжлэл гарч түүний оройноос оршиод дотор бүгд дүүрсэнээр хилэнц түйтгэр зовлон бүгд арилна. Газрын эзэн, догшин лус мэтэд өөрөө бээр газар ухсан, чулуу хөндсөн, мод тасадсан, ус бузарласан тэргүүтнээр тэдгээрийн бие бэртсэн, сүр хүч эрхтэн доройтсон төгс эдлэл доройтсон тэргүүтэнг сэргээгээд урьдаас ч хотол чуулмал

болсоноор хорлол хөнөөлийн муу санаа барилдлага бүхэн амирласанаар өөрт үлэмжид баясан бишрэх бодлыг үйлдээд зуун үсэгт тарни ба Жанма бурханы тарни тэргүүтэнг алин чадахаар урь.

Бас хорлогч тэдгээр үйлийн эрхээр одоо өөрт хорлогч болсон ч урьд төрөлүүдэд ачлалаар тэтгэсэн эх болсон ёсыг санаад тэдгээр амгалангаар ядууран зовлон бодит ба түүний шалтгааныг эдлэх ёсуудыг санаад асархуй нигүүлсэхүй бодлогыг тодорхойгоор авал орхилгын хийг хөлөглөсөн бодлыг олонтой үйлд.

Бас лам багш чухаг гурав, сахиусан лугаа сэлтийн лагшингаас зохилдонгуй гэрэл цацарч амирлангуй, дэлгэр, эрхэнд хураах, хатуу үйл, ба сахин хамгаалах буцаан, няцаах тэргүүтэний үйлийг бүтээхийн зоригдолууд байдагч үүнээ тодорхой бичээгүй тул бусдаас мэдэж үйлд.

## **Гуравдугаарт. Сангийн сүүлийн зан үйлд**

1. Алтан ундаа буюу сэржим өргөх
2. Хишиг даллага үйлдэх
3. Эндүүрсний хүлцэл өчих
4. Зочидуудыг үдэх
5. Өлзий өгүүлэхүйгээр сүүлийг чимэн үйлдэх нүгүүд болой

**Анхан. Алтан ундаа буюу сэржим өргөх нь:** Ерөнхий алтан ундаанд цагаан ундаа, амтат ундаа, цусан ундаа, эрдэнийн ундаа, үрийн ундаа, согтууруулагч ундаа нугуудыг номолсоноос алтан ундаа нь эрдэнийн ундааны ялгавар бөгөөд элдэв эрдэнийг найруулсаныг эрдэнийн ундаа хэмээгээд дан алтыг найруулсаныг алтан ундаа буюу сэржим хэмээн томъёо нэрийдсэн байдаг.

Тэр алинийг ч архи лугаа найруулвал согтоогч ундаа болоод алт тэргүүтэн элдэв эрдэнэ ба элдэв үр, архи лугаа найруулвал ундаа гурвуулан болно. Архийг цацаж болдоггүй учир заримдаа сайн цайны идээ найруулдаг журам байдгийг үес лүгээ мэдэх хэрэгтэй. Ундаа хэмээх нь цангааны нэр бөгөөд цангахыг арилгагч ундааны элдэв ялгаварыг ундаа хэмээн нэрийдсэн. Өргөх үгүйг нь бусдаас гарсан мэт үйлдэнэ. Сангийн үесд алтан ундаа өргөхийг юугаар ч заавал өргөх хэрэгтэй бус.

**Хоёр. Хишиг даллага авах ёс нь:** Хишиг даллага үйлдэхэд хишиг болон шим нь утга нэг тул сансар нирвааны шимийг дуудахыг хишиг даллага хэмээн нэрийддэг. Хишиг хэмээх томъёог "Үндсэн очир эрхин"-ээс дээд болон эдийг өгөгч цог лугаа хишиг хэмээн гарсан учир хишиг дуудан үйлдэхийг төвдүүд өөрийн дураар үйлдсэн бус.

### **Хишиг даллага авах үеийн зоригдол**

#### **(бодол) нь**

Ер нь хишиг даллагын үесд буух бодлын зэрэг нь зочид ерөнхий болон ялгамжтайд сангийн эзэн эдийн тэнгэрүүдийн лагшинаас гэрэл цацарч гох хэлбэртэйгээр дээд доод зүг завсар бүхэнд цацарсанаар сансар нирвааны шим буюу хишиг бүгдийг өлзийт тэмдэг, өлзийт эд, хаан төрийн долоон эрдэнэ, очир, хас, гэрлэн дусал тэргүүтний байдал цасан шихрэг намуухан буухчилан ирүүлж өөрийн бие, төгс эдлэл бүгдэд сив сив шингэнээр хүч их болж байдал баясгалант нүдэнд дулаахан царай сүр жавхлан лугаа төгс болсонд бодоод торгот сумаар даллах бөгөөд хишиг дуудах үгүүдийг өгүүлж үйлд. Хамаг юмс бүхэн шүтэн барилдлагын эрхээр агуулах хэрэгтэй учир эд (зай) тарни бодлого бурханы хүч чадал тэргүүтэн зохилдсон шүтэн барилдлага бүхэн чуулбаас хүч ихийн эрхээр хишиг дуудах дэлгэрэнгүй зан үйл нугуудад эд, хүрд тэргүүтнийг барих арга, өөрийг болон өмнөө бурханы өгүзэр тарни ба бодлогын ялгавар олонтойг номолсон бөгөөд тэр бүгд эс бүрдсэн ч сангийн дашрам төдий авахуй хялбар энэ төдийгээр үйлдвэл чухаг дээдийн адистэд хүч ба өөрийн сэтгэл итгэмжилсэн бодлын хүчээр хишиг хурах болно.

**Гурав. Эндүүрсэний хүлцэл өчих нь:** Эндүүрэлийг наминчилах зуун үсгийг урих үесд дээд доодын зочид бүгдийн оройд Очир садва бурханыг тодорхой бодоод түүний биеэс рашааны үргэлжлэл гарч өөрийн болон зочидуудын оройноос оршсоноор зан үйлийн тасалдсан, илүүдсэн, алдаатай, тахилын эд эс бүрдсэн ариун цэвэр муу тэргүүтэний гэм ариуссанд бодох.

**Дөрөв. Зочидуудыг үдэх нь:** Тавдугаар далай ламын зарлигаас усны хөөс нэвтрэхчилин ухааны хүчээр зочидыг үдэхэд мөн чанар анхнаас төрөөгүйн төвд байдал өөр өөрийн тус тусын оронд ажирвай Вазра мү хэмээн номолсоны утгыг санаад өгүүлбэл сайн.

**Тавдугаарт. Өлзий өгүүлэх нь:** Ерөнхий нийт мэтээр үйлдэнэ. Тэр мэт урьд номолсон зоригдолуудыг сэтгэлдээ бодоод мэдэгдэхүүн утга, гарын авлага эдгээрийг үйлдвэл сан талбих ямагтаар ахуй үес болон эцсийн хэрэг олонтой бүтэх нь эргэлзээгүй.

Өгүүлрүүн:

Алин нэгэн бурхан болон багш нарын чуулган бүхнийг  
Баясган үйлдэгч тахилын үүлэн далай  
Хүн бус бүднэрийн огоот хорт сэтгэлийн  
Халуун энэлгээгч арилгагч саранч мөн  
Төгс оюутаны хүсэлийн тогтор болсон  
Харанхуй чуулганыг эцэслэгч огторгуй эрдэнэ ч мөн  
Түүнчлэн тийн гэтлэх эрдэнийн тивд  
Амар хялбар очих хөлөг онгоц мөн

Тэр мэт сангийн гарын авлагыг дээдсийн зүрхэн зарлигаас хураангуйлан найруулсанаас гарсан буяны үнэр анхилам утаагаар ертөнцийн хамаг доройтол ариусаад ялгуусан бурхадыг баясгагч тахилын үүлэн тулцалдах болтугай.

**Хамаг амьтан Очир дарийн хутгийг асар түргэнээс түргэн олох болтугай.**

## **Дээд сан өлзий хутагийн хурыг буулгагч**

**Ум базра амрида гүндали хана хана хум пад**

**Ум сувава шүддо сарва дарма сувава шүддо хам хоосон чанартай боловой.**

Хоосоны агаараас ариусгалын эдүүд өөр өөрийн нэрийн үсэг анхан дусалаар чимсэн хайлсанаас лам, идам, бурхан, бодь сэтгэлтэн баатар, дагинас, номыг тэтгэгч сахиусан урт наст таван эгч, арван хоёр бат эх, хангайн хан, орон тэнгэр дэлхийн эзэн лүгээ сэлтийг баясган үйлдэх тангарагын эд, мэлмийн болгоолт, тахилын ялгавар сэтгэшгүй нэг лам, идам, бурхан, бодь сэтгэлтэн, баатар, дагинас, номыг номыг тэтгэгч сахиусан, урт наст таван эгч, арван хоёр бат эх, хангайн хан, ороны тэнгэр, дэлхийн эзэн лүгээ сэлтүүдийн мэлмийн мөрд гарч дэлгэрэх болтугай.

**Ум сарва вид бүра бүра сүра сүра авардая авардая хо вазра парана хам гурван удаа өгүүл.**

**Ум аргам-аас шавда аа хум**

**Ум рүба аа хум-аас ум барша хум**

**Ум сувава ви шүдди дарма дэ вазра сиди хум нама сарва дата гада жо вишү мүхэ вая сарва дадхам үдгадэ парана хи мам гаганахам суха. Ум амридэ хум пад**

**Ум агаро мүхам сарва дарма нам адя нүд ба нана дад, нама сарва дата гада ава логидэ ум самвара самвара хум**

**Ум рүрү пүра зула дишта сидда лозани сарва арта садани суха.**

Миний санааны хүч ба

Түүнчлэн ажирсаны адистэдийн хүч ба

Номын төвийн хүчүүдийн

Тусаар алин санасан бүхэн

Тэдгээр бүгд хэр зохистойд

Төрвөлгүй гарах болтугай

**Ум** Аяа зөндөө бүтсэн их амгалангийн ордоноос

Гурван цагийн бурхан лянхуан гавалын эрихын хүч

Арвис баригч баатар дагинасын чуулган лугаа сэлт

Төрвөлгүй нигүүлсэлийн эрхээр ажиран соёрх

Өмнийн огторгуйд лянхуан дэлбээ уужимын дээр

Арслант ширээ лянх нар сарны дээр

Сэтгэлийг булаагч таван зүйл солонгон бүрхүүлийн төвд

Хумсны толион гэрэл тогтон батад оршин соёрх

Ухаан баригч бүтээлийн эрх баялагт лянхуанаас гарагч

Таван зуугийн оройн чимэг Цог төгс Зул зохист

Очир дарийн эрхэт сайн оюунтад алдаршсан цаг

Элдэв хувилгааны бүжиглэл зохиогч түүнд сөгдмүй

Цог төгс шашны их сахиус нөхөр сэлтүүд

Таны зарлиг ба тангарагт оршсон

Дөрвөн зүйл үйлс аяар бүтэх хийгээд

Их номын хүрээ хөгжин дэлгэрэн зохио

**Ум** Ариусгалын эд, тахил, балин гадаад дотоод нууцын

Тангарагийн эд, мэлмийн болгоолт, үхэлгүй дүүрэн

Цуврилтгүй бэлгэ билигийн рашааны ус далай

Хотол сайн тахилын үүлэнд тулцалдах болвой

**Ум аа хум** гурван удаа өгүүлээд адистэдлэ

**Ум** Гурван зарлигийн ачлал төгс ламаас

Очир баригч хүртэлх

Язгуур үндэсний багш хоцролгүй

Одоо үүнд тахилын оронд ажир



Нууц, Амгалант, Аюулгагч гурав ба Цагаан хүрдэн  
тэргүүтэн

Үндэсний дөрвөн аймгийн бурхадын чуулган  
Гурван цаг, түүнчлэн ажирсан хөвгүүн сэлтүүд  
Одоо тахилын оронд үүнээ ажир

Сонсогч, Өөрөө ялагч, шашин сахиус далайн чуулган  
Баатар дагинас бүхэн ба  
Товчилвоос дээд гурав хоцролгүй  
Одоо тахилын орон үүнээ ажир

Бид нарыг дагуулан нигүүлсэгч  
Заяаны тэнгэр сахиус хоцролгүй ба  
Ороны тэнгэр, дэлхийн эзэд бүгд ч  
Одоо тахилын орон үүнээ ажир

Ертөнцийг тэтгэгч их хүчит  
Догшин найман аймагт бүхэн  
Ад, тотгор, өр төлөөсний зочидууд ч  
Одоо тахилын орон үүнээ ажир

**Ум** Язгуур үндэс багш хуурмаггүй чухаг дээд гурав  
Дагинас номыг тэтгэгчийн чуулганаар хүрээлэн оршив  
Догшин найман аймагт ороны тэнгэр дэлхийн эзэн ба  
Зургаан язгуур амьтан ба өр төлөөсний зочид ч хоцролгүй  
байгуулалдав

Дурдсан төдийгөөр дээдийг соёрхогч  
Гэмээс хагацсан эрдэм бүхний сан  
Ороны дээд нөхөр сэлтэд  
Сүжигээр магтан мөргөмүй

Амгалан хоосны уужим огторгуйгаас  
Сайтар гарсан тахилын үүлэнг өргөх нь  
Рашаан тавиг ус далай мэт уйлгалсан  
Үзэсгэлэнт цэцгийн түгээмэл баглаа

Үнэр анхилам үйлсийн эрхин тулцалдсан  
Харанхуйг арилгагч жигдэрсэн зул  
Хүжисийн усны урсгал алгуур буусан  
Зуун амтат идээ сүмбэрлэн цогцолсон

Яруу сүрт хөгжмийн зэмсэгийн зуун дуу  
Хүсэгдэхүүн таван зүйл үүлэн мэт бүрхсэн  
Алтан ундаан рашааны далайн эргүүлгэ  
Нууц их амгалан тэргүүтэн

Гадаад дотоод нууц тахилын чуулган ба  
Бэлгэ билигийн рашаанд адистэдлэсэн  
Мах цус тосон балин үүнийг  
Нөхөр сэлтэд баясал үүсгэхийн тухайд өргөмүй

Улаан цагаан зандан, Агару  
Гавур гүргэм тэргүүтэн  
Зади бойгар даль  
Арц даль агь тэргүүтэн

Ариусгал эд элдэв хүж мянган ба  
Гурил тос тэргүүтэн элдэв эд  
Элдэв үр элдэв торго, таван зүрхэн  
Шижир алт бадарсан адилаан галаар шатаасан

Утаан үүлэн огторгуйд тулцалдсанаар  
Ачит язгуурын багш ариус өчүүхэн дэлгэрүүлбэл  
Агуу их явдлын үндэслэлийн багш ариус  
Гүн үзлийн үндэслэлийн багш ариус  
Адистэдийн үндэслэлийн багш ариус  
Зарлигийн увдисын үндэслэлийн багш ариус  
Мөрийн зэргийн үндэслэлийн багш ариус  
Хуучинт үндэслэлийн багш ариус  
Мөр үрийн үндэслэлийн багш ариус  
Зургаан барилдлагын үндэслэлийн багш ариус  
Шанба зарлигийн үндэслэлийн багш ариус  
Амирлуулагч үндэслэлийн багш ариус  
Маха мудра үндэслэлийн багш ариус  
Буян төгс үндэслэлийн багш ариус  
Хослон орохуй үндэслэлийн багш ариус  
Зургаан номын үндэслэлийн багш ариус

хэмээн өөр өөрийн оюун лугаа тааруулан ямар мэт хүссэн  
багш тус тусын алдарыг оруулж болно.

Товчилон хураавал

Ачит үндэсний багш ариус хэмээгдэх зүйлээс

Ханьцашгүй бурхан шагжаан эрхэм

Түгээмэлийн эзэн Очир баригчийн эрхэтээс

Судар дандарын увдисыг тодруулан зохиогч  
Язгуур үндэсний багш бүгд ариус

Их Цогт Очир аюулгагч ба  
Нууц хураангуй амгалант, Жэдор Цагын хүрдэн тэргүүтэн  
Үндэсний дөрвөн аймгийн бурхадын чуулган ба  
Гурван цагийн ялгуусан хөвгүүн сэлт ариус

Зургаан мутарт Итгэл нөхөр сэлт ба  
Сэтгэлчилэн эрдэнэ, номын хаан  
Гүнр, дөрвөн мутарт, тийн ялгуусан тэргүүтэн  
Номыг тэтгэгч сахиусан бүгд ариус

Дөрвөн хавсаргалт бар хөлөглөгч үхээрийн орны эзэн  
Цэргийн сор Цогт тэнгэр маш бат эх  
Утаан нүүрс цагийн бэлгэ Бэгз тэргүүтэн  
Тангарагтан далайн цэргийн чуулган ариус

Гурван орнуудад оршсон  
Баатар дагина хоцролгүй ба  
Шашныг тэтгэгч цагаан зүгийн наян тэнгэр тэргүүтэн  
Цагаан зүгийг тэтгэгч бүгд ариус

Газрын охин тэнгэр Бат эх тэргүүтэн  
Гурван мянганы дэлхийн эзэн бүхэн ба  
Ялгамжит орон зүг уужим  
Орны тэнгэр, дэлхийн эзэд бүхэн ариус

Их Махранз таван лагшин, раху  
Урт наст таван эгч шашиныг тэтгэг сэлт  
Гариг, од, жил сар хоног цагт  
Гүйн оршигч тэнгэрүүд ариус

Ялгамжтайд бид нөхөр сэлтүүдийн  
Номын үндэс, язгуур үндэст шүтэгдэн заяасан  
Алгасаралгүй мянга нөхөр итгэл зохиосон  
Догшин тэнгэр сахиус бүгд ариус

Хилэнт найман аймагт хоцролгүй ба  
Ад, тотгор, бүднэрийн чуулганууд ба  
Өр төлөөс, өшлөн занাগч тэргүүтэн  
Зочидод зохистой бүхэн ариус

Товчилвоос тус тусад өгүүлэх юун хэрэг  
Сансарын үзүүрээс эхлээд  
Нэрвэгдэлт там хүртэл оршсон  
Амьтан ямар хэдий чинээ буй бүгд ариус

Сансар нирвааны зочидуудад  
Ариусгал тэргүүтэн тахил өргөсөнөөр  
Бид нөхөр лүгээ сэлтүүдийн  
Доройтол бузар хоцролгүй ариусах болтугай

Бидний гэрт ба хээр алинд ч  
Үйл, үйлдвэр юу үйлдэв ч  
Бүхэн өдөөгдөх атаа үйлдэлгүй  
Үргэлжид итгэл аврал нөхөр болон зохиохтун

Санасан хэрэг сэтгэлчилэн бүтэхийн тотгор  
Гадаад дотоод зэтгэр бүхэн ба  
Өвчин, ад, хулгай, дайсан тотгор бүхнийг  
Ойрд амирлуулахын үйлсийг зохиохтун

Нас буян цог учрал  
Нөхөр, төгс эдлэл яруу алдрын язгуур  
Шашин хийгээд шашны үйлдвэр тэргүүтэн нь  
Шиний саран мэт дэлгэрүүлэн зохио

Ертөнц хийгээд ертөнцөөс нөгчсөн  
Есөн хүслийн эдлэл бүхэн ба  
Гурван орны төрөлхтөн амьтан хоцролгүй  
Эрхэнд хурахын үйлийг зохио

Ялгуусаны шашин ба шашиныг баригчдад  
Хорлол өгөгч хөнөөлт хортон ба  
Өөрт уурлах дайсан тотгор бүхнийг  
Хатуу цаазаар гэсгээн цээрлүүлэн зохио

Товчилбоос дээд хийгээд нийтийн  
Шидийг одоо өөрөө олоод  
Богд ламын таалал бүхнийг  
Хоцролгүй би бээр бүтээх болтугай

Үүгээр жишсэн буяны мянган гэрлээр  
Төрөлхтөний хоёр түйтгэрийн харанхуй арилаад  
Амьтан бүхний тусад гурван биеийн  
Зуун дэлбээ илтэд дэлбээлэх болтугай

**Ай** Хоёр түйтгэр ариуссан номын төв

Бат хэлбэрэлт бүхний суурь

Дээр үгүй үнэмлэхүй хишиг

Өнөөдөр хурайлан даллан авмуй

Ариун огторгуйн төв хүчинээс

Солонгон зураг хээлсэн мэт

Янагуухь юунд ургахын хишигийг

Өнөөдөр хурайлан далан авмуй

Асар ариун төгс долоон эрдэнээр

Дөрвөн их тивийг эрхшээгч

Хүрдэн эргүүлэнч цагын хишигийг

Өнөөдөр хурайлан даллан авмуй

Амнаас эрдэнийн хурыг буулга

Огторгуйн санд эрхшээл олсон

Тийн сонсогчын хөвгүүний эдийн хишигийг

Өнөөдөр хурайлан даллан авмуй

Олоноо өргөгдсөн хаанаа сэхлээд

Ариун язгуур нь гангын урсгал мэт

Тасралтгүй хүмүүний үндсийн хишгийг

Өнөөдөр хурайлан даллан авмуй

Гурван сургаал модны ялгуусаны хөвгүүний

Агуу их явдлын үзэсгэлэнт гишүүн

Хоёр зэргийн эцэст хүрсэн үрээр  
Үзэсгэлэнт төгс номын хишиг ба  
Үхлийн эзэний аймгаас ялсан  
Үхэлгүйг бүтээх насны хишгийг  
Өнөөдөр хурайлан даллан авмуй

**Жи** Сансар нирвааны цог учирал хоцролгүй гарахын орон  
Чадагчын шажин өнө удаан орших хийгээд  
Түүнийг баригч дээдсүүд  
Цог учирлаар чимж өнө удаан өлмий батжих болтугай

Багш, Идамуудын адистэд хийгээд  
Номыг тэтгэгч сахиуснуудын хүч чадлаар  
Орон үүнд цог учирал адистэд үл доройтон  
Муу санаа барилдлага хэрцгий амирлан  
Бад багш нөхөр сэлтүүдийн  
Нас буянууд дэлгэрэхийн үйлсийг зохио  
Есөн хүслийн учирал сүүн далай мэт арвидан

Эндэгдэлгүй ухааны алгуур явдал үргэлж  
тасралтгүйгээр  
Өдөр шөнөд сайн оюун төгсийн номын дуугаар  
Хотол чуулганы цагт цэнгэхийн өлзий хутаг орштугай.



## **Дээд сан өлзийн хурыг буулгагчын тайлбар**

**Дээд сан өлзийн хурыг буулгагчын зоригдолын зэрэг ба  
мэдэгдэхүүн утгын гарын авлага бичиг өлзийн бүхэн түгмэл**

Багш лугаа Үлэмжийн тэнгэр ялгалгүйн өлмийд их бишрэлээр мөргөн авралд итгэмүй их нигүүлсэлээр цаг хийгээд ахуй үес бүхэнд дагуулан барин соёрх.

Үүнээ өвөр бусдын төрөлхтөний үл хүсэхүй харш нөхцөл, ойрын хөнөөл бүхнийг амирлуулах хийгээд ахуй үес ба эцсийн тус амгаланы сайн чуулганг арвидуулж хүссэн хэрэг бүхнийг амар хялбар бүтээх гайхамшигт арга нь ариун бус гэм бүхнийг арилгах сан тахилыг хамгыг айлдагч Очирдарь Банчэн Лувсанчойжижалцанбалсанбуугын зохиосон зан үйлийг авахуй хялбар үйлсийн дэлгэрэлт маш их өлзий хутагын хурыг буулгагч буюу Даши Чарвив үүний гарын авлага, зоригдолын зэргийг дээдэс багш нарын зарлигын үргэлжлэлчилэн товч хураангуй өгүүлж үйлдье.

Тэр ч гариг, од, өдөр, сайн буюу үргэлжийн сан мэтэд цаг харгалзалгүй талбисан ч болно. Чухал дээд шүтээний өмнө буюу дээвэр үгүй газар, ариун сэтгэлд зохист хийдэд хорлол, өт хорхой тэргүүтэн шатаагдах гэмгүй саруул оронд сангийн индэр өндөр хүн нохой тэргүүтэн бээр үл алхахаар бэлд.

Үргэлжийн сан мэтэд их бойпар ч болно. Гал нь нүүрсний гал болохгүй бөгөөд аргил, модны нүүрс тэргүүтэний ариун галыг бэлтгэ.

Сангийн эд (эд) зай нь их орон ялгамжтайд ургасан буюу тийм бус ч ариун газарт ургасан арц агь даль нугууд нь сангийн модны эрхэм нь юм.

Тэрэн ч навч, цэцэг дэлгэрсэн цагт түүгээд хүн нохой тэргүүтэний алхаа гишгэлгэд оруулалгүй, ариун бусын язгуураар буртигдуулалгүй өт хорхой тэргүүтэнгүй хатааж бэлдэх хэрэгтэй

Мөн цагаан улаан зандан, агар, жамүг хус мод, хар агар, сухай, хулс тэргүүтэн үнэр анхилам элдэв модны язгуурын бүрдэл.

Хорын язгуур, ларза, шингүн тэргүүтэн үнэр анхилам бус язгуурыг тэвчсэн сайн зургаа.

Бойгар, Даль, Ману, Сила, Матарын хумс Банбай тэргүүтэн эмийн элдэв язгуур таван зүйл эрдэнэ элдэв хувцас элдэв торго, элдэв үрүүд ба мах архи сонгино сармис тэргүүтэн эс хольцолдсон элдэв идээ, гурван цагаан, гурван амттан гурил тос тэргүүтэн сангийн эд ямар мэт бүрдсэн үүдийг тус тусад буюу бүхэнийг орохуй хялбаршуулбал хамт нэг холиод талхлан үйлдсэн ч болохыг таалсан тул хэр хялбараар хурааж үйлдэж чадвал цагаан улаан балин ба алтан ундаа хоёр уст чухал эдлэгч тахил лугаа сэлтийг бэлтгэ.

Хонх, очир буюу дэншиг, цацах арвай тэргүүтэн чухал хэрэгтэй эдлэлүүдийг ч бүрдүүлж үйлд.

Тэндээс амгалант суудалд суугаад буянт сэтгэл ялгамжитын агаараас аврал одуулах, сэтгэл үүсгэх, цаглашгүй дөрөвийг бясалгахыг үндэс лүгээ ижилсүүлэн холихыг магадтай үйлдээд ялгамжтайд бибээр эх болсон хамаг амьтны тусад туулсан бурханы хутагыг олж үйлдэе.

Түүний тухайд сансар нирвааны зочдуудад сан тэргүүтэний тахил өргөөд агуу их чуулганыг хурааж үйлдэе хэмээн шамдаж үйлдээд өөрөө Нууц хураангуй, Дээд амгалант, Очир аюулгагч гурав тэргүүтэн дээр үгүй егүзэрийн бурхан аль нэгний егүзэрийн үргэлжлэлд оршихчилин буюу тэр бус ч агшинаар

бос ч үйлдэх мэтээр бурханыг үүсгэн омогийг бариад ариусгалын эдүүдэд гал талбихад ариусгалын усаар сүрчин адистэдийн үгийг өгүүлэх лүгээ тааруулаад сангийн эд, тахил, балин лугаа сэлтүүд агшинаар хоосон чанартай болсоны агаараас Ум-аас эрдэнийн сав, Аа-гаас гавалын сав гурван мянганы эн мэт уужим агуу ихүүдийн дотор өөр өөрийн нэрийн үсэг анхан дуслаар чимсэн хайлсанаас гарсан сангийн эд утаа лугаа сэлт мөн чанар нь амгалан хоосны бэлгэ билиг бөгөөд байдал үнэр анхилам хүжисийн утаан үүлэн цогцос огторгуйд түгэн тулцалдаж таван хүсэгдэхүүний төгс эдлэл алин хүссэндээ ургуулж бузар ариун бус тэргүүтэний гамийг арилгаад дээд доодын зочидуудад цувралтгүй амгаланг үүсгэх чадал лугаа төгс ба балин, алтан ундааны элдэв ялгавар өнгө үнэр амт чадал төгс хотол чуулсан эд, тавиг ус, чухал эдлэгч, хөгжим хүсэгдэхүүн тав, долоон зүйл эрдэнэ, өлзий тэмдэг, эд тэргүүтэн зочид амирлангуй хилэнт алинд алин зохистой тангарагын эд мэлмийн болгооль тахилын ялгавар сэтгэшгүй энэ лүгээ зүг эс тасарсан маш хэтэрхий далайн ертөнцийн орон бүгдэд дэлгэрэн дүүрсэн бөгөөд орон цаг ахуй үес бүхэнд барагдашгүй гарсанд санаад гурван үг үсэг (ум аа хум)-ыг гурван удаа өгүүлээд адистэдлэ.

Тэндээс зочидуудад орон ялгамжит тус тусаас залах ёсууд байдаг ч үүнд нь дээд доодын зочид бүгдийг амгалан хоосны төвөөс залах болно.

Тэр ч зочид дөрвөн хэсэгт хурах тул өөрт эрх өгсөн, үндэс номлосон, увдис соёрхосон гурван зарлигын ачлал төгс үндэсний лам багшиар гололсон язгуур үндэсний цаг төгс лам багшийн чуулганууд ба нууц хураангуй дээд амгалант, очир аюулгагч, хотол ухагч гэгээн гэрэлт, чадагч гурван тангарагын

байгуулалт тэргүүтэн үндэсний дөрвөн аймаг лугаа барилдсан  
идам хот мандалын бурхадын чуулган.

Ялгуусан таван язгуур тэргүүтэн төгс жаргалангын лагшинт  
Сайн цагын мянган бурхан тэргүүтэн хувилгаан лагшинт  
бурхадууд ойрын шадар найман хөвгүүн тэргүүтэн бодьсатва  
арван хоёр өөрөө ялагч, хутагтын арван зургаан архад тэргүүтэн  
сонсогч, лугаа сэлт чухаг дээд хүндлэлийн зочид.

Гурван орны баатар дагинас, цогт итгэл махгал, бэгз  
тэргүүтэн бэлгэ билигт ба ертөнцийн сахиус лугаа итгэл эрдмийн  
зочид

Тэнгэр лус ягчис тэргүүтэн найман аймагт бүднэрүүд ба  
заяаны таван тэнгэр, жил сар, хоног цаг тэргүүтэний тэнгэр орны  
тэнгэр, дэлхийн эзэн тэргүүтэн зургаан язгуур зуурд лугаа сэлт  
нигүүлсэхүйн зочид

Тотгорын язгуур наян мянга адил язгуур гурван зуун жар  
тэргүүтэн ер төлөөсний зочид.

Товчилбоос тахил өглөгийн оронд зохистой сансар  
нирваанаар хураагдсан зочид бүгдийг

Ум гурван зарлигийн ачлал төгс лам багшиас хэмээх  
тэргүүтэн заллагын үгийг өгүүлэх лүгээ сацууд дээрээс үүл  
манан буух мэт завсарт цасан шуурах мэт доороос их газрын  
чийг босох мэт шуугин залархын бишрэл үйлд.

Ертөнцтөн ч хатуу догшин ширүүний сэтгэл амирласанаар  
өөрт баясан бишрэх байдлаар ирсэнд бод.

Тэдгээрийг гэгээн гэрэлд оруулсанаас идам бурханы  
байдалтай бодвол сайн бөгөөд өөр өөрийн байдалтаар  
агуулсан болох тул алин бишэрсэнээр үйлд.

Алин мэт ч язгуур үндэс багш хуурмаггүй хэмээх тэргүүтэн  
залбирлын үг лүгээ тааруулсанаар өөрийн өмнө зүгт дээд хувьд

нь язгуур үндэсний багш нар түүний доор амирлангуй хилэнт идамууд үндэсний аймгууд дараалалчилан түүний доор төгс жаргалангын болон хувилгаан бурхадууд.

Түүний доор зэргэмжилэн Бодьсэтгэлтэн өөрөө ялагч, сонсогч, баатар дагина, номыг тэтгэгч сахиуснууд.

Тэдгээрийн доор 75 Цогт итгэл, найман аймагт заяаны таван тэнгэр тэргүүтэн жил, сар, цаг, хөлөл, мэнгэ тэргүүтэнийг эрхшээгч тэнгэр, газрын эзэн, ороны тэнгэр дэлхийн эзнүүд.

Доод газарт зургаан язгуурын амьтан ад тотгор ер төлөөсний эзэн өштөн бүхэн хорлол дүүрсэнээр байгуулагдсанд бод.

Тэндээс дурьдсан төдийгөөр хэмээх тэргүүтэнг өгүүлээд өвөр бусад амьтан бүхэн лам багш идам чухаг дээд гуравт биеийг ороны тоосны тоон сацуу хувилгаад гурван үүдээр бишрэнгүйгээр мөргөхийг урьд адуулсанаар амгалан хоосоны уужим огторгуй-гаас хэмээх тэргүүтэн тахил өргөлийн үг лүгээ тааруулж бодитой бэлтгэсэн сэтгэлээр хувилгасан тахилын эд тавиг ус чухал эдлэгч, хөгжим, хүсэгдэхүүн таван тахил алтан ундаа, рашаан, балин тэргүүтэний гадаад дотоод нууц тахилын эд ба тангарагын эд, мэлмийн болгоолт гурван ялгамжит төгсүүд тахилын охин тэнгэрийн чуулган лугаа сэлт газар завсар, огторгуйн эн бүхэнд дүүргэн цацраан өргөсөнөөр тахилын ороны зочидууд миниймхийлэн таалаад үндэстэнд цуврилтгүй ялгамжит амгалан цаглашгүй мэндэлсэнээр таалал машид баяссанд санаад ялангуяа сангийн эдийн утаа хөхрөн дуниартсан төдий бус урьд адистэдлэсэн мэт гайхамшигт үнэр анхилам хүжисийн үүлэн цогцос агуу их тулцалдсанаар бузар ариун бус тэргүүтэний гэм бүхэн арилхаар үл барам үзэсгэлэнт дүрс яруу дуу, анхилам үнэр, амтлаг амт зөөлөн хүрэлцэхүй

лүгээ хүслийн таван эрдэм төгсөөр зочид тус тусын эрхтэнүүдийг цэнгүүлэх ба бас бус орон ордон ширээ дэвсгэр хувцас чимэг эдлэлд идээ ундааны элдэв ялгавар боол үхэлгүй рашаан, өвчнийг арилгагч эм ядуурлыг арилгагч эрдэнэ, хүслийг хангагч үнээ, галвираасан мод, өлзийт эд, хорлолоос аврагч хуяг алин хүссэнд зорчих хөлөг тэргүүтэн дээд доодын зочидууд алинд алин хүссэн бодийн (зүйл) байдалтай санах хэрэгтэй.

Тэрийг нарийвчлан ялгавал лам, идамуудад гадаад дотоод, нууц тахил ба сав шимийн мандал тэргүүтэн тахилын эд элдэвийн ялгавар.

Номыг тэтгэгч сахиусан нарт өөр өөрийн гадаад дотоод нууцын шүтээн эд тахил балин тэргүүтэн.

Ад тотгор тэргүүтэнд дой, золиг гарын хувь элдэв байдалтаар.

Бэрдийн язгуурт рашааны усны үргэлжлэлийн байдалтай санах мэт.

Амирлангуй хилэнтийн байдалт тус тусад идээ сэлтэс, хувцас, чимэг, хөлөг тэргүүтэнг ч тэдгээр лүгээ зохилдсон байдалтай санаад өргөх тэргүүтэн зоригдолын ялгааг тус тусад сайтар ялгавал машид сайн болоод тэр мэт өргөн зориулж тодорхойд шүтсэнээр дээд зочидуудын таалал үндсэнд амгалан хоосоны бэлэг билиг ялгамжит мэндлэх ба доод зочидууд ч юу хүссэнээ төгс эдэлхүйд шүтсэнээр бие сэтгэлийн зовлон бүхэн амирласанаар амгалан хотол чуулсан лугаа төгс үйлдсэнээр ялгамжтайд хорлогчидууд муу санаа барилдлага ширүүнээс хагацсанаар өөрт баясан бишэрсэнд сана.

Тахилын орон, тахил, тахил өргөлчин лүгээ гурав нөхөр тэдгээр ч үзэгдэлд өвөрчилэнгээр эс бүтсэн илбэ зүүдийн тийн

цэнгэл мэтэд харах ба дээр үгүй өгүзэртэн бээр тэр төдийгөөр үл барам амгалан хоосон ялгалгүйн тийн цэнгэл ямагтад бодох хэрэгтэй.

Тэндээс сансар нирвааны зочидууд хэмээх тэргүүтэний утга мэт язгуур үндэсний багш тэргүүтэн сансар нирвааны зочидуудад сан тахил тэргүүтэнг өргөхөд шүтсэнээр өвөр бусадын тэргүүлшгүйгээс хураасан арван нүгэл, цаглашгүй таван нүгэл тэргүүтэний хилэнц ба гурван санваарын цааз лугаа харшилсан унал тэргүүтэний гурван үүдийн гэм бүхэн ба ялгамжтайд лам, идэм сахиусаны лагшин зарлиг тааллын тангарагаас харшилсан доройтол эвдрэл бүхэн ариуссанаар ариун болсонд бодох ба бас энэ хойт хоёуланд үл хүсэхүйг үүсгэхийн шалтгаан нөхцөл машид муу, тангараг санваар доройтсон бодьгал бусадын бузар өөрт тусах тэдгээр лүгээ үг солилцох, түүний эдийг авах, идээ идэх тэргүүтэний төвд ариуссанаар цэвэрлэгдэн ариун болсон бодлыг дахин шамдан үйлд. Хүсвэл их бандид Очир дарь өөрийн зарлигласан ном нугууд өвөрчилэн бүхэн хагацсан ч хэмээх тэргүүтэнг өгүүлбэл их сайн.

Ерөнхий номыг тэтгэгч ба дэлхийн эзэн мэтэд тухайлсан зоригдолоор балин тэргүүтэнг талбихнаан ч завсар үүнд үйлдэж болно.

Тэндээс бид нар хээр гэрт алинд ч хэмээх тэргүүтэн хүссэн хэрэгийн үйлсийг даатгах цагт тэр мэт зочидууд тахилаар баяссанаар сангаар гэм бүхэн ариуссанд шүтсэнээр дээд доодын зочид бүхэн лагшин сүр хүч хотол чуулан сэтгэл нь өөрт баясан энэрэн энэлхийн байдалтай болсонд үйлсийг даатгасанаар хүү бээр өөрийн эхдээ хүссэн хэрэгээ өгүүлэхэд сонсохчилон лам идам бурхан бодь сэтгэлтэн нугууд бээр их

энэрэлээр чухал таалаад адистэд шид хэмжээлшгүйг соёрхон авралд орж сахиуснууд гадаад дотоодын саадыг арилган алин хүссэн дөрвөн үйлийн үйлс торолтгүй бүтэх ба заяаны тэнгэр, ороны тэнгэр дэлхийн эздүүд бээр нөхцлийг арилган хүссэн хэрэг бүтэхийн нөхөр ба сайн орон болоод хорлогчидууд бээр ч өшид барих санаагаа орхисоноор хойшид хэзээ ч хорлол үл үйлдэхүйд ам авсан бод.

Бас лам идам чухаг дээд гурав сахиусануудын лагшинаас рашаан ба таван зүйл гэрэл цацраг хэмжээлшгүй гарч өөрийн бие сэтгэлд оршсоноор хилэнц түйтгэр өвчин ад тотгор бүхэн ариусан цэвэрлэгдэх нас буян цог учирал эш онолын эрдэм тэргүүтэн сайн чуулган бүхэн арвидан дэлгэрээд рашаан, гэрэл цацраг лугаа сэлт өөрийн орон гэрээр бэлэгдсэн савын ертөнц бүхэнд туссанаар гэмүүд цэвэрлэгдэн ариун орон диваажин мэт ба тэнгэрийн үлшгүй ордоны чанартай болоод зоригдолын орон болон үйлдсэний доод зочидуудаар бэлэгдсэн шимийн амьтан бүхний бие сэтгэлд оршсоноор хорлогчидын муу санаа барилдлага бүхэн амирласанаар хамаг амьтаны хилэнц түйтгэр зовлон лугаа сэлт цэвэрлэгдэж агшин тэр ямагтад сэтгэлийн үндэсний түйтгэр лүгээ хагацсанаар тэнгэр охин тэнгэрийн чанартай болоод сав шим бүхэн ариун ямагт болсонд сана.

Сүүлийн үгийн утга мэт зориулга ерөөлийг ч дуршил хатуу хүчтэй үйлд.

Бас ад чөтгөр, лус, газрын эзэн мэтийн хорлол ба зоригдол тодорхой арилгах хэрэг буй.

Тахил, сан өргөх, гэмийг наминчилах нугууд үүнд тухайлан зоригдсоноор үйлдэх бөгөөд завсар үүнд хорлогч тэр доод зочидын дотор буйн ерөнхий утгаар тодорхой үйлдээд дээд лам чухаг дээдүүдийн лагшинаас рашааны гэрэл цацрагын



үргэлжлэл гарч түүний оройноос оршин биеийн дотор бүгд дүүрсэнээр хилэнц түйтгэр зовлон бүхэн арилан газрын эзэн лус мэтэд өөрөө бээр газар ухаж чулуу сүйтгэн мод огтолж, ус хямралдуулан сувагласаны гэм бузар тэргүүтэнээр тэдгээрийн бие муудан сүр туяа ба эрхтэн доройтсон төгс эдлэл доройтон үйлдсэн тэргүүтэнг сэргээгээд урьдаас ч хотол чуулган болсоноор барилдлага бүхэн амирласанаар өөрт үлэмжид баясан бишрэх болсон бодол лугаа сэлтээр зуун үсэгт, гурван үр Жанма бурханы тарни тэргүүтэнг алин чадахаар урь. Дуршвал тэр ямагтад зоригдох асарахуй нигүүлсэхүйг хатуу хүчтэй бясалгаад авал орхилгын зоригдолыг шамдан үйлдэх ба номын өглөгийг ч үйлдвэл машид сайн.

Дээд сангийн дашримд хишиг даллага үйлдэхийг хүсвэл зочид ерөнхий ба ялгамжтайд сангийн эзэн эдийн тэнгэрүүдийн биеэс гэрэл цацраг гохын хэлбэртэй дээд доод зүг завсар бүхэнд цацарсанаар сансар нирвааны шим, хишиг бүгдийг өлзийт тэмдэг өлзийт эд хаан төрлийн долоон эрдэнэ очир, хас, гэрлийн дусал тэргүүтэний байдал цасан ширхэг буухчиланг ирүүлсэнээр өвөр бусдын бие төгс эдлэл орон бүгдэд сив сив шингэсэнээр хүч ихтэй болж байдал баясгалантай сүр хүч туяа болсонд бодоод торгот сум тэргүүтэнээр даллан хишиг дуудахын үг алиныг өгүүлж үйлд.

Тэндээс дурдвал зуу үсэгтийг өгүүлж эндүүрэл хүлцлийг хүлцэн үйлдээд Вазрамү хэмээхээр зочидууд өөрийн оронд ажиран үл зоригдохуйгаар тамгал өлзийг өгүүлэхийг хэр зохистойгоор цэцэгийн хурыг өгүүлж үйлд.

Тэр мэт урьд номлосон зоригдолуудыг сэтгэлд үйлдэх ёс тэргүүтэнг ямар хэдийчилэн гарваас сан талбих ямагтаар ч

ахуй үе хийгээд эцсийн хэрэг олонтой бүтэх болох учир их тустай.

Дээд сан түүний хязгаар шүтээний шүлэглэлд  
Алин энэ тэнгэр ламын чуулганууд бүхнийг  
Баясган үйлдэх тахилын үүлэн далай бөгөөд  
Хүн бус бүднэрийн огоот хорт сэтгэлийн  
Халуун энэлгээг арилгагч саран ч мөн  
Төгс оюунтануудын хүслийн тотгор бологч  
Харанхуйн чуулганыг эцэслэгч огторгуйн эрдэнэ (нар) бөгөөд  
Түүнчлэн тийн тонилохуйн эрдэнийн төвд  
Амар хялбар зорчих хөлөг онгоц ч мөн хэмээсэн эдгээр нь үйл  
анхдаачин нарт ойрчилин туслахын тухайд бодлын зэргийн мөн  
чанар төдийг зүрхэнд хуйлаад мэдэхүй амраар өгүүллээ ёс  
үүний тийн агуулга дэлгэрэнгүй бөгөөд нарийвчилсанг миний  
багш Очир баригч Лувсанчойжинямбалсанбуу бээр зохиосон  
сангийн номлол өлзий хутгын зуун үүдийг нээгчээс мэдэж  
үйлдээрэй хэмээн дээд сан өлзийн хурыг буулгагчын  
зоригдолын зэрэг ба мэдэгдэхүүн утга гарын авлага бичиг  
өлзийт бүхэн түгмэл хэмээгдэх энэ нь багш тэнгэрт ялгалгүй  
сүжиг бишрэл төгс бөгөөд үлэмж санаа буянт хөгшин шавь аяга  
тахимлэг Лувсанжанцандаши бээр шамдан дурдитгасанд  
Цоржханбод дуудагдагч Өтгөс Дамцигдорж бээр дээдсийн  
зарлигаас түйвэрлээд их номын хүрээ гандан  
Шадүвчойнхорлинд найруулсаны бичээс нь тахил ч гэцүл  
Дондүвсанбуу бээр үйлдэв.

Үүгээр ч шашин амьтанд огоот цаг бүхэнд тус болох болтугай.

**Гэндэндүвва**

# **Балингийн тайлбар**

**Балингийн зан үйлийн үгийн утгыг  
машид тодруулагч**

**Их нууц хөлгөн дэхь балингийн тийн агуулга**  
**Балингийн зан үйлийн үгийн утгыг**  
**машид тодруулагч**

Их хөлөгний сайн мөрийг үзүүлэгч багш хийгээд  
Шидийн дээдийг соёрхогч дээд сэтгэлийн тэнгэрийн  
чуулганд

Хуурмаггүй авралын орон чухаг дээд гуравт  
Зүрхнээсээ сөгдмүй,энэрлээр авран соёрх

Өөрийн сэтгэлийн дурдлыг сэргээхийн тухайд ба өөр лүгээ хувь сацуу бусдад тусалж үйлдэхийн тухайд балингийн номлол далай мэт буй эрхэм зарлигаас усны дусал төдий нэгийг аваад өгүүлж үйлдье.

Тэр ч өвөр бусад орчлонгоос уйсаад тонилохуйг /гэгээрэх/ чухалчилагч нар үсэг бичих, тахил, өглөг өгөх тэргүүтэн номын арван явдлыг анхааран авахад шамдах хэрэгтэй.

Түүний дотроос бүтээхүй хялбар их туст тахил ба өглөгөөр хураагдсан балингийн заншил үйлдэхэд анханд мэдэх хэрэгтэй үүний агуулгыг номлож үйдлье,

**Үүнээ хоёр буй:**

**Анхан.** Балингийн анхааран авлагад сэтгэл итгэмжилж бишрэл үүсгэхийн тухайд уг гаралыг номлох.

**Хоёр.** Балингийн гарын авлагын зэрэгт бодитой орох ёс.

**Анхан. Балингийн анхааран авлагад итгэмжилж бишрэл үүсгэхийн тухайд уг гарлыг номлох нь:** Балингийн гарын авлага үүнийг зарлиг болон шашдир алианаас нь номолсон бэ? хэмээвэл гурван сав аймаг ба үндэсний дөрвөн аймгаас номолсон байдаг.

Тэр ч Номхотголоос ариун цэврийг сайтар үйлдэн үнэнийг өгүүлж номыг номлохыг номлосон.

Судрын аймгаас тарни мутар өргөхийг номолсон, Илт номоос зочидийн ялгаврыг ангилах аргыг номолсон байдаг.

**Үндэсний дөрвөн аймгаас балингийн гарын авлагыг номолсон ёс нь:** Дээд амгалант, Хэ очир, Нууцын хураангуй тэргүүтнээс тарниар өргөхийг номолсон.

Үндэсний гурван аймаг заримд тарни, мудрагаар өргөхийг номолсон ба заримд дияанаар өргөхийг голлон үзүүлсэн мөн шашдираас ч номолсон бөгөөд Жанрайсиг, Манзүшри, Очирваань тэргүүтэн бодьсадва Махасадва нар болон тэдгээрийг дагасан Сараха, Гонболүдүв тэргүүтэн их бүтээлчидийн зохиосон бүтээлийн аргуудаас Балингийн гарын авлагыг тодорхой номолсон буй.

Тийм учраас зарлиг, шашдир хоёулангаас номолсон ч тогтоол тарни сүр жавхлант цаглашгүй энэ нь бурханы зарлиг бөгөөд тэрийг ч алианаас зарлигласан, даган үзүүлсэн ба адистэдлэсэн зарлиг гураваас анхных мөн.

Тиймээс үүнийг тарни ба бэлэг чанар алинд хурах вэ? гэвэл тарнид хурна.

Тэр ч үйлийн үндэсэд хураад түүний ёсонд угаал ариун цэврийг голлон үйлддэг үүнд ч тэдгээрийг хичээж үйлд.

Тиймээс үүнийг амнаас номолсон зарлиг бол цаг хэзээ номолсон орон алинд номолсон, бодьсад хэнд номолсон, уламжлал ямар мэт буй вэ? гэвэл Сэржа-аан балгад-ад Жүнгааво ном үзэж суух үеэс шөнийн адаг хувьд амнаас нь гал бадарсан аймшигт нэгэн бэрд ирээд чи долоо хоногоос үхнэ.

Миний идээний хувь болно гэсэнд Гааво машид айж ялж төгс нөгчсөн бурхан багшид айлтгасанд бурхан багш бээр тогтоол тарни сүр хүч цаглашгүй балин өргөх арга үүнийг номолсонд Гааво бээр балин өргөсөнд цаг бусын үхлийн аюулаас гэтлээд цаглашгүй эрдэмийг олсон гэдэг.

**Балингийн гарын авлага үүний үндэслэлийн зэрэг нь**  
Жүнгааво бээр Аяга тахимлэг Гаама-д соёрхсон.

Тэрбээр Аяга тахимлэг Дагзэнма-д

Тэрбээр Аяга тахимлэг Нэнама-д

Тэрбээр Архадад

Тэрбээр ёогч Анандвазра-д

Тэрбээр Дорж данба-д

Тэрбээр Сэрлинба-д

Тэрбээр Жово-д

Тэрбээр Гэвш Донба-д

Тэрбээр Бодова-д

Тэрбээр Шарава тэргүүтэнд номолсон. Түүнээс эхлээд өнөөдрийн буяны садан багш нар хүртэл Балингийн гарын авлагын уламжлал тасралтгүй уламжлагдан ирсэн.

**Хоёрдугаарт. Балингийн гарын авлага  
бодитойд орох ёсонд**

Балингийн мөн чанар

Балингийн ялгал

Балингийн магадлах үг

Балинч бодьгал

Балингийн зочидын ялгаа

Балинг талбих цаг

Балингийн эдийг адистэдлэх ёс

Балинг ямар мэт хүртээх ёс

Балинг өргөсөний буяны үндэсийг зориулах ёс нь

Балинд мөрийн анхааран авлагын аньс бүхнийг

бүрдүүлэх

Балингийн тангараг

Балингийн ач тусыг номлох

Эдгээрээр балингийн гарын авлагын мэдлэгийг  
олгуулна.

**Анхан. Балингийн мөн чанар нь**

Гадаад савын ертөнцийн ариун чанар ном / хамаг юмс/-ийн төв болон дотоод шимийн амьтан тийн ариуны өвөрчилөн чанар ухаан бэлгэ билигээр бэлгэдээд орон хоосон чанар ба оронтон бэлгэ билиг хоёр үгүй нь балингийн мөн чанар юм.

### **Хоёрдугаар. Балингийн ялгаа нь:**

Ер нь балинд гадаад балин, дотоод балин, нууц балин, утгын балин, самадын балин, бэлгэдэлийн балин лугаа зургаан зүйл буйгаас үүнд номлогдох нь анхны гадаад балин юм.

### **Гуравдугаарт. Балингийн магадлах үг нь**

Ямар учраас балин хэмээсэн вэ? хэмээвэл балинг төвд хэлнээ Дорма гэдэг.

Сэтгэлд баримтлал шуналгүй талбидаг учир Дор хэмээгээд зочидуудын өмнө түгээдэг учир ма хэмээсэн.

Тэр мэтийг ч Лавон бодма- бээр баримтлалгүй талбидаг учир дор гээд огоот түгээдэгээр ма гэсэн.

### **Дөрөвдүгээрт. Балин ч бодьгал нь**

Гэнэн сахилаас гэлэн сахил хүртэл санваар сайн сахих аваас буян нь бусдаас их хэмээн таалсан байдаг.

Гэргийтэн тэргүүтэн эгэл хүмүүсүүд бээр ч балин талбиж болно гэж зарлигласан.

Тэрийг ч эрхтэн дээд бээр балин шүтээн сахил үгүй ч зочид тус тусын өмнө ямар мэт хүссэнээрээ хувилган чадаад тэр үгүй ч самади тодорхой бөгөөд тарни мудра, зан үйлийн эндүүрэлтгүйгээр адистэдлэж рашаанд урвуулан чадах хэн ч талбиж болох тул тэдгээрт шамдаж үйлд.

### **Тавдугаарт. Балингийн зочидын ялгавар нь**

Балингийн зочидын ялгааг хураавал тахилгын орон болон өглөгийн орон хоёрт хурдаг.



## **Балингийн зочдыг өчүүхэн дэлгэрэнгүй**

### **ялгавал**

Чухаг дээд хүндлэлийн зочид

Цогт итгэл эрдмийн зочид

Зургаан язгуур нигүүлсэхүйн зочид

Ад, тотгор, ер төлөөсний зочид

лугаа дөрөвт ангилдаг.

## **Мөн Балингийн зочдыг дэлгэрэнгүй ялгавал**

Зочидыг арван нэг ангилсанаас

**Анхдугаарт.** Лам, Идам, чухаг дээд гурав, сонсогч өөрөө ялагч бүгдийг хураагаад өргөдөг.

**Хоёрдугаарт.** Урьдын Тас цогцолсон уул тэргүүтэнд бурхан багшийн өмнө заримууд сэтгэл үүсгэж заримууд гэнэн сахил авсанаар аргам /тавиг ус/ тэргүүтэн ариун тахилын эд соёрхож бурханы шашиныг сахихад ам авсан хутагтын газарт оршсон Дагинийн таван аймаг, ертөнцтөний ёсыг барьсанаар амьтны тусыг зохиогч Эсэруа, Хурмаст тэргүүтэн арван сахиусан тэнгэр, Найман их лус, Найман их гариг, Хорин найман од тэргүүтэн болон бас бус Цагаан зүгт илтэд баясагчуудад өргөнө.

**Гуравдугаарт.** Бэрх хатуужил болон санваарт оршсон таван зөн билэг төгс, арвис тарнийг баригч, тахил өглөг үйлдэгч шившлэг хийгч, тус үйлдэн чадагч, ерөөлөөр бүтсэн арш нар ба хүмүүний өглөг тэргүүтэн дээд найман арш нарт өргөнө.

**Дөрөвдүгээрт.** Хамт төрсөн тэнгэр ба Замбала тэргүүтэн эдийн тэнгэрүүдэд өргөнө. Тэр ч буян ихтэй бодьгалд хамт төрсөн тэнгэр нь олон бөгөөд чөтгөр цөөн буй товчилбоос өөрийн буянаас бүтсэн хамт төрсөн тэнгэр хэмээгдэхэд таван тэнгэр байдаг.

Амьдруулагч тэнгэр  
Сахигч тэнгэр  
Аврагч тэнгэр  
Нөхөр тэнгэр  
Заяаны тэнгэр тав болой.

Анхных нь: Орны тэнгэр

Хоёрдугаарх нь: Амины тэнгэр бөгөөд ертөнцтөнд шулам албан тэргүүтэн, Номтонд итгэлт тэнгэрүүд тэргүүтэн болой.

Гуравдугаарх нь: ертөнцтөнд Дайны тэнгэр тэргүүтэн, Номтонд номын сахиус тэргүүн болой.

Дөрөвдүгээрх нь: төлөгч охин тэнгэр бөгөөд биелүгээ сүүдэр мэт хагацалгүй зүрхэн чухал аврагч эм зүг төдийн тэнгэрүүд мөн.

Тавдугаарх нь: Эр тэнгэр бөгөөд ертөнцөд өвөг эцэг номтонд лам багшаас үндэслэсэн заяаны тэнгэр болой.

Тэдгээр тэнгэрүүд нь өөрийн биеийн сүр хүчийг бүтээдэг учир тэдгээрт балин өргөвөл саад арилж санасан бүхэн бүтдэг. Тавдугаарт орших эзэн дэлхийн эзэн орны эзэнүүдэд өргөдөг. Тэр ч орших эзэн нь Албин хаан тэргүүтэн болой.

Дэлхийн эзэн нь төрөлхтөн хурах газар, ном хурах газар, бүхэн баясгалант хүрээнүүдэд нигүүлсэхүй бүхэнд үзэгдэлт оюун хэмээгдэхэд буйд номолсон.

Хот балгадуудад буяны оюун хэмээгдэх ба гэр нэжгээд нэжгээдэд бүхэн үзэгдэлт хэмээгдэх байна гэж номолсон.

Орны эзэн нь ертөнцийг эрхшээсэн бөгөөд зохилдох нөхцлийг бүтээгчид болой.

Зургаадугаарт ягчас нарт өргөх тиймээс тэдгээр нь найман аймгийн дотор хурсан буюу эс хурсан уу? гэвэл хураагаад

найман аймагт нь аль вэ? хэмээвэл тэнгэр чөтгөр даган  
бараадвал

1. Албан
2. Шулам
3. Хаан
4. Мамо
5. Мангас
6. Гариг
7. Му
8. Ягчас нугууд эдгээр нь ертөнцөд алдширсан найман аймагт болой.

Үйлийн үндэсний ёсонд

Тэнгэр

Лус

Ягчас

Үнэр идэштэн

Асура

Огторгуйн гарьд

Миамжи

Хэвлийгээр одогч тэргүүтэн бөгөөд тэдгээр нь ялгамжит  
найман аймагтан гэдэг.

Эдгээр бурханы гэгээнийг болгоосон номын сахиусанд ч  
зохиох нь байдаг мөн бурханыг үзээгүй хорлол үйлдэгч нар ч  
байдаг.

Долоо дугаарт Ад тэнгэр

Наймдугаарт Зургаан язгуур амьтан

Есдүгээрт бэрдүүд

Аравдугаарт ер төлөөсний эзэд

Арван нэгдүгээрт бүднэр нарт үлдэгдлийг өргөх болой.

Үлгэрлэвэл хурим үйлдсэний сүүлд түгээл хувь хүртээх хэрэгтэй мэт болой.

Тэр ч хүндлэлийн зочидд хаанд алба өргөхийн ёсонд зориул.

Эрдмийн зочидуудад өөр лүгээ хувь сацуу нөхөрт зочин үйлдэх ёсонд зориул.

Нигүүлсэхүй зочидуудад хуримын ёсонд зориул

Өр төлөөсний зочидуудад өр нөхөхийн ёсонд зориул

Анхдугаарх. Зочид чухаг дээд хүндлэлийн зочидод тэр мэт зориулсанаар чуулган агуу ихийг төгсгөвөл тэдгээр нигүүлсэхүйгээр аврах болно.

Хоёрдугаар. Зочид цогт итгэл эрдмийн зочидод тэр мэт зориулбал тус бүтээж саадыг сахих болно.

Гуравдугаар. Зочид зургаа язгуур нигүүслийн зочидод тэр мэт зориулбал бусдын тусыг бүтээж их хөлгөнтөн болно.

Дөрөвдүгээрх. Зочид ад, тотгор, өр төлөөсний зочидод тэр мэт зориулбал өш арилж хожим хорлол үйлдэхгүй болно.

### **Зургаадугаарт. Балин талбих цаг нь**

Ловон бадма бээр шинийн найман, хорин хоёр ба дөрвөн болой.

Бас ариун язгуурт итгэлийн балинг өдөр

Дагинас эгч дүүсийн балинг үүрээр

Зургаан язгуур амьтанд балинг хэзээч хамаагүй

Бэрдэд үдэш талбих бөгөөд бэрд нь үдэш гүйдэг болой.

Сараха хийгээд Арьяандэвийн гэгээнээс Замба тивд наран ургах цаг нь өлзийт цаг учир тэр цагт балин өргөвөл буяны чуулган маш их болно гэж зарлигласан.

Жагарсүрүба-ийн гэгээнээс идээний урьд хагасд орших нэгээр талбиваас чуулган ихтэйд зарлигласан.

Жэгомбын гэгээнээс өдрийн хагасаас дээшидэхэд бэрдэд, бярманы язгуур идээ эрэлцэж үдээс хойш оловч үл идэх учир үдээс өмнө талби өдрийн хагас хэтэрсэнээр хөгширөхийг хүртэлэхэд бэрд цасан шуурга шуурах төдий идээ эрэлцдэг учир тэр цагт талбихийг номолсон. өөрийн ёс нь Жаво-гын гэгээнээс үлгэрлэвээс өлсгөлөнг идээг хэзээ өгөвч баясах мэт бэрдэд ч балинг хэзээ ч өгсөн ч чуулган ихтэй хэмээн номолсон тул цаг магадлагаагүй үргэлжид талбих нь чухал.

**Долоодугаарт. Балингийн эд хийгээд балин түүнийг  
адистэдлэх ёс**

1. Балин хийх сав
2. Балингийн уг
3. Балингийн их багын хэмжээ
4. Балинг бэлтгэх арга дөрөв буй

**Анхан. Балин хийх сав нь:** Гавал аяга, төмөр аяга, гялтгар төмөртэй, ам нь хагархай, ёроол нь цоорхой, өчүүхэн, ариун бус нугууд нь болохгүй.

Гавал аяганд нь бага бэрдүүд айх бөгөөд ариун цэвэртэнд нөхөрт үл таалдаг.

Төмөр нь хатуу болон мэсийн уг мөн учир хуяг мэс тэргүүтэнд үзээд бэрдүүд айдаг.

Ам хагархай болон ёроол цоорхой нь өлзий бус сав тул адистэд үл тогтоно. Сав өчүүхэндвэл бэрд тэргүүтэний нүд үл дүүрнэ. Сав ариун бус бол ариун цэвэртэнд хор болдог. Тийм учраас Балингийн савыг таван эрдэнээр үйлд, алт тэргүүтэнээр үйлдэх буюу эсвэл зэс ба шавар тэргүүтэнээр үйлд. Тэр ч их дор хэмжээ магадлаагүй өчүүхэнд нэг балга ус багтах төдийгээс доошгүй сав хэрэгтэй.

Жэгомбын гэгээнээс Балингийн савыг эрдэнээр үйлдэх аваас адистэдлэг хэрэггүй хэмээн номолсон.

Таван эрдэнэ алин вэ? хэмээвэл "Дээд амгалантын сүүлийн үндэс"-ээс хаан мэтийн барилдлага дээдийн таван эрдэнэ нь алт, мөнгө, болор, усан болор, номин эдгээр болой.

Түшмэл мэтийн барилдлага дундын таван эрдэнэ нь шалтгаан амьтнаас гарсан шүр, сувд, зааны соёо, дун, хясаа.

Албат мэтийн барилдлага өчүүхэний таван эрдэнэ нь зэс, төмөр, гууль, хар тугалга хэмээн номолсоноос үүнд нь анхны тав болой.

Зарим нь балингийн савыг дун аяга тэргүүтэн болж байгаа болохоор эвэр аяга, ширэн аяга тэргүүтэн болох уу? гэвэл амьтнаас гаралтай учир болохгүй зааны соёо хэмээн номолсоны учир шалтгаан адил бус.

**Хоёрдугаар. Балингийн уг нь:** Мах, архи, лууван, сонгино, сармис болохгүй бөгөөд тэдгээр нь хурц үнэр төдийгөөр нь ариун зочид зугтдаг.

Тийм учраас гурван цагаан, гурван амттан, гурван үрийн зүйл, гурил, эрдэнэ, элдэв цэцэг, ариун ус нугууд нь балингийн уг болно.

Гурван цагаан нь сүү, тараг, тос

Гурван амттан нь бурам, мөсөн чихэр, зегийн бал болой.

**Гуравдугаарт. Балингийн хэмжээ нь:** Өөрийн чадлаар оюунаар багтах төдий үйлд идээ нь сүмбэр уул төдий ундаа нь далай төдий хувилга.

Барилдлагад өчүүхэндвэл үр долоон мөхлөг ба атга гурил лугаа балга ус төдийд талбиж болохыг номолсон. “Жэгомбын гэгээн”-ээс барилдлага үгүй аваас арвайн гурил үр нэжгээдэд ч талбиж болохыг номолсон. Саванд усгүйгээр хатсанаар тавьж болохгүй бөгөөд бурхан бээр ариун ус лугаа сэлтэйд зарлигласан.ус үгүй аваас хатсан хөрөнгө талбисан адил эс дүүргэх аваас өлсгөлөнтөд үл цатгах идээ өгсөн адил.

Үзүүлэлгүй өгөх аваас байг харалгүй харвах лугаа адил, дохио барилдуулалгүй өгөх аваас заримууд нь олоод заримууд нь хувь тасарна, усаар цэвэрлэснээр хөдөлгөх аваас саад ирж гэм их болно, ёзоорт сав хоосонд үл агуул үүнд ч дүүргэх

хэрэгтэй заримууд асгасан бөгөөд хөндий талбих хэрэгтэй бөгөөд үүнд ч эгээрэх буй тул шамшаагдах бусад номолсон.

Лованбадма бээр балингийн явдал мөр нь асгарсан, цувирсан тэргүүтэн үгүйгээр номолсон нь дотоод балины эрхэнд зохиосон бөгөөд үүнд гадаад балиныг даган бараадсан тул энэ хоёрыг харшуулалгүй мэдэж үйлд бэлтгэсэнээр хоосон зүглүүлж үл агуул.

Жэгомбын гэгээнээс анхан бэлтгэсэн даруй хайш яашгүй нэг нэгэндээ хүрэлцүүлэлгүй үйлд. Муруй далий бэлтгэвэл бэрдийн оюун амаргүй болж бүтээлчийн ч оюун гулзайж ирэхийг зарлигласан.

### **Балинг адистэдлэх ёс**

Балинг бэлтгэсэн даруй адистэдлэгэ үйлдэх хэрэгтэй бөгөөд тэр адил бус аваас бэлтгэсэнээр үл зориулах хүртэл үүнд хүн бусадууд авчихдаг болой. Үүний учир шалтгаан ч Жэгомбын гэгээнээс номын сахиусны балинг оронд хүргэхэд үнэнч их бясалгагч хэрэгтэй ихэнхидээ чөтгөр авахад олон гэж номолсон. Лам Доржданба бээр бэлтгэсэнээр зориулга чөлөө гаргалгүй азнах төдий болсоноор зориулсанаар зочид илтэд гарснаар чиний үүнийг би үл таална бусад бээр идчихсэн хэмээж хэлэв. Тийм учраас балин сэлтийг агуулах цагт ариусгал усыг цацсанаар сахих буюу сахиусан хүрдийг бясалгаснаар агуулж үйлд.



## Тийм учраас Адистэдлэг үйлдэх ёс нь

Аврал одуулах

Сэтгэл үүсгэх

Бурханыг бясалгах

Зочидыг залах

Тогтоол тарни урих

Дөрвөн бурханы алдрыг өгүүлэх

**Анхан. Аврал одуулах нь:** Аврал одуулахын шалтгаан аврал одуулах орон, аврал зохистой ёс аврал одуулах, сургаалд суралцах нугуудыг Бодь мөрийн зэрэг тэргүүтэн бусдаас мэдэх хэрэгтэй. Аврал одуулахад хоёроос нийт хийгээд нийт бус болой.

**Хоёр. Сэтгэл үүсгэх нь:** Шалтгаан үрийн долоон увидас ба өвөр бусдыг арилжихын үүднээс сэтгэл үүсгэх ёсуудыг бусдаас мэдэх хэрэгтэй. Тийм учраас хамаг амьтны тусад бурханыг олж үйлдье. Түүний тухайд балинг талбимуй хэмээх ерөөх сэтгэлийг үүсгээд ерөөхчилөн балинг талбихад орохуй сэтгэлийг үүсгэ.

Хэлээр бурхан ном чуулганы хэмээхийг өгүүл, бас бус асархуй цаглашгүй нь ганц хүүтэй эх мэт, нигүүлсэхүй цаглашгүй эмийн хаан мэт, баясгалант цаглашгүй зохилдонгуй нөхөртэй учирсан мэт, тэгш цаглашгүй нь огторгуйн мэт тэдгээрийг бясалгах ёсыг бусдаас мэдэж үйлдээрэй.

**Гуравдугаарт. Бурханыг бясалгах нь:** Өөрөө Жанрайсэг-д агшинаар босч үйлдэхийн үүднээс бясалга.

**Дөрөв. Зочидыг залах нь:** Хүндлэлийн зочидын эрхэм бурхан Шагжатүвд арван зүгийн бурхан бодь сэтгэлтэн, сонсогч, өөрөө ялагч тэргүүтэн бээр хүрээлсэн эрдмийн зочидын эрхэм Очирвааньд ариун язгуурын далан таван цогт итгэл тэргүүтэн хүрээлсэн, Нигүүлсэхүйн зочидын эрхэм Жанрайсигт зургаан

язгуурын амьтан бээр хүрээлсэн. Өр төлөөсний зочидын эрхэм Цогт Дамдинд тотгорын язгуур наян мянга тэргүүтнээр хүрээлсэнийг залах болой.

**Заллагын үг нь:** “Самадын хааны судар”-аас номлон мөргөмүй түүнчилэн ажирсны зүрхэнээр амьтан бүхэн огоот түгсэн хэмээх тэргүүтэн ба бас бус алин зохистойгоор үйлд.

### **Тэр мэт дөрвөн зочидуудад**

1. Залахад заллагад үл урих аваас үл залрах
2. Залавч үл залрах
3. Заллагад үл болох
4. Эс залавч залрах дөрвөн зүйл зочин байдаг.

**Анхан нь:** Дөрвөн зочидын анхан хоёр бөгөөд заллага эс уриваас үл заларна. Залах аваас их нигүүлсэхүй ба ерөөлийн хүчээр сүжиг бишрэл буй газарт юугаарч залардаг.

**Хоёрдугаарт нь:** Гартаа тэвш баригч, Урт гарт, Уулын үзүүрийг дүүргэсэн, Мөнхөд согтогч нугууд бөгөөд тэдгээрийг залавч залрах үе үгүй.

Тэвш баригч нь сүмбэр уулын үе зэрэг анхан далайн усны завсарт байдаг ордон усаар автагдахаас сэжигдэн үргэлжид тэвшээр усыг шавхах хэрэгтэй учир залрах үе байдаггүй.

Урт гарт нь сүмбэр уул хазайхаас сэжигдэн сүмбэр уулыг тэвэрч суух учир залрах үес үгүй.

Уулын үзүүрийг дүүргэгч нь сүмбэр уулын үзүүрээс дөрвөн тивийн амьтанд дайсан босохоос сэжигдснээр харуулдах харуул үйлддэг учир залрах үе үгүй болой.

Үргэлжид согтуурагч нь хүслийн таван эрдэмд цаг үргэлж согтуурсанаар залрах үе үгүйд зарлигласан.

**Гуравдугаарт нь: Залж болохгүй зочид нь**

1. Их хүчит газрын эзэн
2. Санг сахигч бэрд
3. Газрын эзэн Шрибадра
4. Лүхамван нугууд болой

**Анхан нь:** Сүмбэр уулын доор буй тул түүнийг залвал Очир загалмай хөдөлсөнөөр амьтны оронд газар хөдлөх, хямралдах, сэтгэл амгалангүй элдэв гардаг учир залж болохгүй.

**Хоёрдугаарх нь:** Сангийн хумхыг бусад бээр авчих учир ертөнцөд зуд ирдэг тул залж болохгүй

**Гуравдугаарх нь:** Гартаа өвчиний тулам барьсан тэр ирвэл туламны ам нээгдэж ертөнцөд хүний өвчин, малын өвчин ирэх учир залж болохгүй.

**Дөрөвдүгээрх нь:** Түүнд үзэхэд хор байдаг тул тэр ирвэл лусын элдэв өвчин ирэх тул залж болохгүй.

**Эс залавч залрах зочид нь:** Огторгуйд гүйгч бэрд ба бярманы язгуур ба үнэр идэштэний язгуурууд бөгөөд тэдгээр балинг бэлтгэсэн төдийгөөр үлгэрлэвээс баланд зөгий хурахчилан ирдэг.

**Тавдугаарт. Тогтоол тарни урих нь:** Рашааны уйлгалтын тарни ба гурван үр, агуу их хүч төгс гэрлийн тарниудыг өгүүлж үйлд. Үүний анхнаар цэвэрлээд хойдохоор рашаанд адистэдлэдэг бөгөөд товчилвоос тэдгээрүүдээр ариусгаагүй гэм бүгд болон хир бүгдийг цэвэрлэснээр рашаанд урвуулах, олонд арвижуулах, хэрэгтэй хүссэн бүхэн гарах ба алин хүссэн эгээрлийг олох ба цэнгүүлэн хануулж үйлдэх тэргүүтэнг үйлддэг.

Жэгомбын гэгээнээс гурван үр үсэгийг гурван удаа өгүүлэхийн анханаар гэмийг арилган хоёрдугаархаар сав эрдэнэ болон рашаанд урвуулж гуравдугаархаар олонд аривтгах ба рашаанд урвуулах самади болой. Рашааныг олж үйлдэхэд агуу их хүч төгс гэрлийн тарнийг урь.

Тарни үүнийг орчуулах аваас

Түүнчилэн ажирсанд мөргөмүй

Лагшин зарлиг тааллын рашаанаар

Ертөнцийн орны амьтдууд

Төрөөгүй амгалангын дээд болох болтугай

хэмээхэд зарлигласан.

Лам Дорж данбын таалалд

Ум-аар савын гэмийг цэвэрлэн

Аа-гаар идээний гэмийг цэвэрлэн

Хум-аар усны гэмийг цэвэрлэнэ, мөн

Ум-аар савыг эрдэнэд урвуулж

Аа-гаар зуун амтай идээнд урвуулж

Хум-аар усыг рашаанд урвуулдаг, бас

Ум-аар савыг агуу их аривтган

Аа-гаар сүмбэр уул төдийд аривтга

Хум-аар усыг рашааны далайд урвуулан адистэдлэх есөн хэсэгт таалдаг болой. Ловон Лүдэв бээр ч гурван үр үсгээр балинг адистэдлэдэгт таалдаг, бас

Ум-аар бүрнэрийг эрхэнд хурааж,

Аа-гаар эдүүдийг ариусгах тэргүүтэнг үйлдээд,

Хум-аар зочидуудад түгээн өгөхийг гурван үрээр балины тэрхүү чанарт номолдог хэмээн номолсон бас заримуудад

Ум-лагшиний хөрөнгө мөнөөр өнгөний гэмийг цэвэрлэх

Аа-зарлигийн хөрөнгө мөнөөр дуу болон үнэрийн гэмийг цэвэрлэх

Хум- тааллын хөрөнгө мөнөөр амт хүрэлцэхүйн гэмийг цэвэрлэхийг зарлигласан.

**Зургаадугаарт. Дөрвөн бурханы алдрыг өгүүлэх нь:**

Түүнчилэн ажирсан ялгуусан Олон эрдэнэт дор мөргөмүй  
Түүнчилэн ажирсан Дээд үзэсгэлэнт дүрс дор мөргөмүй  
Түүнчилэн ажирсан Хязгааргүй лагшин дор мөргөмүй  
Түүнчилэн ажирсан Аюул бүхэн лүгээ хагацсанд мөргөмүй хэмээх болой.

Тэдгээрийг танин барихад заримууд Олон эрдэнэтийг, Эрдэнэ гаргагч, Дээд дүрст, сүрүвагын цогын үзэсгэлэнт дүрст хязгааргүй лагшинтыг Гэгээн гэрэлт, Их цаст далай аюулаас хагацсаныг Тус бүтээгч дор таалдаг.

Сажаба- нь Дөрвүүл тэрийг урьд гарсан өнгөрсөн цагийн бурханы дөрвөн алдар болой. Бурхан эрх баялгийн эрдэм ба Жанрайсигийн тогтоолоос Шагжатувад номолсонд таалаад тэрний ухаанаарч зохистойд номолсон.

Жово эцэг хөвгүүн нь Олон эрдэнэт нь Шагжатув

Дээд дүрст нь Жанрайсиг

Хязгааргүй лагшинт нь Манзүшри

Аюулаас хагацагчийг нь Очирвааньд таалдаг.

**Дөрвөн бурханы алдрыг өгүүлсэн ач тус нь:**

**Анханд.** Мөргөсөнөөр бэрд тэргүүтэн олон төрөлхтөн харам тэргүүтэний муу үйлийг дарснаар төгс эдлэл хотол чуулах болно.

**Хоёрдугаарт.** Мөргөсөнөөр бэрд тэргүүтэний муу дүрсийг тэвчснээр дүрс сайн хүч их, бэлэг найрал хотол чуулах болно.

**Гуравдугаарт.** Мөргөсөнөөр бэрд тэргүүтэнээр биеийн халуун өвчнийг дарснаар балинг мэдэх болно.

**Дөрөвдүгээрт.** Бэрд тэргүүтэн занчигдах хөнөөгдөхийн аюул буй тул тэдгээрээс гэтэлсэнээр бэрдийн хорлол амирлах болно.

Заримууд анхных алдрыг өгүүлснээр савыг адистэдлэж хойд гурвыг өгүүлэснээр балинг адистэдлэдэг хэмээдэг.

### **Наймдугаарт. Балинг ямар мэт хүртээх ёс нь**

Бэрд нэжгээд нэжгээдээр ч үр хувь ба рашааны орон магада-ийн жингийн хэмжээ долоо долоог олохыг номолсон. Жингийн хэмжээ нэжгээд нэжгээдэд цагийн хэмжээ алтны жингийн дөрвөн ачаа ба дөрвөн жинд одох тул үүнд тооцвоос бидний найман жин найман ври олохыг номолдог.

### **Бас бус зочидын ялгаварт**

1. Заримууд бэлтгэсэн төдийгөөр олдог
2. Заримууд самади тарни мутра-гаар зориулсанаар олдог
3. Заримууд талбисанаар цэнгэдэг
4. Заримууд сүүлд нь цэнгэдэг.

Анхных нь: Идээний тунгалаг болон үнэрээр цэнгэхийн язгуурт олон буй тул тэдгээрт зориулах хэрэг буй. Бас бус "Үндэс"-ээс тэнгэрийн зоог болон зул тэргүүтэний үзүүр болон дунд ёзоор тэргүүтэнг идэгч тэргүүтэнд байхыг номолсон тул ариутгалын усыг цацсанаар сахих тэргүүтэнг үйлд. Тэдгээр нь бэлтгэсэнээр цэнгэдэг.

Хоёрдугаарт нь: Зориулсанаар цэнгэдэг зочид ихэнх мөн талбисанаар цэнгэх нь орхих угаас буухыг иддэг тул бэрдийн үүд ёзоорын боол буюу нохой мэт буй.

Гуравдугаарт нь: Талбисаны сүүл үүнийг хагацахад эгээрэх нь сүүлд цэнгэх болой. Тийм учраас балинг ариун газар ширээлэг өндөрлөг газрын дээр талбиснаар түрхэх нэгийг агуулах тэрийг талбиснаар цэнгэхэд таалсан болой.

Дөрөвдүгээрт нь: Балинг гэрээс авснаар тэр даруй нохой тэргүүтэнд өгөх аваас сүүлээр цэнгэхийн хувь тасрах бөгөөд

нохой бээр идчихвэл нохойны соёо буй тул бүднэр орхисоны угаас идээ нүгүүдийг үл олдог.

Тийм учраас ариун газарт цогцлоосоноор хүн нохойноос бүхэл сахиснаар сүүлд гуйлагчин болон нохой тэргүүтэнд өгөх аваас чуулган ихтэй бөгөөд бодьтойгоор дүрст нугууд цэнгэдэг.

Ланританби гэгээнээс тэнгэрийн зоог болон зоог нь тахилын дотроос чуулган ихтэй бөгөөд хүсэлт тэнгэр тэргүүтэнд өргөсөнөөр баясаад тэндээс амьтанд өгвөл амьтад баясанаар хоёр удаа тахил ирдэгт номолсон.



**Есдүгээрт. Балинг өргөсөний буян үндэсийг  
зориулах ёс нь**

Заримууд анханд би хийгээд зочдын буяны үндэс үнэнд бүтсэнээр үйлдээд сүүлд эдгээрийг үнэн үгүйд харвал болохгүй бөгөөд нэг удаа үнэнд бүтсэн аваас цаг хэзээ ч хааж чадахгүй. “Үндсэн билиг”-ээс Өвөрчилөн бусад болох нь хэзээ ч буцаж үл чадах болой хэмээн номолсон. Өөрийн ёс нь хоёр үнэнийг хослон барилдуулж анхааран авах хэрэгтэй тул янагуухад анхан бэлтгэсэнээ эцэст ерөөх хүртэл барилдлага бодит сүүл гурвыг холилдуулахгүй тодорхойд үйлдэх нэг ба үнэмлэхүйд гурван нөхрийг үнэнд үл зоригдохын билигээр эзлэгдэх нэг хэрэгтэй.

“Судрын хураангуй”-гаас

Билигийн чанад хүрэх үл зохилдох

Бодийн сэтгэл үл зоригдох хэмээн номолсон

Үл зоригдохын утга ч илбийн морь үхэр буюу толин доторх царай дүрс мэт тодорхойд үл зоригдох болой.

Тийм учраас зориулага үйлдэх, зориулагч тэргүүтэн үнэнд үл зоригдохын үүднээс бурханыг тахиx ба амьтны тусад зориулах бөгөөд миний санааны хүч ба хэмээх тэргүүтэн ерөөл асар ариуныг талбиж үйлдээд өглөг морь адилаар ерөөл хазаар адилаар ямар мэт ерөөсөн мэт арвидан одохыг номолсон.

**Аравдугаарт. Балин үүнд мөрийн аньс бүхнийг**

**бүрдүүлэн үзүүлэх нь**

Балин үүнд мөрийн аньс бүхэн бүрдсэн бөгөөд зургаан барамэд, хураахуй бодит дөрөв, гурван санваар тэргүүтэн бүрдсэн болой.

**Анхан. Зургаан барамэд бүрдсэн нь:** Бодыг талбисанаар өглөг

Ариун цэвэр лүгээ төгс ба хорлол хөнөөлийг тэвчих нь  
шагшаабад

Амьтанд хорлол үл үйлдэх, хөнөөхийг тэвчих бөгөөд  
бэрхийг даан авах нь тэсвэр

Талбихад турших бөгөөд залхуу үгүйгээр хичээл

Талбих цагт сэтгэл бусдад үл алгасарах нь самади

Зан үйл тэргүүтэн алдаа эндүүрэлгүй, бөгөөд гурван нөхөр огоот ариунд онодогоор билиг бүрддэг.

**Хоёрдугаарх. Хураахуй бодит дөрөв бүрдсэн нь:** Зочид тус тусад зорисоноор өглөг, зочид тус тусыг магтсанаар яруу өгүүлэх, хүссэн хэрэгт залбирдагаар тусыг эдлэх, гурван нөхөр тус тусад огоот ариунд зориулсанаар утга зохиолдох бүрддэг.

**Гуравдугаарх. Гурван санваар бүрдэх нь:** Балинг талбих цагт ариун цэвэр лугаа барилдан амьтанд хорлол хөнөөл тэргүүтэн

Нүгэлийг тэвчдэгээр ангид тониллогчын санваар

Бусдын тусад талбидагаар бодьсэтгэлийн санваар

Бурханыг бясалган тарни урьснаар нууц тарнийн

санваар бүрддэг.

Тийм учраас балинд их хөлөгний гүн болон агуу их мөр нийт ба нийт бус хоёул төгс бүрдсэн учир их хөлөгний бодийн

тусыг чухалчлагч бодьгалууд бээр хялбар номд тооцон  
үйлдэлгүй балинг талбихад шамдаж үйлд.

### **Арваннэгдүгээрт. Балингийн тангараг нь**

Анхааран авлагын тангараг нь хагархай үгүй  
Савын тангараг нь  
Хагархай үгүй бөгөөд ариун цэвэр лугаа төгс  
Шалтгааны тангараг нь  
Доройтсон сэвтсэн үгүй бөгөөд хирээр үл халдаагдах  
тэргүүтэн

Бэлтгэх тангараг нь  
Ширээ төгс бөгөөд үл хөдөлсөн тэргүүтэн  
Адистэдлэсэн тангараг нь  
Самади тодорхой бөгөөд үл алгасарах тэргүүтэн  
Талбих тангараг нь  
Ариун газарт хүргэн балингийн савыг зайлах тэргүүтэнд  
шамдаж үйлд.

Үл хагалах чухлын учир шалтгаан нь Нарова бээр нэг удаа балин хагалсанд зүүдэнд бид нарын бали тасарлаа хэмээн олонтой хэлсэн.

Зоригдол чухлын шалтгаан Нэдар тарничин нэг бээр балинг тасралтгүй талбисанаас нэг өдөр тус эдлэхэд одооноор хүрэлгүй Жомо дээр цаг үүнд бэлтгэн талбисанд тоо гүйцэвч зоригдолгүйн хүчээр балин үүнийг талбих ёсыг урьд лугаа адил ч идээ өчүүхэндлээ хэмээсэн.

Бас бус егүзэр бээр амирлангуй балинг сард үл хаяхыг хаявал аминд хорлолтой Дэлгэрэнгүй ба эрхийн балинг өнө холд эс хүргэхийг хүргэвэл шид бусдад хүлэгдэнэ.  
Мөрд оршиход саадыг арилгах балинг одох зүгт талби, зүг буруудваас хожим туулшрах шалтгаантай.

Үхлийг хуурах өр төлөөсний балинг талбих ба хатуу тотгор арилгах балинг алс хол хая ойр ёзоорт агуулбал нөхөрт хорлолтой

Догшин тотгорыг гэтэлгэгч балинг сор болгож хая хэмээн зарлигдсан.

“Ловон Бадма”-гийн гэгээнээс бүтээлчин Нянба үйлдэх цагт бүтээлийг гаргалгүй балины тэвшийг үл угаах нь номын сахиус хурах хэрэг буй балин талбих үед савыг үл хөдөлгөх аваас зочидууд үл авч чадна. Тийм учраас егүзэрва нугууд бээр балингийн тангараг нугуудын зоригдолыг ялган үйлдсэнээр ёсчлон сахихад шамдах хэрэгтэй бөгөөд эс сахиваас гэм эргүү маш их.

Ловон Бадма бээр балинг эс адистэдлэх аваас хутагтын зарлиг тасрах бөгөөд юунд ч тус үгүй.

Балинг эс үзүүлэх аваас егүзэрва бээр юуч бүтээж

чадахгүй

Балины зориулга буруудвал зориулагч бузардах болно

Балин эс барилдах аваас егүзэрва бээр уулын хярын бэрд

болж төрнө

Балины шалтгааныг эс бүрдүүлвээс Балингийн зочид үл

бүрдэнэ

Тэр эс бүрдэх аваас талбивч үр үл гарна

Балингийн эдийг танин эс мэдвээс егүзэрт тэнгэрийн цааз

ирнэ

Балингийн дээж доройтвол егүзэрт зарлигийн сахиуснуудын

цааз ирнэ

Зан үйлийн гол эс төвшидвөөс үйлийн түйтгэр болно

Тарни болон мудра эндүүрэгдвэл язгуур тасарсан бодьгал

болж төрнө

хэмээн номолсон тул аньс эдгээрийг хянамгайлж үйлдээрэй.

**Арванхоёрдугаарт. Балинг талбисаны  
ач тусыг үзүүлэх нь:**

**Анхдугаарх нь Үйлс бүгдийн урьд одуулах бөгөөд эс гүйцсэний нэмэрлэг болох нь:** Балин нь үйлс бүгдийн урьд одно. Ловон бадма бээр Балин нь үйл бүхний дээд үйлүүдийн урьд одно хэмээн номолсон мэт өвчин адыг амирлуулах, нас төгс эдлэл дэлгэрүүлэх, үл зохилдох зүгээс гэтэлж эрхэнд хураах, дайсан тогторыг гэтэлгэх тэргүүтэнд балин хэрэгтэй.

**Хоёрдугаарт. Үйлс эс бүрдсэний нэмэрлэгт болох нь:** Хангал сэргээлгэ бүгдэд балин шүтэх хэрэгтэй.

**Гуравдугаарт. Насыг уртасгах саадыг арилгах нь:** Балинаар насыг уртасгах бөгөөд тогтоох үүний анхан Жүнгоованы үхлийг хуурч насыг уртасгахын тусад номолсон.

Гэйдор-аас тогтор болон бурууд удирдсанаас амьтдын амыг сахихын тухайд Очир баригч бээр балинг талбидаг хэмээн номолсон. Бас Егээр Гүнданраба хэмээгдэх нэгэн балин талбих цагт хүн бус нарийн олон аялгуу үйлдэн инээдэм үйлдэж байсанд хожим эдгээрүүд хураад уйлсанд та нар юунд уйлав хэмээсэнд чи долоон хоногоос үхэх тул бид нарт балин өгөөчин байхгүйгээр уйлав гэсэнд үүнд арга үгүй юу гэсэнд тэд нар өгүүлрүүн арга буй бүхүй бүгдийг үзэгтүн бид нар далайн захад их эм хэмээгдэх мөнгөн ус буй тул авсанаар адистэдлэсэнээр үүний шимийг авах тун нас чинь арвидах болой хэмээсэнд Егүзэрва бээр эдийн бод буйг бүрэлдүүлэн талбисанаар нас арвидсанаар зуун жил наслав хэмээсэн.

Жэгомбын гэгээний наян жил насалсан нь балины адистэд мөнд номолсон. Балинд хичээсэн гэвш бээр нас

богиносч чилээрхсэнд насны бүтээлийн дээд ч балин мөнд зарлигласан .

**Дөрөвдүгээрт. Балинаар зэтгэрийг арилгах ёс нь:** Балинаар дөрвөн шуламсын зэтгэрийг арилгах бөгөөд талбих цагт сэтгэл үүсгэх тэргүүтэн сайн санаагаар нисваанасын шуламыг дардаг. Халуун өвчин болон зэтгэрийг арилгаж чаддагаар цогцосын шуламыг дардаг.нас амийг арвитган чаддагаар үхлийн эзний шуламыг дарж чаддаг.

Балинаар өвчинг арилгаж чадахын учир шалтгаан нь Балинг рашаанд адистэдлэсэнээр тэр өвчний ерөндөг болдог. өлсөж цангахын өвчинг арилгадаг тул бие чадалт болоод өвчин цөөрдөг.

Ихэнхи өвчин адаар үүсдэг тул ад балинаар цэнгэх болон өвчин буян бусаас гарсныг балинаар муу үйлийг цэвэрлэх тул өвчин арилдаг хэмээн номолдог. Тийм учраас зэтгэрийг арилгахын дээд нь ч балин болой.

**Тавдугаарт. Балинаар царай туяа лугаа төгс болох нь:** Бэрд тэргүүтэн нь туяаг доройтуулдаг бөгөөд балин өгвөл туяа өнгийг их болгодог ба хамт төрсөн тэнгэр тэргүүтэн балинаар баясан үйлдсэнээр биед сүр хүч туяа бүрддэг.

**Зургаадугаарт. Төгс эдлэл арвидах нь:** Үүгээр төгс эдлэл арвитгах бөгөөд мөн балиныг гурван бум өргөвөл төгс эдлэл барагдашгүй хүрдэн эргүүлэгч хаан мэт ба Эсэрва тэнгэр тэргүүтэний төгс эдлэл лугаа төгс болно. Тийм учраас эдийг бүтээхийн дээд нь ч энэ мөн болой.

**Долоодугаарт. Сүр хүч ихдэх нь:** Балинаар их сүр хүч төгс болох бөгөөд номын сахиус хүн бус их сүртүүд балинаар эрхэнд хурснаар тэдгээр бээр егүзэрийн биед сүр хүчийг чухалчлан бүтээдэг.

**Наймдугаарт. Их хүчирхэгжих нь:** Түүний хүч чадал төгс болох бөгөөд балин нь номын сахиусыг баясгахын дээд мөн ба хүн бусууд чухалчилан ойртдог тул үйл алин даатгасныг сонсдог болой.

**Есдүгээрт. Хүн бусыг эрхэнд хураах нь:** Балин үүгээр тэдгээр эрхэнд хурах бөгөөд балин нь арван хоёр бээрээс нааших хүн бусуудыг эрхэнд хураадаг хэмээн залбирсан байдаг.

**Аравдугаарт. Юу санасан бүхэн бүтэх нь:** Балин үүгээр юу санасан бүхэн бүтэх бөгөөд номын сахиус, бярман, арш хамт төрсөн тэнгэр тэргүүтэн балин үүгээр баяссанаар сэтгэлд алин хүссэнийг бүтээдэг. Тийм учраас балинг тасралтгүй өргөвөл нарийн хүн бусууд ч зарим хэсэг шидийг өгдөг.

**Арваннэгдүгээрт. Ахуйн үес сайн заяаг олох нь:** Балин үүгээр тэнгэр хүмүүний хутагтыг олох бөгөөд “тогтоол”-оос бэрдийн орныг тэвчээд өндөр язгуурын оронд төрдөг хэмээн тэнгэрт төрхийг бодитой үзүүлсэн тул хүн болж төрөхийг дашрамд үзүүлсэн.

**Арванхоёрдугаарт. Бурханы хутгыг олох ач тус нь:** Үүгээр бурханы хутгыг олох бөгөөд орон асар ариун лам чухаг дээд гурав тэргүүтэнд боди тийн ариунаар тахих бөгөөд тахилын үүлэн цогцыг рашаан болгож өргөснөөр өглөгийн барамэд тэргүүтэн буяны чуулган төгс ч өглөгийн барамэд тэргүүтэн буяны чуулган төгсөөд гурван нөхөр тийн ариунаар эзлэгдэн билэгийн барамэд тэргүүтэн бэлгэ билгийн чуулган төгсөх болоод түүнд шүтсэнээр хоёр түйтгэрийг баран тэвчээд дээр үгүй бодийг түргэнээ олох болно.

Ахуй үес, эцсийн амгалангийн үрийг соёрхогч

Үг цөөн утга тодорхой балингийн тийн агуулга үүнийг



Дээдсийн зарлигчлин бичсэнийг  
Өвөр бусдын тусад зориулмуй  
Буян үүгээр өвөр бусад амьтан бүхэн  
Их хөлөгний буян саданаар дагуулан эзлэгдээд  
Арван номын явдлын эцэст хүрээд  
Ялгуусны хутгыг түргэнээ олох болтугай

## Номыг тэтгэгч сахиусануудын балингийн зан үйлд чухал хэрэгтэй увдис, зоригдолын зэрэг

### Сав бус дор үзүүлэлгүй маш нууцал

Номыг тэтгэгч сахиусануудын балингийн зан үйлд чухал  
хэрэгтэй увдис, зоригдолын зэрэг

Очирдарь лугаа ялгалгүй

Дээдэс багшийн өлмийд сөгдөн

Бэлгэ билэгийн итгэл тэргүүтэний

Балингийн зан үйл зоригдолын зэрэг заримуудыг  
бичье.

Аврал бүхэн хурсан лам тэнгэр

Би тэргүүтэний үндсэнд Нигүүлсэхүй ба

Үзэгдэл бүхэн илбэ адилын ном бүхний

Мөн чанар амгалан хоосныг ургуулахад

адистэдлэ

Ном хамаг юмс бүхэн өвөрчилэнгээр бүтсэн тоосон  
олсон ч өвөрчилэн үгүйдээ ялгаагүй гадаад дотоод номууд их  
амгалангийн цэнгэлд ургасан бүхэнийг бурханд тодруулсанаар  
эгэлийн үзэгдэл шуналыг хорихыг хичээвэл үүсгэлийн зэргийн  
зүрхэнд номлосоноор суралц.

Номыг тэтгэгч сахиусны бүтээлийн арга ерөнхийн  
зоригдолын зэргийг өөр өөрийн гол номлолчилон үйлдэе.

Адистэдлэлийг буулгах үесийн зоригдол нь өөрийг лам  
Идам бурханы омог тодорхой үзэгдэл баттайгаар хөгжмийн  
дуу эгшигийг хоосон чанарын дуунд бодоод хатуу хүчтэй  
залбирсанаар номын төв хязгааргүйн орон бүхэн дүүрсэний  
багш чухаг дээдээр таалал үндэс дурдитгаад тэдгээрээс  
лагшин нь их бага цаглашгүй ба зарлигийн эгшиг, гийгүүлэгч  
тэргүүтэн өөрийн дууг дуурсгахчилан ба таалал мутрын барьц

байдал цаглашгүй, зун их хур буухчилэн заларч сүм ба лагшин зарлиг таалалын шүтээн эд эдлэл нөхдийн чуулган ба өөрийн бие хэл сэтгэл үндсэнд сив сив шингэсэнээр бэлгэ билигийн их адистэдлэл буусанд бод.

**Тахил өргөх үеийн зоригдол нь:** Тахилын орон лагшинаас гэрэл цацраг ба рашааны үргэлжлэл гарч өөрийн үндсийг адистэдлэн лагшин, зарлиг, таалал, эрдэм, үйлс сэлтийн адистэд оршсонд бод.

**Наминчилгын үеийн зоригдол нь:** Идам, Номыг тэтгэгч нөхөр сэлтийн зүрхний хум үсэгээс рашааны үргэлжлэл цагаанд улаан туяа тогтон бууж тус тусын лагшин биеийн дотор дүүрсэнээр тааллыг эс баясган, хилэгнэсэн тэргүүтэн амирласанаар би хийгээд өглөгийн эзэнд баясан нигүүлсэхийн лагшинхувиас гэрэл цацраг рашааны гэрэл цацраг цацарч би тэргүүтэний бие бүхэн түгэн дүүрсэнээр өвчин, ад хилэнц түйтгэр, хилэгнэл ба тангараг доройтон эвдэрсэн бүгдийн нарны гэрэл цацраг ургасанаар харанхуй өөрөө арилан одох мэт агшинаа ариусан цэвэрлэгдэн их амгалангын бэлгэ билигтөрсөнд бод.

**Хангал сэргээлгийн үеийн зоригдол нь:** Өөрийн зүрхний хөрөнгөөс таван зүйл гэрэл цацарсаны үзүүрт тангаргын эд гадаад дотоод нууц бээр үүлэн цогцос сэтгэшгүй цацран номын сахиус нөхөр сэлтийн биеийн гадна дотно бүгд түгэн гэрэл цацраг тэр зүрхний хөрөнгөнд шингэсэнээр таалал үндсэнд цувиралтгүй амгалангаар баясан цэнгэн мишгэлзэнгүй туяа төгс өөрөө бээр эрхэнд хуран үйлдсэнээр амин даатгасан үйлсийг хоцролгүй одоо торолтгүй бүтээхүйд бод.

**Сануулга болон хариулга тэргүүтэний үесд:** Өөрөө бурханд тодорсоны зүрхнээс гэрэл цацраг улбар хар халуун ширүүн сүржигнэн шуугих дуу лугаа сэлт цацарч өмнө номыг тэтгэгч нөхөр сэлтийн зүрхний хөрөнгөд туссанаар язгуур үндэсний багш бүгдийн өмнө ам авч тангарагласанг даган дурдсанаар тус тусын лагшинаас өөр адилын зардасын чуулган догшин ширүүн огторгуйн ороноо түгмэл цацарч шашин хийгээд егүзэрт уригнасан дайсан тотгор ерөнхий ба ялгамжит бүхэн өөрийн эрхгүй агшинаа ирүүлж өмнө улайдсан төмөр тэсдэшгүй бадрангуй хайрцаг дотор оруулаад тэдгээртмэсийн хур буун мах цус яс дотор бүгдийг хэсэглэн хэрчиж номыг тэтгэгч нөхөр сэлт хамгаалахуйд залбирсанаар дайсан тотгор тэдгээрүүдийн муу санаа ширүүн барилдлага хилэнц түйтгэр бүхэн номын төвийн агаарт шингэсэнд бодоод амгалан хоосоны агаарт агуул.

Мөн зарлиг үед бурхадын чуулгануудаас гэрэл цацраг цацарч мэс, галын цогцос их салхаи бээр шашны дайсан тэргүүтэн хортонго хэрчин шатаан цацсанаар хилэнц түйтгэрийг цэвэрлэн зэтгэрлэгчийн эрхэм нь мунхаг үйл нисваанисыг гэрлийн галаар шатаахыг бодох нь ч догшин зоригдол оньс зөөлөн ихтэйд зарлиглан мөн зарим үед гэрэл цацрагын үзүүрээс хөгжмийн чуулган цацран догшин дуугаар дайсан тотгорын эрхтэн доройтсон ба мэсийн чуулган цацарч гурван үүд ба есөн нүхэнд энэлгээ гэтэлсэнд бод.

Алга таших үед шулам дайсан тэргүүтэнг далайн чанад захад хөөх буюу огторгуйд шингэсэнээр замхарсанд бод.

Тэдгээрийн үесд шалтгааны бүхэн өдөөгдөх дайсан саданы эрхэм болсон амьтаны зовлонг санасанаар нигүүлсэхүйг үүсгэ.

Тэдгээр бүгд өөрийн хүчийн саадыг буцааж үл чадах тул би бээр зэтгэрийг буцааж үйлдэе хэмээх ба цогын бүхэн өдөөгдөх учир шалтгаан үүгээр үнэнд баримтлах дүрс ургасан дайсан тотгорыг үлэмжид хилэнт аймшигт оюуны чадал эрчим лугаа төгс нь чухал ба бас би бээр бусдын тусад бодийг бүтээж үйлдэе тиймийн учир өөрт зовлон хорлол юу гаравч тэсвэрлэлгүй хэмээх айх сэжиггүй чин бат сэтгэлийг бат бат барьж үйлд.

Урилгын үесд амирлангуй дэлгэр тэргүүтэн үйл үйлдвэр алин бүтээх энэ ба түүний зоригдолын зэргийг өөр өөрийн гол номлолоос гарсанчилэн үйлд.

Товчилбоос зөөлөн гурван зоригдол нь энэ ба түүний хөрөнгөөс цагаан гэрэл цацрагын чуулган цацарсанаар би хийгээд хамаг амьтны хилэнц түйтгэрийг ариусан шидийг соёрхож үйлс бүгдийг бүтээсэнд бод.

Шар гэрэл цацрагын чуулган цацарсанаар нас буян машид дэлгэрэн хүссэн хэрэг хур адил буусанд бод.

Улаан гэрэл цацрагын чуулган цацарсанаар цагаан зүгийн амьтад ба хар зүгийн дайсан тотгорууд эрхэнд хурч өмнө сөгдөх лүгээ сэлтээр оршсонд бод.

**Урилгын сүүлийн зуун үсэгтийн үеийн зоригдолын зэрэг нь:** Язгуурын эзэнт зүрхний хум үсэгийн гадуур оршсон зуун үсэгт ба лагшинаас рашаан гэрэл цацраг сэлтийн үргэлжлэл буун өөрийн бие дүүрч илүүдсэн тасарсан гэм бүгд ариусан урилгын гэм амирласанд бод.

**Балин өргөх үеийн зоригдолын зэрэг нь:** Багш, бурхан, номын сахиус баясан төгс эдлэл таалал их амгалан дэлгэрсэний агаараас гэрэл таван зүйл рашааны цацран өвөр бусад бүхэнд туссанаар дөрвөн үйлийн шидийг олох хийгээд тэдгээр багш тэнгэр сахиуснаас хонх очир тэргүүтэн мутрын

барьц ба эвам тэргүүтэн тогтоол тарнийн үсэг цаглашгүй гар ч өөрт шингэсэнээр тэдгээрүүд ямар мэт илт зохиосон тэвчил онол юүлэгдэхчилэн болсоноор тотгор ба бүднэр, шулмасын ялгуураад чадагдахгүй бат нотыг олсонд бод.

Шидийн эд (зай) үүдийг бэлтгэсэн байвал өөрийн зүрхнээс гэрэл цацраг цацар ч өмнө үүсгэсэн бурхадын чуулганд туссанаар таалал үндэсийг дурдитган тэдгээрийн зүрхнээс цаглашгүй гэрэл цацар ч ялгуусан хөвгүүн сэлтийн адистэд ба хүч чадлыг бурхан, тарни мутрын барьцын байдалтай ба дөрвөн махбодын шим, тэнгэр хүмүүний нас буян тэргүүтэн сансар нирваан бүгдийн эрдэм бүхэн рашаан, өлзийт тэмдэг өлзийтэд тэргүүтэний байдалтай ирүүлж эдүүдэд шингэн хүч төгс болсонд бодоод гурван үр үсэгийг урьж төгс эдэлсэнээр урт нас, өвчин үгүй саад амирлан дээд доод шидийг олсонд бод.

**Өлзий өгүүлэх үеийн зоригдолын зэрэг нь:** Түгээмэл огторгуйн бурхадууд баяссанаар цэцгийн хур буулган өлзийн аялгуу эгшигүүд хөгжимийн дуу лугаа сэлтийг дуурсгасанаар нас буян тэргүүтэн өлзий сайн буян агуу их гарч сайн чуулган бүгд шинийн саран, зуны далай мэт дэлгэрсэнд бодоод огторгуйд оршсон бурхадууд баясан гэрлийн байдалтайгаар өөрт шингэсэнд бод.

Чихний үндэслэлийн увдусаас ирсэн нууцаас ихэд нууц гүн увдис эдгээрийг нь сав бус нугуудаас нууж үйлд.

Хэмээгдэх энэ нь: Халхын цог төгс үр төгс Дашичойнпэл дацангын сурагчидад туслах сэлтээр багш дээдсүүдийн увдусаас гарсан мэт Шадвийдорж нэрт бээр шороон эр морин жилийн мичэд од сарын хорин есөнд жигдэлсэний бичээч нь Содномванчир бээр бээр үйлдэв.

Үүгээр ч шашин амьтан бүхэнд туслах болтугай.

Наминчилгын эхэнд зуун үсэгтийн үесд бузарыг арилгах зоригдол нь өөрийн зүрхний хөрөнгөөс гарсан цагаан гэрэл цацрагын үзүүрт тахилын охин тэнгэр тахилын эд элдвийг барин цацраад гурван очирын бурхадын чуулганд тахил өргөсөнөөр баясгаад лагшин очирын зүрхнээс цагаан зуун үсэгт гараад өөрөө ба итгэлийн оройны судлан хүрдний төвд байгуулагдсанаас цагаан рашаан цаглашгүй цаглашгүй буугаад өөрийн бие дүүрсэнээр хилэнц түйтгэр ерөнхий ба ялгамжтайд итгэл эрхэм нөхөрүүдийн лагшины тангараг доройтон эвдэрсэн бүхэн цэвэрлэгдсэнд бод.

Түүнчилэн зарлиг очирын бурхадын чуулгануудын зүрхнээс улаан зуун үсэгт гараад өөрөө ба итгэлийн хоолойн судлан хүрдэний төвд байгуулагдсанаас улаан рашаан гараад өөрийн бие дүүрч зарлигын тангараг доройтон ариуссанд бод.

Түүнчилэн таалал очирын бурхадын чуулгануудын зүрхнээс хөх зуун үсэгт гараад өөрөө ба итгэлийн зүрхний судлан хүрдэний төвд байгуулагдсанаас хөх рашаан гараад өөрийн бие дүүрч хилэнц түйтгэр ерөнхий ба ялгамжтайд таалалын тангараг доройтон эвдэрсэн нь ариуссанд бод.

Итгэл эрхэм нөхөрийн лагшин бие дүүрсэнээр өөрт үл баясах ба хилэгнэсэн бүхэн ариусаад машид баяссанд санах нь магад аньс ихтэй увдис энэ лугаа төгс бусд наминчилахын үгийг өгүүлэвч бэлгэ билигийн итгэлийн өмнө дэмий өгүүлсэнд барагдаж наминчилсанд үл болно.

Ерөнхий хангал сэргээлгэ-д гадаад дотоод нууц хангал сэргээлгэ олонтой байгаагаас тангараг доройтон эвдэрсэнийг сэргээх нь хангал сэргээлгийн дээд юм.

Хангал сэргээлгэ хэмээгдэхийн сэргээлгэ нь тахилын оронууд өөрт үл баясахын хувийг сэргээх юм.

Хангал хэмээгдэх нь өөрт таалал баясгахыг бүтээгч мөн учир бид нарын тангараг доройтон эвдэрсэнийг сэргээх аваас бэлгэ билигийн сахиусан бүгд баясаад шидийг соёрхох нь эргэлзээгүй юм.

Бусдадаа хатсан гурил, эсгэлэн архи тэргүүтэнээр нэрийдсэн идээ мэтийг бэлтгээд тангарагаа гээн орхивол таалалыг хангалаа хэмээн хэр төдий өгүүлж болно уу?

Хангал сэргээлгэ ч бэлгэ чанартай үл болоод бэлгэ билигийн сахиусан ялгамжтадууд өлсөх цангахыг эс эрхшээсэн бөгөөд тангарагыг даган одох буцахыг үйлддэг болой.



Лувсанцүлтэмжамц

# **Мандалын тайлбар**

**Хязгааргүй буяны чуулганыг хураагч  
гайхамшигт сэтгэлчилэнгийн гох**

## Мандалын тайлбар

Хязгааргүй буяны чуулганыг хураагч гайхмашигт  
сэтгэлчилингийн гох

Хязгааргүй ялгуусан хийгээд ялгуугсадын хөвгүүд  
бүхний эрдэмийн цогцийн их сан  
Таны нигүүсэл тааллын цор илтэд увдисласан сайн  
зохиолоор

Хязгааргүй амьтныг хоцролгүй тус амгалангын сайн мөр  
дээдийг үзүүлэгч

Та ямагт шидийг бодитой соёрхогч хэмээн гурван ачлал  
төгс багшийг зүрхнээс дурдая.

Дээд асрал нигүүслийн сэтгэл үүсгэсэний их далайд  
бусадын тусад гурван зүйл номын хүрдэн хүсэлийг хангагчаар  
амьтан бүхний үйл нисваанисын доройтлыг арилган зохиогч  
чадагчыг эрхэт санасаныг арвитгагч эрхэт хааныг оройгоор  
шүтмүй.

Шинжлэх айлдал адилтгашгүйн салхиар  
Найман түм дөрвөн мянган занданы цэцэрлэгийг  
хөдөлгөж

Тааллын тайлбар сайн номлолын сайхан үнэрийг  
түгээхэд мэргэн

Энэтхэг, Төвд, Монголын бандида, бүтээлчийн чуулганд  
юугаар ч хүн ба орны эрхэм гурван ачлал төгс эрхэм багшид  
орон бүхний тахилийн чуулган лугаа сэлтийн орон дэлхийн  
далайн мандалд шүтсэнээр ариун оронд барилдсан анхааран  
авлагыг номлож үйлдэе.

Тэрийг ийн хэмээрүүн:

“Агуу их цэнгэлт”-ээс буяны тийн боловсрол нь амгаланг өгч зовлон бүхэнг арилгана. Буян төгс хүний санаа хурдан бүтдэг хэмээн номолсон мэт бид нарын дээр боловсрох шалтгаан буй нь тийн боловсрол бөгөөд түүнд ч буяны тийн боловсрол ба нүгэлийн тийн боловсрол хоёрт магадлах бөгөөд тийн боловсрол нь газарт боловсрохгүй чулуунд ч боловсрохгүй энэ цогцос өөрт боловсорно.

Үйл буян ба нүгэл алиныг хураавал үр амгалан зовлон амсах шалтгаангүй учир эс үйлдсэн үйл лүгээ үл учирна.

Тэр хоёрыг хурааснаас хойшид тотгорын лугаа эс учирвал үр амгалан зовлон аль нэгэн нь магад гарах тул үйл үйлдсэн нь хэзээ ч шамшаагдахгүй. Судраас амьтадын үйлүүд нь зуун гавал болсон ч шамшаагдахгүй чуулж цаг нь ирвэл үр боловсрох чанартай хэмээсэн үйл буян нүгэл өчүүхэнийг эдлэвч үр машид арвидсанаар амгалан зовлонг өнө урт хатуу хүчтэйг амсах хэрэгтэй болдог.

Үлгэрлэвэл самрын модын нэг үрийг талбих цагт үр олон болж арвиддаг нь илт үзэгддэг мэт дотоод бодын арвидлага нь гадаад бодид үл ирэхийг зарлигласан үүгээр ч үл барам үйл алин үйлдсэн түүний үйл магадтайгаас гадна ямар ч солигдолгүй гардаг.

Одоо ч өөрөө өчүүхэн дарах цагт наран ургахад шүтэж илчийн амгалан нэгэн гарвал тэр нь ч урьдын буяны үр бөгөөд өөрийн биед өргөх хатгах халуун хэмээх гарвал тэр нь ч урьдын нүгэлийн үр юм. Буяны үйлээс үр амгалан ямагт гарахаас зовлон үр гарна. Нүгэлийн үйлээс үр зовлон ямагт гарахаас амгалан үл гарна. өөрөө зовлонг үл хүсч амгалан нэгийг ирүүлэхийг хүсвэл

түүний шалтгаан нүгэлийг юу чадахаар тэвчих ба буяны үйлийг бүтээхийг алин чадахаар магад үйлдэх хэрэгтэй.

Буяны ном асар ариун нэгийг үйлдэхийг хүсвэл сонсогч өөрөө ялагчаас ялгамжтай хутагтын буяны суурь шүтээн эрдэнэт бодийн сэтгэлийг эс төрснийг төрүүлж төрснийг дээш арвитган одуулахын арганд шамдахаас бусад алин ч үгүй.

“Бодьсадын явдалд орохуй”-гаас одоогийн буяны хүч доройг шинжил хилэнцийн хүч машид тэсдэшгүй тэрнээс нь туулсан бодийн сэтгэл нь өөр буян бусад алинаар ч сүрээр үл дарагдана хэмээсэн энэ адилын эрдэнэ бодийн сэтгэлийг үндэсэнд төрүүлэхэд хураан үйлдэх буяныг хураах нуруу хэтэрхий сайн байх хэрэгтэй буян дорд бодьгалын үндсэнд төрөх нь байтугай алдар төдий ч чихний оронд эс сонсогдомуй. Тийм учраас өөрийн үндсэнд буяны чуулган чухалчилан хураан үйлдэх гайхамшигт арга нь мандалын зан үйл энэ юм.

Тиймээс мандалын зоригдолын тайлбарыг номлож үйлдэхэд гурван зүйлээр номолно.

1. Алинаас номолсон уг гарлыг байгуулах
2. Уг уламжлал төгс мандалыг хийх ёс
3. Ёс зохилдсон мандал өргөхийг зан үйл бодит болой.

**Анхан: Хаанаас номолсон утгыг байгуулах нь “Их хот мандалын судар”-аас**

Эд сэлт нь өглөг

Тэгш арчих нь шагшаабад

Амьтныг тодруулдаг нь хүлцэнгүй

Мандал өөрөө хичээл

Нэгэн үзүүрт сэтгэх нь самади

Зүг завсрыг ялгах нь билиг лүгээ зургаа

Бурхан тэргүүтэнд үүнийг өргөвөл

Зургаан барамэдийг олох болно хэмээсэн буй

Гүнтан ринбочэ гэгээн бээр тахил алинаас агуу дээр үгүй тэдгээрийг ялгуусан бүхэнд өргө хэмээхийг угт зохиосноор агуу их ба олз хүндлэлийн тахилыг үзүүлсэн судрын эш олонх нь мандлын уг гаралд одно.

Тарнийн гол номлолоос номолсон ёс нь Ливон Сридсри намдаг дорж бээр мандал машид үзэсгэлэнтэйг рашаан тэргүүтэн үнэрээр сүрчээд сэтгэлд зохист анхилам цэцэгсийг дэлгэснээр арван зүг гурван цагт оршсон чухаг дээд гурвуул тэрийг бодож эрдэмийн чуулганаар магтаж бишрэхүй ёсоор мөргөж үйлд.

Хэр зохистой тахилыг бэлтгэн зэргэмж ямарчилин тарни лугаа өргө хэмээн мандалын түрхэх эд ба цомцогуудыг сударт үзүүлсэнээр чуулганы оронд долоон гишүүн мандал лугаа сэлтийг өргөх ёсыг үзүүлсэн.

“Бодийн гол замнал”-аас зүүн үлэмж биет замбү тив, үхэр эдлэгч тив, яруу бус тив лүгээ дөрвөн тивийн бэлгэдэлийг хагас дугуй, гурвалжин, дугуй, дөрвөлжин ба бас илт хүссэн мандалын зан үйлчилин бурхан тэргүүтэнг машид тахиж үйлд хэмээн дөрвөн тивийн хэлбэр лүгээ сэлтийг бодитой үзүүлээд номолсон Ловон Жамбалдагвын зохиосон “Зүрхэн чимэг”-ээс түрхэлгэ үүнд эрдэнэ буюу үр тос цэцгийн гэмээс хагацсанаар сүмбэр уул тив сар наран сэлт орныг нь машид бэлгэдэн үйлдсэнээр хүрд эрдэнэ морь заан жанжин түшмэл эрдэнэ өөрийн бие, өөрийн эрдэнэ бүхэн төгсийг байдал байгуулалтын итгэлд машид өргө хэмээсэн ба очир алмааз, бадмаараг, гэрэгад, усан болор, цагаан шүр, бэндүрья, индэрнан лугаа төгсөөр өргө.

Лавай их лавай лянхуа их лавай хумх ба сан хүслийн хангагч мод галвирваасан их мод машид дэлгэрсэнийг баатар бээр итгэлд машид өргө.

Сүмбэр уул, нар, сар, тив дөрвүүлийг **вазра рэхэ хум** хэмээн өгүүлсэнээр ариун сэтгэлээр өгүүлж үйлд хэмээн цомцогын тоо, эдлэл алин буйг дутуу үгүйгээр өргөх ёсыг дэлгэрэнгүйгээр өргөхийн номолсон. Ялгамжтайд “Багшийн таван шүлэгт”-ээс дээд сүжигээр гурван цагт хот мандал цэцэг сэлтийг хавсарсанаар лам багшийг хүндлэн өлмийд оройгоор мөргө хэмээсэн. Нийт хийгээд нийт бусын шид бүгд өөрийн үндсэнд төрөх буюу олж үйлдэхийн үндсийн эцэс нь гурван зарлигын ачлал төгс ачит багш цор ганц учир түүнд машид сүжиглэх сүжиг бишрэлээр өдөр бүр гурван удаа мөргөн үйлдэх нь нууц тарнийн сахигдахуун тангарагын эрхэм бөгөөд хүндлэхийн ёс олонтой байвч эрхэм нь хот мандалыг цэцэг лүгээ сэлтийн үүднээс гарын алгаа хавсран багшид өргөх тэр нь тангарагын эрхэм ба хүндлэх ёс мөн юм. Тиймээс тэр мэт хүндлэн үйлдэх хот мандал алин адил нэгэн вэ? хэмээвэл “Нууцын хураангуй язгуур үндэсний наймдугаар бүлгэм”-ээс орон үүнийг долоон зүйл эрдэнээр мэргэдүүдээр огоот дүүргээд шидийг хүссэнээр өгөхийн тухайд өдөр билигтээр өргөмүй хэмээсэн мэт ер нь билигт ялгах үүд олон ч үес үүнд таван зэргийн мөрийн гүн аньс хоцролгүйн эрдэмд бодлын туйлын сүжигээр мэдэх ба олохуйд илтэд хүрсэнээр түүний увидасыг чухалчилан бодьгал дээд эрхтэн нэгэнг билигтэн хэмээгээд үүгээр Маха мудрагын дээдийн шидийг олохыг хүссэн сүжиг урвалтгүй сэтгэлээр дөрвөн тив зуун живаа орон үүний хэмжээ огоот тасарсангүйг оюунаар босгоод мандалын дээр илт байгуулж хаан төрийн долоон эрдэнэ тэргүүтэн товчилбоос

хүссэн төгс эдлэл бүгдийг дутуу үгүйгээр цогцлоож үзэгдэлд өвөрчилөн үгүй тахилд билигийн чуулганыг хураахын тухайд мэргэн шавь бээр буян болон бэлгэ билигийн чуулганыг хураахын тухайд багшид өргөхийг мандал хэмээдэг.

Урьд “Язгуурын үндэс”-ээс татсан түүнийг “Тодорхой зул”-аас багшид ялгамжын эдийг өргөж үйлдэхийн тухайд орон үүнийг долоон зүйл эрдэнээр хэмээгдэх тэргүүтэнг номлоодбадмаараг, индранил, бэндүрья, маргад, очир алмаз, шүр, сувд хэмээгдэх долоон зүйл эрдэнээр огоот дүүрсэн орон үүнийг өдөр бүр өргөн үйлдэх буюу хатан түшмэл эрдэнэ хүрд, илд, заан морин эрдэнэ ч мэргэн бөгөөд буян болон бэлгэ билигийн чуулганд мэргэнээр өдөр бүр өргөж үйлд. Билигт нь дээдийн эцсийн бэлгэ билиг төгс бөгөөд бэлгэ билигийг хүсэх гүйгээр багшаас хоёргүй бэлгэ билигийг тус тусад олж үйлдэхийг хүсэх бөгөөд түүний увидасаар маха мудра-гын шидийг бүтээхийг хүссэн билигээр өргөж үйлдэх бөгөөд самадигаар ч бүгдийг үүсгэж үйлд хэмээн тодорхой номолсон байдаг.

## Хоёрдугаарт. Уг уламжлалаар төгс мандалыг хийх

### Үүнд дөрөв буй

1. Мандалын мөн чанарын номлол
2. Мандал түүний уг
3. Мандал түүний хэлбэр өнгө
4. Мандал түүний хэмжээ

**Анхан. Мандалын мөн чанарын номлол нь:** Мандал хэмээгдэх нь Энэтхэг үг бөгөөд төвдийн хэлмэрчид Жилхор хэмээн орчуулдаг. Монголоор хот мандал хэмээдэг түүний утгыг "Хоёр шинжлэлтийн үндэс"-ээс хот буюу жил нь зүрхэн хэмээн өгүүлэгдэх бөгөөд бодийн сэтгэл нь их амгалан авч үйлдэх хот мандал ямагт хураангуйн хот мандал ямагтад өгүүлдэг хэмээгдэхийг таалалаар Богд лам бээр зүрхэнийг авахуй хэмээн номолсон.

"Үндэс очир үзүүр"-ээс юуны учир хот мандал хэмээн өгүүлбэл дээдийн номын зүрхэн шим гардаг учир түүнийг нь хот мандал гэж өгүүлнэ хэмээхийг номолсон.

Тэр ч мандал магадлахуй үгээр зүрхний үгийн тусгал энэтхэг хэлээр нь сара хэмээгдэх урьд дагах дуун тусгалыг Манү-д агуулсанаар манү сана хэмээгдэх бөгөөд Ладина хэмээгдэх авахын дуун тусгал мөн учир зүрхэнийг даган авахын хэмээхийн утга болой. Хослон орохуйн ялгалгүй бэлгэ билиг нь авах шалтгааны зүрхэний эцэс бөгөөд гэвч зүрхэн эцэс тэрийг анхан өөрөө авч чадахгүй учир мөрийг бүтээхийн зэргийн аргуудыг урьд анхааран авсаны сүүлд авах бөгөөд олох шалтгаан мөний оньсоор мандал гэдэг.

Бас Санжай Санва бээр зохиосон хот мандалын номын товч хураангуйгаас магадлах үг хот /жил/ нь эрхэм бөгөөд мандал /хор/ нь түүний хувилгаан юм. Бас өнгөрсөн хот (жил)



бөгөөд мандал /хор/ хэмээхийг ертөнцөд үйлд хэмээсэн мэт мандал бодитой нь дөрвөн тив мандал лугаа сэлт мөн учир хот ба есөн хүслийн төгс эдлэл сэтгэшгүйд хувилгах нь мандал /хот/ мөн учир хот мандал буюу Жилхор хэмээдэг.

Бас гурван мянган их мянган ертөнцийн орон бүгдийг оюунаар босгож түүний нөхөр ба тэр ч бодийн сэтгэлээр эзлэгдэх буюу амгалан хоосон хоёр үгүй бэлгэ билигийн тийн цэнгэлд ургуулах нь хот /жил/ учир хот мандал / жилхор/ хэмээн номолсон ч болох юм.

Тийм учраас мандал өргөх цагт өөрийн авах зүрхэн алиныг танин барих нь их чухал “Шалгадагын тийн тайлбар”-аас атгагын торуудыг тийн арилгаж гүн агуу их биеийг эрхшээсэн бүхэнд сайн гэрэл цацрагуудыг бүхэнээр цацраагч дор мөргөмүй хэмээсэн мэт бид нарын тусыг чухалчилагдахуун нь хамаг амьтныг зовлонгоос гэтэлгээд бурханы газарт байгуулах энэ бөгөөд түүнээ тэвчил онол огоот төгсгөн дээргүй хутаг нэгийг олоогүйд тэр тусыг бүтээн чадахгүй бөгөөд энэ адилын хутагт ерөнхийдөө номын бие, төгс жаргалангын бие, хувилгааны бие гурав байгаагаас шавь хамаг амьтны нүдний өмнө үзэгдэх гэрэл цацраг мэт алинд алин хүссэнийг үзүүлэх шалтгаант нь хувилгаан бие юм.

Ялгуусаны хөвгүүн нь бодьсатва нугуудад бодитой ном үзүүлэхээс бусадын үзэгдэх оронд үзэгддэггүй таван магад төгс биед оршсоныг төгс жаргалангын бие гэдэг.

Тэр хоёр алинаас гарах суурь нь номын төв машид нарийн түүнчилэн чанараас дахин үл босох ёсоор оршсон цувиралтгүй бэлгэ билигийг номын бие хэмээдэг. Тэр гурваас анхны хоёрыг агуу их бие хэмээгээд сүүлийнхийг гүн бие хэмээдэг. Тэр гурвуул нь бидний авах шалтгааны зүрхэн мөн

учир одооноос зүрхэн түүнийг ологдохуун болгож багшид мандалын тахилыг дахин дахин өргөхөд шүтсэнээр өөрийн үндэс улам ариусч түйтгэр улаж нимгэрч эрдэм улам дэлгэрэн одсоноор эцэст түйтгэр бүхэн огоот баригдаж эрдэм бүгдийг огоот төгсгөдөг учир урьдын ологдохуунд барихын зүрхэн тэрийг авах мөн.

Ёс тэр мэтийг мэдэж үйлдээд мандлыг өргөсөнөөр шинжлэл бусад лугаа адилгүй буйд таалсанаар мандал буюу жилхор хэмээн номолсон.

**Хоёрдугаарт. Мандалын уг нь:** “Ловон Шагша Шригийн зохиосон мандалын зан үйл”-ээс хот мандал сайн нь шорооны чанартай, эрдэнийн чанартай тэв тэгшийг үнэр анхиламаар түрх хэмээсэн Ловон Гамбала бээр зохиосон мандалын зан үйлд сайн шороо элсэнд амьтад тэргүүтэнг цэвэрлээд шавараар сайтар бүтээж үйлд хэмээсэн.

Богдын зарлиг “Таван зэрэг нэгэн дэвсгэртэд төгсгөхүйн улаан хөтөлбөр”-өөс шороо буюу эрдэнэ тэргүүтэний мандал хэмээн номолсон мэт барилдлага буй нугууд бээр алт, мөнгө, номин, шүр, окуу тэргүүтэн эрдэнээр үйлдвэл дээд зэс, хүрэл тэргүүтэнээр үйлдвэл дунд мод чулуу шороо тэргүүтэнээр үйлдвэл адагт номолсон.

Энэтхэгийн багш нарын зохиосон мандалын зан үйлийн ихэнхэд шороон мандалын номолсон байдаг. Богд лам бээр Олха Чойлүнд буяныг хураах ба хилэнцийг цэвэрлэхүй үесд дөрвөлжин чулуун мандал хэрэглэдэг учир нь уг адаг дунд дээд гуравд номолсон нь бид мэтийн барилдлага байвч харамгаар өгч чаддаггүй нугуудад тухайлан чухалчилсанаар номолсон буюу гэлтэй.

### **Гуравдугаарт. Мандалын хэлбэр ба өнгийг номлох**

**нь:** Ловон Санжай санвагын зохиосон мандалын зан үйлээс батадгаж үйлдэх зан үйл нь мандалын өнцөгийг сайтар түрхийг сайтар номолсон хэмээсэн. Богдын гол замналаас хагас дугуй гурвалжин дугуй дөрвөлжин бас илтэд хүссэн мандал хэмээсэн мэт мандалын хэлбэр хязгаар нэгэнд магадлаагүй тул дөрвөлжин буюу дугуй хагас дугуй гурвалжин хэлбэртэй болохыг номлоод өнгө ч таван өнгөөс аль нэг нь болохыг номолсон бөгөөд гол нандин шүтээн тавдугаар далай ламын хэрэглэдэг амирлангуйд мандал мөнгөөр бүтээсэн дугуй хэлбэртэй.

Дэлгэрэнгүй мандалыг алтаар бүтээж дөрвөлжин, эрхийн мандал зэсээр бүтээсэн хагас дугуй хэлбэртэй, хатуу мандалыг төмрөөр бүтээсэн гурвалжин буйд номолсон.

Тэр мэт болохыг ч Ловон Гамбала бээр хэлбэр нь дөрвөлжин хэлбэртэд дотор дугуй хангаж үйлд өнгө нь бүхэн амсар нь хөх ч болно. Эсвэл сэтгэлдээ тааруулж үйлд. Эсвэл хэмжээ ба өнгө хэлбэрийг дөрвөн зүйл үйлсийн ёс лугаа найруул хэмээн тодорхойд номолсон.

**Дөрөвдүгээрт. Мандалын хэмжээ нь:** Бас тэр ямагтаар өргөнд тохойноос дээшхи хэмжээтэй хэмээсэн. Ловон Далай Намжил бээр хэлбэр хэр баясгалантай мандал нь тохойноос дээшихэд хэмээн Энэтхэгийн гол номлолуудаас багын хэмжээг тохойд номолсон тул тохойноос хэр ихийг өөрийн оюун лугаа тааруулахыг номолсон ч дээдсүүд шавийн эрхээр их бага дунд гурвын хэмжээг номолсон үзэгдэх тул мандалын ихийн хэмжээнд магадлаагүй ч адаглаад тохой ба дундын хэмжээ нь захаас зах хүртэл арван зургаа хуруу ба багын хэмжээ арван хоёр хуруу байх хэрэгтэй бөгөөд түүнээс бага мандал байж болохгүй.

**Гуравдугаарт. Ёс зохилдсон Мандалыг өргөх зан үйл  
бодитойд хоёр**

1. Барилдлага түрхэх эд болон цомцогуудыг хураан үйлдэх
2. Мандал өргөх зан үйл гишүүн лүгээ сэлттэй

**Анхан. Барилдлага түрхэх эд болон цомцогуудыг хураан үйлдэх нь:** “Зүрхэн чимэг”-ээс ариусгагч тав нь сайтар хутгасанаар тэгш түрхэж ил хэмээсэн мэт үхэрээс гарсан таван зүйл эдээр сайтар хутгасан усаар мандалын гадна дотно бүгдэд түгмэл түрхээд хэлээр

**Ум вазра рэ хэ аа, хум хэмээх ба**

**Ум сарви вигханан үзадая хум суха хэмээн өгүүл**

Таван рашаанаар түрхэх **Ум амрида хумпад** хэмээн өгүүл тэндээс цомцог нь алт мөнгө тэргүүтэн эрдэнийн язгуур ба элдэв эм алин барилдсан ба элдэв үр ба чулуу элс тэргүүтэн аль болохыг номолсон ч зан үйлд голлон үр зохиосон нь огоот алдаршсан мэт ариун үрийг хальс тэргүүтэнг арилгаж сайн үнэртэн ба таван рашааны усаар угааж чийг лүгээ сэлттэй үйлд.

Тэрэн ч мандалд үхэрээс гарсан эдийг түрхэх хэрэгтэй. үхэрээс гарсан таван эд нь ариусгагч эд мөн учир сахиусны дээд болдог. Цомцогыг сайн үнэрт ус ба таван рашаанаар угаах нь нигүүлсэхүй ба бодийн сэтгэлийн чийг лүгээ үл хагацах бөгөөд таван бэлгэ билигийн мөн чанарт мэдүүлж үйлдэхийн тухайд зарлигласан.

**Хоёрдугаарт. Мандал өргөхийн зан үйлийг гишүүн лүгээ  
сэлттэй өргөхөд гурав**

1. Дуршилыг үүсгэх тухайд ач тусыг номлох
2. Мандалын алинд өргөхийн орныг танин барих
3. Түүнд өргөх мандалын тийн ялгалыг номлох

**Анхан. Дуршилыг үүсгэх тухайд ач тусыг номлох нь:**

Их хот мандалын судрын эшийг урьд татсан даруйгын сүүлд өвчин бүхнээс гэтэлж алтан өнгөтэй болно. Тэнгэр хүн бээр тахих болно. Саран адил бадрангуй туяарна. Эд болон алт эрх баялагт хаан болж төрнө эцэст бурхан болсоноор огоот ариун ороноо төрөх болно хэмээсэн мэт мандалд шүтсэнээр зургаан барамэд тэргүүтэн эрдэм бүгдийг олох ба өвчин тэргүүтэн саадаас гэтэлж тэнгэр тэргүүтэн ертөнц бүхэн баяссанаар тахих ба биеийн царай зүс тодрох, төгс эдлэл ба эрх баялаг хотол чуулах бөгөөд мандалаар хэр төдий дарагдсан тоосон лугаа сацуугаар загарвадыг хаан болж төрнө. Түргэнээ илтэд туулсан бурхан болж амьтаныг орон бүхэн ариун, үл оршигч нирваанд байгуулах болно.

## **Ловон Гамбала бээр тэр мэт өргөсөний**

### **эрдэм нь**

Арван барамэд төгс ч хоёр түйтгэр ариусч чуулганыг төгсгөөд самади хот мандал тодорхой болсоноор өвөрчилин хот мандал үзэгдэх болно хэмээн ахуй үесд хоёр түйтгэрийн авьяас лугаа сэлт зэргэмжээр ариусч хоёр чуулган огоот төгссөнөөр арван барамэдийн эцэст хүрч эцэст гүн самади үнэмлэхүй тэгш агуулах гэгээн гэрэлд оршоод хоёр үнэн ялгалгүйн өвөрчилин үл суралцагч хослон орохуйг үзэж олохыг зарлигласан.

Хачэ Банчин Шагжашри бээр тэндээс амьтан бүхэнд ертөнцийн итгэл чухал нөхрийн дүрсийг хэмжээлэшгүй өргөсөнөөр оронууд бүхэнд тусыг эдлэн хэзээ бодийн зүрхэнийг хүртэл тэдгээр хэзээ ч удирдахын муу заяаны дууг ч үл дуурсган үргэлжид баясгалан жаргаланаар амьдармуй хэмээн мандалаар төгсгөх боловсрох цэвэрлэх гурав огоот төгсгөхийг номолсон.

### **Мандал эс өргөсөний гэм эргүү нь**

Мандал эс өргөсөний гэм эргүүг ч Ловон Гамбала бээр тэр мэт эс үйлдсэн гэм нь төгс батыг ололгүй мандалыг агуулбал дайснууд алмуй тийм учраас шамдан бишэр хэмээн батыг олсоны утга мандал бүтсэний шинж нь бодит байдал зүүдэнд жимс боловсрох, төл төмс сайн боловсрох үрийн хур буух тэргүүтэн дахин дахин гарахыг номолсон энэ төдийгээр бололгүй төгсгөх нь хэмээн дуугаар нэмэх нь тарнийн үзэхүй мөр үнэмлэхүй гэгээн гэрэлд адагт газрын охин үйлдсэнээр тэрнээс дээшидэх бусад бусдад мандалын цацралыг агуулан үйлдвэл халдарт өвчин тэргүүтэн хөнөөл тэсдэшгүй гарч хортон дагинасууд бээр насны орхилыг төгсгөлгүй алах тэргүүтэн гэм эргүү машинд их тул цаг үргэлжид шамдалаар мандал өргөхийн үйлд хичээх хэрэгтэйг зарлигласан.

Тэр мэт Энэтхэг,Төвд, Монголын их бүтээлчин бүхэн мандалд шүтсэнээр дээд хутгыг олсон бөгөөд Гаадамба өөрөө ч Жово Адишигаас эхлээд богд лам эцэг хөвгүүн тэргүүтэн дээдэс бүхэн ч хураах цэвэрлэх лүгээ барилдсан мандал өргөхөд тааллын уг ихээс ихэд соёрхсон онол мэндэлсэн ёсыг зохиосонуудыг мэдэж үйлдээд үйлдэхүй хялбар тус ихт мандалын үйлдвэрт шамдах хэрэгтэй.

**Хоёрдугаарт. Мандалыг алинд өргөх орон нь:** “Ишэй дорж бээр зохиосон тэр ямагтыг үзэхүй мөр”-өөс Мандалыг өргөхүйд ч хоёр бөгөөд чухаг дээд ерөнхий ба багшид өргөх болой.

Ерөнхийд өргөх нь ямар мэт үзэсгэлэнтэй үйлдээд бодитой буюу сэтгэлээр бод дүрс тэргүүтэн бие лүгээ сэлтийг өргөх хэмээн чуулганы орон ерөнхийд бодитой бэлтгэсэн сэтгэлээр хувилгасан бод лугаа хоёр ус, чухал эдлэгч хөгжим ба дүрс тэргүүтэн таван хүслийн тахилын чуулган хэдий буй бүгд ба бие төгс эдлэл буяны үндэс бүгдийг өргөхийг мандал хэмээн нэр нэрийдэн өгөхийг номолсоноор багш алинд өргөх хэргийг нь тэр ямагтаас багшид өргөх нь **Ум хам маха мэра вэнама** хэмээн өгүүлсэнээр төвд цомцог агуулж сүмбэр уулыг бод.

**Ум ям бүрва видэ хая нама** хэмээхээр зүүн тив тогтсоныг бод

**Ум лам абара годи нае нама** хэмээн өгүүлсэнээр хойд тив тогтсонд сана

**Ум я ўва дибая нама** хэмээхээр зүүн урд агуул

**Ум ла ўвади ба я нама** хэмээхээр зүүн хойно агуул

**Ум я ашу радна я нама** хэмээхээр зүүн тивд морин эрдэнийг дүүрсэнд сана

**Ум ра мани радна я нама** хэмээхээр урд чандмана эрдэнээр дүүрсэнд сана

**Ум ла хасди радна я нама** хэмээн өгүүлсэнээр хойно заанаар дүүрсэнд бод

**Ум ва бүрүша радна я нама** хэмээхээр баруунд түшмэлээр дүүрсэнд бод

**Ум я ханга радна я нама** хэмээхээр зүүн урд жанжин эрдэнээр дүүрсэнд сана

**Ум ра сида радна я нама** хэмээн өгүүлсэнээр баруун хойно хүрд эрдэнээр дүүрсэнд сана



Ум ва сарва ниди жо нама хэмээхээр зүүн хойно агуулсанаар элдэв эрдэнээр дүүрсэнд бод

Ум хам суди мэдва нама гүрү вам дари гая ида мандал лани хэмээн өгүүлсэнээр голд хавсаран агуулсанаар дээд сүмбэр уулын оройд лянхуан суудалд багшийг залаад тахил бусад лугаа сэлтээр өргө хэмээн сүмбэр уул дөрвөн тив бага найман тив хаан төрийн долоон эрдэнэ их сан лугаа сэлтийн мандал нь багш ямагтын гарт өргөх хэрэгтэйг номолсон.

Ловон Шиласамвава бээр зохиосон “Хоосон чанарт хураангуй увидас”-аас тэндээс багшийг тахих нь ариун рашаанаар мандалыг түрхэж үйлдэхэд адистэдлэж үйлд үхэрээс гарсан рашаан лугаа сэлтээр **вазра рэнхэ** хэмээн өгүүлж алаг цооггүй сайтар түрх хэмээн тэргүүтэн номолсон мэт ба үүгээр ч урьд “Нууцын хураангуй язгуур үндэс” багшийн тавин шүлэгтээс татсанаар ч мэдэж болох бөгөөд барилдлагын зургаан номын үесд ч долоон гишүүнийг өргөсөний сүүлд мандал өргөөд гурван их тусын залбирал хэрэгтэйг номолсоны аньс ч үүнд тулах тул бид нарын номын чанар ялгалгүйн хоосон чанарыг эс мэдвээс бурхан нэгэнд тахил өргөсөнөөр бурхан бүхэнийг тахисны ач тус үл гарах бөгөөд өөрийн багш ганцыг тахиваас бурхан бүхэнийг тахисаны ач тус магад гармуй.

Зөөлөн цагийн аман эш-ээс үүний хэрэг төгс заримд эдүгээ түүний биед оршоод бүтээлчин бусдаас тахилыг ав хэмээсэн байдаг. Тийм учраас тахил бүгдийн эрхэм мандалын тахил нь чуулганы ороны төвд орших багшид өргөх хэрэгтэй юм.

**Гуравдугаарт Түүнд өргөх мандалын тийн ялгалыг  
номлоход тав буй.**

1. Гадаад хумхын эрх лүгээ барилдсан мандал
2. Дотоод нууц эрх лүгээ барилдсан мандал
3. Нууц билигийн эрх лүгээ барилдсан мандал
4. Хоосон чанарын үгэн эрх лүгээ барилдсан мандал
5. Тэдгээрүүдийг Увдисыг гарт авахуйг үзүүлэх

**Анхан. Гадаад хумхны эрх лүгээ барилдсан мандалд дөрөв буй.**

**Анхан Догон Чойжал Пагбон ёсны гучин долоон цомцогтыг номлох нь:** Мандал өргөхөд урьд одуулгын зэргүүдийг доороос гарсан мэтийг талбисанаар зүүн гараар үр өчүүхэн лүгээ сэлтээр мандал бариад баруунаар үр лүгээ сэлтийн алгаар мандалыг арчиж үйлд. Үүнд номлох ёс нь хоёроос анхны эхэнд үйлдвэл баруунаа гурван удаа эргүүлж арчсанаар өвөр бусад амьтан бүгдийн үндэсний нисваанисын түйтгэр ба мэдэгдэхүүн түйтгэр тэр хоёрын авьяасны түйтгэр тэр гурвыг арилгаж үйлдэе хэмээх дуршилыг үүсгэнэ.

Хоёрдугаарахын эрхэнд үйлдвэл гадагш хоёр удаа арчиж тэндээс дотогш хоёр удаа арчина. Анхны үесд би бээр эс ариуссан савын гэм бүгдийг цэвэрлэж үйлдэе.

Шимийн амьтан бүгдийн үндэсний хоёр түйтгэр авьяас лугаа сэлтийг цэвэрлэж үйлдэе хэмээх ба дотогш арчих цагт би бээр хамаг амьтаны тусад гүн түүнчилин чанарын төв номын биеийг бүтээж үйлдэе. Агуу их хувилган урвуулахад дээр үгүй дүрст биеийг бүтээж үйлдэе хэмээхийн үүднээс сэтгэл үүсгэж ирээдүйн ологдохууны зүрхэнийг танин мэдэж үйлдээд түүнийг юугаар ч олох нэгийг олж үйлдэе хэмээн чин бат сэтгэлийг барь.

Тэр мэт мандалыг арчиж гүйцсэний голд цэцэг дэлгэ. Хэрвээ хоосон гараар мандалыг баривал голлон өөрт эрдэм төрөхөд тоггор болох бөгөөд эгэл төгс эдлэлээр ядуурах ба мандалыг цэцэг үйгүй хоосонд агуулвал бурхан үл залрах харанхуй галбад төрөх ба хааяа гэрэлт галбад төрөх нөөн ч хязгаар орон тэргүүтэн бурханы дуу үл дуурсах оронуудад тарах гэм эргүү ихтэй.

Тэндээс орныг өргөхийг өчмүй хэмээн чуулганы орон бүгдэд нийтийн тахил долоон гишүүнийг өргөсөнөөр багшид ялгамжит тахил өргөсөний тусад яруу сонслоо буулга.

**Ум вазра вүми а хум** хэмээн өгүүлж мандал түгсэнд цэцэг дэлгэд доор суурь хийн мандалын цар эн хэмжээлшгүй бээр түүний дээр усан мандал цар эн арван бум ба хагас сэлт зуун хэсэг дөрөв буй түүний дээр их эрхэт алтан дэлхий зуун иживаа гарсанд бодоод

**Ум вазра рэхэ а хум** хэмээн өгүүлж мандалын эргэн тойронд цэцэг дэлгэн алтан газар нижгээд нижгээдийн эргэн тойрон ба хийн мандал огоот төгсийн эргэн тойронд хатуу бат төмөр уулаар хүрээлсэнд бод.

Цомцог гучин долоон тоот нь сүмбэр уулаас дуаз хүртэл гучин долоо буйгаас сүмбэр уул тив арван хоёр ба хаан төрийн долоон эрдэнийн сан лугаа сэлт хорин нэг бөгөөд урьд татсан түүнийг үзэхүй мөр ба бодийн гол мөрөөс ч тэндээс мандал түүний төвд сүмбэр уул дөрвөлжинд найман үзүүрээр чухал үзэсгэлэнтэй зүүн урд баруун хойд тал нь биндэрьяа болор бадмаараг алтны чанарт тэр дөрвөн эрдэнийн чанар болой. Түүний өмнө хагас сарны байдалтай зүүн үлэмж биетний тив, баруунд гурвалжин замбу тив ард дугуй үхэрийн эдлэгч тив зүүн дөрвөлжин яруу бус дуутын тив болой. Зүүн үлэмж бие

тэргүүтэн ба чухал биет, үлэмж биет, хэлбэр төгс, дээд мөрөөр одогч, Гөвүүрт, гөвүүр бусад яруу бус дуут, яруу бус дуутын сар хэмээн ойрын тивүүд тус тусад бадмаараг, индраганил, бэндүржа маргад очир увд шүр тэргүүтэнээр огоот дүүрсэн болой. Зүүн тэргүүтэний зүгт заан, эрэгтэй, морь, хатан нугууд.

Гал тэргүүтэн завсарын зүгт илд хүрд эрдэнэ их сангуудыг санаад хэмээн номолсон лугаа зохицолдуулж хорин нэг түүний дээр нар сар хоёрыг нэмсэнээр хорин гурав болж байгаа нь их мэргэн Рэнчин-Жүннэйн-байва бээр зохиосон мандалын зан үйлээс багшийн мандалын зан үйл нь Ум вазра вүми а хум хэмээн өгүүлсэнээр сэтгэл үүсгэхийг урьд одуулахын үүднээс үхэрээс гаран рашаан лугаа сэлтээр зүгт түрхэж үйлд.

Тэндээс хот мандалын төвд цэцэг агуулаад Ум вазра рэхэ а хум хэмээгдэхээр адистэдлэж үйлд.

Тэндээс цэцэг дэлгэрэх тарни нь

Ум хам маха мэр вэнама төвөд болой хэмээгдэхээс зүүн баруунд

Ум зандра я нама хэмээх ба “Хачэ Банчэн шагжа шри бээр зохиосон мандалын зан үйлээс

Ум а вазра задүра диба хум

Ум а вазроба ягүда диба хум

Ум а вазра чадра радна хум

Ум а вазра чада мамгала хум

Ум а вазра сиди вишади хум

Ум а вазра сүржа зандра хум хэмээсэн мэт Задүра дөрөв.

Дивилин дөрвөн тив үва я ойрын ашда найм Диба тив хэмээгдэх завсар барилдсан доод адилгүй хурсан урь яшда дээд а, ү-д о-гоор вазро яшда бүтсэнээр оройн найман тив Ашда радна долоон эрдэнэ сан лугаа найм сүржа нь нар заэдра нь сар бөгөөд

арван хоёр тив нар сар лугаа сэлтийг бодитой үзүүлсэнээр дашрамд сүмбэр уулыг үзүүлсэн.

Урьд татсан зүрхэн чимэгээс ч тодорхой номолсон болой. Хорин гурвуул түүний дээр гэнхэлзэгч найман охин тэнгэрийг нэмсэн нь очир эрхиний авшигын хязгаар шүтэх явдлын даган соёрхолтын үесд хүслийн өвөрчиллинг мэдүүлэхийн үүднээс мод дэгжлэг өгөх явдлыг эрхшээхийн шүтэн барилдлагад гэнхэлзээ лүгээ сэлтийн эрхинийг орхи хэмээх тэргүүтэн номолосоныг даган бараадсан бөгөөд гучин нэг түүний дээр эрдэнийн уул тэргүүтэн дөрвийг нь явдалд орохуйгаас эрдэнийн уул түүнчилэн ой цэцэрлэг газар зүг алгыг байдал баясгалант найлзуур модонд цэцгэн чимэг үр цогцолсон. Мод алин ч үнэр сайтай гишүүн унжсан тэнгэр тэргүүтэн ертөнцөд үнэр нь боссон хүн галбирбаасан мод эрдэнийн мод үр жимс боловсорсон төл төмст байдалт хэмээх тэргүүтэнд шүтсэнээр зохиосон бөгөөд гучин тав түүний дээр шүхэр дуанз хоёрыг нэмсэн нь Ловон дава дагва бээр дахин үл хөдлөх лагшинг эрхшээсэн чи бээр гурван сансарын оронд хувилгаануудыг ажирах ба мэндлэх бодь амирлахын хүрдийг үзүүлж зохио хэмээсэн мэт.

Өөрийн ологдохуун үр номын бие хоёрыг одооноос мөр болгохын ёсонд дүрсэнд байгуулаад өргөнө.

Тэр мэт цомцогын тоо зүйлийн номлолыг товч төдий уг лүгээ сэлтээр номолсоноор цомцогыг байгуулах ёс бодит нь. Уулын хаан сүмбэр уул хэмээн өгүүлж мандалын төвд цомцог их нэгийг байгуулах цогт уулын хаан сүмбэр уул дөрвөлжин зүүн тал нь болор урд нь бэндүржа баруун нь бадмаараг хойд нь алтнаас бүрдсэн дөрвөн зүйлийн эрдэнийн чанартай.

Усны завсраас дооши найман түмэн бээр шингэсэн бөгөөд усны завсараас дээшид найман түмэн үлэмж байна тал бүр найман түмэн бээр нижгээд буй сүмбэр уулын дээрх зүг завсарт наймд давхарлагт ордон нижгээд буйн дотор ягчис мутра очирт нижгээд нижгээд ороноос тэнгэрүүд сэрэмжгүйгээс сахисан.

Сүмбэр уулын дээр гучин гурван тэнгэрийн орон буйн төвд харваас гуа болгод хэмээгдэх элдэв эрдэнээс бүрдсэн тал бүрдээ хоёр мянга таван зуун нэжгээд буйн төвд тэнгэрийн эрхэт хурмастын орших орон тийн ялгуусын ордон буй бөгөөд харваас гуа балгадын гадна зүүнд элдэв моддын цэцэрлэг урдад ширүүн бологч, баруунд холилдсон хойно баясгалант цэцэрлэг лүгээ дөрвөн цэцэрлэг буй бөгөөд түүн лүгээ ойр дөрвөн зүгт дээрхи нэртэй адил дөрөв дөрвөн газар буй.

Зүүн хойд завсарт мод огоот хурах газар нэвчигч хэмээх галбирбаасан мод хүссэн хэрэгтэй бүхэн шамдалгүй балгадын баруун урд завсарт сайн нмот тэргүүтэний долоон газар буй болой.

Сүмбэр ууланд дөрвөн үе буйн доод зэргээс индэр анханд гартаа тэвш баригч ягчис хоёрдугаарт гартаа эрхи баригч гуравдугаарт үргэлжид согтуурагч дөрөвдүгээрт дөрвөн махаранзын оронууд буй.

Сүмбэр уулын эргэн тойронд цэнгэлийн далай анхан буй бөгөөд түүний гадна талаас алтан уул анхан бүслүүр баригч уулаар хүрээлсэн буй түүнчилэн цэнгэлийн далай хоёрдугаархаас долоо дугаарх хүртэл ба алтан уул хоёрдугаарх анжис сум баригчаас долоо дугаарх цагираг баригч уул хүртэл солбин хүрээлсэн буй бөгөөд тэдгээрт тэнгэр ба лусын олон орон байдагт номолсон.

Зүүн үлэмжит бие хэмээн өгүүлж сүмбэр уулын өмнө талд цомцог байгуулах цагт цагираг баригч уулын гаднаас давст их далай буйн дотор зүүн талд үлэмж биетний тив хэлбэр нь хагас дугуй адил хоёр талдаа хоёр мянган бээр нэжгээд бээр буй ба огторгуй бүгд мэлмэрсэн цагаанд сана.

Урд замбуу тив хэмээн сүмбэр уулын өмнө талд цомцог байгуулах цагт Замбу тив тэрэг хэлбэртэй хоёр талдаа хоёр мянган бээр нэжгээд ба нэгд бээр хагас лугаа дөрөв буй.

Түүний төвд Энэтхэгт очир суурин зүүн утай таван уул урд онгоц уул баруунд унжсан хойно шамбал ба хойт дөрвөн орон тэргүүтэний бүтээлийн олон орон ба эс бүлээдэгч далай ба галбирваасан мод тэргүүтэн тахихуй зохистой нугууд лугаа сэлт далай ба огторгуй бүхэн нь цэв цэнхэр буйд сана.

Баруун үхэр эдлэгч хэмээн сүмбэр уулын баруун талд цомцог байгуулах цагт үхэр эдлэгч тив хэлбэр нь дугуй эргэн тойрон хагас мянган ба найман бээр буй далай ба огторгуй бүхэн нь мэлмэрсэн өнгөтэйд сана.

Хойд яруу бус дуут хэмээн сүмбэр уулын хойд талд цомцог байгуулах цагт хойд яруу бус дуут хэлбэр дөрвөлжин тал бүрдээ хоёр мянган бээр нэжгээд тэгш байна далай ба огторгуй бүгд тунарсан шар өнгөтэй сана. Тив бүгдийн хүмүүс дүрс царай сайн сэтгэлийнүндэс зөөлөн шудрага төгс эдлэл хотол чуулсан эрдэнэ ба тахилын эд элдэвээр дүүрсэнд санах хэрэгтэй.

Тэндээс тив дөрвүүл сүмбэр ууланд ар зүглэхийн эрхэнд үйлдээд биет ба үлэмжхэн биет хэмээн өгүүлж зүүн үлэмж биет тивийн баруун зүүнд цомцог нэжгээдийг байгуул. Гөвүүрт ба гөвүүрт бусад хэмээн Замбу тивийн баруун зүүнд хэлбэрт төгс ба дээд үзамаар одогч хэмээн үхэр эдлэгч тивийн баруун зүүнд яруу дуут ба яруу бус дуут саран цомцог нэжгээдийг байгуулж

бага найман тив гарсанд сана. Бага тивүүдийн доод суурь нь их тив лүгээ холбоотой байвч дээдх нь далайгаар таслагдаж гол тив лүгээ ихэнхдээ адил байдаг учир бага тив хэмээдэг.

Тэндээ эрдэнийн уул хэмээн өгүүлэх цагт зүүн цомцогын дотор талд эрдэнэ элдэвийн цогц цогцолсон уул эн цар машид агуу өндөр огторгуй хүрсэн элдэв гэрэл цацраг амгалан мэлмэрч цацарсанд сана.

Галвирваасан мод хэмээхээр урд цомцогын дотор талд галвирваасан модны гол машид их навч гишүүн цэцэг үрүүд машид дэлгэрсэнээр хэрэгтэй хүссэн бүхэн сэтгэлчилин гарсанд сана.

Хүссэнийг хангагч үнээ хэмээхээр баруун цомцогын дотор талд хүсэлийг үнээ улаан шаргал өнгөтэй алгуур явдалт тарган бөгөөд харваас гуа барагдашгүй сүүн үргэлжлэл сайн алин хүссэн сүрэг хэмжээшгүй гарсанд бод.

Зэрлэг тариа хэмээхээр хойд цомцогын дотор талд иш навч дэлбэ сайтай боловсорсон тариа өнгө нь шаргал амтат амт шим хот чуулсан их цэцэрлэг гарсанд санаад дөрвөн цомцог байгуул.

Хаан төрийн долоон эрдэнэд бадмааран тэргүүтэн долоог номлох хүрд эрдэнэ тэргүүтэн долоог номлох хоёр ёс буйгаас үүнд загарвадын хаанд огторгуйгаас хаан төрийн долоон эрдэнээр эрхшээл соёрхдог мэт ачит үндэсний багшийн номын хаан төрийг эрхшээх шүтэн барилдлагыг жигдлэхийн тухайд хойд номолсон мэт хэрэгтэй.

Хүрд эрдэнэ хэмээн өгүүлсэнээр эрдэнийн уулын дотор талд Замбу мөрний алтнаас бүтсэн хүрд мянган хигээс төгс хүйс цагираг лугаа сэлт гэрэл цацраг хязгааргүй цацарсанд бод.



Чандмань эрдэнэ хэмээхээр галвирваасан модны дотор хажууд эрдэнэ санасныг арвитган эрхшээгч хаан найман талт өөрийн өнгө нь хөх гэрэл цацраг хэмжээшгүй цацарсанаар доройтол бүхэнийг арилган хүссэн хэрэг шамдалгүй гарсанд сана.

Хатан эрдэнэ хэмээн өгүүлсэнээр хүсэлийг хангагч үнээний дотор хажууд сэтгэлд зохистой дур булаам эмэгтэй гэм бүхнээс хагацсан бөгөөд цувиралтгүй амгалан гарах орны туйл гарсанд сана.

Түшмэл эрдэнэ хэмээхээр зэрлэг тарианы дотор хажууд түшмэл эрдэнэ эрэгтэй бусдад хөнөөлгүй ном бусын үйлдвэрийг тэвчсэн ном төгс үйлдвэр бүхэн мэргэжсэнд сана.

Заан эрдэнэ хэмээхээр биет болон гөвүүр бусад хоёрын завсарт зүүн урд завсарт цагаан заан тарган өхөөрдөм зургаан соёо төгс хүч чадал хотол чуулсанд сана.

Морин эрдэнэ хэмээхээр гөвүүрт ба дэд замаар одогч хоёрын завсарт баруун урд завсарт ажнай морин хөлөг хэлбэр ба бие томтой үзэсгэлэнтэй түргэний хүч адилтгашгүйд сана.

Жанжин эрдэнэ хэмээхээр яруу бус дуутын сар ба хэлбэрт төгс хоёр завсарын баруун хойд завсарт жанжин эрдэнэ сүр хүч их бие хүч төгс эрдэнийн хуяг дуулга өмсөн илд барьж бусдад хөнөөлгүй бөгөөд дайснаас тийн ялах эрдэм лүгээ төгсөд сана.

Бас заримдаа гэрийн эзэн хэмээн номолсон ч байдаг тул гэрийн эзэн хэмээх ба жанжин хэмээх байвал түшмэл гэрийн эзэн дотор хураагдах хэрэгтэй бөгөөд түшмэл гэрийн эзэн хэмээн гарвал жанжин түшмэлийн дотор хураагдана. Түшмэл гэрийн эзэн хэмээх байвал гэрийн эзэн түшмэлийн дотор хураагдах хэрэгтэй ч мэдэж үйлд.

Их сангийн хумх хэмээхээр үлэмж биет яруу бус дуут хоёрын хооронд зүүн хойд завсарт алин санасан есөн хүсэлийг төгс эдлэл шамдалгүй гарах их сангийн хумх тэнгэрийн эдийн хоолойн чимэг лүгээ сэлт гарсанд санаад цомцогуудыг зэргэмжчилин байгуул.

Гэнхэлзэгч охин тэнгэр хэмээн өгүүлэх цагт хүрдийн эрдэнэ дотор талд гэнхэлзэгч охин тэнгэр биеийн өнгө цагаан хоёр гараар бүжиглэхийн ёсыг үзүүлсэн.

Эрхин охин тэнгэр хэмээхээр эрдэнийн дотор талд эрхин охин тэнгэр шар өнгөтэй хоёр гараар эрхи барьсан.

Аялгуу охин тэнгэр хэмээхээр хатан эрдэнийн дотор талд аялгуу охин тэнгэр биван хөгжимдсэн.

Бүжиглэгч охин тэнгэр хэмээхээр түшмэлийн дотор талд бүжиглэгч охин тэнгэр ногоон өнгөтэй хоёр гараар бүжиглэсэн.

Цэцэгт охин тэнгэр хэмээхээр зааны дотор талд цэцэгт охин тэнгэр цагаан өнгөтэй элдэв цэцэг дүүрсэн сав барьсан.

Хүжит охин тэнгэр хэмээхээр морин эрдэнийн дотор талд хүжит охин тэнгэр шар өнгөтэй хүжит сав барьсан.

Зулт охин тэнгэр хэмээхээр жанжин эрдэнийн дотор талд зулт охин тэнгэр улаан цайвар өнгөтэй зул барьсан.

Үнэртэн охин тэнгэр хэмээхээр сангийн хумхын дотор талд үнэртэн охин тэнгэр үнэртний лавай барьсан.

Тэдгээр бүгд үзэсгэлэнтэй дүрстэй идэр залуухан эрдэнийн чимэг лүгээ төгс царай нь мэшгэлзэлгүй үзүүрхэн харах тэргүүтэн байдал үзэсгэлэнтэй хүслийн дэлгэрүүлэх байдал лугаа төгсөд санаад цомцогуудыг тус тусад нь байгуул.

Наран хэмээн өгүүлэх цагт гэнхэлзэгч охин тэнгэрийн дотор талд цомцог байгуулж наран хот мандал галт болрын чанраас бүтсэн цар нь таван зуун арван нэгэн бээр ба зузаан

хагас бээр лугаа сэлт тав илүү лүгээ сэлт халуун бөгөөд гэгээн гэрэл цацраг арван зүгт цацарсанд сана.

Саран хэмээн өгүүлэх цагт аялгуут охин тэнгэрийн дотор талд цомцог байгуулж саран мандал усан болрын чанараас бүтсэн цар нь тавин бээр зузааны хэмжээ наран лугаа адил сэрүүн гэгээн гэрэл цацраг арван зүгт цацарсан хоёр тус тусын дээр алтан хүрээгээр хүрээлсний дотор үлшгүй ордон элдэв эрдэнээр бүтсэн зугаалах цэцэрлэг галвирваасан мод тэргүүтэн тэнгэрийн орон лугаа адил буйд сана.

Эрдэнийн шүхэр хэмжээ өгүүлэх цагт эрхин охин тэнгэрийн дотор талд цомцог байгуулж бэдүр्यान эшэнд алтан мянган хигээст илтэд дэлгэгдсэн тэнгэрийн эдийн сайн хувцас банзалигагаар бүрхсэн бөгөөд индранил охь лугаа төгс хормойн амсарт цэцэг лүгээ маргад гарэгада, очир алмааз тэргүүтэн хагас торон унжлага, бүтэн тор унжлага нэлмийн буусан шүхэр гарсанд сана.

Зүгээс тийн аялсан дуаз хэмээн өгүүлэх цагт бүжигч охин тэнгэрийн дотор талд цомцог байгуулах бөгөөд алтан эшэнд тэнгэрийн сайн хувцсаас бүтсэн дуаз гурван хэлтэй хагас сар очир эрдэнэ гурав давхарласан охь лугаа гөвүүр ба өчүүхэн хонхны дуу сил сил дуурсан торгон дунд хэлэнд гарьд арслан, торгон хэл баруунд ловой матар хурсанаас гарсан бие лавайн хэлбэртэй матар толгойтой.

Торгон хэл зуунд хагас халиу хурсанаас гарсан загас биетэй халиу сүүлтэй үзэсгэлэнтэй чимсэн дуаз гарсанд сана.

Гол тэнгэр ба хүний цог учрал хэмээх тэргүүтэн өгүүлээд голд цомцог балхтал цогцлоогоод өвөр бусдын бие төгс эдлэл буяны үндэс бүхнийг тахлын эд юу байгаагийн байдалд бодоод ергөх хэрэгтэй.

**Хоёрдугаарт. Их бандид Наро ба тэргүүтэн Энэтхэгийн их  
бүтээлчид ба Богд лам Их Зонхаба нарын заншил мэт  
мандалын цомцог хорин гуравтыг өргөх ёс нь**

Энэтхэгийн гол номлолын угын урьд татсан мэт Энэтхэг хэлээр өргөх ёсыг нь Богд лам бээр таван зэргийг нэгэн дэвсгэрт төгсгөхийн улаан хөтөлбөрт байгуулсан мэт бөгөөд түүнийг төвд хэлэнд орчуулаад өргөх ёсыг Богд лам бээр Наровагын зургаан ном сэтгэл итгэмжлэхүй төгс гуравт зарлигласан мэт үйл алины үүднээс өргөсөн ч ялгуугүй боловч үүнд орохуй хялбарын тухайд “Сэтгэл итгэмжлэхүй төгс гурав”-чилэн номлож үйлдэе.

Тэрийг ч богд лам бээр хумхын эрх ганга мөрний усны үргэлжлэлийг өгснөөр эгэлийн үзэгдэл шунал биеийн хирийг угаамуй хэмээсэн мэт тарнийн мөрд орохын үүд нь боловсруулагч шалтгаан дөрвөн эрх тийн ариуныг олох бөгөөд эрхийн дээрээс мөрний хоёр зэрэг үр лүгээ сэлтээ дохио учруулж магадлахын мэдэл тогтох аваас эрх олсонд агуулахаас энэ адилын дохиог учруулалгүй эрхийн эдийг нүдээр үзэж эрхий зан үйлийг чихээр сонсон суувч хоёр зэргийн боловсруулагч шалтгаан эрхийг олоход бэрхтэй болой.

Тэр мэт хумхын эрх өгөхөд шүтсэнээр өөрийн биеийг тэнгэрийн егүзэрт бясалгасанаар эгэлийн үзэгдэлийг тэнгэрийн омогт суралцсанаар эгэлийн шунал илт болохыг хаах үндэс боловсрогдох биеийг эгэлд барихын тийн атгыг цэвэрлэхэд эрхшээх ба мөр цагт анхдугаар зэргийн егүзэрийн гишүүн бусдын тус үйлийн чуулган лугаа сэлтийг бүтээхийн чадлыг агуулсанаар үр бусдын тус хотол чуулсан хувилгаан бие бүтээн үйлдэх авьяас агуулагдахыг номослон мэт мөр цагт үүсгэлийн зэрэгт суралцахын цагт ч хумхын эрхийн цэвэрлэл урвуулга үйлдэл гурав лугаа адилтгаж мөр болгох ёсонд бясалгах хэрэгтэйчилиин

гадаад мандалыг өргөх цагт ч эгэлийн үзэгдэл шунал илт болсоныг хаах ерөндөгт одох нэг хэрэгтэй оньсоор гадаад хумхын эрх лүгээ барилдсан мандал хэмээн дээдсүүд зарлигласан

Тийм учраас хумхын эрхийн мөр лүгээ барилдсан зоригдолуудыг тэтгэх ёс лугаа сэлт мандалыг өргөхөд гарын алгаар мандалыг арчсаны хэрэг нь түүнд бодийн сэтгэлийн судал буйд номолсон магад утгандаа хоосон чанарын судал буйд таалдаг.

Одоо судал тэрийг ч дахин мандал арчихын чуулганы хүчээр сэргээгээд хоосон чанарыг онох цагт судал түүний дотор хий гүйвэл биеэс шагшаабадын анхилам үнэр босдог хэмээн зарлигласан байдаг.

Тэндээс **Ум вазра вүми а хум** алтан дэлхий хэмээхийн үесд сав шим урьд нэг хоосорсоноор хойд сав шим тогтох цагт хий гал ус шороон мандал зэрэгмжлэн тогтох лугаа зохилдуулан доод суурь хий ус, алтан газар дэлхий тогтсонд санаад цэцгийг түгээн дэлгэ.

**Ум вазра рэхэа хум** төмөр уул цагираг хэмээгдэхийн үесд зах төмөр уул бүсэнд санаад цэцэг эргүүл. Төв болон дөрвөн зүгт цомцог байгуулаад голд сүмбэр уул хэмээх тэргүүтэн ба тив өөр өөрийн баруун зүүнд цомцог байгуулаад бие ба үлэмжт биет хэмээх тэргүүтэн хийгээд дөрвөн тивийн дотор талын дөрвөн зүгт цомцог байгуулаад жанжин эрдэнэ хэмээгдэх тэргүүтэн ба морин эрдэнийн дотор талд цомцог байгуулаад нар сар хэмээн өгүүлж сүмбэр уул, дөрвөн тив, найман бага тив, эрдэнийн найман зүйл лугаа сэлтийг урьд номолсончилин тодорхой талбиад тэдгээр бүгд ч мөн чанар нь амгалан хоосон хоёр үгүй бэлгэ билиг бөгөөд байдал нь уул тив тус тусын

байдалд ургасан тэр ч сав бүгд үлшгүй ордон шимийн амьтан бүхэн тэнгэр ба охин тэнгэрийн байдалтай өөр өөрийн буяны чуулган ба огоот цэвэрлэгдсэн бүгд гадаад дотоод нууц тахилын эд элдэвийн байдалтайг барьсанд санаад өвөр бусдын бие хэл сэтгэл хэмээх тэргүүтэнг өгүүлэх цагт сүмбэр уул тэргүүтэн цомцог нэжгээд нэжгээдийн дээр лянхуа гол хорин тав машид дэлгэрсэний хүйс ба гишүү нэжгээд нэжгээдэд хутагт хотол сайн хоёр гараа зүрхэнд алгаа хавсарсаны зовсон сэтгэлчилингийн эрхэт хааныг барьсан нэжгээд нэжгээд оршсоны хүйснээс лянхуа гол хорин тав нэжгээд буй бөгөөд гишүүн цэцэг нэжгээд нэжгээдэд хотол сайн нэжгээд нэжгээд ба түүний хүйснээс лянхуан гол ба хотол сайныг урьдахчилин цацраагаад огторгуйн орон бүхэнд түгсэнд бодоод хотол сайн нэжгээд нэжгээдийн эргэн тойронд өвөр бусад хамаг амьтаны бие төгс эдлэл гурван цагт хураасан буяны чуулган лугаа сэлт бүгдийг дөрвөн уст чухал эдлэгч, хүслийн таван эрдэм, өлзийт тэмдэг, эд тэргүүтэн гадаад тахил, идээ сэлт амтат шим гайхамшигт балин ба таван рашаан тэргүүтэн дотоод тахил, лянхуат тэргүүтэн мудра сэтгэлд зохилт идэр гуалиг цогт охин тэнгэрүүд, нууц тахил, тахигдахуун тахигч бүгд хоёр үнэн ялгалгүй тийн цэнгэлд ургуулах хоосон чанарын тахил лугаа сэлтийг оюунаар босгоод өргө.

**Тэр мэт өргөх мандал нь Хумхын эрх лүгээ  
барилдсан ёс нь**

Сав шим бүгдийг эгэлд баримтлах тийн атгагыг нь хаасанаар сав бүгд ариун бэлгэ билигийн үлшгүй ордонд бишрэх үйлдлээр үлшгүй ордон бодитой оршин бүтэхийн боловсруулагчид одох бөгөөд шимийн амьтан бүгдийн дүрс тэргүүтэн эс ариуссан таван цогцын үзэгдэлийг хааснаар бэлгэ билигийн тэнгэр ба охин тэнгэрийн мөн чанарт бодох мөр болгон толь мэт бэлгэ билиг тэргүүтэн таван бэлгэ билигт илт үйлдэх авьяасыг агуулсан гадаад хаан төрийн долоон эрдэнийг өргөх үйлдлээр номын хаан хаан төрийг эрхшээх шүтээн барилдлага жигдэрдэг.

Нар болон сараар үнэмлэхүй гэгээн гэрэл ба илбийн бие бодитойг бэлгэдэх буюу тэр хоёрыг бүтээгч билиг хоосон чанар ба арга хамт төрсөн их амгаланг бэлгэддэг. Хумхын эрхээр бүтээх үүсгэлийн зэрэг засварт егүзэр гурван дияанаар сав шимийг цэвэрлэх нь эрхэм мөн мэт мандал энэ нь засаж оюунаар орныг цэвэрлэх арга мөн учир хумхын эрх лүгээ барилдсан хэмээн номолсон.

## **Гуравдугаар. Цагийн хүрдний ёсны есөн цомцогт мандалыг өргөх ёс нь**

“Хураангуй үндэс”-ээс хэмээгдэх алт, сэлт, цэцгээр мандал үйлдсэнээр багшид залбир хэмээсний таалалын утгыг тодруулахад “Очир зүрхэн тайлбар”-аас дээдийн номыг уншуулахын тусад өмнө мандал өргө.

Бас таван язгуурын чанарт хийн мандал номын дугуй зүүн үлэмж биет хэмээх тэргүүтэнг номолсон мэт өргөх ёсонд **Ум вазра вүми а хум** очирын дэлхий хэмээгдэхийн үес доороос зэргэмчилин хий, гал, ус, шороон дөрвөн мандал суулган дотор суулга оруулсан мэт давхарлагдан оршсон зузаан өндөр нь таван зуун бээр нэжгээд тэгш бөгөөд шороон мандалын гадна зах хүртэл нэг буман бээр ба доодууд түүнээс хоёр дахин илүү байхад санаад цэцэг дэлгэ.

**Ум вазра рэхэ а хум** төмөр уулан цагираг хэмээгдэхийн үест долоон далайн давст далайн гадна гал мандал оршсон долоон уулт очир уулан төмөр уул эргэн тойронд бүтсэнд санаад цэцэг эргүүл.

Голд уулын хаан сүмбэр уул хэмээгдэхээр шороон мандалын төвд уулын хаан сүмбэр уулын өндөрт нэг буман бээр ба түүний дээрх огторгуйд сүмбэр уулын хоолойд хорин таван мянган бээр тэндээс дээшх нүүрэнд таван мянга тэндээс дээш үснэрт хорин таван мянган бээр бөгөөд сүмбэр уулын ёзоороос үснэрийн үзүүр хүртэлхийг нийлүүлбэл хоёр буман бээр буй.

Түүний хэлбэр нь дугуй байдалтай хүрээ доош уруу унжсан сүмбэр уулын эргэн тойроны гадаад зах лугаа тэгш бөгөөд хүрээний доод түүний завсараас сүмбэр уулын үзүүр хүртэл хувь тэгш дөрөвт хуваасаны завсараас хүрээний илүү дөрөв уруу унжсан хүрээний доодоос дээш цар нь улам их болж



одсоноор дээрх хүрээ сүмбэр уулын үзүүр лүгээ тэгш бөгөөд зүгт дэлгэрсэний зах нь сэрүүн уул лугаа харалдаа тэгш сүмбэр уулын ёзоор нарийн бөгөөд үзүүртулам их буйн ёсонд бодоод голд нь цомцог байгуул.

Зүүн үлэмж биет, урд Замба тив хойд яруу бус дуут, баруун үхэр эдлэгч хэмээн өгүүлж дөрвөн зүгт цомцог байгуулах цогт сүмбэр уулын ёзоор захаас зах хүртэлхэд арван зургаан бээр буй бөгөөд түүний захаар нэг мянган бээрээр дугираглан эргэснийг эргэн тойрон хэмээдэг.

Тэндээс арван зургаан бээрээр хүрээлсэнийг төгс эдлэлийн газар ба тэндээс усан мандалын дотор зах хүртэлхэд хорин таван мянган бээр хүрээлсэнд долоон тивт их Замба тив буюу үйлийн газар хэмээдэг.

Төгс эдлэлийн газрын гадаад захаас гадаад зах хүртэлхэд таван мянган бээр буйн эрхээр сүмбэр уулын үзүүрийн гадаад захаас гадаад зах хүртэл бас таван мянган бээр буй.

Үйлийн газар зүг завсарт арван хоёр бүхэл хувьд хуваасан газар арван хоёр тив буй тул зүүн тив хий махбодийн чанартай хэлбэр нь дугуй буюу хагас дугуй байдалтай үлэмж биетний тив.

Урд гал махбодийн чанартай хэлбэр нь гурвалжиний байдалтай Замба тив, хойд усан махбодийн чанарт хэлбэр хагас дугуй буюу дугуй байдалтай яруу бус дуут тив, баруун шороон махбодийн байдалтай хэлбэр нь дөрвөлжиний байдалтай үхэр эдлэгч ба тэдгээр ч өөр өөрийн бага тив лугаа сэлттэй байна.

Замба тив өчүүхэний газрын энийн хагас дотор мянга хагас сэлт бээр арван хоёрын газрын хувьд урд хойд зургаан хэсэгт үйлдсэний хувиудад дотроос зэргэмчилин төгс цаст,

Гэлаша, Хятад, Ли орон, Төвд хутагтын орон лүгээ зургаан оронд оршсон болой.

Түүн лүгээ хувь сацуу төгс эдлэлийн газар арван зургаан мянган бээрийн дотроо гадагш хувь сацуу арван наймд хуваавал хувь нэжгээдэд найман зуун наян найман бээр гурван жандаг нэг мянга зуун арван нуман алд илүү нэжгээд буйд зургаан тив, зургаан далай, зургаан уул солбин оршдог бөгөөд дотроосоо зэргэмжчилин хувь анханд саран тив хоёрдугаарт балын далай, гуравдугаарт хөх гэрэлт уул түүнчилин цагаан гэрэлт Гүша, Миаимжи, Түнтүн, Догшин лугаа зургаан тив тос, тараг, сүү, ус, архи лугаа зургаан далай Манара, Нишада, эрдэнийн гэрэлтДона сэрүүн уул лугаа долоон уул нугууд солбин оршонд сана.

Тэндээс зүүнд Раха, урд нар хойно сар, баруунд цагийн гал хэмээн өгүүлэх бөгөөд урдын цомцогын дотор талд дөрвөн цомцог байгуулах цагт нар сар хоёр огоот алдаршсан мэт бөгөөд рахын хот мандал хийн чанартай өнгө нь хөх цайвар цагийн гал хот мандал шороон чанартай өнгө нь улаан шаргал хоёулангаас өөрийн гэрэл цацарсанд санаад өргө.

Тэр мэт есөн цомцогын мандалыг өргөх цагт сүмбэр уул тивийн орших ёс нь хэлбэр хэмжээ тэргүүтэнг цагийн хүрдэн өөрөөс номолсон лугаа зохицолдуулан бодох хэрэгтэй тул үүнээ товч төдий номлоё.

## **Дөрөвдүгээрт. Долоон цомцогт мандал**

### **өргөх ёс нь**

“Ловон Шила Самвава-гын хоосон чанарын хураангуй увдис”-аас өөрийн хүссэн ялгавараар ямар хэдий хүссэн цомцог үйлд хэмээсэн ба “Зүрхэн чимэг”-ээс сүмбэр уул нар сар дөрвөн тивийг Вазра рэхэ хэмээн өгүүлсэнээр ариун сэтгэлээр өргөж үйлд хэмээгдэх таалалд шүтсэнээр зохиосон учир мандал газар дэлхийг үнэр анхилам хүжисээр сүрчин алтан дэлхийд гадаад төмөр уул огоот бүтсэн цэцгийг дэлгэж хүрээлсэний төвд сүмбэр уул гадуур нь дөрвөн эрхэм тив хүрээлсэн бөгөөд нар сарны чихний эшан чимгээр чимсэн үүнийг бурханы таалал үүсгэсэн ба ерөөлөөс мэндэлсэн ариун оронд сэтгэлээр хүсэн зоригдохын үүднээс өргөсөн хүчид шүтсэнээр амьтан бүхэн цувиралт сэлтийн хир лүгээ хагацсан орныг төгс эдлээд дөрвөн биеийн хутгыг олох болтугай хэмээн өргөнө.

Цомцогыг байгуулах ёс урд дахин дахин номолсон тул түүнээс мэдэх учир эс бичив.

## **Хоёрдугаарт. Дотоод нууц эрх лүгээ**

### **барилдсан мандал өргөх ёс нь**

Далай лам Галсан Жамц бээр өөрийн бие, хэл, сэтгэл, цогц, махбодь төрөн түгэхүйнүүд огоот урваснаас тоолшгүй ертөнц сав есөн хүслийн хотол чуулсан сангаар дүүрсэн үүнийг лам бурхадын чуулганд өргөмүй хэмээсэн мэт өөрийн бие сэтгэлийн хувь нарийн бүдүүн бүгдийг бүтээлийн суурьт үйлдээд тэр ямагтыг огоот хувиргаснаас уул тив тэргүүтэн тахилын эдийн мандалд бодоод өргөх хэрэгтэй. Үүний үлгэрийн үүднээс номолвол цагаан цэмбэний урьд агшинаар чухал авах хийгээд энгэсэг будаг агшинаар чухал авах хийгээд энгэсэг будаг хойтоор хамт нэгэн үйлдэх нөхцөл болсонд шүтсэнээр цэмбэний агшин сүүлд улаан болох лугаа адил өөрийн биеийн арьсыг хуулсанаар хамт нэгэн үйлдэх нөхцөл ба мандалын дээрх газар дэлхийгээр чухал аван үйлдэж огоот урваснаас дотоод мандалын их эрхэт алтан дэлхий ба түүнчилин өөрийн биеийн их цус рашаан усаар цардаж гэдсүүд нь төмөр хүрээ цээж лүгээ нурууны үеэс сүмбэр уул гар хөлийн мөч гурав гурав лугаа барилдсан дөрвөн гишүүнээс дөрвөн тив гарын бугалга ба хөлийн шагай завсараас хяргаад толгой хоёр хоёр ба эвдэсний найман хувиас найман бага тив толгойноос сүмбэр уулын дээрх ордон мах цус үлдсэнүүдээс долоон эрдэнэ ба их сангийн хумх, хоёр нүднээс нар сар зүрх сэтгэлчинлингийн эрдэнэ өөрийн биеийн таван цогц, зургаан төрөн түгэхүй таван эрхтэн таван орон тэргүүтэн ба биеийн далан хоёр мянган судал ба түүнд оршсон хий махбодь ба бодь сэтгэлийн дусал тэргүүтэн товчилвоос биеийн хувь хэсэг бүгд дутуу үгүй нүгүүдээр тэнгэр хүмүүний есөн хүслийн төгс эдлэл сэтгэшгүй ба гадаад дотоод нууц тахилын үйлэн далайнаар огторгуйн орон дүүрсэнд бодоод

ачит үндэсний багшид өргөх болой. Үүнийг нууц эрх лүгээ барилдсан мандал хэмээгдэхийн учир шалтгаан аль вэ? хэмээвэл Богд лам бээр нууц эрхийн бэлгэ билгийн рашааныг амссанаас хэлний орон хийн гүйдэл тарнид ургамуй хэмээсэн мэт нууц эрхээр хий хэлийг ангидад барих хир ариусан бие, хэл, сэтгэл гурвын нарийн бүдүүнүүдэд эгэлийн шуналын хирээс аглагдан үйлдээд илбийн биеийг бүтээхийн мөрийг эрхшээгчилин дотоод мандал энэ нь өөрийн бие судал махбодь лугаа сэлтийг эгэлд шунахуйг хаасанаар бэлгэ билигийн чанартад бодоод өргөснөөр бие сэтгэл нарийний дээрх хирүүдийн цэвэрлэгчид одох бөгөөд үүнд үтсэнээр дөрвөн махбодь бүдүүний бие сэтгэлийн чуулганыг ч эгэлд шунахыг аглаглуулан үйлдэж чадах бөгөөд түүний хүч буюу чадлыг дээш арвитсанаас илбийн биеийг бүтээхийн бодовсруулагчдад одоход таалсанаар нууц эрх лүгээ барилдсан хэмээн номлов.

## **Гуравдугаарт. Нууц билигийн эрх лүгээ барилдсан мандал өргөх ёс нь**

Богд лам бээр хамт төрсөн баясгалангийн гохоор сэтгэлийн төрөлхтөнг үнэмлэхүйн төвд тат хэмээсэн мэт хий бүгд үхэлийн зэрэг адил зүрхний үл эвдрэхэд шингэсний гэгээн гэрэлээс боссон илбийн бие тэр дахин утгын гэгээн гэрлийн агаарт огторгуйд солонго замхарах мэт цэвэрлэгдэх цагт хамт төрсөн амгалан ба хоосны бэлгэ билигийг ялгалгүй болсон тэр хум үсгийн байдалд цацарч огоот урваснаас баясгалангийн хувь арван зургаа ба хоосны хувь арван зургаа бүд гучин хоёр сүмбэр уул тив тэргүүтэний байдалд бишрээд өргөх болой.

Тэр мэт өрөх мандал нь билигийн эрх лүгээ барилдсан бөгөөд гуравдугаарх эрхээр алин үзэгдэлийг амгалан хоосны бэлгэ билигт ургуулах чадлыг агуулах бөгөөд тэр мэт ургуулахад түйтгэр хирийг цэвэрлэхчилин мандал энэ нь хувилгаан суурь хамт төрсөн амгалан хоосон ялгалгүй бэлгэ билиг мөн төдийгөөр үл барам хувилгаан мандалын хувь тус тусад ч баясгалан ганц хоосон ганц ганц төдий бус амгаланг хоосоноор тамгалан хоосныг амгалангаар эзлүүлэн үйлдээд өргөсөнд шүтсэнээр алин үзэгдэл бүгд эгэлд үзэгдэх эндүүрэл мэдэл мууг цэвэрлэгчид одсоноор амгалангын бэлгэ билиг ба хоосны бэлгэ билигийг ангидад баримтлах сэтгэлийн хирийг ариусган чадах бөгөөд орон хоосон чанар ба оронт хамт төрсөн их амгалангийн бэлгэ билиг хоёр усанд ус хийсэн мэт ялгалгүй нэгэн чанартай болсоны бэлгэ билигийг эрхшээх авьяасыг агуулан чадахын эрхээр билигийн эрх лүгээ барилдсанд номолсон.

## **Дөрөвдүгээрт. Хоосон чанар үгийн эрх лүгээ барилдсан мандалыг өргөх ёс нь**

Богд лам бээр хослон орох утганд нүүр таниулсанаар эцэст хүргэх оньсонд сэжигийг тосд хэмээсэн мэт хослон ороход хоёр зүйл байх хэрэгтэй тул үзэгдэл зүг аргын өвөрчилин бэлгэ найргаар чимсэн төгс жаргалангын илбийн бие ба хоосон зүг билигийн өвөрчилин үнэмлэхүй гэгээн гэрэл маха мудра-гын бэлгэ билиг хоёр болой. Хоёр үзэгдэл нарийнаар ч тасралтгүй тэгш агуулах даган олох нэжгээдээр агуулагдалгүй цаг нэгэнд чуулсаныг хоёр үнэн ялгалгүй бэлгэ билиг хэмээгдэх бөгөөд энэ адилын бэлгэ билиг тэр хум үсгийн байдалд цацарч огоот урваснаас сүмбэр уул, тив тэргүүтэний байдалд хувилгаад өргөх болой.

Энэ нь үгийн эрх лүгээ барилдсан ёс нь дөрөвдүгээрх эрхийн онол нь янагуух үнэн ариун илбийн бие ба үнэмлэхүй үнэн утгын гэгээн гэрэл хоёр шүтэгдэхүүн шүтэгч ялгалгүй чуулсаныг хослон орохуй сэтгэшгүй хэмээдэг бөгөөд бэлгэ билиг тэр нь мөрийн онол эцэст хүрэх бөгөөд үүнд ч бэлгэ билиг тэр ямагт мандалыг өргөснөөр хослон ороход мэдэл үүсгэн авьяасыг сэргээх үйлдэл ба шүтэн барилдлага буйн онолоор үгийн эрх лүгээ барилдсанд номолсон.

Мандал хойт гурвын оньсуудыг мэдэхэд төгсгөлийн зэргийн гүн мөр таван зэрэгт мэдлэг сайтар тогтох нь их чухал тул үүнд үсэг олондоос сэжигдэн эс бичсэн тул богд ламын зарлиг тэргүүтэн их гол номлолуудыг үзэх онохыг сайтар үйлдээд мэргэжиж үйлдэх хэрэгтэй.

## **Тавдугаарт. Тэдгээрүүдийг увдис гарын авлагыг үзүүлэх нь**

Орон гэрийг цэвэрлэн үйлдээд зоригдолын шүтээн лагшин зарлиг тааллын шүтээнийг дэлгэн тахилыг бэлтгэх тэргүүтэнийг бусдаас гарсан мэт сайтар бүрдүүл.

Мандалын тахилын үе үүнд ламын егүзэр аль нэгтэй барилдах хэрэгтэй учир өөрөө Гандан Лхавжа-гын хөтөлбөр олсон бол түүн лүгээ барилдсан ёс ламын егүзэрийн хөтөлбөр мэт ба ламын тахилга амгалан хоосон ялгалгүйн хөтөлбөр олсон бол түүн лүгээ барилдуулан үйлдэх бол бүтээлчин бээр амгалант дэвсгэрт суугаад сэтгэлээ засаад их амгалангийн агаараас өөрөө лам бурхан хэмээгдэхээс сэтгэшгүйгээр дүүрэв хэмээхийг хүртэл өгүүлээд аврал одуул.

Ерөнхий болон ялгамжит сэтгэл үүсгэ сав шим тахилын эд лүгээ сэлтүүдийг адистэдлэ. Амгалан хоосон ялгалгүйн гүн огторгуйд хэмээгдэхээс хослон орохуй очир дарийн эрхэтийг олохын тухайд зориулмай хэмээхийг хүртэл чуулганы орныг тодорхой талбин заллага оршоон соёрхох угаал ба долоон гишүүнийг өргөхийг урьд талбисанаар мандалын бодит суурийг өргөхүйд урьд номолсон мэтийн зоригдолууд бүгдийг тодорхой үйлдээд орон дэлхийг өргөхийг өчмүй.

Ум вазра вүми а хум их эрхэт алтан дэлхий хэмээгдэхээс ялгууснй дуаз төвд тэнгэр хүмүүний цог учирал хотол чуулсан дутуу үгүй орон тийн ариун тэр ямагтыг ачит язгуур ба үндэс лүгээ сэлтийн цог төгс дээд багш нар ба ялгамжтай чадагчын эрхэт их очир дарь богд Лувсан Дагвын бурхадын чуулган нөхөр лүгээ сэлтүүдэд өргөж үйлдэе.

Их нигүүсэлээр амьтаны тусад таалан соёрх таалсанаар би тэргүүтэн огторгуй лугаа сацуу хамаг амьтанд дээд хийгээд



нийтийн шидийг хоцролгүй өгөн соёрх хэмээн гучин долоон цомцогт мандал өргөөд газар дэлхийг хүжсээр сүрчин хэмээгдэхээ орныг эдлэх болтугай. Идам энэ Гүрү лам Радна чухаг дээд мандал орон дэлхий Хам огторгуй Ниря даями өргөж үйлдэе хэмээгдэхийн утгыг нийлүүлбэл эрдэнэт чухаг дээд гурван зүйл хурсаны чанарт багшид орон дэлхий огторгуй лугаа сацуу энэ ямагтыг өргөж үйлдэе.

Тэр мэт лам ба авралын орнуудад мандал өргөн баясгаад лам ба чуулганы орон бүгдийн лагшин зарлиг таалалын адистэд ба эрдэм ба шид бүгд өөрт шингэсэнд бодоод мандалыг өөрт зүглүүлэн дотогш хураа.

Тэндээс Шаши бойжүгма-гаар тоо хэр төдийг хүссэн мандал өргөхийг бүтээх аваас дахин хорин нэгэн цомцогт мандалыг өргөж үйлдээд Ум вазра вүмү а хум их эрхэт алтан дэлхий Ум вазра рэхэ а хум төмөр улаан цагираг, голд уулын хаан сүмбэр уул, зүүн үлэмж биетэн, урд Замбу тив, баруун үхэр эдлэгч, хойно яруу бус дуут, бие ба үлэмж биет, гөвүүр, гөвүүрт бус, хэлбэрэлт төгс дээд мөрөөр одогч, яруу бус дуут, яруу бус дуут саран, зүүнд заан эрдэнэ, урд гэрийн эзэн эрдэнэ, баруунд морин эрдэнэ, хойно хатан эрдэнэ, зүүн урдад жанжин эрдэнэ, баруун хойно хүрд эрдэнэ, баруун хойно чандмань эрдэнэ, зүүн хойно их сан өөрийн зүүнд нар баруунд сар өвөр бусад бие, хэл, сэтгэл гурваас адистэдлэн соёрх.

**Тэндээс Дотоод мандал өргөх нь:** Арвис их эрхэт алтан дэлхийн дээр их цусан рашааны усаар цардуул талбин мах, цус, цэцэг байрлуулан цомцоглуулан гишүүнүүдээс дөрвөн их тив ба чухал гишүүн нь найман бага тив болсоны төвд цээж эрдэнэ олонтоос давхарласаны үзүүрт толгой тийн ялгуусан

үзэсгэлэнт ордон, хоёр нүд харанхуйг арилгагч нар сар. Зүрх нь чандмань эрдэнэ. Эрхтэн дотор огоот урвасанаас тэнгэр хүмүүний хүсэлийн эрдэм цог учирал хотол чуулсан ачит үндэсний багшийг баясгахын тухайд өргөмүй.

**Нууц мандал нь:** Аргын дээд их амгалан очирын цэнгэл наадмаар хоосон зүг билигийн лянхауд цэнгэснээс цувиралтгүй хамт төрсөн баясгалангын өвөрчилиний сав шим хот мандалыг байгуулсанаар баясгах болтугай.

**Хоосон чанарын мандал нь:** Их амгалан хотол сайны тийн цэнгэлийн тахилын үүлэн юунд ч ургах илбүүдийг анханаас өвөрчилин хоосонд мандал олсон хослон орохуйн дээр үгүйн тахилаар баясгах болтугай хэмээн өргөөд гурван их тусын үүднээс залбирах аваас би бээр буяны саданд эс бишрэхээс эхлээд эгэлийн үзэгдэлд нарийн хүртэлх чанх буруу элдэв оюуны бүгд хаагдахад адистэдлэн соёрх.

Буяны саданд бишрэхээс эхлээд үл суралцагч хослон орохуй хүртэлх чанх буруу элдэв оюун бүгд амар хялбар төрөхөд адистэдлэн соёрх

Нөхцөл гадаад дотоодын харш нөхцөл зэтгэр бүгдийг чухал амирлуулахад адистэдлэн соёрх хэмээн гурван удаа буюу долоо тэргүүтэнээр дуршил хатуу хүчтэйгээр залбираад бурхан бодьсатва бүхэн аас зэргэмжчилин суралцаж үйлдэе хэмээн гурван удаагаар ерөөл орохуй хоёр ба лам бурхан бодьсатва бүхэн аас амьтаныг гаслангаас нөгчсөнд байгуулмуу хэмээх гурван удаагаар нарийн зан үйлийн үүднээс барь. Тэр цагт би төрөл буйгаас Тэнгэр Асура тэргүүтэнг баясгаж үйлдэе хэмээн сэтгэл үүсгээд дуршилыг үүсгэ.

Бодийн дээд эрдэнэт сэтгэл тэргүүтэн ба хоосон чанарын үзэл тэргүүтэн ба Шагшаабадын сургаал тэргүүтэн ба Зөөлөн цогт баатар тэргүүтэнээр мөрд ерөөлийг агуу их талби.

Тэндээс мандалыг өөрт зүглүүлэн хураагаад эрдэм гарах орон шагшаабадын их далайд хэмээгдэхээс хотол чуулганы цогт цэнгэхийн өлзий хутаг орших болтугай хэмээгдэхийг хүртэл уншихчилин тухайлсан залбирал ба самадын эрх өчих хоёр мөрийн зэргийг ургуулан бясалгах ба зүрхэн оршиолгын зоригдол, зориулга, өлзий өгүүлэхүйгээр сүүлийг чимээд хувийн завсарт ор.

### **Мандалд шүтсэнээр үйл бүтээх ёс нь**

Зоригдолын нэмэлтэд шүтсэнээр зөөлөн гурван үйл бүтээх ёс ба мандалыг сор болгон орхих тэргүүтэнээр хатуу үйлийг бүтээх ёс тэргүүтэн байдаг чихний үндэслэлийн удвис лугаа төгс шалгадаг багшийг өнө удаан баясган үйлдэхийн үүднээс амны рашаан ямагтаас мэдэх хэрэгтэй тул бичиж үл чадлаа.

### **Гэвч хэсэг бусаг үйл нэжгээдийг бүтээхийг хүсвэл**

Өвчинг амирлуулахын тухайд бол мандалын завсар зай бүгд арүр, гавүр, гүргүм, задь тэргүүтэн өвчин алины ерөндөг эмүүдээр дүүрсэнд бодоод өргөх.

Ядуурал доройтлыг арилгахыг хүсвэл эрдэнэ ба хувцас, торго тэргүүтэнээр дүүрсэнд бодох.

Оюун ухаан болон билигийг дэлгэрүүлэхийг хүсвэл мэргэд ба бандида нарын эрдэм бүгдийг хоёр ирт илтний байдалтай бодоод өргөх.

Насыг дэлгэрүүлэхийг хүсвэл насны арвис баригч олсон бүтээлчидийн нас эрдэм бүгдийг хасны байдалтай бодоод өргөж болно. Тэр мэт гадаад, дотоод, нууц, хоосон чанарын мандалд шүтсэнээр түйтгэрийг цэвэрлэх чуулганыг хураахын арганд шамдах нь энэ хойт хоёуланд тустай дээр үгүй анхааран авлага бөгөөд ялгамжтайд ирээдүйд төгс эдлэх орнуудыг сэтгэл бодолоор ариун орны ёсонд мөр болгон үйлдээд багшид өргөхөд шүтсэнээр сэтгэлийн дээрх хирүүд ариусах үзэгдэлийн хувиас ариун оронг бодитой бүтээхийн шалтгаан чуулган сэтгэшгүйг хураан чадах тул ёс үүнд шамдах хичээлийг султгалгүй үйлдээд едөр шөнө бүхэнд зүрхэнийг авч үйлд.

### Өгүүлрүүн

Орнуудын өвөрчилин хоосон ч үзэгдэх орон  
Орны дээд далайд бишрэх мандал орныг  
Орны дээд багшийн өмнө сайтар мөргөмүй  
Орныг цэвэрлэн буяны чуулганыг ч хураагч энэ буяны  
орон

Эгэл бүхэн ч цувиралт сэлт тариаланд  
Алжаан ядравч шамдалаар бүтээн үйлддэг  
Оюун төгс төрөлхтөн бээр ашидын амгалан тариалан  
үүнд бүтээн

Үйл үйлдэх нь хаанаас болох  
Өөрийн даган бараадсан хагацалгүй нөхрийг  
Үйл хийгээд үр мөнд зориглосноор  
Цагаан үйлийн үр тус амгаланы нөхөр ба хагацалгүй  
арганд шамдалтай

Үүнд шамдсан сайн үйлдлээр тахилын хот мандалаар гурван  
ачлалт төгс багшийн мэлмийн замд чухал боловсроод эх болсон  
амьтныг болгоох алгасралгүй таалалын хөвгүүн болгон барих  
болтугай.

Лувсанданжан

# **Тарничидын тангарагийн эдийн тийн агуулга**

**Тарничидын тангарагийн эдийн тийн агуулга  
машид тодорхой зул**

## **Тарничидын тангарагийн эдийн тийн агуулга**

### **Ум сайн амгалан болтугай**

Цог төгөлдөр үл урвах их амгалангын далай элдэв рид адилаын давалгаа зүг чанад хязгаарт цацраах хийгээд хураахын баясгалант Бэлгэ билигийн тоосон олон давхарласан үхэлгүй уулан бэлгэ найрлын буман солонго адилаар машид тэврэн цувиралгүй учирлын төгс жаргалан үнэхээр төгс нигүүлсэлийн үүлэн тулцалдан дуун эгшиг гүнг орчлонгийн чанд хязгаарын амьтанд сайн буяны хурын үргэлжлэлийг байдал бүхэнд барагдашгүй.

Сансар нирвааны илт хүсэлийн цэнгэл юунд ч үзүүлэхийн бүжиглэхийн эрх баялагт очир баригч лугаа ялгалгүй дээд багшийн өлмийд мөргөмүй.

Хот мандалын эзэн бээр хир үгүй үндэсүүдэд дээр үгүй хөлөгнөөр зорчих шавь нарт дүр ёсны дээд гишүүнийг зарлигласан хутагтын их орны шалгадаг төгс мэргэдүүдийн тайлсан утга хоёрдугаар ялгуусны тайлал ямар мэтэд хөвгүүдийн ууган бээр "Егүзэрийг баясгах хурим"-д сайтар номолсоны утгын хувь заримуудыг тодорхой үгээр үүнээ найруулан үйлдэв.

Тэр ч Богд хамгийг айлдагч бээр их нууцын мөрийн зэрэгт Егүзэр бээр шүтэн үйлдэх тангарагийн гишүүн очир хонх, биеийн чимэг тэргүүтний тийн агуулгын мэдэлийг тарничин бүхэн явдал ариуны арганд чухалчилсан ч гол номлол арвитахаас сэжигдэн эс номлосон зарлигын таалалыг хангахын тухайд Хайдүв өгүүлэхүйн наран бээр "Егүзэрийн цэнгэлийн баясгалантын хурим"-д очир хонх, дамар, тооны эрхи, биеийн чимэг, хадамга,

уух сав, өмсөх хувцас, суудал тэргүүтэн бусад долоон зүйл энэ номлохдохууны мөн чанар мөн хэмээн хавсарган номолсоны дараалал ямар мэтэд тодорхой дэлгэрээр ачилан соёрхсон болой. Түүнд оюун лугаа төгс нугууд нь ер нь богд эцэг хөвгүүний эрхэм зарлигт нийцүүлэн үйлдэх аваас үеэсийн утга нугуудад мэдэл өгөх нь туйлаас их бөгөөд зарлигын тусгаарт ч машид гайхамшигт утга олонд магадлалыг олохын хэрэг машид их буй. Ялгамжаатайд тангарагийн гишүүн тэдгээрийн хэмжээ хэлбэр, ямар мэт урлахын ёс, урласнаар машид оршил үйлдэх ёс, ямар мэтэд шүтэхийн ёс тэргүүтэн энэ хийгээд эдгээрүүдийн үндэс хийгээд Энэтхэгийн гол номлол алин хийгээд алинаас ямар мэтэд номолсон хийгээд тэдгээрээс бусдад үзүүлсэн эш ухаан, гоомой үзэлд шүтсэнээр агуулга үйлдсэнүүдэд бололгүй ухаж мэдэхийн үүднээс тийн агуулгын үнэхээрүүдийг лавтай магадлахад Егүзэрийн цэнгэлийн баясгалангын хурим мэтэд дахин дахин ижилсүүлдэн үйлдэх хэрэгтэйгээс утга бүдүүн өчүүхэн нэжгээдийг үзүүлсэн элдэв хэсэг бусаг бичиг нэжгээдэд сэтгэл бат сэлтээр оршивоос Богд эцэг хөвгүүний эрхэм зарлиг ялгуусны зарлиг лугаа ялгалгүй тэдгээрт авьяас тавихын сайн хувцас өнөд хол болох тул эцэг хөвгүүний эрхэм зарлиг тэдгээрт сонсох, унших сэтгэхүйд оюун хийгээд хичээлийн хүчийг үүсгэж үйлд.

Үүнд нь бүх эрхэм зарлиг тэдгээрийн утгыг оюундаа багтаан үл чадах эхлэн суралцагч нарт урьд татсан хавсарган үзүүлсэнээс тооны эрхи, хувцас суудлаас бусад болон тарнийн их мөрийн зэрэг, гал мандалын гол номлол шидийн далайгаас бурханы хумх цутгуур гутгуурын агуулгыг зарлигласануудаас ямар мэтэд үйлдэхийн ёсыг мэдхүй хялбар өгүүлж үйлдэе.



### **Үүнд дөрөв**

Очир, хонхын тийн агуулга

Дамар, биеийн чимгийн тийн агуулга

Хадамгаа, гавалын савын тийн агуулга

Бурханы хумх тосгуур хутгуур шанагын тийн агуулга

### **Анхан. Очир, хонхын агуулгад**

Ёгиос гарсан тийн агуулга

Дээр үгүй үндэсээс гарсан тийн агуулга хоёр буй

**Анхан. Ёгиос гарсан тийн агуулга нь:** Багш гүнтэн бээр “Очир гаргалга”-аас номолсон утгыг товчлон хурааваас таван язгуурын түүнчилин ажирсан хийгээд түүний хоёр язгуураас түүнчилин ажирсанд цэцэг туссан нугуудаар нь түүнчилин ажирсаны хонх, очирьг барьж үйлдээд түүний уг нь алт тэргүүтэн эрдэнээр үйлдсэн хэмжээ нь арван хоёр хуруу лугаа төгс, хэлбэр таван үзүүрт эвэр нугууд голын эвэрт хүрэлцэж үйлдсэн. Түүний язгуурын бурханд цэцэг туссан нугууд бээр нь их очир дарийн очир бөгөөд, очирсадийн очирьг барьж үйлдээд түүний уг нь эрдэнээр үйлдсэн, хэмжээ их бага магадлагаа үгүй, хэлбэр таван үзүүрт эвэр өчүүхэн дэлгэрсэн хүйсний хоёр талд гэрлийн эрхин лүгээ сэлтийг үйлдэх бөгөөд энэ нь Очир ягчисаас бусад Очир хаанаас Очир буулгыг хүртэл бүгд адилд номолсон болой.

Түүнчилэн ажирсаны очир хийгээд очирсадийн очир хоёулангийн уг нь эрдэнээр үйлдэхийг номолсон ч бурхан алин хийгээд алин түүний өнгөт эрдэнээр үйлдэхийг номолсон. “Гурван ертөнцөөс ялсаны онол”-оос очир энэ хоёуланг арван зургаан хуруунд ч номолсон. Очир ягчис хийгээд очир хум

зохиолын очир нь хилэнтийн очир мөн бөгөөд энэ нь огторгуйн төмөр машид судалснаар үйлдэх хийгээд төмөр буюу зэс алин болохоор үйлдэх ёс хоёрыг номлоод арван хоёр хуруу хэмжээт эвэрийн үзүүр машид хурц бөгөөд ихэд дэлгэрсэн. Энэ хийгээд урьд номолсон очир тэдгээр бүгдийг гурван хувь тэгш үйлдэнэ. Бас бус есөн хувьт эрдэнийн үзүүрт таван үзүүрт очироор бэлгэдсэнийг эрдэнийн язгуур арван зургаан лянха дэлбээгийн найман дэлбээ нь уруу дэлгэрсэн бөгөөд найман дэлбээний ам хумьсны төвд багтсан таван үзүүрт очирог лянхийн язгуур. Очирын хүйс цагаан зүүн гурван эвэр хөх, урьд гурван эвэр шар, зүүний гурван эвэр улаан, хойд гурван эвэр ногоон нь үйлийн язгуурын очир болно.

Язгуур тэдгээрүүдийн хонх ч өөр өөрийн язгуурын очироор иш үйлдсэнээр хонхонд үйлдэхийг номолсон. Түүний очир хонхны хэмжээ хэлбэрийн ялгаа дээр үгүй үндсийн үеэс гарсан лугаа зохилдуулан номлов.

**Хоёрдугаарт. Дээр үгүй үндсээс гарсан тийн агуулгад  
үүнд хоёр**

Очирт хийгээд хонхны ялгал

Хэмжээ тэргүүтний бэлгэ чанарын номлол

**Анхдугаарт. Очир хийгээд хонхны ялгалд**

Очир бэлгэдхүүн утгын очир

Бэлгэдэгч тэмдэгийн очир хоёр буй

**Анхан. Очирт бэлгэдэхүүн утгын очир нь:** Ялгуусны таалал хоёр үгүйн бэлгэ билиг бөгөөд түүнийг нууцын очир хэмээсэн ч буй.

**Хоёр. Бэлгэдэгч тэмдэгийн очир нь:** Бэлгэ билигийг бэлгэдэн үйлдэх бөгөөд түүнд “Очир дагина” хийгээд “Маннэ”-гаас номолсон мэт нэгэн үзүүрт очир, есөн үзүүрт очир, элдэв очир нугууд буй боловч түүний дунд гурвыг амирлангуй, хилэнтийн ялгалаар эвэр нь хумьсан, дэлгэрсэн хоёр хоёр буй. Мөн амирлангуй хатуугийн эрхээр очирын үзүүр хурц болон хурц бус хоёр байвч “Дагинасын далай”-гаас номолсон мэт мянган эвэрт хүртэл буй. Элдэв очирд зүгийн эвэр гурав буй болон тав таван эвэрт хоёр буйгаас урьдыг арван хоёр үзүүрт иш үйлдсэн хийгээд есөн үзүүр очироор иш үйлдсэн болон урьд номолсон мэт арван хоёр үзүүр элдэв очироор иш үйлдсэн ч буй бөгөөд сүүлд хэмжээ, хэлбэрийн үесд номлогдохуун ялгалууд ч буй. есөн үзүүрт очир хонхонд бэлгэ билигийн очир хонх хэмээгээд таван үзүүрт очир хонхыг тангарагийн очир хонх хэмээн “Очир дагина”-аас номолсон бэлгэдхүүн утгынх дотоод очир хонх хийгээд бэлгэдэгч тэмдэгийн очир хонхонд гадаад очир хонх

хэмээн “Дагинасын далай”-гаас номолсон бөгөөд “Данши”-ийн тайлбараас дурьдсаны учир шалтгаанаас ч тэр мэт номолсоноос гадаад дотоодын ялгавараар таван үзүүрт болон есөн үзүүртээр үйлдэх нь зохисгүй.

**Хоёрдугаарт. Хэмжээ хэлбэр тэргүүтэний номлол үүнд хоёр**

1. Очир дагина болон Самвүди тэргүүтэнээс гарсан тийн агуулга
2. Цагаан хүрдэнээс номолсон тийн агуулга

**Анхан. Очир дагина болон Самвүди тэргүүтэнээс гарсан тийн агуулгад**

Очирын тийн агуулга  
Хонхны тийн агуулга хоёр буй

**Очирын тийн агуулгад**

Барьж үйлдэхийн очир  
Чимэгийн очир хоёр буй

**Барьж үйлдэхийн очир үүнд гурав**

Алинаар үйлдэхийн уг  
Ямар адил нэгэнд үйлдэхийн хэлбэр  
Хэр төдий үйлдэхийн хэмжээ болой

**Анхан. Алинаар үйлдэхийн уг нь:** “Очир дагинын язгуурын тайлбар”-аас амирлангуй, хийгээд хатуу очир хийгээд таван үзүүрт, есөн үзүүрт тэргүүтэн бүгдийг ч алт тэргүүтэнээс мод тэргүүтэн хүртэл аль болохоор үйлдэж болохыг номлосон.

**Хоёрдугаарт. Ямар адил нэгэнд үйлдэхийн хэлбэр нь:**  
“Увидасын хонгорцог эрхэнд урвуулсан”-аас гурван хувийн гурваны нэг хувийн хэмжээнд хүйсний найман хэсэг болой хэмээхүйгээр голчлон хувийн ч гол бүдүүн бөгөөд хоёр хязгаар түүнээс нарийн болой хэмээхийг хүртэл хийгээд “Очир дагина”-аас бүхний үзүүр төв нь бөөрөнхий хэмээснээр тэр ч өчүүхэн найман өнцөгтөд үйлд хэмээхийг хүртэлх долоон шатаар утгыг “Увидасын хонгорцогт” номлосон хийгээд “Самвүди”-д бүс үйлдсэн сайн хэмээгдэхийн утгыг “Увидасын хонгорцогт” номолсон хийгээд “Очир дагина”-аас найман хувь бүсээр нь чимгэл хэмээн номолсоны утгыг түүний тайлбарт номолсон.

Мөн “Увидасын хонгорцог”-т эвэр нь матарын шүдний завсарт орших нугууд хэмээсэн хийгээд “Тармал эрхин”-д саран оршисон гурван хүрээгээр хүрээлэгдсэний ёзоорт голын эврээс бусад зүүн тэргүүтэний эвэр нь матарын шүдний завсарт оршино хэмээсэн. Бас “Самвүди”-гаас матарын амнаас гарсан үзүүр гэрэл саранд оршин хэмээсэний утгыг “Увидасын хонгорцог”-т номолсон. Бас “Увидасын хонгорцог”-т бүс үүний голын хувь нь өчүүхэн илүүд үйлдэх болой. Хувь үлдсэнүүд нааш цааш тэгш бөгөөд зэргэмжээр хоёр дахин өндөр болой хэмээсэн. “Очир дагина”-ийн тайлбараас эсвээс гурван хувь хэмээгдэх нь голын хүйс болой бүс нь үүнд хоёр зургаар хүрээлсэн бөгөөд хэмээн номолсонуудын утгыг хамгийг айлдагч Хайдүв бээр нотлон буулган дэлгэрэнгүй зарлигласанг таалал лугаа харшуулалгүй товчлон хураан өгүүлэх аваас үүнд барьж үйлдэх очир нь голын хүйс, лянхуа лугаа сэлт нь нэг хувь дээд доодын эвэр хувь нэжгээд нэжгээд бүгд нийлээд гурван хувь тэгшид номолсоны хүйс найман хувьт эрдэнэ мэт найман өнцөгт буюу голын эвэр наймд таалах ёс мэт бөгөөд хүйс өнцөг үгүй

бөөрөнхий тэр хоёр алин ч хоёр хязгаарт эрхи түүний гадуур лянхуа, лянхийн дээр саран мандал түүний дээрхи гадуур цагирган эрхин эргэсэн, түүний дээр гол болон зүгт очирын эвэрнүүд ёзоороос ч үзүүр нарийн голын эвэрийн дундахын бүдүүний харалдаа бэлхүүс цагирагсан намссан голын эвэр өндөр бөгөөд хоёр зах нь нам “Эрхин” хийгээд “Увдисны хонгорцог” мэтээр голын болон зүгийн эвэрүүд дөрвөн талт ба бүгдийн доод тал нь өчүүхэн дугуй зүгийн эвэрнүүдийн ёсоор матрын амнаас гарсан үзүүр нь голын эвэр гүн зүглэн бөхийсэн хоёр заханд гэрлэн эрхин лүгээ сэлттэй бөгөөд эдгээр нь таван үзүүрт очир хийгээд есөн үзүүрт очир тэргүүтэн бүгдийн нийт хэлбэр болой.

Ялгамтайд нь зүгийн эвэрнүүдийн үзүүр голын эвэрд хатгасаны ёсоор буй.

Догшин очир нь зүгийн эвэрнүүд голын эвэрд өчүүхэн эс хүрэлцсэн төдийхэнээр үзүүр гадагш дэлгэрсний үзүүрүүд машид хурц хийгээд таван эвэр нь голын эвэрийн дөрвөн зүг хийгээд есөн үзүүрт нь зүг завсар наймд эвэр буй. Зүгийн эвэрүүд голын эвэрт бөхийсэний эрхээр голын эвэрний үзүүрийг илүүд гарган үйлдэх бөгөөд эдгээр нь хэлбэрийн тийн агуулга болой.

**Гуравдугаарт. Хэр төдий үйлдэхийн хэмжээ нь:** Ер нь очир их бага хэр төдийд үйлдэхийг нь “Увдисын хонгорцог”-оос дөрвөн хуруугаас эхлээд хорин хуруу хүртэлд алдаршсан болой. Ямар мэтэд хүссэнд болой хэмээн зарим нэгэн болой хэмээн өчүүхэн хэмжээ дөрвөн хуруугаас ихийн хэмжээ хорин хуруу хүртэл магад барьж үйлдэх хийгээд дөрвөн хуруугаас ч бага болон хорин хуруугаас ч ихээр ямар мэт хүссэнээр үйлдэх хоёр

ёсыг номолсон бөгөөд “Очир дагина”-ын тайлбараас өчүүхэний хязгаарыг зургаан хуруунд ч номлосон.

Очир их бага алин ч урьд номолсон мэт гурван тэгш хувьдүйлдэх нь адил бөгөөд түүнд голын эрхи барих хувь нь нэг хувь дээд доодын эвэрийн уртад хувь нэжгээд нэжгээд лүгээ гурван хувь үйлдэхийг “Очир дагина”, “Самвүди”, “Увдисын хонгорцог”-оос номлосон барих хувийг ч хүйс нэг хувь, дээд доодын эрхин, лянхуа, сар лугаа сэлт хувь нэжгээд нэжгээд бүгд дотор зуураа гурван хувь болой. Энэ нь барьж үйлдэх очирт мөнөөс үлшгүй ордоны доод суурийн элдэв элдэв очир тэргүүтэнд хэмжээ энэ хэрэггүй.

Тийм учраас голын эвэрийн уртад очирын биеийн гуравны нэг байх бөгөөд голын эвэрийн үзүүрт зүгийн эвэрийн үзүүр эс хүрсэний хувийг нь “Увдисийн хонгорцог”, “Эрхин” хоёроос номолсон.

Энэ нь Очирын өчүүхэн хязгаар дөрвөн хуруу нэгийн хэмжээний тийн агуулгыг үлгэрлэн бариад үүгээр жишсэнээр их очируудад ч мэдэж үйлдэхийн тусад мөн учир үүний ёс нь очир дөрвөн хуруут нэгийн уртын хэмжээг гурван хувь тэгшид үйлдсэний нэг хувийг очир үүний эвэрийн уртын хэмжээ бөгөөд үүнийг дүүрэн хуруу ба хоёр арвай ба арвайн гурван хувийн нэг буй бөгөөд голын эвэрийн үзүүрээс урууд арвай алины хэмжээ төдий ирсэний харалдаад зүгийн эвэрүүдийн үзүүр хүрэлцэн үйлдэх аваас сайтар засвартай бөгөөд үзэсгэлэнтэй ирээд түүний ухаанаар их очируудад ч голын эвэрийн уртад арван хувь ба нэг хувийн гуравны нэгд үйлдсэнээр голын эвэрийн үзүүрээс урууд нэг хувь ирсэний харалдаад зүгийн эвэрүүдийн үзүүр хүрэн үйлдэх аваас сайтар завсартай бөгөөд тууш даруйг нь уг хоёр лугаа ч зохилдсон нь хуучин урлал лугаа ч зохилддог.

Захын эвэрүүд алинаас гарсан матрын нүүрний уртыг эвэрийн дөрөвний нэг хувь ба матрын хамар эвэрээс гадагш үлэмжийн хэмжээнд арвайн өргөний хэмжээ хагас бөгөөд хурууны найман хувийн нэгийн хагасын хэмжээ болно.

“Эрхин” хийгээд “Увдисын хонгорцог”-оос матрын хамар цагаан будааны хэмжээнд номолсоны утга нь цагаан будаан хальс туушид хагаслан хуваасны хагас түүний өргөний хэмжээнд номолсон.

Матрын нүүрнээс гадагш илүү хамрын хэмжээнд тэр мэт үйлдэх хэрэгтэйн утга бөгөөд урьд арвайн өргөний хэмжээ хагас буюу хурууг найм хуваасны нэгийн хагасд номлосон тэр ямагт болой.

Үүнд “Егүзэрийн цэнгэлийн баясгалант хурим”-д уртын хэмжээ хэмээгдэх байвч өргөний хэмжээ бөгөөд уртын хэмжээ бол үрийн халь бүхэлийн хэмжээ бэлгэ чанараар болохыг хагаслан хуваасны хэрэг алин ч үгүй болой.

Тийм учраас үүнийг үсэгийн эндүүрэл гарсанд үзэгдэхийг Хайдүв богд бээр тэр мэт таалсан бус.

Голын эвэрийн бэлхүүсний ороолт гурван зэрэгт давхарласаны өргөний хэмжээг “Эрхин” ба “Увдис хонгорцог”-т тодорхойгүй бөгөөд Хайдүв тамжид чинба бээр “Очир дагина”-д түүний хагаст бүсийг таалсан хэмээхийн эшээр утга үүнийг номолсонд таалсан бөгөөд үүний өргөний хэмжээг матрын нүүрний хагасын хэмжээнд үйлдэхийг номолсон.

Бэлхүүсний гурван ороолт нь эвэрийн харалдаа алинд үйлдэхийг “Увдис хонгорцог”-оос голын эвэр арвайн хэлбэртэд номолсон учир дээд доодоос хэмжсэний төв тууш бүдүүнд үйлдэх хэрэгтэй.



Голын эвэрийн бүдүүний хэмжээ үе алинд урьд татсан үндэс болон Энэтхэгийн гол номлолуудаас уг болгон татаад номлон зохиогоогүй бөгөөд цагийн хүрдэний очир хонх нь бэлгэ чанарыг номлохын үесд “Хураангуй үндэс”-ээс эвэрийн бөөрөнхийнүүд нь дөрвөн хувь болой хэмээсэн ба түүний тайлбараас номловол дээд доодын хоёр эвэр аль нэгний эвэрийн бөхийлт ихийн харалдаагаас утсаар эргүүлж түүнийг сунгавал голын хоёр эвэрийн үзүүрээс үзүүр хүртэлх урт лугаа сацуу болохын утга нь энэ мөн хэмээн номолсоны таалал нь дээр үгүй болой.

Тэр мэт ийн хэмээн номолсон хэмжээ тэдгээр бүгдийг таван эвэрт, есөн эвэрт хоёулангийн нийтийн бэлгэ чанарт мэдэж үйлдээд таван эвэртэд зүгийн дөрвөн эвэр нь зүгийн лянхуан дэлбээ тус тусын харалдаа саран дэвсгэрээс гарсан ба есөн эвэртэд зүг завсарын лянхан дэлбээ тус тусын харалдаад гарах орон магадтайд үйлд.

Гурван эвэртэйд ч ам дэрвийсэн, хумьсан хоёр буй бөгөөд зүгийн хоёр эвэр баруун зүүний лянхан дэлбээ хоёр тус тусын харалдаад гарч үйлдээд.

Нэгэн үзүүртэнд нь үзүүр нь хурц бөгөөд захын эвэр үгүй бөгөөд очир тэдгээр бүгд ч гурван хувь тэгш тэргүүтэн бэлгэ чанар бусадуудыг урьд номолсон лугаа адил болой. Мутрын барьцны элдэв очирт таван үзүүрт, гурван үзүүрт хоёр буй. Тэдгээр ч урьдын бэлгэ чанар нийтүүдийг бүрдүүлэх хэрэгтэй. Барьж үйлдэх очирын тийн агуулгыг товч төдий өгүүлэв.

### Хоёрдугаарт. Чимэг очир нь

“Очир дагина”-аас Таван хувийн хэмжээ лүгээ төгс нь оройн үснэрийн очир хэмээн алдаршсан чихний ээмэгийг зургаан хувийн хэмжээнд үйлд. Хоолойвчийг дөрвөн хувьд ба зүрхэнд таван хувьд барьж үйлд ямар мэт үзэсгэлэнтэй шинжилж үйлд хэмээн номолсон утгыг “Увдисын хонгорцог”-оос

Оройн очир таван хуруу

Чихний ээмэг зургаан хуруу

Хоолойвч дөрвөн хуруу

Зүрхэнийх таван хуруу

Нууц орны харалдаах очирьг зургаан хурууны хэмжээнд үйлдэх буюу эсвэл орон тус тусын очир тэдгээрийг их бага ямар мэт үзэсгэлэнтэйгээр үйлдсэн ч болохын утганд номолсон.

Эдгээр нь тотгорт зарлиг тушаах болон бүжиг цамын үйлдвэр тэргүүтэний хувьд орох үеүүдэд ба чуулганы хүрдэн ба явдлын зарим үе тэргүүтэний биеийн чимгэнд хэрэгтэй бөгөөд тэр ч ясан чимгэнд очир тэдгээрийг ясаар хийж үйлдээд эрдэний чимгэнд нь тэдгээрийг алт тэргүүтэн эрдэнээр урлахыг өөр өөрийн орон ямар мэтээр байгуулж үйлдээрэй.

### **Хоёрдугаарт. Хонхны тийн агуулгад**

1. Уг алинаар үйлдэх
2. Хэлбэр ямар мэт үйлдэх
3. Хэмжээнмй тийн агуулгыг номлох гурав буй

**Анхан. Уг алинаар үйлдэх нь:** Уг нь “Очир дагина”-аас бүхэнд хүрэл буюу эсвэл гурван төмөрөөс нь хонх бөгөөд хэмээсэн хийгээд “Увдисын хонгорцог”-т тэдгээрийн хувь гуравт нь амнаас эхлээд хүрэл ариуны өвөрчилд үйлд. Түүний дээд хоёр хувийг нь алт тэргүүтнээр үйлд хэмээн номолсон тул хонхны хөндий хэл лүгээ сэлтийг нь хүрэлээр үйлдээд дээрх очир билигийн эхийн нүүр, хумх, суудал эрхин лүгээ сэлтийг нь алт мөнгө зэс лүгээ гурван төмөр аль нэгээр нь үйлдэнэ.

**Хоёрдугаарт. Хэлбэр ямар мэт үйлдэх нь:** Дээрх очир нь барьж үйлдэх очирын хэлбэртэй адил бөгөөд доорх билигийн эхийн нүүр тэргүүний үе, эрдэнийн титэм, ээмэг лүгээ сэлт нь эвэрийн доорх саран дэвсгэрээс цар ихгүй бөгөөд түүний доорх хумх нь эн цар түүн лүгээ таарсан. Түүний доорх хумхын суудал дөрвөлжин түүний доорх эрхин гурван давхарлаж үйлдсэн эрхиний доор хонхны хэл хэмээгдэх хонхны хөндийд эшийн ёсонд барилдсан. Түүний доор хонхны хөндий бөгөөд тэр ч хөндийний төв нь өндөр бөгөөд зах нь нам хөндийний дээд тал нарийн бөгс нь бүдүүн ам нь зэргэмжээр гадагш дэрвийсэн доод нь өчүүхэн дотогш хумигдсан цохигч хэл нь төмөрөөр үйлдсэн найман талтын байдалтай байна.

### **Гуравдугаарт. Хэмжээний тийн агуулгыг номлох нь:**

Хэмжээг нь "Очир дагина"-аас гурван хувь төгс үйлд хэмээсэн ба "Дагинасын далай"-гаас ч хонхыг үргэлжид гурван хувиар тэнгэр бээр үнэхээр чимж үйлд хэмээсэн. Увдисын хонгорцогт хонхнууд бүгд гурван хувь тэгш нь очир лугаа даган зохилдсон хэмжээ болой. Тэдгээрийн гурван хувь нь амнаас эхлээд хүрэл ариуны өвөрчилинд үйлд. Дээд хоёр хувь нь алт тэргүүтнээр үйлд хэмээсэн ба "Эрхинд" ч хонхыг гурван хувь тэгш буй нь очир лугаа даган зохилдсон хэмжээ болой хэмээн номолсон.

Тэдгээрийн утгыг заримууд хонхны хөндий нь нэг хувь түүнээс дээшихийг хоёр хувьд үйлдсэний утганд номолсон хэмээн бусад ёсонд байгуулах төдийг зохиосноор өөрийн ёсонд сайныг огоот барьсанаас хонх бүхэнд зургаан хувьд түүний дөрвөн хувийг хүрэлээр өвөрчилин эс холилдсоноор үйлд бусдыг нь бусдаас шинжилж үйлд хэмээн хонхны зургаан хувиас дөрвөн хувийг бусад алт тэргүүтэн эрдэнээр урлан үйлдэхийг номолсон тул ёс үүнийг дэлгэрэнгүйд номлоход түүний дээр нэг хувьд гурван эрхин түүний дээр хумх алт буюу зэс мөнгө гуулиар хийх. Түүний дээр тэр төдий хэмжээнд зүүнээ харсан билигийн эхийн нүүр урла. Нүүр түүний дээр хагас очир нь урьдын хагас очир мэт хэмээн гурван эрхин зэргэмж хумх суудал сэлт билигийн эхийн нүүр лүгээ сэлт нь нэг хувь.

Дээрх хагас очир лянхуа лугаа сэлт нь нэг хувь эрхиний доорх хэлнээс хонхны ам хүртэл хүрэлийн чанартайг доороос номолсон мэт дөрвөн хувь бөгөөд бүгдийг нийлүүлбэл зургаан хувьд үйлдэхийг номлоод үүний хоёр хувь гурван хэсэг ба урьд татсан үндэсний тайлбаруудад гурван хувь нь таалал нэгэнд гарсан тул тэр мэт үйлдэхийг номлоод хүрэлийн өвөрчилингийн дөрвөн хувь үйлдэхийг ч дүрсгүй орныг бэлгэдэгч хэл нэг хувь нь

дүрст орныг бэлгэдэгч цээжний дээрх лянхуа ба хажуугийн тор хагас тор бүгд нэг хувь. Хүсэлт орныг бэлгэдэгч хагас торын үзүүрээс хонхны ам хүртэл хоёр хувь бүгд тэр мэт дөрвөн хувь үйлдэнэ.

Үүнийг “Егүзэрийн цэнгэлийн баясгалант хурим”-д хөндий дээрээс тэр хагас торын үзүүрээс дээшид хоёр хувь хэмээн өгүүлсэн байвч хөндий дээрх хэлнээс хэмээхийн үсэг доройтсон бөгөөд санбо ёнсүнгын энийг урьд татсан мэт хүрэлийг дөрвөн хувь үйлдэх хэрэгтэй бөгөөд хүрэлийн дөрвөн хувийн нэгэнд хэлийг эс тоолбол урьдах шалтгаан бусад үгүй тул хэлний уг эрдэнэ бусдаас үйлдэх хэрэгтэй бол энэ адилаар гарын авлага хаана ч үзэгдэхгүй байна.

Хөндий дээрээс тэр хагас торын үзүүрийн хүртэл хоёр хувь үйлдэх бол түүний доодох илүүгч хоёр хувь лүгээ дөрвөн хувь бүгд нь хонхны хөндийд одсоноор түүнээс дээшх хоёр хувь ямагтад очир билигийн эхийн нүүр суудал, хумх хэл лүгээ сэлтийг багтаах хэрэгтэй тул хэлбэр хэтэрхий зохицохгүй болно.

Санбо ёнсүнгын утгаар зургаан хувьд хувьсах ёсыг өөрөө бээр номолсон лугаа ч нийлдэггүй болой. Хонхны амны цар хэмжээг Санбо ёнсүн бээр хонх түүний доторх огторгуй урт өргөн нь тэнцүү хэмээсэн.

“Увдис хонгорцог”-оос түүний хүрэлийн төвийн огторгуйн цар нь урт өргөн нь тэнцүү хэмээн номолсон тул хонхны цээжний амны харалдаа төвөөс дээд дээвэрт тулахыг хүртэлх өндөрийн хэмжээ ба ам дотогш хумьсаны урдах өргөний харалдаагын цар хэмжээ тэгшид үйлдэнэ.

Эдгээр нь хонхны ерөнхий биеийн хувиудын хэмжээ бөгөөд язгуур тус тусын бэлгэ чанар адилгүйг гурван зүйлээр номлодог.

**Хонхны ялгал нь:**

1. Очир садвагын хонх буюу бэлгэ билигийн хонх
2. Баатарын хонх
3. Язгуур тус тусын түүнчилин ажирсаны хонх болой

**Анхдугаарт. Очир садвагын хонх буюу бэлгэ билигийн хонх нь:** Очирсадвагын хонх буюу бэлгэ билигийн хонхыг “Очир дагина”-аас есөн үзүүртийн эрхэмд номолсон ч таван үзүүрт ч буй бөгөөд хоёулаа ч бэлгэ чанар адил номолсон тул хоёулаа хошуу өчүүхэн хумьсаны харалдаа дээр төдийд цэцгэн эрхийн төвд очирын эрхи их бага ямар мэтийг тааруулан үйлд.

“Эрхин” хийгээд “Увидасын хонгорцог”-т хумхын доорхид индэр үйлдэхийг номолсон нь түүний суудал дөрвөлжин тэр мөн бөгөөд гурван эрхний доор лянх үйлдэхийг номолсон нь цээжний дээд талын гаднах дээр лянхуа үйлдэх тэр мөн Эрхин болон хэлний завсарт үйлдэх бус. Үүнд нүүрний доорх хумхын оронд нүх үйлдэх ба лянхуа үйлдэх нугуудад уг үгүйд номолсон болой.

Цээжний дээрх ам доош зүглэсний лянхан найман дэлбээнд найман охин тэнгэрийн хөрөнгө байгуулахыг номлоод тэр ч “Эрхин”, “Самвүди”, “Дөрвөн дэвсгэрт” нугуудаас хөрөнгүүдийг байгуулах зүг ба дараалал үл зохилдох нь адил үзэгддэгч зүүнээ “Дархи”-аас урд Жанма хүртэлх дөрвөн хөрөнгийг зэргэмжилин номолсонууд нь зүүнээс зүг зүүнээ эргэхийн эрхинд үйлдээд Жанма-гаас Дархи хүртэлхийг зэргэмжилин номолсонуудыг нь урдаас зүг баруунаа эргэхийн эрхэнд үйлдсэн болой. Үйлдвэл сайн буюу хэмээн номолсон тул түүнчилэн үйлд.

Завсарын охин тэнгэрүүдийн алдарыг ч “Очир дагина”, “Дөрвөн дэвсгэрт”, “Самвүда” нугууд үл зохилдогч утгандаа Сэржанма, Догзэнма, Догсанма нар нь Норжүнма.

Бранзама, Арвама, Яннянма нь Гүлжидма буюу Зүнда болой.

Сажидма, Идонма, Зэйма нар нь тойнэр жанма бөгөөд Очирчилвама нь Очир эрхин бус болой.

### **Тийм учраас тэдгээрийн хөрөнгийг зүг алинд байгуулах нь**

Зүүний дэлбээний дотор Дархийн хөрөнгө Дам

Түүнчилин хойно Гойгармагын хөрөнгө вам

Баруунд мамагигийн хөрөнгө Мам

Урд Жанмагын хөрөнгө Лам

Баруун урдад Зүндагогын хөрөнгө Зүм

Баруун хойно Тойнэржанмагын хөрөнгө Врим

Зүүн хойно Прэнвамагын хөрөнгө Мам

Зүүн урдад Норжүнмагын хөрөнгө Вам үсэгүүдийг байгуулж үйлдээрэй.

“Дөрвөн дэвсгэртийн тайлбар дурдалын учир шалтгаан”-аас найман охин тэнгэрийн дүрс буюу хөрөнгийг байгуулахыг ч номолсон байдаг.

“Очир дагина”-аас Дээд лянхуа дэлбээнд тор хагас торон эрхинээр чимсэн хэмээн номолсоны утга нь дээд талын лянхуан найман дэлбээний дэлбээ бүрийн харалдаа хонхны хажууд тор нэг нэг лүгээ найман бүтэн тор байна.

Тэдгээрийн завсаруудад хагас тор нэжгээд нэжгээд ба хагас тор ч наймд үйлдэхийг номолсоны тор тэдгээрийн дээр

цэцгэн эрхин хоёрын голд буй очир тэргүүтний эрхин салбан оршиж үйлдээд тор тэдгээрийн дотор зүүнд хүрд, урдад эрдэнэ, баруунд лянхуа, хойно илд, зүүн урдад нүд, баруун урдад очир, баруун хойно лянх, зүүн хойно удвал байх ба тор хагас торын үзүүрүүдэд Гүмүда, лянх, Удвал, Бадра, Эрдэнэ, Ногоо тэргүүтэнг ч үйлдэхийг “Увидасын хонгорцог”-т номлосон.

Үүнд эрдэнэ нь Бэндэряа тэргүүтэн эрхин мэт хэлхсэн. Ногоо нь эрдэнийн нарийн алтан Бадра уйлгалсны дотроос үзүүр гадагш гарсаныг хэлдэг.

Санбоёнсүн-гаас эрхин удвал найман бэлгэ хэмээх тэргүүтэнг номолсоныг татсанаар тэр мэт хумхны доторх эрхин гурван зэргийн доор удвалын дэлбээ үйлдэхийг номлоод энэ нь Санбоёнсүн мэт бол тэр мэт үйлд хэмээхийн утганд тодорхой учир хязгаар нэгэнд тэр мэт үйлдэх хэрэгтэйн утга бус.

### **Билигийн эхийн нүүр зүг алинд**

#### **харах нь**

Зүүнээ харахыг билигийн нүүр үйлд хэмээн татсан даруй мэт хонхны цээжний дээрх зүүний лянхуан дэлбээг дархийн хөрөнгө үсэг Дам буй зүгийн түүнд харж үйлд.

“Очир дагина”-аас лянхуан дэлбээнд тор хагас тороор чимсэн урдахчилин бэлгэ чанар төгс охин тэнгэрийн бэлгээр үзэсгэлэнтэй зүүний зүгт лянхуаг нь хэмээх тэргүүтэнг номолсон мэт найман торын дотор найман охин тэнгэрийн бэлгийг байгуулахыг ч номолсон тул Очир садвагын хонхыг торны дотор урд мэт дөрвөн згуурын бурхан, дөрвөн охин тэнгэрийн мутарын барьцыг байгуулах ба энэ хоёр алинаар нь ч үйлдсэн болох нь үзэгдээд “Увдисын хонгорцог” мэтэд ч ёс энэ хоёр болоход таалсан.



“Очир дагина”-аас элдэв эрдэнэ бадарсан ба Очир бүслүүр хоёр эрхиний хэмээн номолсон нь хонхны амны дээр очирын эрхин, тор хагас торын дээр эрхин хоёрыг үйлдэхийн утганд номолсон бөгөөд дээдхи очир нь хэвтээ байдалтай доод нь дээш боссонд үйлдэх энэ төвдийн багш дээдсүүдийн заншил мөнийг номолсон төдийгээс хаана бүтээн зохиогоогүй учир үүнээс бусдад үйлдэх төгс хэмжээний уг үгүй учир түүнчилэн үйлдэхийн утга болой.

**Хоёрдугаарт. Баатарын хонх нь:** Баатарыг хонхыг нь “Очир дагина”-аас энэ нь баатарын хонх бөгөөд очир эрхин бүслүүр төгс түүнчилэн билиг ба рашааны хумх, билиг чанар бүхэн огоот төгс тор ба хагас торгүйгээр үйлд есөн хуруу өндөр байх ба амсарыг нь таван хурууны хэмжээнд үйлд.

Тэндээс өчүүхэн илүү үйлдэх бус есөн үзүүрт хэмээн баатарын хонхыг нь очир эрхин, билигийн эхийн нүүр, хумх, эрхин лүгээ сэлт тэргүүтэн урьдын Гэлгэ чанар бүхэн лүгээ төгсгөөд ялгамжтайд тор хагас тор үгүй өндөр нь есөн хуруу ба амсарын цар хэмжээ тэргүүтэн таван хурууны хэмжээгээр магадтай үйлдээд үүнд ч таван үзүүрт, есөн үзүүрт хоёр буйд номолсон бөгөөд “Увдисын хонгорцог”-т ч утга тэр адилд номолсон.

Очир эрхиний бүслүүр төгс хэмээх төдийгээс нэг хэмээхийн зоригдол тодорхойгоор эс зохиосон тул дээд доодын очир эрхин хоёул хэрэгтэй хэмээн номолсон бөгөөд тийм учираас цээжний гаднах очир эрхин үгүй нүцгэн үйлдэж болохгүй болой.

**Гуравдугаарт. Түүнчилэн ажирсаны хонх нь:** “Очир дагина”-аас тэндээс түүнчилэн ажирсаны хонхны бэлэг чанарыг номлож үйлдэе хэмээн номлоход тангараг тавьсанаар хүрэлээр үйлдвэл яруу дуугардаг хөндий хоосон, хумх төгс, очир эрдэнэ, лянхуа илд тэргүүтэн бэлтгэж тор хагас, тороор бэдэрлэсэн матрын амнаас гарсан таван билиг асар ариун таван үзүүр төгс бөгөөд хоёр бүслүүрийн төвд нь хүрдний хоёр эрхин төгс түүнчилин хоёр бүслүүрийн төвд лянхуа болон лянхуан эрхин хоёр эрдэнээс нь эрдэнэ түүнчилин бүслүүр төгс үйлд үйл бүтээгч хэмээгээд хоёр бүслүүрийн төвд илдээр чимсэн бүхэнийг билигийн нүүр төгсөөр баатар бүхэнээр ялах болно хэмээн номлоод хүрэлээс гарсан хэмээх хоёр бадагын утгыг мэдэхэд хялбар очир эрдэнэ хэмээх тэргүүтэн гурван бадагыг “Егүзэрийн цэнгэлийн баясгалант хурим”-д номлол эс зохиогч язгуур тус тусын хонхонд торын дотор очир тэргүүтэн язгуур тус тусын тэмдэгийг магадтай үйлд очирын язгуурт найман тор дотор найман очир агуулахаас үйлийн язгуурын торын дотор найман илд агуулахыг хүртэл мэдэж үйлдэх хэрэгтэй.

Матрын амнаас гарсан хэмээх тэргүүтэн гурван бадагаар таван язгуур тавуул таван үзүүртэйд магад барих хэрэгтэй номлоод хоёр бүслүүрийн төвд нь хэмээх тэргүүтэн найман бадагаар түүнчилин ажирсаны язгуурын хонх нь цээжний дээд доод хоёрт хүрдний эрхин үйлдэхээс үйлийн язгуурт илдний эрхин үйлдэхийг хүртэл жишиж үйлдээрэй.

**Бүслүүр нь:** Урьд номолсон мэт цээжний эхэн доодод цэцгэн эрхин хоёр давхар бөгөөд язгуур тус тусын тэмдэгүүдийг түүний завсарт байгуулж үйлдэнэ.

Бүхэнд билигийн нүүр төгсөөр хэмээх тэргүүтэн хоёр бадагын анхны утгыг мэдэхэд хялбар бөгөөд хоёрдугаарт номлол эс үзэгдэнэ.

Тийм учраас урьд номолсон очир садвагын хонх буюу бэлгэ билигийн хонх нь язгуур бүгдийн эзэн хонх юм.

Үүнийг ч бас очир дарийн хонх ч хэмээдэг учир энэ адилаан доторх мутрын барьцыг язгуур дөрвүүлэнд үйлдээд үүнд нь язгуур хэсэг бусагын мутрын барьцанд үйлдэх хэрэгтэй нь илт бөгөөд урьдын хуучин хонхнуудад мутрын барьц хэсэг бусаг адилаан дотор байгуулсан ч олонтой үзэгдэнэ.

“Увидасын хонгорцог”-т хонхны голд найман талт бэлгэ билигийн хэл хэмээгээд “Очир дагина”-аас ч голд бэлгэ билигийн хэлийг нь найман талтаар үзэмжтэйд үйлд хэмээн номолосн мэт цохигч хэлийг найман талтай үйлдээд тэр ч үзүүрийг нь тэгш тасдсан мэт бус голоос өчүүхэн нарийсгаж үйлдэх хэрэгтэй.

Үүний угыг нь сайн төмөрөөр үйлдэхийг шалгадагт номлодог ч ямар мэт зохицуулж үйлдэхийн утга болой.

Язгуур тус тусын түүнчилин ажирсаны хонх тэдгээрийг очирын үзүүр дэлгэрсэн нь догшин ба очирын үзүүр хумисаныг амирлангуй хоёр зүйл байдаг.

“Увдисын хонгорцог” болон “Эрхин”-д хонхны ам гадагш өчүүхэн дэлгэрснийг лянхуйн ам хумьсан бөгөөд өчүүхэн нүхэлснийг үхрийн амны байдалтай. Өчүүхэн хумин лянхуаны ам товойсоны байдалтай гурван зүйл номолсон ч амирлангуй хилэнтийн эрхээр тэр мэт үйлдэхийг “Очир дагина” ба “Самвүди”-гын тайлбар лугаа сэлтээс номлодоггүй. Тэр мэт очир дагина ба самвүда тэргүүтэнээс номолсон очир хонхны тийн агуулгыг номлон төгсгөв.

## **Хоёрдугаарт. Хонхны цагийн хүрднээс номолсон**

### **тийн агуулгыг товч төдий өгүүлэх нь**

“Хураангуй үндэсийн бэлгэ билигийн бүлэг”-ээс эрдэнэ. Үснэр магнай, хоолой зүрхний орон ба хүйс нууцад ч очир нь нэг хоёр усны сан, сум, лусын эрхэт ес сэлт гэрэлтэгч хуруунуудийн зэргээр болой хэмээн номолсоны утгыг “Их тайлбар”-аас чих, эрхий, магнай, хоолой, мөр, зүрхнүүдэд зүүх очирьг зэргэмчилэн нэг хуруу, хоёр хуруу, дөрвөн хуруу, тав, найм есөн хурууны хэмжээтэй үйлдээд хурууны очир арван хоёр хурууны хэмжээтэй үйлдэхийг номолсон байдаг.

Гэвч “Хураангуй үндэс”-ний үг үүнийг эрхий мөр нь тодорхойгүй бөгөөд их тайлбарын үгэнд үснэр хүйс хоёр нь тодорхойгүй бөгөөд үл харшлахын ёс тэр мэт мөн хэмээн номолсоныг ч эс зохиосон үзэгдэнэ. Үеэс үүнээ “Егүзэрийн цэнгэлийн баясгалант хурим”-үүнд чихний чимэгийн очир эрдэнэ тийн ариуныг бэлгэдээд гадааддаа ертөнцийн хийн орон тийн ариуныг бэлгэдсэн болой хэмээн тэргүүтэн зэргэмжчилин найруулснаар номлож үйлдээд хэмээн номлоход тангараглах нь адил нэг байвч номлож үйлдвэл хэмээх хэрэгтэйн тангараг мэт болгон номлол зохиох хэрэгтэй учир эс зохио.

## **Тэндээс Очир, хонхны бэлгэ чанарыг дэлгэрэнгүй номлоход**

“Хураангуй үндэс”-ээс тив дээд доод гурван хувь лугаа хумьсан болон тийн дэлгэрийг амирлангуй догшин хэмээх тэргүүтэн зургаан бадагыг номолсон байдаг. Түүний утгыг “Их тайлбар”-аас номлосонуудыг Егүзэрийн цэнгэлийн баясгалант хуримын таалал лугаа харшуулалгүй товчлон хурааж өгүүлвэл чимэгийн очир ба хөдөлгөх очир бүгдийг гурван хувь хуваах нь адил бөгөөд амирлангуй догшины ялгалаар очирын үзүүр хумьсан ба дэлгэрсэнд ялгах бөгөөд хонхыг ч очир адил гурван хувь хуваагаад цээжний дотор ба дээш хагас очир нүүр хумх лугаа сэлт гурван хувь тэгш хуваадаг.

Амирлангуй хонхны ам үхрийн ам өчүүхэн нээгдсэн бөгөөд хумьсаныг дээд очирын эвэр ч хумьсан ба догшин хонхны ам лянхуа мэт гадагш дэлгэрсэн очирын эвэр ч дэлгэрсэн бөгөөд очирын нэг зүгийн эвэрийн уртын хэмжээ тэрийг очирын биений гурваны нэг хувь бөгөөд очирын голыг барих хувь тэрийг ч гурван хувь үйлдээд голын хувь нь хүйс нүүр нүүрт зүг хоёрын хувийг лянхуад үйлдэнэ.

Үүнд очирын хүйсийг дөрвөн нүүрт байхыг номолсон бөгөөд түүн лүгээ зохилдуулан хонхны бэлгийн эхийн нүүрийг ч дөрөвт үйлдэхийг номолсон эсвэл арга гийгүүлэгч үсгэнд ам эгшиг үгүй учир очир өгүүлэхийн үүд нүүр эс үйлдээд билиг эгшиг үсэг нь утгыг өгүүлж үйлддэг учир хонхонд нүүр үйлдэх ёс зохилддогыг номолсон. Таван эвэрт, есөн эвэрт алин ч зүг нэгийн эвэрээс түүний харалдаах зүг бусдын эвэрийн хооронд харалдаа хэмжээнд эвэрүүдийн гаднаас дугуйруулан эргүүлсний хэмжээний гурван хувьд болоод тэр мэт харалдаа үлсэн хэмжээ тэр ба очирын эвэрийн уртын хэмжээгч тэгш бөгөөд эвэрийн

гаднаас дугуйруулан эргүүлээд түүний гурав болсны хэмжээ ба очирын биеийн уртын хэмжээ тэгш болой. Үндэсний уг үүнд эвэрийн дугуй нь очирын гуравны нэгийг дөрөвт хуваасны нэг болой хэмээн номолсоны утгыг бусадууд олон янзаар номлодогч өөрийн ёсонд голын эвэрийн бэлхүүс бүдүүнийг дугуйруулан эргүүлсний хэмжээ бөгөөд эвэр түүний дөрөвний нэг хувьд үйлдэж болохыг таалдаг.

Зүгийн эвэрүүдийн гуравны нэг хувь доош өчүүхэн дотогш хумиад ёзоорт матрын ам лугаа сэлттэй үйлдээд дээд хоёр хувь нь бадра угалзны өргөс мэт улмаар нарийсаад үзүүрүүд нь голын эвэрт барилдсаны ёсоор хумьсан ба гадагш дэлгэрсэн хоёр буй.

Тэр мэт Очир, хонхны хэлбэр ба хэмжээний тийн агуулгыг товч төдий номлон төгсгөв.

### **Дашримд Хонх Очирыг адистэдлэх ёс нь**

Өөрийг Уринт Очирт бурханд үүсгэсэнээр очир хонхыг адистэдлэхэд их хэрэгтэй бөгөөд бүтээлийн аргыг бясалгахын эхнээс эхлээд гурван тангараг лугаа үл хагацах нэг хэрэгтэйг мэдүүлж үйлдэхийн тухайд юм.

Өөрийг Урин очир бурханыг эх лүгээ сэлтэд үүсгэх нь мудрагын тангарагийг тодорхой талбих

Очир хонхыг адистэдлэх нь очир болон хонхны тангарагийг тодорхой талбих ёс болой.

### **Хонхны очирыг адистэдлэн үйлдэх ёс нь**

Хонх, очирыг ариусган цэвэрлэн үйлдсэнээр адистэдлэх ба бэлгэдэл утгыг дурдахын үүднээс адистэдлэдэг хоёр ёс буйгаас анхных нь цагийн хүрд тэргүүтний ёс бөгөөд үүнд нь хойд мэт юм.

Тийм учраас үүнд үзүүлэх адистэдлэх хонх, гадаад очир хонх, бэлгэдэгч тэмдэг очир хонхнууд нь утга нэг болой.

Заримууд нь таван үзүүрт очир хонхыг дотоод очир хонх гээд есөн үзүүртийг гадаад очир хонх хэмээх нь болохгүй тэр хоёулаа гадаад очир хонх бөгөөд тэр хоёулаа бэлгэдэгч үлгэрлэсэн очир хонх юм. Өөрийн ёсонд очир хонхыг дуугаар өгүүлэгдэх язгуурын үүднээс ялгавал:

1. Бэлгэдэгч тэмдэг очир хонх
2. Бэлгэдэхүүн утгын очир хонх хоёрт ялгана.

Очир хонхыг ялгавал нэгэн үзүүрт очир, гурван үзүүрт очир, таван үзүүрт очир, есөн үзүүрт очир, элдэв очирууд буй нэгэн үзүүртээс есөн үзүүрт хүртэлхэд хурц бөгөөд дэрвийсэн үзүүртийг хилэнтийн очир гэдэг. Түүнээс буцсаныг амирлангуй очир хоёр гэдэг. Элдэв очирд ч гурван үзүүрт, таван үзүүрт хоёр

буй. Чимэгийн очир нь чимэгээр хэр үзэсгэлэнтэй үйлдсэн гурван үзүүрт очир тэргүүтэн болой.

Хонхыг ялгавал бэлгэ билиг буюу Очир садвагын хонх, баатрын хонх ба Ажирсаны хонхнууд буй. Анхныг есөн үзүүртийг голлон номолсон ч таван үзүүрт буй бөгөөд тэмдэг нь үхрийн амны цэцгэн эрхин хоёрын завсарт очирын эрхээр хүрээлсэн. Баатарын хонх нь унжлага тор, хагас тор чимэг үгүй байдаг.

Түүнчилэн ажирсаны хонх нь гэгээн гэрэлтээс үйл бүтээгч хонх хүртэл дөрөв буй бүгд таван үзүүрт тэрбээр ялгаа нь зэргэмжилэн хүрд, эрдэнэ, лянх, илдэн эрхээр хүрээлсэн. Бас очирын хонхыг ялгавал тангарагын очир хонх, бэлгэ билигийн очир хонх хоёроос анхан нь таван үзүүрт хоёрдох нь есөн үзүүртэд ангилдаг. Мөн очир хонхыг ялгахад нэг үзүүртээс мянган үзүүрт байдаг.

“Дагина далай”-гаас есөн үзүүрт, таван үзүүрт, нэг үзүүрт гурван үзүүрт тэр мэт тэргүүтэн их хонх мянган үзүүр хүртэл байдаг хэмээн номолсон.



### **Хоёрдугаарт. Бэлгэдэхүүн утгын очир хонх нь**

Тиймээс очир хонхоор бэлгэдэн үйлдсэн утга ямар мэт вэ хэмээвэл тэрийг ч бурхан лугаа найруулбал Очирын хүйс нь Очир садва дээд таван эвэр нь гэгээн гэрэлт тэргүүтэн таван язгуур бурхан дээд найман лянхуан дэлбээгээр хутагтын найман замын чанар майдар тэргүүтэн найман бодьсадыг бэлгэдсэн Самвуда-д галыг гэгээн гэрэлт зүүн нь үл хөдлөгч түүнчилин Төгс эрдэнтийг урд эвэрт Цаглашгүй гэрэлтийг баруунд байгуулна. Хойно Үйл бүтээгч бөгөөд таван эвэр нь таван бурханы чанарт болой лянх нь бодийн найман гишүүн хэмээн тэргүүтэн ба голд гурван үе бөөрөнхийд таван бэлгэ билигийг нь шингээж үйлд хэмээн номолсон байдаг. Доод таван эвэрээр дагинийн таван аймаг ба доод найман лянхын дэлбээгээр дөрвөн гамма болон дурдигтах охин тэнгэр тэргүүтэн наймаар бэлгэдсэн.

Хонх гурван хувьд оршдогоор гурван орон ба дотор нь хөндий хоосон буйгаар гурван орон өвөрчилингөөр хоосоныг бэлгэдсэн. Хэлээр нь өвөрчилин хоосон чанарыг онох арга үр цагийн хамт төрсөн их амгалангийн бэлгэ билигийг бэлгэдсэн. Бэлгэ билиг амгалан лугаа хоосон ялгалгүй нь рашааны хумхаар бэлгэдсэн амгалан хоосонг ялгалгүй бэлгэ билиг тэр билиг барам эдийн эхийн үргэлжлэлт дөрвийг бэлгэдсэн.

Тэр мэтээр Очироор арга Очир садва-г хонхоор бэлгэ Очир төвийн эрх баялагт эхийг бэлгэдсэн. Очир хонхыг нааш цааш тэвэрсэн нь долоон гишүүн учрал төгс жаргалангын биеийг бэлгэдсэн. Хонхы дуугаар төгс жаргалантын биеэр очир хөлгөний хүрц номын үргэлж тасралтгүй эргүүлэхийг бэлгэдсэн. очир хонхоор нь амгалан хоосон ялгалгүйн бэлгэ билиг ба тэрийг удирдагч арга билиг ялгамжтайг бэлгэдэх ёс нь

очироор аргыг бүтээгчин ба түүний нууцын очир хоёуланг бэлгэддэг.

Очир хүйсээр эрийн очирын дүди-гийн доод үзүүр ба хүйсний найман талтай байгаагаар эрдэнийн голын найман судлан дэлбээний судалыг бэлгэдсэн. Хонхын хэлээр эмийн судалын доод үзүүр дагинийн нүүр ба хонхны хэл найман талтай байгаагаар нууцын доторх хүрдний найман судлан дэлбээг бэлгэдсэн.

Очирыг зүг наймд хөдөлгөх ба хонхны хэлийг зүг наймд хөдөлгөн цохих нь бүтээлчиний очирын эрдэнэ бээр мудрагын ум судалын доод үзүүрийн амыг нээхийн тухайд ба нууцын дотоод найман судалыг хөдөлгөх тэрийг бэлгэдсэн.

Хонхны дээрх хагас очироор эр эм тэгш орших тэрийг бэлгэдсэн. Очир хонхыг нааш цааш эвцэлдүүлэхийн ёсоор үйлдэх нь эр эмийн төв судалын хоёр доод үзүүрийг учруулснаар хоёр хий холилдоод дөрвөн хүрдэнд бадраах, цувирлахыг бэлгэдсэн. Тэр цагт илчийн галыг бадраах нь очир болон хонхны наран дэвсгэрээр бэлгэдсэн илчийн галыг бадрааснаар бодь сэтгэлийг /дусал/ холилдуулах нь саран дэвсгэрээр бэлгэдсэн. Зургаан хүрдний судлан дэлбээг нь очир хонхны лянхуагаар бэлгэдсэн дөрвөн хүрдэнд шүтсэнээр ёс дагуу ёс урвуу дөрөв дөрвөн баясал лугаа наймыг нь очирын хүйс ба хонхны хэлний найман талаар бэлгэдсэн .

Тэр мэтийн хамт төрсөн их амгалан түүнийг буцаан ялгавал таван бэлгэ билигт буйг нь таван эвэрээр бэлгэдсэн. Тэдгээр эвэрүүд нь матрын амнаас гарсан нигүүлсэхүйгээр амьтаныг үл талбихыг бэлгэдсэн. Лянхуан дээд доодын эрдэнийн эрхи ба гэрлийн цацраган зургаар шавийн эгээрэлийг хангахын үйлс дэлгэрэхийг бэлгэдсэн. Бас очироор хоёр үгүй

бэлгэ билиг таалал ба хөрөнгө тэргүүтнээр бэлгэсэн хонх нь бие хоосон чанарыг дуурсгах хонхны дуугаар зарлигийг бэлгэдсэн.

Товчилбоос тэр гурав нь үнэмлэхүйн бодийн сэтгэлийн мөн чанарт бишрэх гурван очир ялгалгүйн чанартайд харах хэрэгтэй юм.

Тийм учраас их амгалангийн бэлгэ билигийн магадлахуй утга нь очир хоосон чанарыг онох, билиг нь магад утгын хонх бөгөөд магадлахуйн очир, хонх, дотоод очир, хонх, бэлгэдэхүүн утгын очир хонхнууд нь утга нэг болой.

Магадлахуйн утгын очир, хонх амгалан хоосон ялгалгүйн бэлгэ билигийг ялгавал таван мөр буй бөгөөд “Хавсаргалт”-аас очирьг цацралын барилдлагаар очир амьтныг орчлонгоос гэтэлгэдэг. Очир нь ирүүлэх егүзэр ба очир нь хөшөөх егүзэрт мэт харанхуй мэтийн нисваанисыг тийн мэдэл зул лугаа хамт нэгэн бэлгэ билигийн очироор дарж үйлд.

Үзэгдэх зүгийг нь олох очир нь бүтээл бүхэнд очир би хэмээхийг үзүүлэн хэмээн номолсон.

### **Очир хонхыг адистэдлэх ёс бодитой нь**

Очир хонх адистэдлэх ёс бодитойгийн тарни ба шүлэглэлүүдийг нь “Самвүда” “Гүр”-ээс номолсон бөгөөд очир барих тарнийн утга ч бусдад буй.

### **Очир барих тарнийн утга нь**

Ум үсэгт А, ү, ма гурав байдгаар лагшин, зарлиг, таалал очир гурвыг тус тусад бэлгэдсэн А-д ү-г оруулснаар О болдог. Түүнд ма үсгийн дусал болон өгснөөр Ум үсэг нэгд болох нь лагшин зарлиг таалал очир гурвыг ялгалгүй бэлгэдсэн бэлгэдэл

утгыг дурьдахын үүднээс Ум хэмээн нэг удаа өгүүлбэл буяныг ихэд олдог учир эрдэнэ баригч тарни хэмээн өгүүлдэг.

**Сарва дата гада нь түүнчилин ажирсан бүхэн**

**Сиди нь бүтээл**

**Вазра нь очир**

**Самая нь тангараг**

**Дашта нь авах буюу бат**

**Эхасдам дара я ми нь үүнийг би бээр барьж үйлдэе.**

**Хи хи хи хи хи** таваар таван бэлгэ билиг

**Хум хум хум** гурваар лагшин зарлиг таалал гурван очир ялгалгүйг бэлгэдсэн

**Пад нь** утга тэрийг тодруулан үйлдэх

**Суха нь** хилэнцийг дарах ба буяныг арвитгах тэргүүтэний үйлдэл лүгээ төгсөөр хямралдахыг гаргах “Очир үзүүр”-ээс суха хэмээгдэхийн утгыг өгүүлбэл хилэнц бүгдийн амирлуулан үйлдэгч, буяны чуулганыг арвитган үйлдэгч гэм бүхнийг булаагч, зовлон бүгдийг дарагчийн дээд хэмээн номолсон.

### **Товчилбоос Очир барих тарнийн утга нь**

Түүнчилин ажирсан бүгдийн бүтээл очирын тангараг үүнийг баттай барьж үйлдэе. Тэр аль вэ? хэмээвэл Очир садва-гийн өвөрчилин таван бэлгэ билигийн чанарт лагшин зарлиг таалал ялгалгүй их амгалангийн бэлгэ билиг энэ болой хэмээгдэх болой.

### **Хонхыг барих тарнийн утга нь**

Хонхыг барих тарнийн утгыг тайлбарлавал **вазра ганда хум** хэмээгдэхийн **вазра ганд** нь очир хонх бөгөөд ном бүхэн үнэнээр хоосоныг тэгш чанартайд онох бэлгэ билиг нь хонхны магадлахуй утга бөгөөд бэлгэдэл утга тэрийг дурдахын үүднээс

хонхыг хөдөлгөн түүний дуугаар ч хоосон чанарын дууг дуурсгасанд санаад хум-аар таван бэлгэ билиг орон лугаа сэлтийг бэлгэдсэн. Бэлгэдэл утга тэрийг дурдахын үүднээс нэгэн удаа өгүүлбэл зовлонг шалтгаан сэлттэй тасдагч бөгөөд "Очир үзүүр"-ээс хум үсэгийг өгүүлбэл зовлонг арилган дарж үйлддэг.

Хортонг тарниар алж үйлдээд

Сансарын цаламыг тасдан үйлдэгч

Хум-ыг нь дээдэд дурдаж үйлд хэмээн зарлигласан.

Түүний сүүлд очир хонхны бэлгэдэл утга нь амгалан хоосон ялгалгүйн бэлгэ билигийг өөрийн үндсэнд үүсгээд Очир садва тэргүүтэн бурхан бүгдийг баясгаж үйлдэе хэмээн санаж өгүүлсэнээр хум-ын аялгууг авч үйлдээрэй. Очирыг хөдөлгөхийн хэрэг тэрийг үзүүлэхэд амьтаныг мунхаг лугаа хагацуулах хэмээх тэргүүтэн нэг шүлэг гарсан түүний утга нь магад утгын очир амгалан хоосон ялгалгүйн бэлгэ билиг тэрийг хөдөлгөн өөрийн үндсэнд үүсгэх нь үзэсгэлэнтэй бөгөөд сайн.

Амьтадыг нь балар мунхаг лугаа хагацаан үйлдэхийн үүднээс орчлонгийн зовлонгоос тийн тонилгох үйлдэхийг үйлдэх бөгөөд тэр мэт үйлдэн чадах нь бэлгэ билиг түүгээр ном бүгдийн хоосон чанарыг олдог тийм учраас хоёр үгүй бэлгэ билиг нь дотоод очир ба тэрийг бэлгэдсэн очирын цацрал лугаа сэлтээр барих нь зохистой бөгөөд учир шалтгааны номлол нь сая номолсоных болой.

Тэндээс хойд зүг тэргүүтэн зүг наймд хөдөлгөн хум гурав ба Хо-г гурав өгүүлнэ. Гурван хум-аар гурван очир нааш цааш ялгалгүйг бэлгэдсэн. Хонхыг хөдөлгөхийн хэрэг ба хөдөлгөх ёс **Ум вазра дарма ранида** хэмээн тэргүүтнээр үзүүлсэн буй

Түүний утга нь

Ум нь урьд адил

Вазра нь очир бөгөөд хоосон чанарыг бэлгэдсэн

“Очирын үзүүр”-ээс хатуу бөгөөд

зүрхэн хөндий хоосон үгүй шатаагддаггүй хагалагддаггүй, эвдэрдэггүй бөгөөд дарагдах үгүй учир хоосон чанарыг очирт өгүүлж үйлддэг хэмээн номолсон.

Дарма нь ном ранида нь дуурсгах

Браранида нь машид дуурсгах

Сам браранида нь бүхэнд дуурсгах

Сарва вүдда нь бурхан бүхэн

чэда нь орон бра зала нь хөдлөх

бранза бра мида нь билигийн чандад одох

нада нь дуу

сувава нь өвөрчилин

вазра саду нь очир садва

хри дая нь таалал

сандо ка нь бүхэнд баясах

хум гурав ба ха гурав

суха нь урьдахчилин

Тарнийн утга нь товчлон хураавал хоосон чанарын дууг дуурсгаж машид дуурсган бүхэнд машид дуурсган бурханы орон бүгдийг хөдөлгөн үйлдмүй. Алинаар хэмээвэл билигийн чандад хүрсэний дууны чанараар болой.

Хэрэг юуны тухайд гэвэл Очир садва-гын тааллыг баясган үйлдэхийн тухайд болой. Тэр ч билигийн чандад одсоны өвөрчилин хоосон чанарын дуу дээд дунд адаг гурваар гурван очир ялгалгүй Очир садва-гын таалалыг баясгаж үйлдсэнээр

дээд дунд адаг гурван амьтадыг орчлонгоос гэтэлгэж үйлдэе хэмээхэд мэдэж үйлдээрэй.

Тэр мэт бүтээлийн аргын эхэнд очир хонхыг адистэдлэхэд гол хэрэг нь бэлгэдэгч үлгэр очир хонхны бэлгэдэл утга амгалан хоосон ялгалгүйн бэлгэ билиг тэрийг мөрийн дээд амьд мэдүүлэхийн тухайд юм.

## Хоёрдугаарт. Дамар ба биеийн чимэгийн тийн агуулагад хоёр

Анхан Дамарын тийн агуулгыг өчүүхэн уг алинаар үйлдэхийг өгүүлэхэд нь Самвүда-гаас тэндээс дамарын бэлгэ чанарыг номлоё. Вазра шрикийн үндэс ба улаан зандангаас гаргасанаар ба бусадууд алин нугууд тэдгээрийг нь сэтгэлд хүрсэнээр үйлд хэмээн очирт мод ба зандан үхэрийн толгойны модоор үйлдэхийг номолсон.

Увидасын хонгорцогт очирт мод ба Ширикада мод нь цутга нэгд ч номолсон. Тэдгээр нь угийн эрхэмийн эрхэнд үйлдээд тэдгээр нь эс олдвол мод алин ч болох сэтгэлд хүрсэнээрээ үйлдэж болохыг урьд татсан мэт буй.

Модноос бусад гавалаар үйлдэхийг үндэс түүнээс бусад гавалаар хэмээн номлоод “Рид хувилгааны тарнийн үндэс”-ээс хүний гавалаар дамарыг хэмээн номолсон. Хэмжээг нь Самвүда-гаас түүний хэмжээг зарлиглавал арван хоёр хуруу ба арван хуруу, аманд хуруу нь зургаа, тав, есөн хуруу арван нэг ба аманд түүний хагас нь болой хэмээн дамарын өндөрийн хэмжээг арван хоёр хуруу амны цар хэмжээг зургаан хуруу байна. өндөр арван хуруу хэмжээтэнд амсар таван хуруу түүнчилин өндөр арван нэгэн хуруу ба өндөр есөн хуруунд ч амсарын цар хэмжээг өөр өөрийн өндрийн хагасын хэмжээнд үйлдэхийг номолсон. Дээд хэмжээ нь өндөр нь арван хоёр хуруу дунд хэмжээ нь арван нэгэн хуруу ба арван хуруу адаг хэмжээ нь есөн хуруу бөгөөд энэ дөрвөн зүйлээс өөр зүйлийг номолсон нь эс үзэгдэнэ.

Амсарын хэлбэрийг нь гавлаар үйлдвэл гавалын хэлбэрийн эрхэнд одох хэрэгтэй модоор үйлдвэл дугуйруулан үйлдэнэ. Тэр ч дамарын бэлгэ чанар бүрдвэл үүгээр зан үйлийн



гавал дамар лугаа хэлбэр адил хэрэггүй. Үлгэрлэвэл Бодици болон рүрагча тэргүүтэний эрхи гавлын эрхи лүгээ хэлбэр адил хэрэггүйчилин болой. Гавал дамар ч арван зургаан настай эрэгтэй ба арван хоёр настай эмэгтэйн хоёр гавалыг дагзаар нь хавсран үйлддэг. Үүнд хэрэг ялгамжит байдаг номолсон.

Заримууд модон дамарын гадаад хэнгэрэг гавал дамарыг дотоод хэнгэрэг хэмээдэг ч үндэс болон Энэтхэгийн гол номлолуудад номлоогүй байдаг.

Мод болон гавал аль нь ч дамарын амсарыг бүрхэхийг нь Самвүда-гаас бичний арьсаар бүрх хэмээн номолсон мэт үйлдээд түүнд алин зурахыг Самвүда-гаас түүнчилин хавсарсан хоёр лянхуа зурж үйлд зурахад эмэгтэйн цусаар үзэсгэлэнтэй зур ба лянхны цоморлигт хот мандал нугуудыг зурж үйлд хэмээн номолсоны утгыг номловол эмэгтэйн анхны сарын тэмдэг үүгээр бүрхэх арьсны дотор талд найман дэлбээт лянхуа зур. Лянхуан цоморлиг хүйс хоёрт бүтээлчин өөр өөрийн дээд сэтгэлийн бурхан дээд амгалант, баясгалан очир, эрлэгийн элч тэргүүтэн хот мандалын эзэн алин түүний лагшин буюу тарни буюу мутарын барьцыг зурахыг номлоод тарнид ч зүрхэн ойрын зүрхэн, үндсэн тарни аль нэг нь болох бөгөөд эр эмийн хоёр тарнийг эрэгтэйн гавал ба эмэгтэй гавлын амсарыг бүрхэвч хоёр тус тусад нь бичээд дээд доодын харалдаа буулгаж үйлдээд хожим дээд доод эндүүрэлтгүй ба өнцөглөн босгоод агуулахнаан ч дээд тал нь баруун доод тал нь зүүнд ирнэ хэмээн номолсон. Дээд доодыг эндүүрэхийн тухайд дээд талын бүрхэвчийн гадна хум үсэг зурдаг уламжлал байдагч урьд номолсон мэт лянхуа цэцэг лүгээ сэлтийг дотор нь зурахыг номолсон.

Урьдын зарим лам нар дээр нь дээд сэтгэлийн бурханы хөрөг буюу мутарын барьц, доор нь номын сахиусны мутарын

барьц ба найман дэлбээ нь зүүнээс баруунаа эргэсэн очир алх, сүх, соёо, хүрд, дуаз, илд лавай нугуудыг зурах нь увидас юм гэж зарлигласан.

Рид хувилгааны тороос хоёр талд нь лянхуа зурахыг эмэгтэйн цусаар үзэсгэлэнтэй үйлдээд зүрхэнд нь Тим үсэг зураад хэмээн лянхуаны зүрх буюу хүйсэнд бусадыг номлолгүй Тим үсэг зурахыг номолсон. Үндэс үүнд үхээрийн орон дахь эрэгтэйн үсээр хэмээсэн ба "Рид хувилгаан"-ы тороос хүний үсээр зүүсэнээр хэмээн дамарыг утсан тороор үйлдэхийг номлоод үүний ёс нь дамарын амсар лугаа харалдаад арьс тэргүүтэнийг машид уяныг модны татуураар нийлүүлээд сайтар барилдуулан батадгаж үйлдээд дээд доодын эвцэлдсэн хоёул түүнд арван зургаа арван зургаа хол ойр тэгш нүхлээд дээд доодын нүхнүүд харалдаа ирүүлж үйлд.

Үүнд нүх зургаа зургаа хэмээн номолсон байвч доор нь баясгалан арван зургаа хоёр хэсгийг бэлгэдэхийн тухайд торон номын гаралган хүснэгт дээр доор арван зургаа нэжгээд ирж үйлд хэмээн номолсон лугаа харшилна.

Нүх зургаа зургаад үйлдэх гол торон номын гаралга арван зургаан хүснэгт ирэх аргагүй болой. Тийм учраас арван зургааг зургаа хэмээх үсэг эндүүрч бичсэн бололтой.

Тэр мэтээр дээд доодын нүхнүүдээс нарийн жигд эрчилсэн утас татаад зөрөлдүүлэн татвал дээд доод хоёрт номын гаралга арван зургаан хүснэгт нэжгээд ирэх үүгээр нь дээрээс буух ба доороос батадгах арван зургаа арван зургаан баясгаланг бэлгэдсэнийг номолсон.

Утас нь үндсэн хоёрын ишийг урьд татсан мэт хүний үсээр үйлдээд заримууд "Үндэс хоёр шинжлэлт"-ээс хулгайчийн

үсээр бус тэргүүтэнийг үйлдэхийг номолсоны ухааныг найруулсанаар үүнд ч хулгайчийн үсээр үйлдэхийг номолсон.

Ер нь дамарыг төвдөөр Жандэу хэмээгээд дамар ч хэмээх Энэтхэг үг мөнөөр энэ хоёрын тоо зүйл адил. Хадамга дамар, бадар аяга чөмөгийг баатарууд барьж үйлд хэмээсэн ба билиг дамарын дуугаар хэмээн тэр хоёрыг ялгалгүйд номолсон. Тийм учраас утсан тор буйг Жандэу гээд үгүйг дамар болой хэмээн ойлгож болохгүй.

Цохилуур нь “Рид хувилгааны тор”-оос хөх үрэлийг хөлийн ясаар хэмээн номолсоныг тайлбарлахад Ловон бүннян бээр хөлийн яс тэрийг дамарын цохилуурт номолсон.

Урьдын зарим багш нар үндэс үүнд цахлай шувууны хөлөөр цохилуур хий хэмээн номолсоны утганд зохиосоноор цахлай шувууны хөлний ясыг лав ба нимгэн бүрхүүлээр хуйлаад хүний үсэн утас тэргүүтэнээр зүүж цохин үйлдэхийг номолсон байдагч Авяа бээр Увидасын хонгорцогт Самвүдагын эш цахлай шувууны хөлний ясаар цохь хэмээсэнийг цахлай шувууны хөлийн оронд цохь хэмээхийг орхисоноор түүний утгыг ороныг тэтгэгчийн дагинасыг ирүүлэх үйлийн барилдлага зохиох цагт Егүзэрва бээр зүүн хөлөө цахлай шувууны хөл мэт дээш өргөн газар дэвхцэх үе нэгэн буй түүний утганд номолсонд зарлигласан.

Дамарт яруу дуу гаргахын тухайд тор бэлхүүснээс торон тэргүүтэн бүслүүр өргөнд үзүүр хоёр хуруу төдий буй зөөлөнгөөр өчүүхэн ороо хэмээн заримууд номолсон бөгөөд түүнийг гараар барих дээсэд ч зүүж үйлд.

Бас нууц хэнгэрэг ба их лавайн линбү үйлдэх ёс нэгийг номолсоноор тэр мэт үйлдэх ёсыг “Тарнийн дээд явдалд нууц далай” хэмээгдэх үндэсээс гарсан хэмээн заримууд номолдогч

үндэс энэ нь төвдөд үзэгдэхгүй бөгөөд шинэ тарнийн гол номлолд эс гарав хэмээн хамгийг айлдагч Хайдав бээр номолсон.

Тэр мэт Дамарын тийн агуулгыг номлон төгсөв.

### **Хоёрдугаарт. Биеийн чимэгийн тийн агуулгад**

Ёогийн үндэсний үесд газрын зан үйлд ороход титэм, манжлага, эрдэнийн чимэгүүдийг тус тусын тарниар тарнидсанаар өмсөхийг номолсоноос бусад чимэгийн бэлгэ чанарыг нарийвчлан номлоогүй.

Дээр үгүй үндэст нь “Нууц хураангуйн” үесд ч егүзэрийн үндэс лүгээ адил эрдэнийн чимгээс бусад ясан чимгийг номлоогүй бөгөөд тэрийг ч барилдуулвал язгуур үндэсний арван зургаа дугаарт мэт хот мандалын бурханы баг өмсөн чимэг зүүгээд эсвэл бурханы биеийн өнгө лүгээ адил будгаар биеэ будаад тэр адилын өнгөт хувцсыг өмсөн эрдэнийн чимгээр чимсэнээр газрыг барих тэргүүтэний зан үйлийг үйлддэг хэмээн Вүдан тамжад чинба бээр номолсон.

Үндэсний зан үйл тэрэнд голлон хэрэглэх үесийг номолсон ч газрын зан үйлд хэрэглэхийг Лүжангын хорин хот мандалын зан үйл тэргүүтэнээс номолсон.Тэр ч

1. Оройд эрдэнийн титэм
2. Цэцгэн эрхин
3. Чихний дээрх удвалын цогнойлт
4. Биед эрдэнийн найман чимэгээр чимэхийг номолсон.

**Анхан. Титэм нь:** Шанхлан цомцоглосонд шүтэж эрдэнийн бүслүүр гурван зэрэгт эрдэнийн охиудаар үзэсгэлэнтэй үйлдэж оройд эрдэнэ оршсон хагас очироор бэлгэддэг бөгөөд энэ нь шанхан цомцог бодитой буюу хиймэлийг үснэрийн дээрээс малгай мэт өмсөх нэгийг хэлдэг.

**Хоёр. Цэцгэн эрхин нь:** Цэцгэн эрхинийг ямар мэт өмсөх нь тодорхойгүй ч үсний завсараас гавалыг ороож үйлддэг болвуу.

**Гурав. Манжлага нь:** Чихний ард титэм хоёрт зангидсанаар үлдсэнийг унжуулан үйлдэх чимэг бөгөөд одоо таван язгуурын

титэмийн завсараас холбон татсан утсанд унжуулсан титэм хэмээн алдаршсан энэ нь түүний орлол мөн нь илт болой.

**Дөрөв. Удвалын цогнойлт нь:** Чихний дээр байх чимэг бөгөөд тэр ч чимэг бусад лугаа чих тэргүүтэнд наалдсаны ёсонд бус иш нь чихний ар талаас дээш боссоноор өмнө талруу бөхийсэн нь магнайн цогнойлт мэт үйлдсэний үзүүрт Удвал цэцэг найгахчилин болой.

**Тав. Эрдэнийн найман чимэг нь:**

1. Титэм
2. Ээмэг
3. Хоолойвч
4. Бугуйвч
5. Шагайвч
6. Цэцгэн өвчүүний чимэг
7. Сондор унжлага
8. Сондорт бүс

Үүнд өвчүүний чимэг нь хойно номлох ясан сугавчилуур лугаа хэлбэр адил

**Сондорт бүс нь:** Бүсний нэг төрөл бөгөөд суурь хавтгай бүсэнд шүр тэргүүтэн олон нэлмэрсэн ба тэдгээрийн үзүүрт алт тэргүүтэн чимэг, хонх, гөвүүр тэргүүтэн олон уншлага төгс болоод нэлмэрэх унжлагын тоо тэргүүтэн нь ясан чимэг лүгээ адил үйлдэж болохыг илтэд номолсон.

**Титэм нь:** Таван язгуурын бурханы лагшин буй бөгөөд гадуур нь алтан угалзаар асарласаны ёсонд эргэсэн нарийн үзүүрт болой.

**Чимэг бусадууд нь:** Угийн ялгаанаас бусад урлал, хэлбэр нь ихэнхдээ ясан чимэг лүгээ адил болой.

Цагийн хүрдэн тэргүүтэн олноос ясан чимэг ба зургаан мудра-гаар чимэхийг номлоод тэр ч зургаагийн тоолох ёсонд их бүтээлийн Лү ева-гын илт онолд хоолойвч, бугуйвч, ээмэг, хоолойн эрдэнэ, сугавчилуур, үнс нүүгдийг номолсон бөгөөд илт өгүүлэх лам нар ихэнх нь оройн эрдэнийг тоололгүй толгойн эрхинийг тоолох бөгөөд "Хоёр шинжлэлт"-ээс бясалгаачины байдалыг баригчидын чихэнд сайн ээмэг тэргүүтэн найман бадагыг номолсоныг оройн үснэрийн эрдэнэ сугавчилуурыг тоололгүй, хүрд ба бэлхүүсний чимэгийг тоолохыг "Бүтээлийн арга эндүүрэлийг тэвчсэн"-д тэр мэт номолсон.

Зундуйбалшэйнэн бээр тэр хоёрыг ойрын мудрад номолсон. Цагийн хүрдэнд хүрдийг эс тоолдогч ариуныг номлох цагт хүрдийн ариуныг номлох хэрэгтэй тул ёс үүнд ч хүрдийг таалах хэрэгтэй болой.

Тийм учраас цагийн хүрдэнд оройн үснэрт очир эрдэнэ хэмээн номолсон тэр ч хүрдний голд орших эрдэнийн үзүүрт очироор бэлгэдэн үйлдвэл сайн хэмээн номолсон. Үнс нь хүний ясны үнс ба чимэг үлдсэнүүдийг ч хүний ясаар үйлдэхийг номолсон нь олон бөгөөд Богд хамгийг айлдагч нь яс үгүй бол хулгайчийн үсээр бугуйвч тэргүүтэнг үйлдэж болох бөгөөд "Хоёр шинжлэлт"-ээс үс бүс хоёр давхарлан үсэн сугавчилуур хэмээн номолсон тул үзүүлсэнд тааллаа хэмээн Хайдүв богд номолсон.

## **Чимэг тэдгээрийн байдалыг**

### **ямар мэт үйлдэх нь**

**Оройн үснэрийн чимэг нь:** Үзүүрт таван үзүүрт очироор бэлгэдсэн найман хувьт эрдэнэ буюу есөн хувьтын ёзоорт хүний ясан хүрд найман хигээстийн хүйсэнд бат оруулж үйлд. Хүрдний хигээсний завсаруудаас найман нүхнээс хэлхэсэн ясан эрхин хүрдний хигээс мэт баясныг найм үйлдэхийг номолсон ч хүрд үүнд цагираг буй үгүй нь тодорхойгүй бөгөөд ясан эрхин тэдгээр уруу унжихыг Далай лам гаслан Жамцын гэгээн бээр Аюулгагчийн үүсгэлийн зэрэгт зарлигласан байдаг.

**Таван хатсан хохимой титэм нь:** Хүрд түүний арын гурван хигээснээс бусад таван хигээсний харалдаа хүний хатсан таван толгой хэмжээ нь таван хуруу хоёр очирын эрхинээр цээж бөгснөөс хэлхсэн мэт үйлдэхийг номолсон тул хатсан хохимой тус тусын ард очирын эрхин дээд доод хоёрын утсанд эрхи хэлхэн нүхлэхийг дээд доод хоёр нэжгээд буйд үйлд.

**Үүнд Шанхлан цомцоглосон нь:** Тэргүүний үс бүгдийг оройд хурааснаар зангидсаны үсний үзүүрүүдийг дотогш оруулж илэрхийгүйгээр үйлдэн өндөрлөг болгон зангидсаныг хэлнэ. Түүний өндөрийг нэг төө төдий хэмжээтэй байхыг номлоод хиймэл үснэрт ч байдал тэр мэт үйлдэх хэрэгтэй.

Хатсан гавалыг хэлхсэн очир эрхин доороос унжсан ясан унжлага хагас унжлага үйлдээд түүний доод үзүүр нь магнайн харалдаа үзүүр нь гурван хуруу төдий буусан ба чихний харалдаа чихний хагас төдийд хүргэж үйлд.

**Ясан сугавчилуур нь:** Зүрхний харалдаа өмнө ард ясан хүрдний хүйсэнд гурван үзүүрт очироор бэлгэдэн үйлдсэн бөгөөд хүрд хоёулангийн суурь дөрвөлжин үйлдсэний дөрвөн үзүүрт нүхлэн үйлдсэнээр утсаар хэлхсэн эрхин загалмайлан хүйсний



үргэлжлэл хоёр мөр ба суганы доор хоёрт ирсэнээр холбогдон үйлдэх бөгөөд тэр ч мөрний дээд баруунаас ирсэн эрхиний утас хүрдний суурь дөрвөлжилсөний дээрх баруун өнцөгийн нүхнээс доод зүүн өнцөгийн нүхэнд нэвт гарсан ба мөрний дээд зүүний эрхин ч түүнчилин дээд зүүн өнцөгөөс доод баруун өнцөгт нэвт гарсаны ёсоор солбиулан баридуул. Эрхин үүнд ч гурав зэргэцсэн болохыг номолсон.

**Шагайвч, бугалгавч бугуйвч нь:** Үес үүнд хоёр зах төв лүгээ гуравт ясан чимэг голд үе лугаа хязгаарын шүтээн үйлдэх хэмээх тэргүүтэнг номолсоны утга нь ясан ялтасд очир тэмдэг байгуулсан суурь лугаа завсарын сунгасан байдалтай гурвын нүх тав тав хатгаад тэдгээрээс татсан утсан хэлхээний эрхин тав тавыг зөрүүлдүүлэн нийлүүлж үйлдэж түүний доод талд унжлага гөвүүр өчүүхэнүүдээр үзэсгэлэнтэй үйлдэх нь гурвууланд адил бөгөөд ялгаа нь чимэг тэрийг зүүх орон нарийн бүдүүний эрхээр бугалгавч баруун зүүнд урт түүнээс шагайвч богино түүнээс бугуйвч богиноор үйлд.

**Таван эрхинийг зөрүүлдүүлэн хавсарах ёс нь:** Ясан ялтасуудын завсар завсарт эрхинүүд солбиулан ирж үйлдэх хэрэгтэй буюу шинжилж үйлд. Ялтас тэдгээрт урд үргэлжийн очируудад тус тусын хэмжээний тийн агуулгыг үндсээс номолсоныг ямар мэт байгуулах аваас үндэсний таалал лугаа зохилдохоос хохимой яс, тахилын охин тэнгэр тэргүүтний дүрсийг үйлдвэл шалгадаг төгсийн уг үгүй болой.

**Хоолойвч нь:** Голын гол нэг ба захын шүтээн хоёр лүгээ ясан ялтас гурвын завсар ясан найман эрхинээр солбиулан хэлхэж түүнээс унжлагын ёсонд унжсан эрхийн үзүүрт найман унжлага буйд үйлд.

**Сондорт бүс нь:** Урьд номолсон мэт бүсний төрөл бөгөөд энэ нь төв гол гурав ба хоёр захад ялтас тавуул нэжгээд нэжгээдэд баруун зүүн хажууд найм найман нүх үйлдсэнээс татсан найман хэлхээнд найман эрхин зэргэмжээр солбиулан барилдуулсан буюу эсвэл Ловон Авяа бээр номолсон мэт эрхин арван зургаан зэрэгээр үйлдээд тэр хоёр алин ч түүнээс унжсан таван унжлага тор хагас унжлаг тор гурван хэсэг зургаа үйлдээд баруун зүүний гурван хагас унжлага тор гурав гурван хэсгийн хагас унжлага тор хоёр хоёр өвдөгний харалдаа хүрсэн. Тэр бүгдийг үзүүрт ясан унжлага гөвүүр тэргүүтэн олноор унжсан товчилвоос хагас унжлага тор гол эс хүрсэн төвүүдийн хажуугийн хагас тор хоёр хоёр бүгд арван хоёр нь богино байна.

Үүнд ч “Егүзэрийн цэнгэлийн баясгалат хурим”-д таван унжлагат тор хагас унжлагат тор арван гурав буюу бүгд арван найм байна хэмээгдэх үзэгддэгч унжлага торын завсарт хагас хагас унжлага тор солбих аваас ч тэр мэт эс жигдэрсэнийг бусдад үйлдэх арга ч үгүй тул унжлаг тор тав ба хагас тор арван найм хэмээгдэхийг таван унжлага тор хагас унжлага тор арван гурав лугаа арван найм хэмээн алдаатай бичсэн үсгийн эндүүрэл болой.

Үүнд гол номлолд ч баруун зүүний гурав гурав хэмээн баруун зүүнд хагас тор гурав гурав лугаа зургаа байх нь тодорхой бөгөөд хагас тор нэжгээд нэжгээдэд ч гурав бүрдсэн мөнийг зарлиг үүний цацарлаг ямагтад гол нь нарийн гуяа хүрсэн бөгөөд түүний баруун зүүн хоёр хоёр нь өвдөгийг дарах төдий үйлд хэмээхээр бүтсэн болой.

**Ээмэг нь:** Голдоо гурван үзүүрт очироор бэлгэдсэн ясан хүрд бөгөөд нэжгээд нэжгээдэд гурван унжлага тор ба хагас унжлага тор солбисон тав таваар чимсэн байна.

**Их үнс нь:** Дээд амгалант баясгалант очир, цагийн хүрдэнээс бол бие бүгдэд түрхэхийг номолсон бөгөөд зан үйлд орох цагт тэр мэт эс чадвал магнай хөмсөгний завсарт хүний үнсэн дусал буюу гурвалсан зураас үйлдэхийг номолсон зарим багш нар биед их үнс түрхэх баясгаж үйлдээд хүний ясын шатааснаар цагаан болгоод нарийвчилиин талхлаад таван хурууны үзүүрээр авч таван хуруугаар нийлүүлэн магнай тэргүүтэн оронуудад хүрэлцэх аваас суурь их үнснээс цагаан таван тэмдэг гарах бөгөөд үүнийг их үнсэн цомцог хэмээн номолсон байдаг.

“Тэгш барилдсан үндэс”-ээс Мамын орны дээд үнсийг бүхэн магнайн сахиус нь дусалан гурван зураас үйлд зүг завсар огторгуй хүлэх аваас сахиус бүхний дээр үгүй мөн хэмээн номолсон энэ нь сая номолсон хүний үнсэн цомцог ба хөмсөгний завсарт хүний өөхөн зураг гурван үзүүртийг үйлдэх өөхөн зураг ба өөрөө гарсны цэцгээр хөмсөгний завсараас бусад биеийн орон хэр зохистод дусал үйлдэхийг цусан дуслыг үзүүлсэн болой хэмээн номолсон боловч тэгш баридсаны зан үйлийн үе бусын сахиусын үйлийн барилдлагад номлоод үнсэнээс бусад хоёрыг үндэсний үг үүгээр бодитой далд алинд ч эс үзүүлсэн эрийн чимэг, эмийн чимгийн ялгааг тодорхой нарийвчилснаар гол номлолд уг нь эс гарсан бөгөөд охин шанх гуравт гурван хатсан хохимойгоос өөр үгүйг Ловон Гонгажин бээр номолсон мэт ба эр тэнгэрт хүний нойтон толгой эмд хатсан толгойн унжлага зүүх ба охин тэнгэрүүдэд их үнс үгүй учир эр тэнгэрт зургаан мудра ба тавын ялгаа төдийг номолсон.

Биеийн чимгийн тийн агуулгыг номлож төгсөв.

**Гуравдугаарт. Хадамгаа болон гавалын  
тийн агуулгад хоёр**

**Анхан. Хадамгааны тийн агуулгад** Хадамгааны ишний хэмжээний урт богинод магадлагаа үгүй бөгөөд доод үзүүрт нь нэг үзүүрт очироор бэлгэдсэн байна. Ишний дээр шар хумх түүний дээр элдэв очир хэвтээ байдлаар оршсон түүний дээр хүний толгой гурав давхарласан байна. Тэрэн дээр нь хүний хатсан цагаан толгой түүний доор хүний хуучин улаан толгой түүний доор нойтон хар толгой байдаг. Бүгдийн үзүүрт таван үзүүрт хар очир огоот төгс нэгэн байна.

Хумхны доор иш лүгээ барилдсанын завсарт сугавчилуур ба өчүүхэн хонх элдэв өнгөт дарцагууд зүүлттэй сугавчилуур алин нь тодорхойгүй ч хүний үсэн цангүд мөн нь илт.

### **Хоёрдугаарт. Гавалын тийн агуулгыг өчүүхэн өгүүлэх**

**нь:** Үес үүнд гавал сав ба лянхуа сав өгүзэрийн бадар аяга хэмээгдэх нь утга нэг тоо зүйл болой. Мөн гавалыг ванда хэмээгдэгч буй. үүнд гавал бодитой үгүй бол түүний оронд хүрэл, зэс, алт, мөнгө, хясаа, яст мэлхийн цээж нугууд ба эвэр мод шавар тэргүүтнээр үйлдэж болохыг “Хавсаргалтын гаргалга”-аас шаварын чанартай яст мэлхий түүнчилин хүрэл, зэс төмрийн төрөл хэмээх тэргүүтэн наймаг бадгаар үзүүлсэнийг “Хавсаргалтын гаргалгын тайлбар”-аас номлосон.

Үүнд Гавалын бэлгэ чанарыг шинжих аргад зургааг номолсон буй

1. Хяргахын урьд харсан зүгийг шинжих
2. Хяргасны сүүлд бүхлийн тоог шинжих
3. Өнгийг шинжих
4. Хэлбэрийг шинжих
5. Шүдийг шинжих
6. Нүхийг шинжих

**Анхан Хяргахын урьд харсан зүгээр шинжих нь:** “Хавсаргалтын гаргалга”-аас газар сайн тэгш орон ба хэмээгдэхээс хажууд хэвтсэн зандалитыг савын бэлгэ чанартад мэдэж үйлд хэмээгдэх арван зургаан бадгаар номлоод “Түүний утгын тайлбар”-аас дайн байлдаанд үхсэн буюу их үхээр тэргүүтэнд орхиосон хүүр унасан харах зүгийг шинжлэхийг номлоод тэр ч урд зүгт харан байвал бярман нарт өгүзэрийн аюул гарна, урьд зүгт харсан байвал үхэрт тэр мэт аюул гарна. Баруунд харсан байвал алдарт муу, баруун хойш харсан байвал тарнийн шид эвдэрнэ хойш харсан байвал эрх баялаг хотол чуулах болно. Зүүн хойш харсан байвал тарнийн шид шидийг өгөх бөгөөд шагшаабадын үргэлжлэл доройтолгүй үүсэх болно.

Зүүн урагшаа харсан байвал тарнийн шидийг булаадаг бөгөөд шид үл гарна. Ам нь доош харсан байвал хулгайч дууддаг, дээш зүглэсэн байвал гавал тэрийг баригчины эмэгтэй нь доройтон үйлддэг. Хажуу зүглэсэн аваас боол тэргүүтэн дарагдан үйлдэхийн утганд номлоод үүнд хажуу хэмээгдэх нь дээд доод хоёр бус хажуу нь зүг завсар наймд магад бөгөөд бусад долуулыг урьд номолсоноор зүүг зүгрүү ам нь зүглэсэнийг барих хэрэгтэйд номолсон.

Тэр мэт хойд зүүн хойдод ам харсан хоёр нь дээд урд ба баруун урд ба доош зүглэсэн гуравыг өөр өөрийн үест номолсон үр тэрийг хүсвэл авч үйлд. Баруун баруун хойно, зүүн зүүн урд дээш ам зүглэсэн төв нь мууд үзэгдэх болой.

**Хоёрдугаарт. Бүхэлийн тоог шинжих нь:** Хөмсөний завсараас шилний хонхорын үүд хүртэл дугуй шугам талбиад доройтуулалыг хус ч ариун цэвэрийг сайтар сахиад шинж.

Тэрийг ч “Хавсаргалтын гаргалга”-аас бүхэл нэг бээр нь орон болно хэмээх тэргүүтэн есөн бадагийг номлоод түүний утга бүхэл нэгт гавалаар хорин дөрвөн оронд одохыг эрхшээсэн ба тэдгээрт одоход үл уйсах тэргүүтэний утганд бусад бээр номлоод шид бүтээх оронд болсоны утганд ч сэтгэсэн болой хэмээн зарлигласан бүхэл хоёр гавал нь олны тахил болон хот мандалын эзэн болон эрхшээдэгийг урьдын дээдсүүд номлосон хэмээгдэх төдийгөөс өөрийг номлоогүй.

Гурван бүхэлт гавал нь алин хүссэн шид хотол чуулж  
үйлддэг.

Дөрвөн бүхэлт гавал нь тарнийн шид бүтнэ.

Таван бүхэлт гавал нь амирлангуй дэлгэр үйл бүтдэг.

Зургаан бүхэл гавал нь гуйлга олдох болно.

Долоон бүхэлт гавал нь эрхийн үйлийг бүтээдэг.

Найман бүхэлт гавал нь амирлангуй тэргүүтэнээс бусад үйл үл бүтдэг бөгөөд хатуу үйлд авч үйлд. Бүхлийн тоогоор үл барам хэлбэр ба өнгөний муу бэлгэ бүгдийг хатуу үйлд хэр зохистойгоор зохицуулахыг номолсон дөрвөн бүхэлт гавал нь тарнийн шидийг бүтээхийг номлосон нь тарни түүний хэрэгтэй шидийг бүтээн үйлдэхээс гурван бүхэлт үр номолсон лугаа адилгүй хэмээсэн.

**Гуравдугаарт. Өнгө нь:** “Хавсаргалтын гаргалга”-аас Бярман хааны язгуур, богдын язгуур хэмээх тэргүүтэн зургаан бадагын номолсоны утга нь ер нь бярманы өнгө цагаан хааны язгуур улаан тэргүүтэн томьёо буй лугаа зохицолдуулан гавалд өнгөний үүднээс язгуур тус тусын гавал хэмээн нэр нэрийдсэн бөгөөд тэр ч цагаан гавал нь бярманы язгуур цагаан улаан туяатыг хааны язгуур шар улаан шар нь богдын язгуур, ногоон нь дорд язгуур ба үнсэн өнгөт тэргүүтэн нь зандалчиний язгуур хэмээн тайлбараас номолсон мэт үйлдээд түүний цагаан ба цагаан улаан туяат хоёр нь дээд шар, улаан шар хоёр нь дунд үлдсэнүүд нь адаг бөгөөд тэвчиж үйлд.

Үйл тус тусад нь сайншаасан өнгө нь үндсэн түүнээс Лавай ба Гүнда өнгө адил хэмээн тэргүүтэн арван найман бадагаар номлоод түүний утгыг нь өнгө цагаанаар тарни бүхний шид бүтэх ба шараар дэлгэрэнгүй үйл бүтэх ба улаанаар эрх ба ирүүлэх үйлийг бүтээдэг. Тэдгээр бүхэнд өнгө нь нүнжигтэй сэтгэлд зохистой нь сайн бөгөөдцайвар улаан навтархай, шар навтархай тэргүүтэн нүнжиг туяа үгүйг тэвчихийг номолсон. Бат чийрэгт бус хүнд үгүй хөнгөн, газар доод одсон, хэврэг сийрэг болсонуудыг тэвч.

**Дөрөвдүгээрт Хэлбэр нь:** “Үндэс тэр ямагт”-аас дорд илүү чимэгтэй түүний байдал элдэв дүрстэй хэмээн нимгэн бөгөөд хэлбэр дорд тэргүүтэний дорд хөрсний навтархай их чийгтэй ба түүнээс бусад хэлбэр сайн тэргүүтэн элдвүүдийн ялгаа ялгаснаар тэвчиж авч үйлдэхийг номлоод илүүг номолсон нь үл үзэгдэнэ. Утга нь их хатуу, товгор, хонхорхой тэргүүтэн нийтийн хэмжээнээс илүүд үйлдэх хэрэгтэй юм.

Хэлбэр мууг бэлгэдэх төдийг өгүүлбэл “Үндэс тэр ямагт”-аас хонхорхой хоёрт зааны ар мэт түүнчилэн очир, хэрээний мөр хэмээхийг номлоод тэр нь дагзны ард хоёр хонхор байх, орой дээрх гол нь доор хоёр зах нь өндөрийг зааны ар мэт гэдэг ба гавалын дотор хэрээний хөл буюу түүний мөр мэтийн зураг буй бол энэ тэргүүтэнг тэвчиж үйлд.

**Барьж үйлдэх гавалын хэлбэр нь:** Голын оронд дөрвөн хонхор буйг хүсэлийн модод мэдэж үйлд. өмнө зүгт хоёр хонхорхойтыг сэтгэлчилин эрдэнэд мэдэж үйлд хэмээн номлоод голын орон хэмээгдэх нь гавалын доторх эсэруа нүх буйн зүгийн төв бөгөөд түүнд дөрвөн хонхор буй хэлдэг өмнийн хоёр хонхорч магнайн төвд хоёр хонхор бөгөөд тэдгээр нь сайн бэлгэ болой.

Урьдын заримууд аюулгагчийн үндэсийн хэсэгт таалаад хожмын мэргэд заримууд эргэлзээний оронд таалсан бөгөөд “Охин тэнгэр орны хотын үндэс” ба түүний даган бараадсан гавалын бэлгэ чанарыг шинжих арга тэргүүтэнг үзүүлсэн. Дэва Агара Зандра бээр зохиосон хэмээх шашдир тэргүүтэнд гавалын шанааны баруун зүүнд гишүү дэлгэрсэн мод мэтийн үндэсний үзүүр нь эсэруа нүхний харалдаа гарсан нь галвирваасан мод ба түүнд үсгийн үр, мутрын барьц, өлзийт найман тэмдэг тэргүүтэний тэмдэг аль нэг үр тогтсон мэт буй бол дээд сайн.



Шилний хонхороос төв хүртэл гүн хонхор зураг нэвтэрсэн буй бол егүзэрийн идээний хөндий дотор нүүр тэргүүтэн хөрөөний ир хэмээгдэх түүний хуруугаар тохож унжуулж чадах нь егүзэрийн амин мод муу бүхэнийг чадна хөрөөний ир мэтийн баруун зүүнд дөрвөн хуруу нэжгээдийн завсар зааны соёо мэтийн зураг нь егүзэрийн эрх баялаг.

Гавалд өөрийн газар, тэнгэрийн газар, багшийн газар тэргүүтэн есөн хувьд хуваасанаар өөрийн газарт дугуй дусал дугираг нарны цацраг мэтийн зураг байвал хонгийн булаг дотор нь нарийн цагаан зураг байвал насны зам хэмээгдэх тэргүүтэн олон нэгийг номолсон бөгөөд харах зүг ба бүхэлийн тоо тэргүүтэний үесд ч үндэс лүгээ үл зохилдох номлол олон байдаг ба гавал шугам тавьж есөн хэсэгт байгуулах тэргүүтэн нь шалгадаг төгс гол номлол алинаас ч гараагүй бөгөөд элдэв холилдсон онол олонтой үзэгдсэн ч үүнд тэдгээрийн тийн агуулгыг эс бичлээ.

**Тавдугаарт. Шүдийг шинжих нь:** “Үндэс”-ээс бурууд төрсөн хорхой идсэн түүнчилин хэмээсэн ба шүд үгүй буюу шүд доройтсоныг буян дуршигчид барин бүү үйлд. Ногоон шүд нь нисваанис олон хэмээн шүдийг хорхой идсэн шүд үгүй шүдний өнгө ногоон урваж хуучин мэт шүд хөхөрсөн, урваж шинэ мэт шүдийн буйл үгүй буруу ургасан тэргүүтэн мууг тэвчиж үйлд. Тэр ч толгой бүхэнд гэм тэдгээр буй үгүйг онохын эрхэнд үйлдсэн болой.

**Зургаадугаарт. Нүхээр шинжих нь:** “Үндэс”-ээс ганц нүхтэй нь бярман болой хоёр нүхтэй нь хааны язгуур, богдын язгуур хэмээгдэх гурван нүхтэй доод язгуурууд нь дөрвөн нүхтэй буюу нүх үгүйг ч мэргэд бээр тэвчиж үйлд. Эмэгтэй гавал болохгүй хэмээн номлоод ганц нүхт нь эсэруа нүх бөгөөд түүнээс

олон нүх нь үндсэн үзүүрээс гавалаа нүхэлсэнээр гадагш гарах буюу гарахад дөхсөн нүх болой. Бярман тэргүүтний томьёог нь гавалд тэр мэт нэрийдсэнээс бодгалийн язгуур тэр мэтийн гавал мөн хэмээхийн утга бусдыг урьд номолсон мэт болой. Эмэгтэйн гавалд эсэруа нүх байдаггүй бөгөөд налвү гавал гавалын хөндий хөрөөний ирийн харалдаагаас магнайн голд буй эмэгтэйн гавал тэргүүтэн болохгүйг номолсон тэдгээр ч шидийг бүтээхэд мөнөөс үйлийн барилдлага заримд магад хэрэгтэйг үндэсний аймгуудаас номолсон буй.

Тэр мэт номлосон харсан зүг бүхэл өнгө, хэлбэр шүд, нүхүүдийг алин номлосон эрдэмүүдийг бүрдүүлж түүний буцсан зүгийн гэм үгүй нь дээд бөгөөд эрдэмийн хувь их нь дунд, гэмийн их хувь нь дорд тул тэвчихийг номлосон.

Үндэс болон Энэтхэгийн гол номлолуудад өөр өөрийн гавалыг үүсгэх зан үйлийг номолсон ба эх үндэсний дүр ёсонд өгөх цагт эр эмийн тарнийг гурван урьсанаар гавалыг өгөх, гавалыг рашаанаар дүүргэсэнээр амгалан хоосон ялгалгүйд барилдуулсан бэлгэдэлийг дурдан үйлдээд барих төдий нэгийг номлосоноос бусад барих ёсыг дэлгэрэнгүй эс номолсон тул алин сайн гавалд шид гарахын барих арга дундад үйлсийг бүтээхийг барих арга мууд гэм үл гарахыг барих арга хэмээх тэргүүтэн олонтой өгүүлсэнүүдийг эс бичив.

Тэр мэт Гавалын бэлгэ чанарыг номлон төгсөв.

## **Дөрвдүгээрт. Бурхан хумх болон хутгуур цутгуурын тийн агуулгад хоёр**

**Анхан. Бурханы хумх буюу бумба нь:** Хумхны угыг алт, мөнгө, зэс ба шавараар үйлдэх буюу бас гууль тэргүүтэнээр үйлдэж болохыг Очир дагинаас номлосон.

Хумхны хэмжээг нь “Цагийн хүрд”-ээс амирлангуй дэлгэр хумхны хүйсийн бөөрөнхий харалдаа арван зургаан хуруу эргэн тойронд түүнээс гурав дахин өндөрдөө ходоод нь ёроолоос ам хүртэл хорин хуруу хоолойны өндөр зургаан хуруу. Ходоодны өндөрт хэмжээ тодорхойгүй хумхын өндөрийн хэмжээ хориос зургаан хуруу нь хоолойны хувьд одсоны үлдэгдэл арван дөрвөн хуруу нь ходоодны өндөр болой. Цоргоны дээд талаас зах хүртэл харалдаад найман хуруу буй бөгөөд тэрийг гурван хувьд хуваагаад хоолойны хөндийд хоёр хувь зүг нэгийн хошууны дээд талын өргөнд хагас хувь зүг бусдад ч тэр мэт хагас хувь бөгөөд тэр мэт гурван хувь болой хэмээн энэ нь амирлангуй дэлгэр хоёрт номолсон ч эрхийн үйлийн хумханд ч адилд таалсан, амны завсараас доош унжсан хошууны өргөнд хоёр хуруу буй бөгөөд энэ нь хумхны өндөрийн хэмжээнээс тусдаа болой. Өнгө нь цагаан бөгөөд хар хир үгүй ёроол суурь үгүй хэрэгтэй бөгөөд хоолойноос доош нарийн бүдүүнийг ямар мэт тааруулаад дээш зэргэмжээр арвадлага ихтэй бүрээний ам мэт буйн дээд үзүүрт урьд номолсон хоёр хувийн хэмжээтийг үйлдээд хошууны зах лугаа жигдэлж үйлдээрэй.

“Тодорхой хослон орохуй” мэтээр бурханы хумх бусдаас тийн ялсан / намжил / хумх ямагтын хэмжээ магадлагаат бөгөөд энэ нь хоолой найман хуруу ходоодны дугуй тойрог таван төө гэж номолсон тул таван төө нь жаран хуруу бөгөөд түүний гурван хувь нь хорин хуруу нь ходоодны дугуйн харалдаах цар хэмжээ

юм. Ам болон хошуу тэргүүтэний хэмжээг номлоогүй ходоод их бөгөөд хүзүү урт хошуу унжсан ёроол суурь эс наалдсан өнгө цагаан сэлтийн бэлгэ чанар эдгээр нь ёс урьд хойд хоёуланд адил болой.

### **Хоёрдугаарт. Цутгуур хутгуур тийн агуулга нь:**

Цутгуур шанага, хутгуур шанагын угыг Дарига бээр алт мөнгө зэс төмөр гууль хүний яс гал мандалын мод лугаа далай аль нэгээр үйлдэхийг номолсон.

Хэмжээ болон хэлбэр нь цутгуурын ишний уртад шалгадаг төгс эрхий хуруу хорин дөрөв, ишний доор эрдэнэ гурван хуруу түүний доор очир гурван хуруу үйлдэх бөгөөд тэр хоёр сэлтээр ишний уртад гучин хуруу байна.

Хутгуурын ишэнд ч түүнчилин болой. Цутгуурын ишний бүдүүний хэмжээг нь очир лугаа сэлтийг гараар хэр амар барьж болохоор ба хутгуур иш нь түүнээс хагасаар нарийн байна.

Цутгуурын ишний дээр шанаган сав бодитой хэлбэр нь дөрвөлжин цард дөрвөн хуруу түүний голын гүнд хоёр хуруугаар доор буйн толионд таван үзүүрт очир хоёр хуруугаар бэлгэдсэн толио түүний цар хэмжээнд гурван хуруу байна. Дөрвөлжин амсар түүний дээр захаар амсар хагас хуруугаар очир эрхинээр чимсэн шанага түүний дээр үзэсгэлэнтэй үйлдсэн лянхуан дэлбээний хэлбэрт амсар хашлага лугаа сэлт дөрвөн хуруут гүнд чигчийний хэмжээ төдийд очир дөрвөн хуруутаар бэлгэдэж үйлд. Үүнийг богдын зарлигт үзэсгэлэнтэй хэмээх нь үзэгдэхгүй ч үзэсгэлэнтэй үйлдэх нь илт бөгөөд шанага үзэмжтэйн тухайд бус хэрэг бусад үгүй болой. Амсарын тулгуур бугуй нь ч илт бөгөөд гүнд хэмээн номолсон буй түүний уртад голоос туушийн ёсонд шим цувирах нүх эрхий буюу чигчийний хэмжээ төдий буй үзэсгэлэнтэй үйлдсэн шимийн нүх лүгээ сэлтийн дээрээс амыг бүрхэхийн ёсонд гурван үзүүрт очир дөрвөн хуруу хэмжээтэйг магад үйлд.

Үүнийг Богдын зарлигийн үгэнд цутгуурын ишний дээр дөрвөлжин хэмээсэн ба дөрвөлжиний дээр лянхуан дэлбээний

хэлбэрт хэмээсэн ба түүний дээр гурван үзүүрт очир, дөрвөн хуруут болой хэмээн тууш нэгэнд номолсныг жишвэл ишний үзүүрт цутгуурын сав дөрвөлжин түүний үзүүрт лянхуан дэлбээний хэлбэртэй түүний үзүүрт гурван үзүүрт очир буй нь адил нэг үзэгдэвч тэр мэт үйлдвэл шим гойжих нүхний үзүүрт очир гурван үзүүртээр хаах нэг гарах бөгөөд хэлбэр үзэсгэлэнгүй ба заншилд ч энэ адил эс үзэгдэх тул тэр мэт эндүүрэн бүү үйлд.

Тэр мэт үйлдэх ёс бусад үгүй учир урьд номолсон мэт нь таарах бололтой.

Хутгуур нь ишний дээр лянхуан дэлбээний хэлбэртэй шанагны цар хэмжээнд хоёр хуруу гүнд нэг хуруу хэмжээт таван үзүүрт очирыг голд байгуулж үйлд. Цутгуур шанаганы хоёр цард хоёр хуруу ба гүнд нэг хуруу номолсон ба цутгуурын доторх цар гурван хуруу ба гүнд хоёр хуруунд номолсон тул хоёр шанагат цар их бага гүн гүн бусын ялгаатай үйлд.

Цутгуурын шанага, хутгуурын шанагын тийн агуулгыг номлон төгсөв.

Тэр мэтээр алин номлогдох номлолууд бүхэн төгсөв.

Төрөлхтөн Сансарын хол замд төөрсөн ёсыг

Тэсдэшгүй хатуу нигүүлсэл машид хөдлөөд

Дээд бодиос өнөд холдсон хувь төгсийг

Ялгуусан бээр дээд хөлөгний түргэн мөрийг зарлиглав

Мөр үүнд зорчих арвис тарнийг баригчдад сахил, идээ шүтэх, тангарагийн эд үгүй байж болохгүй хэрэгтэй эдлэлүүдийг үндэс болон таалалын тайлбаруудаас тодорхой зохиосон буй.

Одоо ёс үүнийг чухалчилагч эгэлүүд хэрхэн онох оюуны хүч дордыг болгоон Хайдүв богд бээр сайн номлол “Егүзэрийн цэнгэлийн баясгалант хурим” хэмээх зохиолоо зохиосон.

Түүний утгыг зүрхэнд болгож аваад гарын авлагад авахуй хялбар үгийн ялгал үүнийг өөрийн дурдалыг дахин дахин сэргээхийн тухайд ба хувь сацуу бусдад тустай болов уу гээд зохиов.

Үүнд эрхи, хувцас ба суудлуудын урлах ёс гарт авах журам өчүүхэнийг орхиод бурханы хумх, цутгуур хутгуур шанаганы хэмжээ хэлбэрийг богд ламын зарлигчилин үүнээ байгуулав.

Агуу их гол номлолын таалал гүн уужимд

Миний оюуны нялхасын доройтлоор бүхэнд нэрвэгдсэн

Хүлцэн зохиогоод огоот цэвэрлэн соёрхо

Эрхэм зарлигийг барин тийн шинжлэн дадуулан

байгуулсаны сайн хувийг чухалчилиин бүтээгч

тэдгээрүүдийн өлмийд мөргөмүй

Амьтны сэтгэлийн огторгуй талд цөвийн цагийн зузаан харанхуй зэргэмжээр бүрхэснийг сайн номлолын яруу хоолойтын эрхэт галуун хаадууд ч аглагын хойморт дияаныг үйлдэн сайн мууг үзэх оюуны нүдэн нээгдэж мунхаг нойроор согтсон доройтол үүнийг эцэг хөвгүүний эрхэм зарлигийн нарны эрх баялагт дээдэд бадарсаны гэрлээр түргэнээ эзлэгдэх болтугай.

# DEDICATION OF MERIT

May the merit and virtue  
accrued from this work  
adorn Amitabha Buddha's Pure Land,  
repay the four great kindnesses above,  
and relieve the suffering of  
those on the three paths below.

May those who see or hear of these efforts  
generate Bodhi-mind,  
spend their lives devoted to the Buddha Dharma,  
and finally be reborn together in  
the Land of Ultimate Bliss.  
Homage to Amita Buddha!

## NAMO AMITABHA

南無阿彌陀佛

《蒙古文：THE EXPLANATIONS OF BUDDHIST RITUALS》

財團法人佛陀教育基金會 印贈

台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

**The Corporate Body of the Buddha Educational Foundation**

11F., 55 Hang Chow South Road Sec 1, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198, Fax: 886-2-23913415

Email: [overseas@budaedu.org](mailto:overseas@budaedu.org)

Website: <http://www.budaedu.org>

**This book is strictly for free distribution, it is not for sale.**

Зарж борлуулахыг хориглоно

Printed in Taiwan

3,000 copies; Sep. 2007

MO012 - 6826